



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 12 дүгээр сарын 16-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-18
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	19-112
<hr/>	
1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	24-29
2.“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн 2022.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	29-48
3.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль зүйн байнгын хороо боловсруулсан/	48-57
4.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	57-58
5.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар/ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	58-89
6.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	89-94
7.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	94-103
8.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	103-104
9.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	104-105
	105-112

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 16-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 56.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 13 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, П.Анужин, Б.Жаргалмаа, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Д.Сарангэрэл, Ч.Ундрал, Б.Энх-Амгалан;

Тасалсан: С.Батболд, Д.Бат-Эрдэнэ;

Хоцорсон: Г.Амартүвшин -2 цаг 13 минут, Т.Аубакир -1 цаг 01 минут, Э.Бат-Амгалан -6 цаг 56 минут, Э.Батшугар -03 минут, С.Ганбаатар -1 цаг 22 минут, Х.Ганхуяг -10 минут, Ж.Мөнхбат -1 цаг 22 минут, Ц.Мөнх-Оргил -49 минут, М.Оюунчимэг -05 минут, Б.Саранчимэг -23 минут, Ц.Сэргэлэн -39 минут, Н.Учрал -48 минут, Ж.Чинбүрэн -03 минут, Н.Энхболд -37 минут, Ж.Эрдэнэбат -2 цаг 52 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Б.Баттөмөр нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Б.Баттөмөр нар, мөн Улсын Их Хурлын гишүүдийн олонх үг хэлэхийг зөвшөөрсөн тул Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, мөн газрын шинжээч Б.Төрбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн дарга Ц.Түвшинзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт Г.Баярмаа нар байлцав.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал Улсын Их Хурлын гишүүдийн үгээр үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Чинзориг, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 13
Бүгд: 49
73.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн 2022.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Баделхан, Н.Учрал, Г.Ганболд, О.Цогтгэрэл, Н.Энхболд, Д.Ганбат, Ш.Адьяа, Д.Батлут нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Г.Дамдинням, Ц.Цэрэнпунцаг, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 21
Бүгд: 53

60.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль зүйн байнгын хороо боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, мөн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Б.Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Т.Энхтүвшин, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 22

Бүгд: 48

54.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Мөнхбаатар, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго, мэргэжилтэн Б.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл болон Хууль зүйн байнгын хороо хуралдах тул хуралдаан 13 цаг 00 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Тав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар/

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Монгол Улсын Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн референт Ж.Монголжингоо нар байлцав.

Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, С.Ганбаатар, Т.Доржханд нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 16 цаг 06 минутаас хуралдааныг даргалав.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Мөнхбаатар, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго, мэргэжилтэн Б.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Одонтуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ш.Адъяаа, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын цахимжуулалт, мэдээллийн технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, С.Чинзориг, Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж, Н.Учрал нар үг хэлэв.

С.Одонтуяа: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.1, 41.2 дахь хэсэг болгох:

“41.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн.

4.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн тайлбарыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 11

Бүгд: 44

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.14.2 дахь заалтын “шадар зөвлөх” гэснийг “эрхэлсэн зөвлөх” гэж, 41.14.3 дахь заалтын “жинхэнэ зөвлөх” гэснийг “ахлах зөвлөх” гэж өөрчилж, 41.14.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 11

Бүгд: 42

73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.16 дахь хэсгийн “цолд хамаарах албан тушаалын ангилал,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 11

Бүгд: 42

73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.17 дахь хэсгийн “Албан хаагчийн” гэснийг “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн” гэж, “мэргэшлийн, эрдмийн” гэснийг “докторын, мэргэшлийн” гэж өөрчилж, “нэмэгдлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 13

Бүгд: 42

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

С.Одонтуяа: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 41.18 дахь хэсгийн “оногдуулах” гэснийг “ногдуулах” гэж, 3 дугаар зүйлийн “Улсын байцаагч” гэснийг “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч,” гэж, ““41.7.2.” гэснийг “41.8.1.” гэж, “41.7.3.” гэснийг “41.8.2.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.4.” гэснийг ““41.7.2.” гэснийг “41.8.2.” гэж, “41.7.3.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.4.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.6.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Одонтуяа: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалт,” гэсний дараа, мөн зүйлийн 57.5.4 дэх заалтын “гаалийн байгууллагын ажилтан” гэсний өмнө “гадаадын иргэн, харьяат,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтын “шинжээч, мэргэжилтэн” гэсний дараа “, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор О.Мөнхбаатар, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Баатарсайхан, мөн холбооны гишүүн, өмгөөлөгч Д.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 16 цаг 42 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, С.Чинзориг нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Гэмт

хэрэг үйлдсэн этгээд түүнийг яллагдагчаар татахаас өмнө” гэснийг “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9 дэх хэсгийн “дууссан эсэхээс” гэснийг “дууссанаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дахь хэсгийг хасах.

“1.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс ажлын чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тэнцүү байна” гэсний дараа “Энэ хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгт оногдуулах торгох ялын нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байна” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “найман жил” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэснийг “хүртэл хугацаагаар” гэснийг “хүртэл, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “энх тайвны эсрэг” гэсний дараа “, авлигын” гэж гэснийг “энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй.” гэсний дараа “Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Ажлын хэсгийн 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсгийн “улс төрд нөлөө бүхий этгээд” гэсний дараа “, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “1 дэх хэсэг:” гэснийг “1 дэх хэсэг, 1.1,1.2 дахь заалт:” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 1 дэх хэсгийн “хууль ёсны болох нь тогтоогдоогүй бол” гэснийг “үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай Тайлбар нэмэх:

“Тайлбар.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “томилогдох” гэснийг “ажиллах” гэснийг “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “сонгогдох” гэснийг “ажиллах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 10
Бүгд: 43
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “заалт, 22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын “3.1.4-т” гэсний өмнө “3 дугаар зүйлийн” гэж, мөн зүйлийн “4.1-д” гэсний өмнө “4 дүгээр зүйлийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 12
Бүгд: 43
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны

санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Хорин хоёрдугаар бүлэгт заасан” гэснийг “Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 10
Бүгд: 42
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалт, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “гэмт хэргийг” гэсний өмнө” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 11
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн дарга Ө.Мөнх-Ундарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга Н.Хүдэрчулуун, мөн хорооны Даатгалын газрын дарга З.Батболд, Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Ж.Батжаргал, Монголын эрчим хүчний барилга засварын холбоо болон Монголын үндэсний барилгын ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн М.Батболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Батлагдсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:23/

2.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:24/

Хууль зүйн байнгын хороо хуралдах тул хуралдаан 17 цаг 24 минутаас 18 цаг 12 минутад завсарлав.

Ес.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор О.Мөнхбаатар, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Баатарсайхан, мөн холбооны гишүүн, өмгөөлөгч Д.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагүү хураалгах санал.

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 4 дэх” гэсний дараа “хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 2
Бүгд: 46
95.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв./18:31/

Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Г.Занданшатар: 1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 2
Бүгд: 46
95.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны “эсрэг” гарсан санал хураалтын дүнг “дэмжсэн”-ээр хуралдааны тэмдэглэлд авсан болно.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 2
Бүгд: 46
95.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны “эсрэг” гарсан санал хураалтын дүнг “дэмжсэн”-ээр хуралдааны тэмдэглэлд авсан болно.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 2
Бүгд: 46
95.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “эсрэг” гарсан санал хураалтын дүнг “дэмжсэн”-ээр хуралдааны тэмдэглэлд авсан болно.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 2
Бүгд: 46
95.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Дээрх хуулиудыг эцэслэн баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 42 минут үргэлжилж, 76 гишүүнээс 61 гишүүн хүрэлцэн ирж, 80.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 13 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 10 асуудал хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт дүрэн мэдүүлсэн хуулийн төслүүд, хоёрт, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 12 гишүүний санаачилсан тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудал, тогтоолын 3 дугаарт, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, дараа нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, дараа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг, 6 дугаарт Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг, наймдугаарт, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, хуулийн төсөл эцэслэн батална. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх асуудал нэмэх горимын санал гаргахаар Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Дашидондогийн Ганбат, Баагаагийн Баттөмөр нараас албан бичгүүд ирүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүдийн энэ өдрийн мэндийг айлтгая. Тэгэхээр нэг хэсэг энэ 7 жил биш, 5 жилээр тэтгэврээ тогтооцгооё гэдэг энэ асуудлаа ярилгүй завсарлалаа. Яагаад гэвэл бас энэ Тогтохсүрэн дарга, Занданшатар дарга нар бас яг энэ асуудлыг чинь манай бүлэг хэлэлцээд бас тодорхой шийдэлд хүрсэн гэж ярьсан учраас би ингээд байгаад байгаа. Гэтэл хамгийн гол нь одоо нийгмийн даатгалын багц хуулиудтай хамтарч хэлэлцэнэ гэдэг нэрийн дор ингээд хойшлуулаад байна. Гэтэл иргэд над руу гомдол гаргаад байгаа. Энэ асуудлаа хурдлуулаач. Ер нь бол ингээд энэ улс орны нөхцөл байдал энэ одоо эрх баригчдын аяг аашийг харах юм бол ер нь цаашидаа энэ халамжийн энэ систем ерөнхийдөө багасах ийм шинэж рүү орж байна.

Өөрөөр хэлбэл маш их олон хүмүүс 36 сарынхаа одоо тэтгэмжээ авч чадахгүй, өөрөөр хэлбэл хойтноос тийм нөхцөл байдалд орно. Байгаа дээр нь тэтгэвэртээ гарчихъя гэдэг ийм зүйлийг яриад байгаа байхгүй юу даа. Аргагүй л дээ, аргагүй л дээ, тэгээд одоо ингээд хүмүүс болохоор над руу жагсаал хийе гэхээр би энэ гадаа байгаа хүмүүс дээр чинь нэмээд жагсаал хийчихээр чинь бүр одоо нэг алиных нь жагсаал нь мэдэгдэхгүй болчих гээд байгаа байхгүй юу. Тийм учраас одоо энэ Аюурсайхан сайд ер нь өнгөрсөн долоо хоногт байхгүй үг хэлж болоогүй, өчигдөр

сүрхий байж байна гэсэн чинь бас тэгээд өнөөдөр алга болчихлоо. Тэр багц хуулиа хурдан оруул. Давхар дээл өмсөөд одоо ингээд нэг тийм ямбатай болчих юм ямар учиртай юм та нар чинь одоо. Чуулганд суухгүй ингээд, ингээд бүгдээрээ ингээд сайдууд нь голуу алга болчихсон байна шүү дээ. Болорчулуун сайд байна, өөр хэн байна Ганбаатар байна, Энх-Амгалан сайд байна, Чойжилсүрэн байна.

Г.Занданшатар: Бямбацогт байна. Жавхлан байна.

Б.Пүрэвдорж: Бямбацогт байна, Жавхлан байна ингээд. Үгүй ээ, ингээд үдээс хойш алга болчихдог оюм болиорой та нар. Тэгэхээр одоо энэ багц хуулиа хурдан оруулж ир, Аюурсайхан сайдаа ажлаа хий. Одоо хэдэн сар боллоо шүү дээ тэр ажил дээр очоод. Тэгээд л нэг ингээд хойшоо суусан тэрэнд чинь нөгөө миний өөрийн бодлого ийм, ийм бодлого байна гэдгээ нэг хэдхэн л өгүүлбэр, хэдхэн бодлого байгаа шүү дээ. Тэрнийгээ л 2 өдөр бодож байгаад оруулаад л тэгээд наашаа оруулчихна биз дээ. Хэрэв оруулахгүй бол тэр энд энэ жагсаалаар одоо дайран дээр давс гэж энэ жагсаал дээр юм нэмж яах юм. Тэр ялалтын талбай дээр очиж жагсана шүү. Танай дүүрэг гэж байгаа биз. Аюурсайхан энэ суухгүй байна, тэгэхдээ сонсох байна, сонсож байгаа байх. Ялалтын талбай дээр чинь очиж жагсаал хийнэ шүү, хурдан ажлаа хийгээрэй. Энэ хүн иргэдийг бодоорой. Ирэх жил энэ жил одоо нийтдээ 48 мянга орчим хүмүүс тэтгэвэрт гарч байгаа, ирэх жил дахиад тавь орчим мянга орчим хүн тэтгэвэрт гарна. Энэ олон хүмүүсийн асуудлыг шийдээрэй, 5, 6-хан тэрбум төгрөгийн асуудал байгаа шүү.

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Баярлалаа өглөөний мэнд. Гадаа 30, 40 хэмийн хүйтэнтэй сая наашаа ирж байхад өглөө ажилдаа ирж байхад нөгөө эрдэнийн соёмбот далбаагаа мандуулаад л Монгол иргэд, монголчууд

жагсаж л байна. Тэгээд энэ Эрүүгийн хуулийг яаравчилсан горимоор оруулж ирж байна л даа энэ зөв байх. Гэхдээ энэ гадаа байгаа, жагсаж байгаа хүмүүсээс бас хэлэлцүүлсэн үү, асуусан уу, саналыг нь авсан уу гэдэг нэг зүйл байна.

Хамгийн гол зүйл бол энэ алдагдсан боломжууд юм. 10 жилийн өмнөөс эхлээд. 3 хүний нэг нь ядуу явж байгаад сүүлийн 1, 2 жил бол 2 хүний нэг нь ядуу болчихсон. Энэ явдалд одоо хэн нь буруутай юм бэ? Одоо манай Улсын Их Хурлын дарга Япон лугаа хөгжсө л гэж ярьдаг л даа. Тэгээд яг Япон шиг ёс зүйтэй баймаар байна шүү дээ. Бид нар эхлээд удирдлага, удирдлагуудаас эхлээд яримаар байна. Улсын Их Хурлын тар гээд байна лээ, Улсын Их Хурлыг тар гэдэг субъектүүд нь бол Улсын Их Хурал өөрөө шүү дээ. Тэр Батжаргал гишүүн яг л зөв ярьж байна лээ. Ингэж болохгүй шүү дээ, Япон чинь өөр шүү дээ. Тэнд эзэн хаан нь байдаг. Үүнээс гадна би энэ 5 гишүүнд маш их баярлаж байна. Та хэдийг маань одоо хулгайчаар нь зарлалаа, нүүрсний хулгайчаар. Тэгээд Ерөнхийлөгч, хуучин бол АТГ-ын даргыг тавьдаг байсан, одоо бол Ерөнхий сайд тавьж байгаа. АТГ-аас та бүхнийг зарлалаа. Тэгээд та хэд маань одоо бас жинхэнэ уур амьсгалыг парламент ямар байх ёстой, яг сөрөг хүчин ямар байх ёстойг мэдрүүлж өгч байна. Энэ маш зөв.

Манай хэд манай ч гэж дээ, АН-ын нэр дээр сонгогдсон жангийн хэдэн нөхдүүд байгаа юм. Би бас одоо та нарыг хэлэхээс гадна бас өөрсдийгөө ч гэсэн хэлэх ёстой. Үнэнийг нь. Энэ хэд бол яах вэ дээ, одоо тэр амин найзынх нь хэлсэн шүү дээ. Нүүрсний хамгийн том хулгайч гэж. Тэгээд хулгайчийн нөөцтэй гэсэн үнэн дандаа л цүнхийг нь барьж байсан улсууд, дэд сайд, төрийн нарийн, тэгээд зөвлөх зөвлөхүүд л байсан шүү дээ. Тэр Ерөнхийлөгчид түй ч хамаагүй Алтанхуягийг, түй ч хамаагүй Ганбаатарыг дэвшүүлнэ гээд л өлсгөлөн зарлаж байсан улсууд. Үгүй ээ, үнэн юмыг үнэнээр л ярь л даа энэ танхимд. Тэгээд яасан 7, 8-уулаа зогсож байгаад л хууль одоо энэ нөхрийн мөхөөлдөсний компанийн

эзэн өнөөдөр одоо бетонон ширэнгэ ямар эх үүсвэрээр бариад байгаа нь мэдэгдэхгүй, одоо энэ хууль батлагдчихаар шалгуулах байх. Өөрийнхөө бланкан дээр хууль бичээд л ганцхан хүнд зориулсан хууль батлуулах гээд л ингээд л явж байсан шүү дээ. Тэгээд ийм нөхцөл байдалтай байна.

Тэгэхээр энэ Ерөнхий сайд энэ Хууль зүйн сайд эд нартай хариуцлага тооцож түдгэлзүүлдэг юм уу, огцруулдаг юм уу, ингэсний дараа энэ шалгалтуудыг эхлүүлэе. Тэгэхгүй бол учир дутагдалтай байна. Би одоо Монголын ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийн талаар бол нэг их олон долоон юм яриад яах вэ. Тэр хүн бол АТГ-ын даргыг томилж байгаагүй. 10 хуруундаа алтан бөгжтэй прокурор одоо хууль сахиулж чадахгүй гэж байна лээ. Гартаа алтан цагтай, гадаадад зугаалж байгаа нөхөр бас хууль сахиулж чадах уу? Адилхан л байх хэрэгтэй. Та хэд 5 маань бас дуугараарай, хэлээрэй. Энэ уур амьсгалыг зөв явуулах ёстой шүү. Тэгэхгүй бол ард түмэн одоо хоног хоногоор бухимдаж байна. Ингээд шалгая л даа, шалгуулъя тийм.

Тэгээд энэ АН-ыг булаах гээд л янз бүрээр оролдож байна. Нөгөө муу нэртэй Эрдэнэ бид 2 АН-ыг чирээд энд тавиад ирлээ шүү дээ. Өдий хүртэл. Гадна дотнын хүчнүүд, гар хөлүүд нь анхны хонгилыг угсрагчаар авхуулаад л, тэд нарын бэлтгэсэн боловсон хүчнүүд. Үнэн юм ярьж хэдүүлээ. Үнэнийг энэ танхимд ярьж. Хэрэв үнэнийг зөвийг энэ танхимд ярьж байвал гадаа энэ ард түмэн ингэж жагсахгүй шүү дээ. Энэ одоо 14, 15 хоног. Үгүй ээ, тэр Хууль зүйн сайд нь ямар баян жагсаал вэ. Миний цаг, манай цагдаа нар хоолыг нь очиж идэж байна гэж байна шүү дээ. Үгүй ээ, цагдаа нарыг ийм байлгадаг нь энэ хүний буруу биз дээ. Үгүй ээ, тэгээд хар л даа, тэр зуун сая төгрөг хамаатан саднууд нь өгч байна гэж байна шүү дээ сонгуульд. Нэг хүнээр хэдхэн үг хэлүүлэхийн төлөө. Үгүй ээ тэгээд хэдэн жилийн өмнө хууль.../минут дуусав/

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуудал нэмэх тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн албан бичиг ирсэн байна. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ ардчилал зах зээлийн нийгэмд шилжсэн энэ 30 жилийн хугацаанд Монгол Улсын одоо хөгжлийн потенциал бол асар өндөр байдаг юм. Би энд бол үнэхээр санаа зовж явдаг. Их Хурлын чуулган дээр хэлдэг, намын бүлэг дээр хэлдэг, Байнгын хорооны хурал дээр хэлдэг. 30 жил хөгжихдөө 15-хан тэрбум долларын эдийн засгийг бий болгож байна. Дэлхийд 15 тэрбумаас дээш борлуулалтын орлоготой 11000 ААН байна, компани байна. Бид энэ Оюу толгой, Таван толгой, Эрдэнэт бүгд нийлээд эдэнтэйгээ нийлээд, тэгээд эдний дараа жагсаж байгаа. Үнэхээр харамсалтай байгаа одоо байхгүй юу. Энэ одоо хөгжил яагаад ингээд саатсан юм бэ гээд ингээд үзэхээр ерөөсөө хулгай авлигал, боловсон хүчний буруу бодлого. Энийг би шүүмжилдэг, өнөөдөр шүүмжилнэ. Төрд бэлтгэгдээгүй хүмүүс өнөөдөр Монголын төрийг бусниулж байна шүү дээ. Хар л даа энэ Таван толгойг хар л даа. Тэр одоор Ганхуяг гээд нөхөр. Би тэрнээс авлига авчихсан бол би ингэж хэлж чадахгүй байх л даа. Ариунболд гээд нөхөр байсан, бүгд шоронд.

Энийг хэн гэж өгшиүүлж тавиад байгаа юм. Асуудал их байна, шударга байцаа. Энэ дотор одоо энэ би бол энд бас нэг та бүгдтэй 2 жил өнгөрөх хугацаанд сууж байж шударга хүмүүс одоо зууны ерэн есөн хувь нь шударга хүмүүс байгаа. Хэдхэн хүмүүс байгаа шүү дээ. Хулгай хийчихсэн улсууд. Энэ Эрдэнэс таван толгой гэдэг одоо ямар одоо юу байдаг юм нарийвчилж өчигдөр үзлээ. АТГ-ын тэр сайт дээр байсан мэдээллийг үзлээ. Байгуулагдсанаас хойш 12.6 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн юм байна. Гэтэл сүүлийн 5 жилийн хугацаанд 7.5 их наяд төгрөгийн худалдан авалт хийчхэж, тендертэй, тендергүй, тэгээд л одоо янз бүрийн байдлаар. Нүүрсийг нь Хятадууд авдаг. Монголын ганцхан компани, ганцхан

банк л одоо тэрийг зуучилдаг юм байна. Тэгээд одоо манайхан дундаас нь тэгээд л тэрийг гэрээ хийсний төлөө байдаг ч юм уу, зуучилсны төлөө л дундаас нь тонн тутамд хэдэн доллар хэдэн юань л авдаг л бололтой юм. Хулгай ийм л юм байна харагдаж байна лээ.

Энэ 7.5 их наяд төгрөгийг одоо юунд зарчихсан юм бэ гээд үзэхээр үнэхээр шог байгаа байхгүй юу. Даатгалд аваачаад хэдэн зуун тэрбумаар нь даатгачихсан, буцаад тэр даатгалаас авч байгаа юм юу ч байхгүй. 141 тэрбум төгрөгийг контейнер худалдаж аваад л бүр аймшигтай, энийг одоо ерөөсөө энд ярих юм бол энийг 5 минутад бол багтахгүй. Үгүй ээ, одоо ерөөсөө энэ Таван толгой гэдэг энэ хулгай нүүрлэсэн газрыг одоо цогц шалгая. Төрийн эрх барих дээд байгууллага бол Их Хурал, энэ Засгийн газартайгаа нийлээд тэр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, энэ цагдаа, хууль хяналтын байгууллагаар төгс шалгалт хийгээд. Энд хулгай нүүрлэсэн, Монголын төрд хулгай нь нүүрлэсэн байна.

Архинд орсон хүнийг өөрөө гарч чаддаггүй, эмчилж гаргадаг. Хулгай хийсэн хүмүүст бол тэр хулгайгаас болиулна гэж бол байхгүй. Тэрийг солих, тэр шоронд нь хийх ийм л одоо эмчилгээ байгаа шүү дээ. Дэлхийн одоо практик ийм байна шүү дээ. Манайхан толгойг нь илдэг, хулгай хийчихсэн хүмүүсээ хаацайлахын тулд энд нэг хаана хамаагүй улсуудын нэр зарладаг ийм л болчихсон байгаа байхгүй юу. Би одоо ХОМ дээрээ нэг шатахууны бизнес хийдэг нэг компанийг би одоо гучаад жилийн өмнө байгуулаад одоо ингээд явж байгаа юм. Үгүй ээ, энэ компани аваачаад нийлүүлчихсэн юм уу гэсэн чинь нэг ч шатахуун, нэг литр шатахуун нийлүүлээгүй. Шунхлай гээд нэг компани 77 тэрбум төгрөгөөр шатахуун нийлүүлчихсэн л байдаг юм байна.

Тэгээд би ямар хэрэгт холбогдсоныгоо одоо ерөөсөө огт ойлгохгүй. Энэ улс орны хөгжлийн төлөө дуугарсныхаа төлөө одоо хэлмэгдэх гээд

байгаа юм уу, яагаад байгаа юм. Энэ бол 37 он биш шүү, маш их материал байна бид тавд бол. Одоо энийг бол ингээд үргэлжлүүлээд гаргаж ирж тавих ёстой, энийг тавина гэж бодож байгаа. Одоо энэ АН-ын бүлгээс сая одоо өчигдөр урьдчилаад зарлаад байна лээ. Зарлаад байгаа ил болгоогүй байгаа хоёр оффтейк гэрээгээ болго гэж байна лээ. Энийг дэмжиж байна, ил болгох хэрэгтэй, нууц юм бол байхгүй шүү дээ. Төмөр зам барихад одоо тэрийг юунд нууцлаад байдаг юм, аймшигтай байна шүү дээ, эмнэлгүүдэд аваачаад л одоо олон тэрбумаар нь аваачиж үйлчилгээ үзүүлсэн гээд л олон тэрбумаар нь өгөөд, зөвлөх үйлчилгээ гээд олон зуун саяар нь нэг цаасанд нэг ийм хавтастай бичиг авахын тулд. Энэ төрийн хяналт гэдэг юм байдаг юм уу, үгүй юу? Энэ хяналтыг хэн хийж байх ёстой. Бид одоо хууль батлаад байдаг, хууль батлаад байдаг, тэрний хэрэгжилт, хяналтыг хэн хийж байгаа юм, хэн хийх ёстой юм бэ? Ийм юм бол байхгүй шүү. Одоо энэ 21 дүгээр зуун шүү. Бид нар бол одоо энд нэг хэдэн хүн хэлмэгдээд ингээд нэг их гарна гэж бол байхгүй.

Өнөөдөр энэ 5 хүн одоо гарч ирж байна, дараа нь юу гарч ирэхийг мэдэхгүй, яаж хэлмэгдэхийг одоо мэдэхгүй ийм байгаа шүү нөхдүүд ээ. Одоо ингээд энийг одоо хэлэхээс өөр алга байхгүй, энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалд орно. Раднаасэд гишүүн сая бичиг ирүүлсэн боловч өчигдрийн 17 цагийн байдлаар энэ системд бүртгэлгүй учраас хуулийн зөрчилтэй болоод байгаа учраас үг хэлүүлэх боломжгүй байна. Шатарбалын Раднаасэд гишүүн үг, олонхын.

Ш.Раднаасэд: Бид нар энд жагсаал тараах гээд хууль хийгээд л ингээж байх хооронд чи энэ хулгайч нар чинь зугтааж байна шүү дээ. Одоо тэр Голомт банк чинь Богд хаан төмөр зам нэг километрийг 11 саяар доллароор барина гэсэн гэрээгээ устгачихсан, санамж бичиг байгуулсан гээд мэдүүлэг өгөөд явж байна шүү дээ.

Ийм л, ийм л байна шүү дээ. Жинхэнэ хулгайч нар чинь энэ цаана чинь нуугдаж үлдэж байна, энэ хооронд хугацаа өгч байна. Ийм юмны төлөө ингээд бид нар энд суугаад байх уу. Улсын Их Хурал гадаад, дотоод бүх асуудлыг л авч хэлэлцэх бүрэн эрхтэй. Энийг одоо ингээд л хэдүүлээ хараад л дуугай суугаад л Таван толгой-Зүүн баян сая доллар. Таван толгой-Гашиун сухайт таван сая доллар, нэг километр замын өртөг. Богд хаан нэг километр нь 11 сая доллар гээд ийм харилцан адилгүй ингэж идэж ууж болох юм уу? Тэгээд энийг та нар хүлээн зөвшөөрч байгаа юм уу? Та нар 24 онд дүнгээ тавиулна шүү ард түмэнд. Энэ хулгайгаа та нар тасалж чадахгүй бол. Хулгайгаа та нар тасалж чадахгүй бол.

Энэний эсрэг энэ гишүүд ингээд дуугүй байгаад байх юм уу та нар? Гараад нэг нэгээрээ уулзахаараа алаад өгье, талаад өгье л гэдэг. Одоо тэгээд үг үсгээ хэл л дээ. Бямбацогт сайдаа тэр үнэнийг нь хэл л дээ та. Энэ ямар өртөгтэй километр, ямар өртөгтэй зам баригдаад байгаа юм. Тэгээд Ханги мандал-Таван толгой ямар өртгөөр барьж байгаа юм, тэр бол бодитой өртөг, хувийн зардлаар барьж байгаа учраас. Энийг тооцоо гаргахад энэ дээр хэчнээн төгрөгийн цавчаа, хэчнээн тэрбум долларын ашиг хийж байгаа нь харагдаж байгаа шүү дээ. Ийм балиар юмтай ингээд эвлэрээд явах юм уу? Тэгээд нэг сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга барихаараа булаацалдаад л, цаагуур чинь тэрнээс чинь хэд дахин илүү мөнгийг чинь идэж ууж байна шүү дээ. Энэ газрын баялаг ард түмний өмч юм бол энэ өмчөө хамгаал л даа, та нар бага ард түмэн гэж өөрсдийгөө ярьдаг биз дээ. Энийгээ хийхгүй юм уу. Энэ Аюулгүйн зөвлөл дээр ярьсан юм уу, яриагүй юм уу? Аюулгүйн зөвлөлийн шийдвэр 3 хүний нэг нь эсэргүүцэхэд тэр зөвлөлийн шийдвэр гарах ёсгүй. Энэ бол хууль, Аюулгүйн зөвлөлийн хуульд байдаг хууль. Энэ Засгийн газрын гишүүд энэ нууцад хамааруулсан биз дээ. Нууцын хуулиар.

Одоо энэ Эрүүгийн хуулиар та нар хамтын удирдлагын байгууллагын гишүүд хийх ёсгүй юмаа хийсэн, эсхүл хийх ёстой юмаа хэтрүүлэн хийсэн байх юм бол та нар эрүүгийн хариуцлагад татагдахаар энэ төсөл дээр явж байгаа шүү. Энэ бүх хамтын удирдлагын байгууллагууд явж байгаа. Энэ Засгийн газар, Аюулгүйн зөвлөл, тэр иргэдийн хурал. Их Хурал ч гэсэн тэрэн дотор ер нь яг явах юм бол явна шүү. Ингээд дуугүй байх уу? Би намайг л тойроод явж байвал хамаагүй сайхан гээд. Энэ Эрүүгийн хуулийг чинь дахиад засаж байна шүү дээ нөгөө Засгийн газраас өргөн барьсан авлигатай тэмцэнэ гэсэн. Дахиад ажлын хэсэг хуралдаад тэрэн дотор нь нөгөө нэг сайхан заалтуудыг нь Авлигатай тэмцэх газрын өөрсдийнх нь бичиж өгсөн заалтуудыг нь засаад янзлаад явж байна шүү дээ дахиад.

Энэ Улсын Их Хурлын гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг яагаад Авлигатай тэмцэх газар шалгаж болдоггүй юм бэ? Яахаараа Ёс зүйн байнгын хороо гээд энд хадгалаад байх ёстой юм бэ? Ёс зүйн хороо гэж одоо байхгүй болсон. Хуучин байсан юм. Одоо тэрийг хариуцдаг ч хүнгүй болсон. Юунаасаа ичиж айгаад байгаа юм бэ хулгай хийгээгүй юм бол. Одоо энэ хулгайч нартайгаа тэмцье л дээ тэгээд. Би хэлээд байгаа шүү дээ өнөөдөр бид нар энэ боломжийг ашиглаж, энэ боломжийг ашиглаж бид нар энийг дарж авахгүй бол маргааши, нөгөөдөр энэ хулгай чинь дахиад л байна. Дахиад л Ганхуягийн оронд өөр нэг Ганхуяг очоод хулгай хийнэ. Өөр Ганхуягийг томилсон дараагийн хүн нь очоод л хулгай хийнэ. Энэ байдал чинь 10 оноос хойш давтагдаж байгаа гэж хэлээд байгаа шүү дээ. Энэбишээс хойш. Тэгээд энэтэйгээ эвлэрээд ингээд суух уу та нар.

Г.Занданшатар: Одоо хэлэлцэх асуудалдаа орно. Хууль зүйн байнгын хороо хуралдаж байгаа Эрүүгийн хуулиа өнөөдөр бас бид нар яаралтай горимоор хэлэлцэж байгаа. Энэ даширамд бас энэ гишүүдийн хэлсэнтэй холбогдуулаад хэлэхэд гишүүд санаачлаад энэ нээлттэй сонсгол болон бүх асуудлаар энэ оффтейкийн гэрээ бүх юмаа

ярих асуудал бол нээлттэй. Гадаад, дотоод бодлогын аль ч асуудлаар хэлэлцээж болно. Өчигдөр бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас мэдээлэл ирүүлж, оффтейкийн ямар ч гэрээг хэлэлцээж нууцад авах шийдвэр авах шийдвэр гаргаагүй гэдэг ийм шинжээчийн дүгнэлт гаргаснаа танилцуулсан. Хэлэлцээгүй юм байна лээ, танилцаагүй юм байна лээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд нь ч гэсэн тэгж хэлж байна. Үе үеийн үед том үндэсний бүтээн байгуулалтыг өрнүүлэх, хөгжүүлэх тийм бодлогын зөвлөмжүүд л гаргаж байдаг болохоос биш хууль хэрэгжүүлэх, хууль биелүүлэх ажлыг Үндсэн хуулиар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хэрэгжүүлдэггүй, нууцад авахыг. Одоо ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Төрийн болон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Үг хэлэх 3 гишүүн өчигдөр бүртгүүлсэн. 3 гишүүн үлдсэн байгаа үг хэлэх гишүүдээс дэмжсэн, дэмжээгүй 3 гишүүн үг хэлнэ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлэх нь.

Б.Энхбаяр: Гишүүддээ өглөөний амгаланг айлтгая. Засгийн газраас өргөн барьсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэлэлцэхийг дэмжиж байгаа. Бид нар 27 жилийн дараа Төрийн өмчийн хуулийн шинэтгэлийг хийх гэж байгаа. 27 жилийн өмнө буюу 1995 онд баталж, 1996 онд Зандаахүүгийн Энхболд анхны Төрийн өмчийн хорооны даргаар нь ажиллаж эхэлсэн энэ хууль бол социализмын үед төвлөрсөн байсан бүхий л төрийн өмчүүдийг хувьд шилжүүлэх

агуулгаар батлагдсан хууль байсан. Өөрөөр хэлбэл төрийн өмчийг хувьд шилжүүлэхтэй холбоотой, хувьчлах хууль байсан. Бид энэ хувьчлах хуулиараа 27 жил явсан. Энэ хуульд юу одоо бид тухайн үед тооцож хараагүй вэ гэхээр 90 онд энэ төрийн эзэн байсан, хяналттай байсан тэр хяналтын бүхий л механизмуудыг нэгдүгээрт одоо устгаж өөрчлөөд, ингээд хувьчилж байна гэдэг тэр дуулианаар өнөөдөр одоо юу болсон өнөөдрийн баялгийн тэгш бус хуваарилалт шударга ёс алдагдсан ийм хувьчлалуудыг хийсэн.

Энэ хувьчлалаас одоо хамгийн их өрмийг нь авсан хүмүүс нь улс төрд орж шийдвэр гаргаж ирсэн. Халтмаагийн Баттулгаас эхлээд мах, талх, буудал бүх л юмыг нь авсан. Ингээд дараа нь өөрөө улсын Ерөнхийлөгч болтлоо явлаа. Ингээд дараа нь төмөр зам, нүүрс одоо юутай ч хутгалдсан юм. Өөрийнхөө тэр компанийг байгуулсан утга нь бол тэр ер нь одоо бодоход учиртай л байсан юм байна лээ. Тэр Женко гэдэг нэр. Женко гэдэг чинь одоо загалмайлан эцэг кино дээр гардаг мафиин компанийн нэр шүү дээ. Тэгээд одоо өөрөө энэ одоо хамгийн том хулгайны загалмайлан эцэг болсон байна, киноныхоо гол баатар бол болсон байна, амьдралд хэрэгжүүлжээ, чадаж. Тэгэхдээ нэг юмыг дутуу тооцсон. Ард түмнээс улсаас дээш давсан эрх ашгийг Монголын ард түмэн хэн ч зөвшөөрдөггүй юм. Бид нар хаант засаглалтай байх үедээ ч гэсэн энэ ард иргэд газар ус, шороо, байгалийн баялгийнхаа энэ ашиг сонирхлоос давсан хэнийг ч толгой дээрээ залж байгаагүй.

Тэгэхээр одоо энэ өмчийн асуудал гэдэг маань үндсэндээ эзэнгүй. Тухай тухайн үед шийдвэр гаргаж байсан улс төрчид, тэр одоо улс төрчдийн төлөөлөл болж компанид нь томилогдсон хүмүүс, тэр хүмүүсээс хөдөлмөрийн баатар, гавьяат болтлоо одоо шоконд оруулж, ингэж одоо авлигынхаа төлөөсийг авч байсан. Төрийн шагналаар, шагналыг авлигын зэвсэг болгож хувиргасан. Төрийн нэр хүндийг. Энэний бүх одоо зүйлүүд бол илэрч байна. Яг одоо өнгөрсөн оны

өнгөрсөн онд, одоо Улсын Их Хурал дээр бас энэ хаалттай асуудал ярьж байхад миний би хэлж байсан. Энэ Таван толгой тойрсон асуудал чинь удахгүй цөмийн бөмбөг болж тэсэрнэ. Наад нууц юмнууд чинь бүгд ил болно. Эртхэн одоо энийг учраа олоорой л гэж хэлж байсан яг энэ танхимд. Тэгээд одоо жам ёсоороо болж байгаа юм. Одоо энэ хулгайчдыгаа цээрлүүлэх ажлыг хуулийн байгууллага бол орж байна. Улсын Их Хурал бид юу хийх ёстой вэ. Бид дахиж ийм асуудлыг гаргахгүйн тулд эрх зүйн шинэтгэлийг нь хийх ёстой. Тэр нь энэ одоо бидний хэлэлцэж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. Өмчөө эзэнтэй болгоё, харуултай болгоё, хяналттай болгоё, хариуцлагатай болгоё гэдэг хуулийн шинэтгэл орж ирж байгаа юм. Энийг хийхгүй, дэмжихгүй гэвэл бид тэр 97 оны эзэнгүй Өмчийн хуулиараа цаашаа үргэлжлүүлэе гэсэн үг. Өөрөөр хэлбэл хулгайгаа үргэлжлүүлэе, харсан ч хараагүй царайлъя, гар хөлөө тэнд тавьдаг байдлаараа явъя гэсэн үг.

Тийм учраас миний хувьд энэ орж ирсэн шинэтгэлийг Улсын Их Хурал яаралтай хийх хэрэгтэй. Миний бие өмчийнх нь Компанийн хуулийг ахалж байгаа. Энэ Компанийн хуультай зэрэгцүүлээд нэг ажлын хэсгээрээ одоо ахлаад Улсын Их Хурлын хаврын чуулганд хэлэлцэн батлахаар бодож ажиллая гэсэн ийм саналтай байгаа. Тийм учраас дэмжиж байна, баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: За яах вэ, энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яах вэ, хэлэлцэх эсэхийг нь дэмжиж авъя гэсэн бодолтой бол байна. Гэхдээ Байнгын хороон дээр ажлын хэсэг гараад, нэлээн одоо бас өргөн бүрэлдэхүүнтэй, бас цаг зав нэлээн зарцуулж байж ажиллаж байж гаргах шаардлагатай гэсэн ийм бол бодолтой бол байна. Дотор талд нь бол үзэхээр авах ч юм байна, авахгүй

авахааргүй юмнууд бол байгаад байгаа юм. Миний хэлэх гээд байгаа санаа ер нь бол бид нар энэ төрийн өмчийг өмчийн удирдлага, зохицуулалт, хяналтыг тавьж байгаа гэж бид ойлгодог энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг. Энэ газрын чинь статус одоо ер нь маш их одоо бүрхэг болсон. Өмнө нь энэ Төрийн өмчийн хороо гээд Засгийн газрын тохируулагч агентлаг байсан. 2012 онд АН Алтанхуяг Ерөнхий сайд болонгуутаа Баттулга гэж хүнийг ХАА-н сайд болгоод, тэр ХАА-н сайдаа бас голсон юм уу, жаахан бяр хэрэгтэй юм нэмж өг гэсэн юм уу, Төрийн өмчийн хороог ХАА-н сайдын эрхлэх асуудалд өгчихсөн.

Тэрнээс эхлээд энэ Төрийн өмчийн хороог хүчгүйдүүлэх, төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг сулруулах ийм одоо ажил бол эхэлсэн шүү дээ. Тэрнээс эхлээд Хэрэг эрхлэх газрын дарга, төрийн өмчийн, ялангуяа энэ уул уурхайтай холбоотой төрийн өмчит хуулийн этгээдийн бодлого, зохицуулалтыг эрхэлдэг ийм одоо асуудал руу орсон. Ингээд энэ Төрийн өмчийнхөө бодлого, зохицуулалтынхаа газрыг бид статусыг нь дордуулаад, эрх хэмжээг нь бууруулаад ингээд хүчгүйдүүлсэн. Одоо ер нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар юу хийж байна гэхээр бол үндсэндээ нэг хэдэн азда-нуудыг л хариуцаж ажиллаж байх шиг байгаа юм. Ний нуугүй хэлэхэд төрийн өмчийн энэ удирдлага, зохион байгуулалт, хяналттай холбоотой асуудал чинь миний ойлгож байгаагаар бол 3 толгойтой болсон. Нэг хэсгийг нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хариуцаж байгаа нэртэй явж байгаа. Ялангуяа энэ томоохон энэ уул уурхайтай холбоотой, төрийн өмчийн болоод төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бодлого зохицуулалт, хяналттай холбоотой асуудал нь Хэрэг эрхлэх газар дээр яваад байгаа юм уу, эсвэл тэр Эрдэнэс Монгол дээр яваад байх уу гэдэг нь ойлгомжгүй болсон. Бүх одоо яамнууд, сайдууд өөрсдийнхөө харьяанд байдаг төрийн өмчит хуулийн этгээдүүдийг удирдлагыг нь томилох, удирдах, зохион байгуулах, хяналт тавих бүх эрхийг

яамнууд нь буцаагаад авчихсан юм байна лээ.

Одоо ингээд миний ойлгож байгаагаар бол энэ төрийн өмчийн болоод төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн чинь бодлого зохицуулалт, хяналт тавих энэ чиг үүрэг чинь бол 3 толгойтой болсон. Энийгээ одоо бид нар цэгцлэх хэрэгтэй, ийм одоо олон толгойтой явах юм бол энэ төрийн өмчит гарч байгаа хулгай луйвар бол үндсэндээ зогсохгүй, дийлдэхгүй гэж. Цаашидаа одоо бид нар энэ хуулийн хэлэлцүүлгийнхээ явцад, ер нь энэ төрийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хангаж ажилладаг, хяналт тавьдаг энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын статусыг яах юм, чиг үүргийг нь яаж одоо өргөжүүлэх юм гэдэг асуудал нэлээн нухацтай ярих ёстой гэсэн ийм байр суурьтай бол байгаа. Яг одоогийн байгаа ийм статустайгаа чиг үүрэгтэйгээр бол энэ хэчнээн сайн хууль гарлаа ч энэ ерөөсөө бодитой үр дүн бол гарахгүй гэж.

Хоёр дахь асуудал, энэ хуульч гишүүд бол, ялангуяа манай Энхбаяр гишүүн төрийн өмчтэй холбоотой асуудал нэлээн яриад байгаа. Бас дараа нь бас санал бодлуудаа бас хэлэх байх гэж. Ер нь энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар чинь Засгийн газрын агентлаг тохируулагч агентлагаас энэ хэрэгжүүлэгч агентлаг болгочихсон. Одоогийн орж ирж байгаа хуулиар бол Төрийн өмчийн хороо гэж одоо болох юм байна лээ. Нэр өөрчлөгдсөнөөр бол энэ толгойг нь одоо нэг одоо болгохгүй бол энэ үр дүн бол гарахгүй л дээ. Ер нь миний нэг эргэлзэж байгаа зүйл бол Засгийн газрын тохируулагч агентлаг байна уу, хэрэгжүүлэгч агентлаг байна уу, аль ч статустай агентлаг байсан хамтын удирдлагатай агентлаг гэсэн ийм одоо зарчим байх нь зөв үү гэдгийг би бас бас бас жоохон эргэлзэж байгаа. Энэ дээр манай одоо бас хуульч гишүүд ч гэсэн бас санаа оноогоо бас хэлэх болов уу гэж бол бодож байгаа юм.

Тийм учраас бол цаашидаа бид нар энэ хуулийн хэлэлцэх эсэхийг нь бол

дэмжээд авъя. Гэхдээ энэ хүрээндээ бид нар энэ хуультай холбоотой асуудал ярихаас гадна ерөөсөө энэ төрийн өмчийн удирдлагыг зохицуулалт хийж байдаг, бодлогоор хангаж байдаг, хяналт тавьж байдаг ийм одоо бүтэц одоо байх юм уу, байвал статус нь ямар байх юм, ямар чиг үүрэгтэй байх юм, ийм одоогийнх шиг ийм одоо олон толгойтой байх юм уу, нэг толгойтой байх юм уу. Тэр хамтын удирдлагын зарчим Засгийн газрын агентлагт байх нь зөв үү, буруу юу гээд ингээд маш одоо олон ярих асуудлууд байгаа юм. Энийг цаашидаа хэлэлцүүлгийн явцад ярьж, одоо бас шийдэх нь зүйтэй байх гэсэн ийм саналтай бол байгаа гэдгээ хэлье.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийг нэлээдгүй харсан. Үзэл баримтлалынх нь хувьд дэмжээд хэлэлцэхийг нь дэмжих нь зөв юм байна. Хэлэлцүүлгийн явцад ажлын хэсгийг нээрээ нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй байгуулж, тал бүрээс нь харж, зөв зохицуулалтын үйл явцыг нь хангах ёстой юм байна, энэ байж байгаа уур амьсгал, энэ улс орныхоо эдийн засгийн өнөөгийн байдал, энэ иргэдийнхээ аж амьдралын байдал, энэ бүх юмыг харахаар зэрэг энэ ард түмний мэдэлд байх ёстой, үр өгөөжийг нь хүртэж байх ёстой энэ том өмчүүд нь эзэнгүйдээд болж өгөхгүй байгаа юм. Тэрийг тойрсон янз бүрийн асуудлууд үүсээд байгаа юм. Хуулийнхаа заалтад бид нар төрийн нийтийн өмч гэдэг нэрээр Үндсэн хуулийнхаа үзэл санааг оруулж ирсэн. Гэхдээ энэ нийтийн өмчийн удирдлага, зохион байгуулалт, үр өгөөж, бүртгэл хяналт хаана хэн дээр явах юм гэдэг асуудал биежиж ороогүй байна. Энүүнийг бид биежүүлж оруулж байж сая энэ үр өгөөжийг дээшлүүлэх, хараа хяналтыг сайжруулах, үр өгөөжийг нь ард түмэнд нь хүртээх энэ асуудлын суурь харилцаа энэ хуульд өөрөө шингэх ёстой юм. Тэгж байж энэ илүү үр дүнтэй болох ёстой гэж.

Хоёр дахь зүйл Засгийн газар хийгээд Төрийн өмчийн хорооны чиг үүрэг дэндүү бүрхэг байна. Дам дамаа энэ нийтийн өмчтэй холбоотой асуудал, асуудал. Тэр тусгайлсан өмчтэй холбоотой асуудлууд чинь тун тааруу байна. Бид тусгай хуулиар зохицуулна гэж ярьж болох боловч зохицуулах гээд байгаа харилцааны чинь суурь энүүндээ орох ёстой. Төрийн болон орон нутгийн өмчтэй компани байгуулна, тэр тусгайлсан хуулиар тэр харилцааг зохицуулна гэж ярих гээд байх шиг байна. Тэгвэл өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх төлөөллийг бид хаанаас, ямар шалгуураар томилох ёстой вэ, тэр төлөөлөлд бид ямар чиг үүрэг өгч, ажлынх нь үр дүн, гүйцэтгэл юмыг тооцох ёстой, буцаагаад хариуцлагынх нь асуудал юу байх ёстой вэ гэдэг юм энэ хуульдаа шингэх ёстой юм. Тэгж байж дараагийн хууль яг тэр малгай зорилтоо хэлбэржүүлж авч явах задаргаа нь үүсэж гарч ирэх ёстой юм. Энэ асуудал чинь үнэхээрийн байхгүй байна. Төрийн өмчийн хорооныхоо чиг үүрэг дотор ч алга, Засгийн газрын чиг үүрэг талдаа ч дэндүү бүрхэг болсон байна. Тийм учраас энүүнийг их тодорхой болгож авч явах ёстой гэдгийг зориуд би хэлмээр санагдаад байна.

Дараагийн нэг зүйл Бид 23 оны төсөв батлахдаа дагуулж тогтоол баталсан. Тэр тогтоолд энэ ерөөсөө төрийн өмч, төрийн өмчит аж ахуйнууд, энэ төсвийн ил тод байдлыг хангах үйл явцыг одоо тодорхой болгосон хэд хэдэн заалтыг оруулсан юм. Тэр заалтууд энэ хуулийн үзэл санаанд орох ёстой. Ерөөсөө л төрийн өмчийн өөрийнх нь тэр ил тод, тунгалаг байх, иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгож чадах, тэрүүгээрээ дамжуулж энэ удирдлага зохион байгуулалт үр өгөөжтэй явагдаж, үр дүн нь гарч ирдэг байх, энэ харилцаанууд угаасаа энэ заалт дотор тусч орох ёстой гэдгийг зориуд би хэлмээр байна.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл, төрийн өмчийн үр өгөөж, төсвийн зардлыг бууруулах тухай асуудал одоо бидэн дээр их томоор босож ирнэ, яагаад тэгж байна вэ

гэхээр зэрэг энэ төрийн байгууллагуудын чинь байр ашиглалт, тогтмол зардлын өсөлтийн хурдац их хурдтай явж байгаа. Тэгэхээр энэ дээр хэн хяналт тавьж явах юм бэ, яаж энэ зардал юмны өсөлтийн хурдцыг бууруулах ёстой юм бэ, дутагдаад байгаа талбай юмнуудаа түрээсэлдэг юм байжээ, тэрнийг хэн хянаж түрээслэх эрхийг нь олгох юм бэ, илүү гарчхаад байгаа талбайгаа бусдад түрээслүүлдэг юм байжээ, тэрийг хэн зохицуулах юм бэ гээд олон зүйл байгаа. Энэ асуудлуудын ерөнхий бас суурь ойлголтыг нь эндээ бид шингээж өгч, тэгээд буцаагаад тэр холбогдох нэгжүүдийнхээ харилцааг зохицуулсан, тэр хууль тогтоомжоороо зохицогдох ёстой гэж ингэж ойлгож байна.

Дараагийн нэг зүйл орон нутгийн өмчөөс төрийн өмч рүү хөрөнгө авах тухай асуудал байгаа юм байна. Нийтийн хэрэгцээ, нийгмийн зайлшгүй шаардлагын хүрээнд гэж. Тэгвэл тэрүүнийг шилжүүлэхийн тулд орон нутагт ямар оролцоотой, ямар саналтай байх.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй гишүүн үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна, тэгээд санал хураалт явуулахын өмнө манай гишүүд бас нэлээн, санал хураалтад бэлтгээе гишүүд. Ингэнэ, энэ Батжаргал гишүүний, Энхбаяр гишүүний гишүүдийн ч өчигдөр асуулт хариултад олонтоо давтагдсан. Судалгааны ажлыг суурь судалгааны ажлыг их гайгүй болж байна гэж ойлгоод яваад байсан, яг бичилт дээрээ энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хаана, хэн байна вэ, түүхийрүүлж оруулж ирсэн маш түүхий хууль болсон. Одоо хууль бичихдээ дандаа энэ түүхий, дутуу дулимаг боловсруулсан юм оруулж ирээд бөөс хуурсыг нь Улсын Их Хурал түүдэг байж таарахгүй гэж олонтоо хэлсэн. Одоо энэ хуулиа бичихдээ ядаж тэр Үндсэн хуулийнх нь утга агуулга, 94 оны Төрийн өмчийн тухай хуулийг баталж байхад энэ хуулийг хийсэн Чимэд гуайн Бяраагийн Чимэд гуайн хэлсэн үг энэ төрийн өөрийн өмч, төрийн

нийтийн өмчийг тайлбарласан, төрийн нийтийн өмч чинь Батжаргал гишүүний энэ хуучин хуульд нь байсан юм. Чимэд гуай оруулсан юм байна лээ. Тэгээд Чимэд гуай оруулснаас авч Үндсэн хуульд оруулсан юм. Тэгээд тэн дээр тайлбарласан тэр үзэл баримтлалыг хууль хэлэлцэж батлахдаа хийсэн протоколыг ядаж уншаад үзчих хэрэгтэй байхгүй юу. Огт уншиж үзээгүй.

Тэр суурь концепцоо олгоогүй болохоор энд төрийн өмч, орон нутгийн эмч бүгдийг нь холиод эрх үүргийг нь. Өмчийн эрх зүйн үндэслэлийг нь тодорхой болгохгүйгээр, тэгээд одоо онолын 2 том маргааныг хагалахгүйгээр ингээд бөөрөнхийлөөд шидчихсэн. Тийм учраас энэ төрийн өмчид чинь хулгай гараад байна шүү дээ. Ийм учраас төрийн өмчийн энэ хулгайг таслан зогсоож, хяналтыг нь сайжруулах, энэ үндсэн асуудлыг орхигдуулсан хууль байна. Шилжих, бүртгэх, тооллого хийх энэ тэр гэсэн үндсэн техникийн ажилдаа илүү их детальд анхаараад, философийг нь хаясан. Тийм учраас энэ дээр одоо бол маш том ажлын хэсэг гаргаж ажиллах хэрэгтэй. Хэлэлцэх эсэхийг дэмжээд, үг хэлээд дуусчихсан алх цохисон. Одоо ингээд гишүүд санал хураалтад бэлдэнэ. Энийг ингээд дэмжээд хэлэлцэх эсэхийг нь шийдээд, тэгээд энэ дээр л Их Хурал дээр том ажлын хэсэг, эрдэмтэн судлаачдаас оруулаад ажиллуулах хэрэгтэй.

Ингээд санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд бэлэн байна уу, санал хураалт. Бүртгэлийн болон тест. Бүртгэл дээр эсрэг гарсан гишүүдийг тасалснаар тооцно. 14 гишүүнийг дууд. Санал хураалт. Дээр нэр дурдсан хуулиудыг хуулийн төслүүдийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 73.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд иилжүүлж байна. Дараагийн асуудалд орно. Цэнгэл даргаа судалгаа дээр ажилласан хүмүүсийнхээ нэрсийг гаргаж өгөөрэй. Тэгээд энэ академи энэ тэртэй хамтраад ажлын хэсэг байгуулъя, дэд ажлын хэсэг байгуулъя.

10.57 цагт

Хоёр. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн 2022.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна, индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн тавын нэгд, Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэж заасан байдаг. Бодит байдал дээр манай эдийн засаг, төрийн өмч зонхилсон бүтэц, тогтолцоотой болжээ. Нөхцөл байдал ийм болсныг хэдхэн үзүүлэлт тодорхой харуулж байгаа юм. Тухайлбал, 2012 оноос 2020 оны хооронд буюу сүүлийн 9 жилийн дунджаар төсвийн зарлага ДНБ-

ий 33.2 хувьтай тэнцэж, ДНБ-ий 22.2 хувийг төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрууд бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл, давхардсан тоогоор ДНБ-ий 55.4 орчим хувийг төр шууд төсөв болон бусад шууд бусаар төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газар бүрдүүлж байна. Үүн дээр дор дурдагдах төрөл бүрийн төсөл, сангуудын нөлөөллийг нэмэхэд уг үзүүлэлт цаашилан өсөх болно.

Шилэн дансанд бүртгэлтэй 460 компани, үйлдвэрийн газраас томоохон 107 компани сүүлийн 10 жилийн хугацаанд нийт татварын орлогын 33 хувийг бүрдүүлжээ. Гэтэл Монгол Улсын нийт татвар төлөгч ААН-үүдийн тоо 228012 байгаа бөгөөд дээрх 107 компани үүний 0.05 хувь юм. Тэгэхээр нийт ААН-үүдийн 99.95 хувь нь татварын нийт орлогын үлдсэн хэсгийг л төлж байна. Татварын төлөлт талаас энэ нь сайн мэдээ мэт боловч Монголын бизнесийн хамгийн өгөөжтэй, хамгийн далайцтай, макро эдийн засгийн орчинд бодитойгоор нөлөөлөхүйц хэсгийг нь нийт компаниудын 0.05 хувь нь буюу ТӨК-иуд л хариуцан эрхэлж байна гэсэн үг юм. ААН-үүдийн 0.05 хувьтай тэнцэж буй энэ нэн цөөнх компаниудын Монгол Улсын экспортод эзэлж буй хувь хэмжээ, татварын орлогын хэмжээнд эзэлж буй хувийн жингээс бүр илүү буюу 42 хувь байна.

Дээрх компани, үйлдвэрийн газруудаас гадна нийт 123 төслийн нэгж, Засгийн газрын тусгай сан, сум хөгжүүлэх сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан зэрэг 49 сангаар дамжуулан төр эдийн засагт шууд оролцож байна. ДНБ-д эдгээрийн үзүүлж буй нөлөөг нарийвчлан тооцож нэмэх аваас эдийн засаг дахь төрийн оролцооны хувийн жин дээрх 55.4 хувь гэсэн үзүүлэлт мэдэгдэхүйц өсөж гарах нь тодорхой. Зөвхөн эдгээр үзүүлэлтээс харахад сүүлийн 10 жил төр, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн орлого, орлого эдийн засагт эзлэх хувийн жин нь эрс нэмэгджээ. Гэтэл ДНБ-ий наяд хувийг бүрдүүлдэг гэх хувийн хэвшил

бодит хэрэг дээрээ уг хүлээлтээс 2 дахин бага хувь хэмжээнд ногдох болсныг анхаарч засахгүй байх аргагүй болжээ.

Удирдлагын академиас гаргасан судалгаанд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн засаглалын үнэлгээний ерөнхий индекс 54 хувьтай байгаа нь хангалтгүй бөгөөд өнөөгийн нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил, Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуулийн түвшинд хийгдсэн өмчийн эрх зүйн шинэтгэлээс хоцорч, үндсэн чиг үүргээ хангалттай биелүүлж чадахгүй болсон байна. Төр болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн ТУЗ-ийн шийдвэр гаргах эрх мэдэл дутагдаж, Засгийн газар, яамдаас асуудлыг ялангуяа гэрээ хэлэлцээрийг хойшлуулдаг, шуурхай шийдэж өгдөггүйн улмаас хугацаа алдаж, орлогын төлөвлөгөө тасалддаг, ашиггүй ажилладаг байдал байсаар байна. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь нээлттэй, ил тод байдал дутагдсанаас хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт бий болгох, удирдлагын буруу шийдвэрт хариуцлага тооцдоггүй, ашиг сонирхлын зөрчил үүсэж авлига тэлэхэд хүргэж байна.

Үүний хамгийн ойрын жишээ, хамгийн ойрын тод жишээ бол Хөгжлийн банк, нүүрсний хулгай, хулгайтай холбогдож үүсээд буй нөхцөл байдал юм. Аливаа хувийн банк Хөгжлийн банкны хэмжээний муудсан зээлтэй, урт удаан хугацаанд яваад байх ямар ч боломжгүй байх байсан. Зээлийн олголттой холбоотой зүй ёсны бүхий л шалгуур үзүүлэлтүүд, улс төр, танил тал, арын хаалганы дарамтад бүдгэрсэн, бүдгэрсэн байсан нь ил болоод байна. Үүний зэрэгцээ хувийн хэвшилийнхэнтэй өрсөлдөн нөгөө л төрийн өмчит ААН-үүд Хөгжлийн банкнаас чамгүй хэмжээний зээл авсан байгаа нь илэрсэн. Авсан зээл нь бүтэлгүйтсэн нь ч тодорхой болов. Хөгжлийн банкны нэг аравны их, 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн 30 хувь нь төрийн өмчит ААН-д ноогдож байна. Нүүрсний хулгай дээр ч

асуудал тод илрээд байна. Энэ тогтоолын төслийг өргөн барих үед энийг ярьсаар л байсан.

Иймд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох хяналтын хяналтыг сайжруулах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн боломжит хэсгийнх нь хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр гарган арилжих, олон нийтэд нээлттэй ХК болгон өөрчлөх, бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлага тулгараад байна. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулж, олон улсын жишигт хүргэж байж, төрийн өмчийн аливаа хулгайгаас сэргийлж, авлигын индекс буурна.

Мөн гадаадад хувьцаа нь арилжаалагдаж буй Монголд бүртгэлтэй компаниудын хувьцааг МХБ дээр арилжаалах эрх зүйн үндсийг тавьсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 6.4 дэх зүйлийн хэрэгжилтийг гүйцэд хангаж ажиллах шаардлагатай байна. Ингэж хангаж ажиллахыг эрчимжүүлэхэд энэхүү Улсын Их Хурлын тогтоол чухал нөлөөтэй юм. Иймээс төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох зайлшгүй шаардлага үүсээд буйг харгалзан Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Тогтоолын төсөлд тусгагдсан арга хэмжээг тодорхойлохдоо хэрэгжихүйц бөгөөд хэмжигдэхүйц бодитой, хэрэгжилтийн цаглаврыг оновчтой тооцсон байх зэрэг төлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан.

Экспортыг нэмэгдүүлэх замаар улс орны эдийн засгийн суурийг тэлнэ, ДНБ-д, ДНБ нэмэгдэхэд түүнд саад болж байгаа хязгаарлагч хүчин зүйлсийг арилгах, төрийн оролцоог бууруулах зорилтыг тус тус

харгалзан үзэж тусгалаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданиатар: Одоо төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна, индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүнээс 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг тодорхой хугацаагаар хориглох, одоо үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг цомхотгон цөөлөх, хувьцааг Хөрөнгийн бирж дээр арилжиж, олон нийтэд нээлттэй ХК болгон өөрчлөн зохион байгуулах, ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх цогц судалгаа, бодлогыг боловсруулах зорилгоор тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн байна. Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж төсөл санаачлагч үзсэн бөгөөд тогтоолын төслийг D-парламент.мн цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг төрийн өмчийг хувьчилснаар гарах үр дүн, ач холбогдол, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шинээр байгуулахыг хориглох шаардлага байгаа эсэх талаар асуулт

асууж, хариулт авсан болно. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Нямаагийн Энхболд гишүүн. Дашдондогийн Ганбат гишүүн орохгүй байна гэж байна, Батлут гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Хууль санаачлагчаас асуух асуулт бол байхгүй. Зарчмын хувьд бид нар энэ асуудлыг дэмжиж батлах ёстой. Өнөөдөр Монголын төр сүүлийн магадгүй хорь гаруй жилийн хугацаанд энэ нэг Монгол стандартын төрийн өмчийн компаниуд бий болох гэж их оролдсон. Одоо бүтэхгүй гэдгээ ойлгосон. Хулгай хаана байна, төрд байна, хулгайг хаагуур дамжуулж хийж байна энэ төрийн өмчийн компаниар дамжуулж хийж байна. Тэгэхээр бид нар ерөөсөө энэ дэлхийгээс гажсан, стандартаас зөрсөн, шинэ дугуй зохиох гээд байх шаардлага бол үнэндээ байхгүй. Одоо бодит байдал, улс төрийн нөхцөл, өнөөдрийн энэ гарч байгаа энэ хулгай зэлгээ энэ бүх зүйл бол нотолж харуулж байна угаасаа. Тэгэхээр бид нар цаашидаа угаасаа энэ төрийн өмчийн компаниудаа бүгдээрэнг нь чөлөөлөөд, хувьчлаад, илүү хувийн хэвшлээ хөгжүүлэх,

чөлөөт зах зээлээ дэмжсэн бодлого шийдвэрийг бол гаргаад явах ёстой, гаргаад явах ёстой.

Үндсэндээ Монгол төрийн энэ байгаа тогтолцоо, байгаа засаглал, өнөөдрийн улс төрийнхөө нөхцөл байдал дээр бид нар өнөөдөр бодитоор үнэлэлт, дүгнэлт хийгээд цаашид бид нар энэ төрийн өмчийн компаниудыг бий болгох, цаашид энэ зарчмаар ажиллуулах боломжгүй гэдгийг бид нар өнөөдөр бодитоор ойлгох ёстой. Үндсэндээ төрийн өмчийн томоохон 105 компани байгаа байх, орон нутгийн өмчийн оролцоотой 270 орчим компаниуд байгаад байгаа байх. Эд нар бол зүгээр компани шүү дээ, компани. Тэгэхээр бид нар Монголд байна уу, өөр улсад байна уу ялгаагүй юм чинь бүгдээрээ нэг стандарттай. Компанийнхаа засаглалаар бүгдээрээ хөгжих ёстой. Монгол Улсын хувийн хэвшлийн энэ олон, олон зуун мянган ААН-үүдийн нэгэн адил энэ зарчмаар явах ёстой байхгүй юу. Бид нар энүүгээр явж чадахгүй байна шүү дээ.

Өнөөдөр бид нар энэдээ бодит дүгнэлт хийгээд, ерөөсөө энэ төрөөс нөлөөлөлгүй ажиллах, улс төрөөс нөлөөлөлгүй байх, дарамт шахалтгүй байх, дэмжлэг тусалцаагүй байх энэ зарчмыг бид нар хэрэгжүүлж чадахгүй юм бол компанийн засаглалыг нь бид нар хөгжүүлж чадахгүй юм бол одоо ерөөсөө эндээ цэг тавья л даа. Бүх төрийн өмчийн компаниуд бид нар ерөөсөө энд ингэж төрд дарамт болдог, хулгай зэлгээ хийдэг, өр зээлэнд баригддаг, энэ нөхцөл байдлаар бол ажиллуулаад байх ямар ч шаардлага байхгүй, нэг ч төрийн өмчийн компани Монголд өнөөдөр үндсэндээ хэрэггүй гэж би харж байгаа юм. Илүү харин хувийн хэвшилээ дэмжсэн, чөлөөт зах зээлийнх нь зарчмаар нь явуулсан илүү либерал байдлаар харин бид нар нэг илүү том бодлогын өөрчлөлт, хандлагын өөрчлөлтийг бол хийгээд явах ёстой.

Тэгэхээр бид нар бол энэ зарчмаар л энэ асуудлыг дэмжээд явах ёстой. Өнөөдөр бодит байдалдаа дүгнэлт хийе, энэ

тогтоолыг шуурхай гаргая. Өөр цаашид, өөр бүр цаашид энэ төрийн өмчийн компаниудтай холбоотой хуулиуд орж ирж байна. Төрийн өмчтэй холбоотой компанийн хуулиуд орж ирж байна, энэ хуулиуд дээр бүр асар том өөрчлөлтийг хийгээд, цаашид хувийн хэвшилдээ тулгуурласан улс орон болоод явна гэдгийг бид нар зарлаж тунхаглаад ингээд явах ёстой гэж харж байгаа юм. Энэ дээр бид нар том бодлогын өөрчлөлт хийцгээе гэж би эцэст нь бас гишүүддээ уриалж байгаа юм, энэний төлөө зүтгэцгээе, явцгаая, одоо цэг тавья боллоо.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ, санал юм даа тийм даа тийм ээ? Хавдисламын Баделхан гишүүн.

Х.Баделхан: Баярлалаа. Ер нь төрийн өмчийн компани бол эзэнгүй байна. Энэнээсээ болоод их хулгай явагдаж байна. Бид нар 92 оны онд шинэ Үндсэн хуулиа батлаад зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн. 92-оос 96 онд социализмын 70 жилийн хугацаанд бий болгосон олон үйлдвэр аж ахуйн газрыг хувьчилсан. ХК болгосон, хувь нийлүүлсэн компани болгож хувьчилсан. Энэ хувьчлалаар бол алдсан юм ч байгаа, оносон юм шиг байгаа. Тухайлбал, малын хувьчлал бол эзнээ олсон, малчид малаа аваад тухайн үед хорин сая байсан мал наян сая хүртэл өсөөд үр дүнгээ өгсөн. Үйлдвэр аж ахуйн газрыг хувьчилсан нь бол үр дүнг өгөөгүй. Олон компаниуд тонож дээрэмдсэн, тоногдсон. Тухайлбал, манай аймагт бол мянга гаруй ажилчинтай, барилгын том трест байсан. Монгол Улсын хэмжээнд бол барилга барьдаг, материаллаг баазтай. Энэ одоо хувьчлагдаад, ажилчид нь бол гудамжинд гарсан. Тэр бүх тоног төхөөрөмж нь бол тоногдоод Хятадад төмөрт ачигдаад өнөөдөр барилга барьж чадахгүй байгаа. Энэ мэтийн жишээ бол манай улсад их байгаа.

92 оноос өмнө бол бид нар аж үйлдвэр, хөдөө аж ахуйн орон байсан. Өнөөдөр бол бид нар 90 оноос хойш

сүүлийн 36, 30 жилийн хугацаанд бол бид нар аж үйлдвэрээ хөгжүүлж чадсангүй. Ер нь аж үйлдвэрийн салбарт бол өсөлт бараг байхгүй. Тийм учраас энэ төрийн өмчийн компанийг нэмж байгуулахгүй гэсэн энэ өргөн барьсан тогтоолын төслийг бол дэмжиж байгаа.

Хэдэн асуулт байна. Сая тогтоолын төсөл дээр бол ер нь ДНБ-ий 54 хувийг ТӨК-ууд одоо бий болгож байна гэж. Тэгэхээр бид нар олон, одоо ТӨК-уудыг хувцаслачхаад хувьдаа шилжүүлээд эргээд төрийн өмч дээр үндсэн дээр бол бид нар үйл ажиллагаа явуулж байгаа. Төрийн өмч бол эзэнгүй, төр солигдвол удирдлагууд солигдоно, тэгээд бүгд солигдоод, тэгээд тоногдоод тоногдож байгаа. Өнөөдрийн энэ Хөгжлийн банк, Таван толгойн энэ компаниудын асуудал бол яг энэтэй холбоотой байгаа. Нүүрс, нүүрс экспортлож байгаа олон компани байгаа, хувийн компани байна, төрийн компани байна. Хувийн компаниуд дээр өнөөдөр асуудал яригдахгүй, тэр төрийн компани, орон нутгийн Таван толгой компани дээр л ер нь хулгай нүүрлэж байгаа шүү дээ. Тийм учраас цаашдаа бол төрийн компани ашиггүй.

Тэгэхээр нэг асуулт бол яг өнөөдрийн байдлаар манай улсын хэмжээний нийт одоо компаниудын хэчнээн хувь нь одоо дүрмийн сангаараа тооцоход хувийн компани байна вэ, хэчнээн хувь нь төрийн компани байна вэ? Ер нь төрийн компани хэр зэрэг одоо үр дүнтэй, хувийн компаниуд хэр зэрэг үр дүнтэй ажиллаж байна вэ гэсэн тийм бодит судалгаа байна уу? Энэ дээр хариулт авъя гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн асуултад хариулъя.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр энд нийт бид нар бол Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч ААН бол 228000 байгаа юм. Энэ төрийн компаниудын одоо яг нарийвчилсан ингээд тоог аваад үзнэ гэхээр

энэнээс бол мэдээж хамаагүй бага. Гэхдээ яг гүйцэд, одоо энэ нөгөө миний тэр дурдаад байгаа хөгжлийн сан, орон нутгийн төрөл бүрийн сан, энэ чинь бүгдээрээ тодорхой мөнгө санхүүтэй харьцаад эдийн засагт тодорхой худалдан авалт хийх үү, тодорхой үйлчилгээ үзүүлэх үү ингээд оролцоод яваад байгаа юм. Энүүгээрээ ингээд аваад үзвэл яг эцсийн тоо байхгүй. Мэдээж энэтэйгээ бол харьцуулиггүй цөөхөн байгаа.

Гэтэл эдийн засагт эзэлж байгаа хувь хэмжээг нь аваад үзэхээр уг нь бид нар ДНБ-ий наян хувийг хувийн салбар бүрдүүлж байгаа гэж үзэж байгаа шүү дээ. Тэгсэн чинь бодит байдалд энэ бол маш өнгөцхөн, бид нар судалгаа хийсэн. Яагаад гэвэл энийг бүр нарийвчилж судлах ёстой юм байна. Яагаад гэвэл энэ судалгаа байхгүй байна. Тэгээд юу гэж байгаа гэхээр шууд асуулт асуугаад явуулангуут өөдөөс төрийн албаны байгууллага нь хариулж байгаа нь наян хувь шүү дээ гээд хариулт өгч байгаа юм. Үгүй ээ, ийм байх ёсгүй гээд бид нар ингээд өнгөцхөн судлахад 55.4. Нөгөө миний саяын дурдсан санг дурдаад явбал энэ чинь бүр тэрнээс цаашаа том болоод явчихна. Өнөөгийн нөхцөл байдал ийм байгаа. Бид нарын хамгийн их санаа зовж байгаа юм тэгэхээр энэ аль хэдийн төрийн өмчит эдийн засаг бүхий ийм зах зээл бид нарт бүрдчихээд байгаа. Гэтэл шийдвэр гаргалт нь бол улс төржсөн, авлигажсан, ашиг сонирхолд өртсөн ийм л нөхцөл байдал руу. Тэгэхээр та бодлоо Монгол Улсын ДНБ-ий жар гаруй хувь нь ийм байдал руу шилжчихсэн байна гэсэн үг байхгүй юу.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Цогтбаатар гишүүн их цаг үеэ олсон ийм тогтоолын төслийг санаачилсан. Тэгээд бидний гишүүд дэмжээд өргөн барьсан. Тухайн цаг үед нь хэлэлцээд шийдчихсэн байсан бол тэр цагаас хойш төрийн өмчийн компаниуд ингээд л бас нэг борооны дараах мөөг шиг олон байгуулагдахгүй байх байсан л даа.

Тэгэхдээ одоо энэ асуудлыг одоо Их Хурлаар хэлэлцээд яаралтай батлах хэрэгтэй. Өнөөдөр Хөгжлийн банкны энэ түр хороо байгуулагдсан. Тэгээд энэ Хөгжлийн банкны түр хороон дээр ярьж байгаагаар бол Хөгжлийн банкны чанаргүй зээлийн бараг 1/3-ийг төрийн компаниуд авсан байна гэж байгаа юм. Хувийн компаниуд бол тэр зээлээ төлчихнө, наад хэд чинь бизнес төлөвлөлтөө гаргаад, цаг тухайд нь зээлээ төлөөд явна шүү дээ.

Төрийн компанийн тэр чанаргүй зээлийг хэн төлөх юм бэ, хэн төлөх юм бэ гэдэг асуулт гарч ирнэ. Өнөөдөр Цогтбаатар гишүүний сая хэлж байгаагаар 228000 ААН байгаа. Эд нараас НДШ төлж байгаа үзүүлэлтийг нь харахаар үнэхээр одоо энэ НДШ-ийн чинь бараг л дал гаруй хувийг нь хувийн компаниуд бүрдүүлж байна шүү дээ, ачааг нь үүрч байна шүү дээ. Гэтэл өнөөдөр төрийн өмчийн ААН-үүд одоо бүгдийг хийж чаддаг юм шиг царайлсаар өнөөдрийг хүрлээ. Өнгөрсөн 16 оноос хойш авхуулаад л энэ олон сангууддаа хөндлөнгийн менежмент хийе, хөрөнгийг байгаа чигээр нь байлгаад байвал илжирдэг юм гэж тэр Лодойдамба гуай Тунгалаг тамир дээр бичсэн байгаа шүү дээ. Хөрөнгийг байгаа чигээр нь байлгаад байдаг, манайх шиг улс гэж байхгүй. Хөрөнгийн менежмент хийх ёстой шүү дээ. Хөрөнгийн менежмент хийхгүйгээр Засгийн газрын тусгай сан гэдэг нэрийдлээр нэг баахан мөнгө тавьчихдаг. Тэгээд төрийн өмчийн хэдэн компани байгуулчихдаг. Нөгөө хэд нь хөрөнгийн менежмент хийх байтугай анхан шатны ч ойлголтгүй баахан нөхдүүд цуглачхаад л үр ашиггүй баахан дэргэдэх охин компани байгуулснаар өнөөдрийг хүрсэн.

Тэгээд бид бол Их Хурлын индэр дээр хувийн хэвшилээ дэмжинэ, төр хувийн хэвшилээс, одоо хувийн бизнестээ орооцолдохгүй гэж ярьдаг мөртөө заримдаа харахаар бүр нэг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг руугаа алхам алхмаар яваад байгаа ч юм шиг санагдах үе бол зөндөө гардаг. Хувийн хэвшилээ

бодитоор яаж дэмжих юм бэ, хувийн хэвшил чинь бодитоор энэ эдийн засгийг ар нуруун дээрээ авч явж байгаа юм бол яагаад өнөөдөр энэ оролцоод байгаа юм бэ гэдэг асуудлыг бол олон хувийн хэвилийн компани, ААН-үүд тавьж байгаа шүү дээ. Зах зээлд шилжчихсэн улс байж байж. Тэгэхээр өнөөдөр Засгийн газраас бол энэ хуримтлалын сан, баялгийн санг байгуулах, энэ уул уурхайн баялагтаа эзэн болох энэ эрх зүйн орчныг боловсруулахаар ажлын хэсэг байгуулаад Амарбаясгалан даргаар ахлуулаад ажиллаж байна. Миний хувьд бол Их Хурлын даргын захирамжаар байгуулсан энэ тэтгэврийн шинэчлэлийг ажлын хэсгийн хүрээнд хуулиудыг нь боловсруулаад өргөн барьсан. Их Хурал дээр бол миний хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг хөрөнгийн зах зээлийг дэмжих бодитой санаачилга гаргаад ирсэн хуулийг хав дарсан. Хаана дарагдсан юм бүү мэд. Нэг хүн ахалсан гэсэн, тэр нь хаана байгаа юм мэдэхгүй.

Тэгээд ер нь бол ажил бол өнөөдөр нэг ажлын хэсэг дээр ирээд л таг гацдаг. Тэгээд танай наад хувийнхан чинь ажил хийж чадах юм уу гээд. Хөрөнгө оруулалтын сангийн хуультай. Өнөөдөр 4, 5-хан хөрөнгө оруулалтын сан байгаа. Хөндлөнгийн менежментийн компани түүнийг нь удирддаг. Хаашаа хөрөнгө оруулалт оруулахаа өөрсдөө шийддэг шүү дээ. Бид нар хөрөнгийн менежмент хийх энэ төсвөөсөө энэ олон одоо сангуудыг салгаад баялгийн сангаа бодитоор нь байгуулаад баялагтаа эзэн бол гарц шийдлээ гаргахгүй бол болохоо больсон. Тэгээд Цогтбаатар гишүүнээс ер нь энэ тогтоол санаачилснаас хойш хэдэн компани байгуулагдав л гэдэг асуултыг асуумаар байна.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн асуултад хариулъя.

Д.Цогтбаатар: За яг энэ моратори байгуулъя гэдэг энэ санааны гол юу Учрал гишүүн яг л хөндөөд л ярьж байна л даа. Энэ ингээд хэлэлцэгдээд явж байхад энэ завсар бас нэлээн хэдэн компани

байгуулагдсан. Яг одоо би ингээд тоогоор нь энэ орон нутаг эд нараар чинь ярих юм бол өөр тэнд байгуулагдсан байхыг хэлэхийн аргагүй. Юу яриад байна гэхээр энэ үзэгдэл чинь өөрөө ингээд зогсох, цаад суурь сэтгэлгээнд нийгэмд аливаа асуудал үүсэхээр энийг шийдэхэд мөнгө санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй, тэрийг яаж хийх вэ гэхээр компаниар бизнес байгуулаад, тэгээд нийгмийн зорилгоор компани байгуулах. Компани чинь арилжааны байх ёстой, тэгж байж зах зээл дээр байр сууриа олж авна. Тэгтэл нийгмийн зориулалттай хийчихээр чинь бүх компани дампуурах эрсдэлд орно биз дээ. Одоо ингээд та бүгд маань бодоод үзээрэй. Төрийн гэж байгаа Монгол Улсын үндсэн баялаг болсон маш том компаниуд дээр ч гэсэн энэ нөгөө нийгмийн ачаа нь маш их байдаг. Цэцэрлэг, эмнэлэг өчнөөн юм болоод л явж байдаг.

Тэгэхээр энэ компаниуд чинь өөрсдөө тэр арилжааны журмаар биш ажиллаад ирэхээр энэ татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Тэгээд үр дүнгүй ажиллаад өөрсдөө цаашидаа дампуурах эрсдэл рүү орж байгаа нэг ийм л юм байгаа. Тэгэхээр сая бол яг сүүлийн үед нэлээн хэдэн компани нэмээд байгуулагдсан байна лээ. Би яг тэр дотоод тоог нь мэдэхгүй байна. Би тэрийг бас олж танд жич хариу явуулъя.

Г.Занданиатар: Тодруулъя. Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Хувийн хэвилийнхэнтэй уулзахаар төр та нарт яаж туслах вэ гэхээр хэлдэг гай болохоор зай болоорой л гэж. Тус болж чадахгүй юмаа гэхэд ус болохгүй холхон байя улс төрчид өө, энэ хувийн хэвйлээс. Гай болохгүй зай больё л гэж хэлмээр байна. Тэгээд Цогтбаатар гишүүн бас өмнөх энэ хуулийн тогтоолын төслийг өргөн барьж байхад хэлж байсан үг байгаа. Эдийн засгийн эрх чөлөөгүй газар үзэл бодлын болоод, улс төрийн эрх чөлөө удаан тогтдоггүй гэж. Бид бол үргэлж санаж явах ёстой юм байна лээ.

Г.Занданиатар: Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би бол энийг бол ойлгохгүй байгаа, ямар тогтоолын төсөл юм, яах гэж байгаа юм. Түр хугацаа гэдэг нь ямар хугацаа юм бэ? Тэгээд та нэг яг ТӨК гээд л байнга борооны дараах мөөг шиг байгуулаад байдаг гэж бодоод байх шиг байх юм. Та яг сая зөндөө олон байгуулагдсан гэж байна тогтоол өргөн барьснаас хойш. Нэг тодорхой жишээ хэлээдхээч. Энэ орон нутагт чинь. Энэ төр чинь ямар компани авч явдгийг та мэднэ биз дээ. Эсвэл томоохон, одоо энэ стратегийн ордын хувь, эсвэл энэ хог нохой, энэ сайжруулсан түли дандаа алдагдалтай бизнес болоод л төр чирч явдаг шүү дээ. Орон нутагт жишээлбэл тохижилт үйлчилгээний компаниуд, сайжруулсан түлиний компаниуд, ногоон байгууламжийн, авто замын засвар арчлалтын, эрчим хүчний. Хувийнхан аваад явчихдаг бол тэр бизнесийнхээ зарчмаар тэртэй тэргүй төртэй орж ирээд л аваад явж байна шүү дээ.

Хувийнхан авч явж чадахгүй тэр салбаруудыг чинь л төр нуруун дээрээ үүрээд чирээд явчихдаг байхгүй юу. Тэгэхээр зэрэг энэ дээр одоо заавал одоо энийг хязгаарлалаа гээд нэг их тийм хязгаарлахгүйгээр өдөр шөнөгүй байгуулаад компани гэж байхгүй, хэзээ ч тийм юм байхгүй. Тэгэхээр зэрэг одоо энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хууль дээрээ харин хэдүүлээ ямар төрлийн компанийг төр байгуулж болох вэ, ямар төрлийн компанийг байгуулж болохгүй гэдэг заагаа л тогтоогоод өгчих ёстой байхгүй юу. Энэ чинь орон нутаг чинь өөрсдөө бие дааж хөгжих гээд л, эдийн засгаа хөгжүүлэх гээд л элдвээр л үзэж байна шүү дээ. Одоо энэ орон нутгууд чинь сая одоо төсвийн хууль дээр та бүхэн мэдэж байгаа. Сая орон нутгууд төсвөө баталлаа. Орон нутгийн, нэг жоохон өмчтэй ААН-тэй аймгууд нь төрийн албан хаагчдынхаа цалинг 2 дахин нэмээд л, тийм юм байхгүй аймгууд нь төрийн албан хаагчдынхаа цалинг 10, 20-хон хувиар нэмээд л ингээд л тус тусдаа

одоо өөрсдөө шийдвэр гаргаж эдийн засгийн чадавхтай холбоотой асуудал болж байна шүү дээ.

Тэгэхээр нэг одоо аймагт одоо яадаг юм, нөгөө нэг томоохон уул уурхайн орд гараад ирье. Тэрэнд нь нэг стратегийн орд гээд 34 хувийг чинь Монголын төр эзэмшинэ биз дээ. Тэгэхээр нэг ААН байгуулах зайлиггүй шаардлага гарна даа. Тэгээд энийг одоо тэгээд ер нь цаашидаа яаж зохицуулж явах юм бэ? Одоо сумдууд чинь том том 10000, 20000 хүнтэй сумдууд зөндөө болж байна. Тохижилт үйлчилгээний компани хог нохойтойгоо ноцолдох гээд нэг аж ахуйн, за компани байг гэхэд нэг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар ч юм уу, нэг юм байгуулж таарна даа. Тэр чинь тайлан тооцоо нь заавал одоо ингээд аж ахуйн тооцоотой байж байж үйл ажиллагааныхаа зардлаар юм уу, эсвэл улсаас татаас авч ингээж л явна шүү дээ. Тэгээд эд нарыгаа тэгээд одоо яаж зохицуулах юм бэ? Одоо Ховд дээр гэхэд нэг сайжруулсан түлшний үйлдвэр одоо барьж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд тэрийг барьчхаад хувьд өгөх юм уу? ТӨК байгуулж болохгүй гээд. Тэрийг тэгээд яаж авч явах вэ? Ийм жишээнүүд зөндөө байна шүү дээ.

Одоо ингээд энэ ХААЯ-наас гаднын тусламжаар зуун хувийн санхүүжилтээр энэ махны үйлдвэрүүд барьж байна шүү дээ. Тэгээд ашиглалтад орохоор нь яах юм, компани байгуулж болохгүй гээд хэн нэгэн одоо байгаа компанийн суганд аваачиж хавчуулах юм уу? Тэгээд энийг одоо хэдүүлээ нэг ингээд тайлбарлаж байгаа нь бол ингээд нийгэмд нээрээ хурмээр юм шиг, яг бодит амьдрал дээр бол энэ бол ТӨК-иуд чинь бол элгийн юмнууд байгаа шүү дээ. Төр зайлиггүй чирч явах ёстой салбар байна шүү дээ. Тэгээд энийгээ бас нэг жаахан зааглаж, ялгаж хугацааг нь тогтоож, эсвэл одоо энэ төрийн өмчийн саяын өнөөдөр орж ирсэн, төрийн болон орон нутгийн өмч дээр өмчийн хууль дээрээ одоо явж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн өмчит компаниудынхаа хууль дээр л одоо ийм төрлийн компани байгуулахыг

хориглоно, ийм төрлийн компани байгуулж болно. Энийгээ л бид нар заах ёстой болохоос биш юу ч байгуулж болохгүй гэдэг ийм хатуу тогтоол Их Хурал гаргаж ерөөсөө болохгүй шүү дээ. Амьдрал баян, одоо Орос, Хятадын нөгөө хий хоолой ч билүү.../минут дуусав/

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Би энд нэг ийм хариулт өгье. Нэгдүгээрт ингээд нэг олон нийтэд гоё харагдах гэж гээд тэр би сүүлээс нь эхэлье. Гишүүнээ, би тийм хачин хөгийн юм хийж явдаг хүн биш, олон нийтэд гоё харагдах надад ёстой чухал биш нэг.

Хоёрт энэ чинь моратори буюу хориг гэж орж ирж байгаа. Яг таны одоо хэлж байгаагаар бас ийм санаа агуулга гарч болзошгүй гэдэг үүднээсээ би тодорхой хугацаатай оруулж ирж байгаа. Яагаад гэвэл таны ярьж байгаа тэр түк эд нарыг ерөөсөө би оролдох гээгүй. Тийм учраас би цөөлье гэж яриагүй байна шүү дээ. Өнөөдрийг болтол энэ байгуулчихсан байгаа ААН-үүдээр дамжуулаад төр хийх хэрэгтэй юм байвал зөндөө юмаа хийх угаасаа боломжтой, хангалттай тэр механизмууд нь бий болчихсон байж байгаа юм. Тэрүүгээрээ дамжуулаад юм хийх зөндөө боломж байгаа. Харин миний нэг айж байгаа юмыг та яг сая хэлчихлээ. Одоо ингээд нэг орд газар гараад ирнэ, стратегийн орд. Тэгээд тэрэнд зориулаад ахиад шинэ, үгүй ээ, энэ чинь Эрдэнэс Монгол гээд бүхэл бүтэн том holding компани байхгүй юу. Монголын хаана ч том стратегийн ордууд гарч ирвэл тэрийг хариуцаад явах машин нь аль хэдийн байгуулагдсан. Одоо орд болгон дээр тусдаа ийм төрийн компани байгуулбал та энэ менежментийг хэзээ ч хянаж дийлэхгүй. Энэ мөнгөний төлөөх, энэ авлигал хээл, энэ системийг нь бий болгочоод хэчнээн хүнийг аваачаад шоронд хийнэ. Энийг энэ энэ чигээр нь үлдээдэг юм бол 5 жилийн дараа дахиад

шинэ аавын хүүхдүүдийг шоронд хийх л ажил гарч ирнэ.

Хүн төрөлхтөн чинь хувийн сектор руу шилжээд байгаа нь тэр аягүй гоё учраас биш зүгээр л тэр 80 жилийн түүхээрээ энэ нь үр дүнгүй байгаад зах зээлийн эдийн засаг хамаагүй үр дүнтэй байх нь харагдсан байхгүй юу. 80 жилийн дотор Монголын дотоодын нийт бүтээгдэхүүн 90 онд 2 тэрбум доллар байсан 70 жилийн хөгжилд. 30 жилийн дотор чөлөөт зах зээлийн эдийн засаг, ардчилсан тогтолцоонд шилжээд 30 жилийн дотор 12 тэрбум болсон. 2 дахин бага хугацаанд 6 дахин илүү баялаг Монгол Улсад бүтсэн шүү дээ энэ бодит үнэн шүү дээ. Тэгэхээр зах зээлийн эдийн засаг өөрөө ажилладгаа харуулчхаад байхад бид нар яаж юугаараа бодохоор буцаад төрөөр бүх юмаа хийлгэх гээд, тэгээд өнөөдөр энийг би нэг сард ярьж байсан. Энэ хулгай чинь дийлдэхгүй шүү, авлига хээл хахуул, энэ ашиг сонирхлын зөрчил чинь дийлдэхгүй шүү гээд яриад байж байтал 6 сард Хөгжлийн банк гарч ирсэн. Одоо нүүрсний хулгай гараад ирсэн. Тэгэхээр ийм байдлаар хэчнээн удаан бид нар ингэж дүр эсгэж ард түмний төлөө юм шиг хэдхэн удирдаж байгаа хүмүүс өөрсдөдөө ард түмний нэрээр завшаад яваад байдаг тогтолцоог харсаар байж цаашаа үргэлжүүлэх вэ?

Жишээлбэл Америкийн компаниуд G..., Microsoft бүгд хувийн компани. Гэхдээ тэр Америкийн компани байж байна шүү дээ. Америкт татвар төлж, Америкийн ажиллах хүчин хүмүүст ажил олгогч байгаа компани. Гэхдээ тэрийг б... компани гээд Америкууд лав ад үзээд, энэ бидний өмч биш, энэ хүний өмч гэж ингэж ярьдаггүй шүү дээ. Тийм учраас АНУ дэлхийн хамгийн хүчтэй эдийн засаг болсон байхгүй юу. Тэгээд бид нар ийм л сонголтыг 90 оны өмнө хийсэн. Тэгэхээр нэг алдаагаа дахиж давтаад баймааргүй байна л гэж байгаа юм. Таны асуултад одоо яг энэ ингээд гараад явж байхад Эрдэс гээд компани байгуулагдсан. Эрдэнэтээс тэр одоо юу хийлээ гэж яах гэж байгаа юм тодорхой хувийн байнгын

шимтгэл авч байх тийм тогтолцоотой лав орж ирж байх шиг байна лээ. Ингээд би энийг сая Учрал гишүүн асуусан нарийвчлаад илүү тодруулна. Яг энэ хугацаанд хэдэн шинэ компани байгуулагдсан гэдгийг. Баярлалаа.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулъя.

Г.Ганболд: Би ер нь ойлгож л байна л даа. Гэхдээ ингээд хавтгайруулдгийг л би эсэргүүцээд байгаа шүү дээ. Би бол таныг энэ тогтоолын төсөл өргөн барьснаас хойш бараг нэг ч компани байгуулаагүй гэдэгт би итгэлтэй байна. Тэр чинь тийм зүгээр ингээд дур зоргоороо өдөр болгон байгуулаад явдаг юм биш. Тэр дундаа би орон нутагт бол би нэг ч байгуулагдаагүй гэдэгт итгэлтэй байна. Улсын хэмжээнд тэр Эрдэс гэнэ үү тэрийг бол би мэдэхгүй байна. Гэхдээ үнэхээр тэр уул уурхайн 34 юм уу тийм юмнуудыг бол хориглож болно. Эдийн засагт орох тийм юмнуудыг хориглож болно. Би хавтгайруулаад ерөөсөө л төрийн өмчит тийм аж ахуйн нэгж компани байгуулахыг хориглохыг бол заамаар байна шүү дээ. Ийм төрлийн гэж зааж болно шүү дээ та. Тэрнээс би түрүүн хэлсэн шүү дээ. Төр чинь үнэхээрийн алдагдалтай юмнуудаа л нуруун дээрээ үүрч явдаг шүү дээ. Тэгээд энэ төрлийн юмнуудыг бид нар хориглоод яах юм бэ? Тэгээд 10000 хүнтэй, 20000 хүнтэй сумнуудад ТҮК байгуулж байна. Тэд нарыг бид нар хориглож яах юм бэ авч явах л ёстой, үүрэх л ёстой төрийн нуруун дээр явах ч ачаа шүү дээ.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Тэгэхээр таны яг ярьж байгааг л бид нар тусгаад моратори буюу моратори гэдэг чинь тодорхой хугацаатай түр хорьж байгаа юм. Амьдрал баян. Тэр хугацааны дараа ямар юм гарч ирэхийг би үгүйсгэхгүй байгаа учраас миний хамгийн түрүүн хийе гэж байгаа цохилт төрийн өмчөөр нийгмийн асуудлуудыг шийдээд, нийгэмд асуудал

гарах болгонд төрийн өмчөөр шийдэх гэж оролдох тэр в... сэтгэлгээг яг одоо үнэнээр нь хэлье. Зогсоох хэрэгтэй. Тэгэхгүй бол наадах чинь цаашаа үргэлжлээд нийгмийн асуудлыг нь шийдвэл төрийн өмчийн оролцоотойгоор явахгүй. Төр бодлогоороо энэ бүгдийг зохицуулах боломжтой. Үндсэн хууль бүх хуулиараа угаасаа энэ ардчилсан зах зээлийн эдийн засагтай нийгмийн төрийн оролцоо чинь зохицуулалтдаа байгаа юм. Тэр чинь хангалттай хүч шүү дээ. Яагаад энэ нь хангалттай биш болоод өөр нэмж мөнгө хийе гээд. Тэгээд мөнгө хийхээр чинь юу болдгийг бид.../минут дуусав/

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: 30 жилийн өмнө нийгмийн хувьсгалт өөрчлөлт болоод чөлөөт эдийн засаг, нээлттэй нийгмийн тогтолцоог сонгож, энэ нь хувийн өмч дээр тулгуурлах юм гэдэг үндсэндээ ийм том зарчмын өөрчлөлт энэ 30 жил туулаад ирсэн. Нэг харсан чинь одоо эргээд нэг харсан чинь 30 жилийн бараг тэр үеийн байр сууриндаа очиж, төсөв нь улсынхаа ДНБ-ийхээ бараг тал руу дөхөж явна. Төрийн өмч нь одоо яг бодит тоогоо ч мэдэхгүй, хараажсаар одоо энэ нөхцөл байдал гарч байгаа, авлига хээл хахууль, ТӨК-уудын нөхцөл байдал олон зүйлийг харахад зах замбараагаа алдчихсан, ийм л нөхцөл байдалтай. Энийг харин зүүний чиглэлийн нам том төрийг байх ёстой гэж сурталчилдаг нам олон жил энэ байдлыг хөхүүлэн дэмжиж яваад харин эцэст нь яг одоо анхан шатнаасаа хөрс сууринаасаа энэ чинь болохгүй юм байна гэж тал талдаа ойлгож, яг өнөөдөр гэхэд энэ тогтоол төрийн болон орон нутгийн өмчийн тухай гээд яг энэтэй холбоотой маш олон хууль тогтоолууд, энэ чинь Их Хурлаар орж ирж байгаа нь үнэхээр бас талархууштай. Энэ бол яг явах ёстой зүй зохистой замаараа л явж байгаа гэж ойлгож байгаа юм.

Харин энэтэй холбогдуулж хэлэх гэсэн нь яг энэ төрийн өмчийг шинээр

байгуулах гэдэг нэршилээс арай өөрөөр аж ахуйн үйл ажиллагаанд төрийн оролцоог хязгаарлах гэдэг ийм тогтоолын төслийг хавар 4 сард би Засгийн газраас санал аваад харин өргөн барьж амжихгүй явсаар байгаад энэ долоо хоногт өргөн барьсан. Тэгэхээр энэ тогтоолын төслийг утга агуулгын хувьд их ойролцоо болохоор Улсын Их Хурлын даргыг бас хамтатган хэлэлцүүлэх ямар нөхцөл бололцоо байдаг юм, энийг шийдэж өгөөч. Энэ дээр бол бас зарим зүйлүүд нь ойролцоо, жишээ нь шинээр нэмж байгуулахгүй гэж биш, энэ дээр тодорхой хэмжээний тооны дээд хязгаарыг нь тавьж өгье. Жишээ нь өөрчлөн байгуулах замаар нэмж бий болгох, өөрчлөн байгуулах хэлбэрээр нэмж бий болгох, эдгээрийг бий болгохдоо хувьцаа худалдан авах, өрийг хувьцаагаар солих гэх мэт нэг ийм байж болох, дараа гарч болох ийм, ийм зүйлсүүд, ийм арга барилуудыг төрийн өмч, төрийн оролцоог нэмэгдүүлэх энэ арга барилуудыг нь арга замуудыг нь хаасан, дахиад ойролцоо шинж чанартай ийм тогтоолын төсөл байгаа юм. Тэгэхээр хууль санаачлагчаас бол асуулт алга. Их Хурлын даргаас энийг хамтатган хэлэлцүүлэх ямар бололцоо байдаг вэ? Энийг та бас энэ дээр хариулт өгөөч.

Г.Занданишатар: Эхлээд Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ дээр бол Цогтгэрэл гишүүнээ, миний хувьд бол ямар ч зөв юм л хийгдэж байвал та санаачлагчид хамтарч орж ирээд хэдүүлээ текстээ зөв боловсруулаад л явна. Үр дүн л чухал байгаа юм. Энэ дээр яг өөрийн чинь ярьж байгаа нөгөө хэд хэдэн сая Ганболд гишүүнд ч гэсэн би нээрээ хариулахаа мартчихаж. Жишээлбэл, менежментийг өөрчлөх заалтууд нөгөө явж байгаа шүү дээ. Энд чинь яг одоо 6 сарын өмнө энэ асуудал гараагүй байхад чинь л санхүүгээ ил тод болго. Тэгсэн одоо ингээд л зөндөө оффтейк гэрээ гэдэг асуудал чинь өөрөө гараад ирж байна шүү дээ. Нөгөөдөх нь болж байгаа ТӨК-уудыг олон нийтийн болго. Одоо тэгвэл төр тэгээд байгуулах

гээд байгаа юм бол дэмжиж өгөөд, биржээ хөгжүүлээд олон нийтийн компаниуд харин байгуулахад дэмжлэг үзүүл л дээ. Энэ бол аягүй том зах зээлийн механизмыг өөрийг нь зөв голдирлоор нь ашиглаж байгаа алхам болох байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ахиад л олон нийтийн компани болонгуут TVЗ-өөсөө авхуулаад л аягүй олон өөрчлөлтүүд гарах хэрэгтэй. Санхүүжилтийн нөгөө юу санхүүгийн тайлан тооцоо бүх юм нь ил тод болох ёстой гээд зөндөө олон эерэг өөрчлөлтүүд орно. Тэгэхлээр таны ярьж байгаа юмнууд, бас энд явж байгаа болохоор би нэгтгэхэд бол нээлттэй байна.

Г.Занданшатар: Тэгвэл энэ дэгийн тухай хуулийн 39.24-д заасны тухай дагуу нэг асуудлаар 2 ба түүнээс дээш гишүүн хуулийн төсөл санаачилсан бол хууль санаачлагчид нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол анхдугаар хэлэлцүүлэг дээр Байнгын хороо төслүүдийг хамтатган хэлэлцээд санал, дүгнэлтээ нэгтгэн танилцуулж явж болно гэсэн ийм дэгтэй. Хэрэв хууль санаачлагчид зөвшөөрөөгүй бол тус тусад нь хэлэлцэнэ, зөвшөөрөх юм бол нэгтгэн хэлэлцээд явна. Тэгээд өнөөдөр хэлэлцэх эсэхээ шийдчихээд, Цогтгэрэл гишүүний төслийг ч гэсэн хэлэлцэх эсэх асуудлыг шийдчихээд, Байнгын хороон дээрээ саналаа нэгтгээд явчхаж, одоо 2 хууль санаачлагчид санал нэгтэй байгаа учраас Байнгын хороон дээрээ нэгтгээд хэлэлцээд явчих нь зүйтэй. Зүгээр ер нь яах вэ, амьдрал баян учраас заавал болохгүй энэ тэр гэвэл хуульд өөрөөр заагаагүй бол хуулиар бол одоо байгуулж болно гэж нээж өгөх нь байна шүү дээ. Хуульд өөр, гарцаагүй шаардлага гарвал. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн компани шинээр байгуулахыг хориглоно. Ер нь тэгэхдээ нэг *private sector led market economy* гээд байгаа шүү дээ. Тэгэхээр хувийн хэвшил манлайлсан давамгайлсан зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлэх зорилгоор энэ тэр үг үсэг энэ тэрээ. Тэгээд ер нь хувийн хэвшилээ л дэмжиж байх тэр агуулга энэ тэрийг бас зөвхөн төрийн өмчийн компанийг негатив зохицуулалт

буюу хязгаарлахаас гадна нөгөө талдаа хувийн хэвшлийг дэмжих чөлөөг нь олгох, эдийн засгийн либералчлалыг илүү түлхүү хэрэгжүүлэх тийм нэг багц хуулийн төслүүд бас явж байгаа юм.

Тэгээд тэр энэ тэртэй уялдуулах байдаг юм уу, энэ шаардлагыг бол Эдийн засгийн байнгын хороо яриад байгаа, энэ дээр нэгтгээд явах нь зүйтэй байх. Байнгын хороон дээр шийдэгдэнэ. Тэгээд 2 хууль санаачлагч нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрч байна гэвэл тэгээд л болоо. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Би энэ тогтоолыг ер нь зарчмыг дэмжиж байгаа юм. 1993 онд төрийн албаны шинэчлэлийн тухай маш том төсөл Монгол Улсын Засгийн газраас гадаад санхүүжилт, техникийн туслалцааны мөнгөөр эхлүүлж байсан юм. Тэр ажлын гол санаа нь юу вэ гэхээр ерөөсөө эцсийн дүндээ төрийн алба, улс төрийн алба, мөнгө хоёрыг хол байлгаж. Бизнес, улс төр хоёрыг хол болгоё гэсэн санаатай. Төр ийм юмнуудаа хариуцна, бизнес ийм юмаа аваад явна гээд Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлээд энэ том шинэчлэлийг эхэлсэн юм. Одоо ингээд дахин, дахин Төрийн албаны тухай хууль өөрчлөгдөөд л бизнест хандаж байгаа бодлогууд өөрчлөгдөөд л байна. Энэ ингээд л бид нар би одоо ингээд ажиглаад байхад алхам алхмаар ухраад байгаа юм. Бүр сүүлдээ миний ажиллаж байсан Засгийн газрууд дээр ч тэгж байсан юм. Төрийн өмчтэй, төрийн өмчийн оролцоотой томоохон компаниуд дээр улс төрийн төрийн албаны хүмүүсийг TVЗ-д нь оруулж томилдог болж эхэлсэн. Үгүй ээ, энэ болохгүй ээ, наадах чинь нөгөө хамгийн анх гаргаж байсан шинэчлэлийн бодлого концепцоосоо зөрөлдөөд байна гэж тухайн үед нь хэлж байсан. Одоо бид нарыг заримдаа тэгдэг юм, улс төрд удчихаад тэр үед юу хийж байсан юм гээд.

Тухай бүрд нь хэлдэг байсан. Тэгээд асуудлыг Их Хурал дээр ч, Засгийн газар дээр ч олонхын саналаар шийддэг явахаар нийгмийн уур амьсгал, хүлээлт энэ юмыг

дагаж алхам алхмаар явсаар байгаад өнөөдөр бид нар яг ийм байдалд хүрчихсэн байж байгаа юм. Томоохон ялангуяа томоохон төрийн өмчтэй газруудын удирдлагад нь төрийн албаныхан, улс төрийнхөн ороод суучихсан. Маш энгийнээр бол өнөөдрийн одоо шуугиан тарьж байгаа асуудлууд яг энэнээс үүдэлтэй. Яам бодлогоо боловсруулна, Засгийн газар бодлогоо боловсруулна, яг гүйцэтгэх доор байгаа ажлуудыг нь агентлагууд хийнэ. Хэрэгжүүлэгч агентлаг, тохируулагч агентлаг, тэд нар нь бизнесээ дэмжээд явна гэдэг энэ юм өөрчлөгдсөөр байгаад одоо ийм байдалд хүрчхэж байгаа юм л даа.

Сая Цогтгэрэл гишүүн хэлж байна. Энэ ганцхан зүүний одоо үзэл баримтлалтай нам ингээд ийм байдалд хүргэчихсэн юм шиг. Бас тийм биш юм. Би улс төржиж байгаа юм биш шүү, манай одоо АН-аас сонгогдсон Ерөнхий сайд маань хүртэл энэ Засгийн газар, Ерөнхий сайд чинь юу ч шийдэж болдоггүй юм байна шүү дээ. Нэг хүн томилох эрхгүй байдаг юм байна. Энэнээс болоод ажил явахгүй байна гээд л ингээд гомдол гаргаж байсныг би маш сайн санаж байна. Тэгэхээр энэний цаад санаа нь юу вэ гэхээр яг нөгөө улс төрчид, төрийн албаныхан бизнест орохгүй бол болохгүй байна гэдэг юмаа, энэ санаа бас явж л байсан. Сайн санаж хэлж байсан байх гэж бодож байна энэ ажлаа явуулах гэж. Гэхдээ яг ийм хүчин зүйлүүд бөөгнөрсөөр байгаад тэгээд бид нар өнөөдрийн байдалдаа хүрчихсэн байх байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо бид нар энэ анхнаасаа тууштай явахгүй, эргэн дахин, дахин бодлогоо өөрчилж, ухарч буцаж байсныхаа л одоо хор уршигийг өнөөдөр амсаж байна л даа. Тэгээд бүр аргагүйн эрхэнд болоод яах аргагүй үнэхээр болохгүй юм гэдгийг дийлэнхээрээ ойлгоод эхэлж байгаа учраас, тухайлбал өнөөдөр Улсын Их Хурал дотор миний ойлгож байгаагаар энэ нээрээ болохгүй юм байна, цаашидаа энэ төр, улс төр, төрийн алба, мөнгө хоёрыг хооронд нь холбоогүй байлгахгүй бол болохгүй юм

байна гэдгийг нэг уур амьсгал давамгайлж ирж байгаагийн шинж энэ тогтоол гэж би ойлгож байгаа юм. Энүүгээрээ явах нь зүйтэй гэж бодож байна.

Зүгээр гишүүдийн санал дотор янз бүрийн юмнууд байна л даа. Нээрээ тухайлбал одоо ийм юм зайлиггүй төр яаж ч бодлогоор дэмжээд хувийн сектор хийдэггүй тийм зүйлүүд бий. Энэ юман дээрээ жоохон ялгаатай хандах хэрэгтэй. 2 тогтоол хамтраад хэлэлцье гэж байгаа юм байна. Тэрэн дотроос шаардлага байвал ийм, ийм зүйл, эсхүл төрийн алба хийх, хувийн хэвшил хийхгүй гэж байгаа зүйлүүдийг нь гэдгийг нь одоо зөв томъёолоод гаргаад ингээд явахад бол би бас болохгүй зүйлгүй гэж бодож байна. Ер нь ингээд буруу явдал бодлогын маань үр дүн юмнаасаа ухарч.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Цогтбаатар гишүүнээ дэмжиж байна. Та их сайн байна шүү. Бас ийм тогтоол өргөн бариад ингээд батлуулах гээд явж байгаа нь яг л хэрэгтэй л юмаа хийж байна л даа өнөөдөр ус агаар шиг хэрэгтэй ийм зүйлийг хийж байна. Шүгэл үлээгчийн тухай хуулийг та бас санаачлаад явж байсан. Энэ дээр чинь бол бас их сайн байна гэж танд хэлмээр байна. Гэхдээ бас сайд хийж байхдаа та дарамтад байхдаа бас нэг Шанхайн байгууллагад элсье гээд явдаг байсан. Тэр чинь одоо яг өөрийн чинь үзэл бодол биш байлгүй дээ, тухайн үеийн байдлаас л болж ингэсэн байх.

Би энэ хувийн өмчтэй холбогдуулаад та бодвол мэдээж хэрэг энэ тогтоолыг өргөн барихтай холбогдуулаад нэлээн зүйл энд тэндээс харж байсан байлгүй дээ. Үгүй ээ, 2 жилийн өмнө Баттулга Ерөнхийлөгчийг байх үед энэ Одонтуяа, Цогтгэрэл энэ тэр бөөнөөрөө нийлж зогсчоод л хувийн өмчийг хураая гэсэн ийм зүйл яваад байсан. Тухайлбал, МАК-ийн хөрөнгийг хураая энэ тэр гээд л. Тэр тогтоол шийдвэр, хууль хууль нь хаанаа

явдаг юм бол, хүчинтэй болсон уу, хүчингүй юу? Үнэт зүйл, үзэл баримтлалаасаа л урвасан л юм хийж байсан л даа, энэ нөхдүүд. Тэрүүгээр одоо цалин нэмье, тэтгэвэр тэтгэврийг нэмье, тэтгэврийн өрийг даръя гээд. Өмнө нь ч гэсэн одоо тэр гадаадын хөрөнгө оруулалттай ямар селвир ч билээ тэр компанийг одоо шүүхийн шийдвэргүйгээр Хятадуудын оролцоотой байна гээд л хурааж байсан, зодож нүдээд л. Энэ бол буруу юм байгаа шүү дээ. Хувийн хэвшил бүгдийг нь хийж чадна. Дайн хийхээс бусдыг нь. Үгүй ээ, сансарт нисэж байна шүү дээ өнөөдөр АНУ-д. Хувийн хэвшлийн чадахгүй, мэдэхгүй юм гэж байхгүй. Бас үнэ энэ нэг юм тодруулаад асуухад үгүй ээ, тэр 91 оны хуулиар гэв үү, энэ коммунист маягийн улсууд чинь тэр томилж байна шүү дээ. Хувийн 49 компанийн хувьцаатай тэр газарт. Иймэрхүү хуулиудыг одоо болиулах цаг нь болсон.

Одоо өнөөдөр Монгол Улсын эдийн засаг 20 хувь нь төсөв гээд явж байна. Тэр нь одоо 50 хувь, бараг төрийн өмчтэйгөө компанитайгаа нийлүүлж 60, 70 хувь, 40 их наядын Монгол Улсын жилийн ДНБ-ийг хулгайлчихсан байна. Тэгээд өчигдөр тэр Хууль зүйн сайд гэдэг нөхөр бараг л өмч хувьчлалыг буцаая ухааны юм ярьж байна лээ шүү дээ. Тэгээд яах юм, энэ иргэдийн одоо авсан орон байрыг буцааж хувьчлах уу, буцааж нийгэмчлэх үү. Тэр энэ малыг одоо АН-ын үед хувьчилсан энэ буруу юу, бас буцааж одоо нийгэмчлэх үү? Би одоо зүгээр иргэн Ганбат байхдаа ганзага хийж, гахай үүрч олсон мөнгөөрөө Хөрөнгийн бирж дээрээс хувьцаа авсан нь миний буруу юу? Нэг иймэрхүү юм ярьдаг энэ коммунистуудаа хэзээ болиулах юм бэ? Тэр Үндсэн хуулийн үзэл санааны эсрэг юм ярьж байна шүү дээ Хууль зүйн сайд чинь. Ганцхан би боломжтой байсан юм шиг. Монгол Улсын иргэд бүгдээрээ боломж байсан шүү дээ, хуулиараа бүгдийг нь нээж өгсөн шүү дээ. Тэгээд ийм зүйлийг энэ дээр яриад сууж байдаг ийм нөхдүүдтэй бас хариуцлага тооцмоор байгаа юм. Ийм л Засгийн газартай болчихоод байна шүү дээ бид нар.

Тэгээд энэ зүйлүүдийг дээр яримаар байна, хэлмээр байна, засмаар байна, энийг ч одоо шаардаж байна. Тэр одоо манай энэ Одонтуяа, Цогтгэрэл хоёрыг гараад очиход нь бол хөөж байна лээ шүү дээ жагсагчид бол. Та нар бол үнэт зүйл, үзэл баримтлалаасаа урвасан гээд. Энэ Ерөнхий сайдыг ч гэсэн шидэж байлаа шүү дээ, ажлаа хий гээд худлаа жагсаал хийлгэжээд дараа нь ажлаа хийсэн юм байхгүй, ингэж гарч ирлээ гээд. Ард түмний амьдрал муудчихсан байна гээд тэр лааз шидэж л байна лээ шүү дээ. Ард түмэн.../минут дуусав/

Г.Занданиатар: Хариулт байхгүй үг байна, тийм ээ? Дамдины Цогтбаатар гишүүн асуултад хариулъя.

Ш.Адьяа: Энэ Цогтгэрэл асуултад хариулах юм байна.

Г.Занданиатар: Хариулт.

Д.Цогтбаатар: Тэр хувийн өмч хурааа энэ тэрээ гэж байсан тогтоолыг бол би үнэндээ мэдэхгүй байна. Гэхдээ энэ тогтоолын гол санаа бол харин иймэрхүү юмнуудаа хэдүүлээ цаашидаа зогсооё. Нөгөө миний хэлээд байгаа гол санаа бол энэ чинь моратори гэдэг чинь түр хугацаанд үйлчлэх. Тэгэхээр зарим хүмүүсийн санаа зовоод ингээд эгнэгт ингээд хаачих гээд байгаа юм байх. Үгүй энэ чинь одоо яг хэлэлцэж байгаад түр хугацаанд хэдүүлээ тогтоогоод, энэний гол үр дүн нь яг саяын таны ярьсан шиг ийм сэтгэхүй дээр суурилж, олон түмэн сонсоход нэг их гоё юм шиг, тэд нарын төлөө яриад байгаа юм шиг мөртөө эцсийн дүндээ тэд нарыг яаж хорлодог вэ гэдгийг одоо болж байгаа үйл явдал харуулж байгаа байхгүй юу. Ард түмний нэрээр өмчлөөд байгаа юм шиг боловч тэдний нэрээр хэдхэн хүн хулгайлаад явчих эрсдэл байдгийг энэ систем харуулж байгаа юм. Тэгээд энэ мораторийн гол санаа нь яг энийгээ ойлгооч, би нөгөө хамгийн гол эцсийн дүндээ хүрэх үр дүн бол толгойдоо байгаа энэ сэтгэлгээг л өөрчлөх хэрэгтэй. Толгойд

байгаа сэтгэлгээ өөрчлөгдөөгүй цагт шинэ, шинэ уран бүтээл хуулиуд гарсаар л байх болно. Хүн яг тухайн үедээ ингээд сонсоход нэг их гоё сонсогдоно, нэг их олны төлөө хийж байгаа юм шиг. Тэгтэл тэр нь эцсийн дүндээ олны төлөө биш, харин тэр хүмүүсээ ядууруулах, орлогогүй болгох ийм л тогтолцоог өдөөгөөд байгаа. Тэгэхээр энийг л яг одоо тэр зөв сэтгэлгээ рүүгээ, зөв голдирол руугаа бид нар тууштай буцаад орох ёстой л гэдэг энэ санааг юу гаргаж байгаа энэ юу тогтоол л доо.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн нэг минут тодруулъя.

Д.Ганбат: Баярлалаа Цогтбаатар гишүүнээ. Яг таны наад ярьж байгаа зүүний намын талаас сонгогдсон гишүүн гэхэд бол яг ус агаар шиг хэрэгтэй зүйлийг та ярьж байгаа байхгүй юу. Ингэж ярьснаараа та хариулт өгснөөрөө энэ ард түмний бодол, сэтгэлгээ энэ тэрийг бол бас өөрчилж байгаа. Зарим нэг төөрөлдсөн улсуудыг. Жишээлбэл, ОХУ гэхэд одоо тэр Путины дэглэмийн үед тэр н... орчихсон, бүр одоо 70 хувь нь хэвээрээ л байна шүү дээ тэр дайн хийхийн төлөө, тэр бусдын газар нутаг руу явахын төлөө. Европын холбоо тэрийг чинь террорист улс гээд зарлачихлаа шүү дээ. Үгүй ээ, энэний чинь эсрэг одоо ганц нэг хүн дуугардаг л байх ёстой. Би л ганцаараа дуугарч байна лаа шүү дээ, би л ганцаараа цалингаа хандивлаж байлаа шүү дээ. Тухайн үед л бүгдээрээ намайг үзэн ядаж байсан улс орноороо шахуу. Үгүй ээ, одоо нөхцөл байдал зөв юм болохоор ингээд өөрчлөгдөж байгаа биз. Яг таны наадах чинь зөв байхгүй юу. Бүгд одоо дараа нь алга ташаад л маш сайн байна л гэнэ, ийм л.../минут дуусав/

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Цогтгэрэл, Цогтбаатар нарын өргөн мэдүүлсэн энэ хуулийн тогтоолын төсөл бол үнэхээр өнөөдөр энэ гуч жилийн төрийн өмчийн компаниудын гажуудлыг засах ийм ач

холбогдолтой ийм тогтоолын төсөл байсан. Их удаж байж орж ирлээ. Олон нөхцөл байдал байсан байх. Тэгэхдээ энэ Монголын төр зах зээлийн системд шилжсэнээс хойш одоо гуч гаруй жилийн хугацаанд төрийн өмчид тулгуурласан, орон нутгийн өмчид тулгуурласан олон ийм төрийн өмчийг идэж уух боломжоор хангасан ийм компаниуд гарч ирсэн. Энэ бол зөвхөн энд байгаа асуудал биш. Төр барьж байсан бүх намууд байсан асуудал, ялсан намын үеэ өнгөрөөсөн улс төрчдийн амралтын газар болдог. Ялсан намын цүнх баригчид, залуучуудын дамжаа болдог. Улс төрчдөд нөлөө бүхий компаниудын мөнгө угаадаг схем, хулгай луйвар хийдэг хөрөнгийн бирж болсон шүү өнөөдөр. Энийг хатуу хэлэх ёстой. Энэ дээр бид зарчмын өөрчлөлт хийх ёстой.

Зах зээлийн эдийн засагт шилжсэн л юм бол тэр зарчмаар явах ёстой, тэр зарчмаар явах ёстой. Үнэхээр ТӨК тэр ард түмний, нэн ялангуяа энэ байгалийн баялагтай холбоотой тэр Үндсэн хуулийн 6.2-т байх үндэсний баялагтай холбоотой ийм одоо ТӨК-ууд өнөөдөр Монголчуудыг Монголын төрийг ямар байдалд оруулчихаад байна. Бид өнөөдөр нийгмээрээ, улс орон даяараа энийг бид шүүмжилж, гасалж, зэвүүцэж, эсэргүүцэж байна энэ ард түмэн. Энэ зөв. Гэтэл энэ бид дүгнэлт хийж, цаашид ийм асуудал гаргахгүйн төлөө, цаашид ийм төрийн өмчийг иддэг, уудаг, ашигладаг улс төрчдийн түүний хамаарал бүхий компаниудын баяждаг ийм схем байж болохгүй. Энийг одоо маш зоригтой зүйл хийж, манай Их Хурлын хэд хэдэн гишүүд энэ тогтоолын төслийг оруулж ирсэн. Надад энд асуух асуулт байхгүй, би дэмжиж байгаа учраас яагаад дэмжих гэж байгаа гэдгийг бас энийг хэлж байгаа юм.

Энэ тогтоолын төслийг бид ул суурьтай, судалгаа дээр тулгуурласан энэ асуудлыг шийдэх ёстой. Төрийн өмч байвал яах юм байхгүй бол яах юм. Тэр Хөрөнгийн биржээр олон нийтийн мэдэлд байдаг, олон нийтийн хяналтад байдаг тэр төрийн өмчийн компанийн засаглалыг бид энд

сайжруулах энэ анхны гарц гэж үзэж байгаа. Энэ олон бэрхшээлтэй, олон эсэргүүцэлтэй тулгарч байж орж ирсэн. Энэ дээр үндэслэж бид энэ Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд ч гэсэн энийг бид өнөөдөр энэ зах зээлийн зарчим, чөлөөт эдийн засгийн бодлого, компанийн засаглалын зарчмыг бид барьж, бодлогоо тодорхойлж байж өнөөдөр Монгол Улс эдийн засаг нь эрүүл байх, төр нь одоо аливаа асуудалд орооцолддоггүй байх, ард иргэд нь баян байх, хүн бүхэн энэ байгалийн баялгаас хүртэх энэ чөлөөт зах зээлийн энэ зарчмыг.../минут дуусав/

Г.Занданишатар: Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе. Би Цогтбаатар гишүүн нарын оруулж ирсэн энэ тогтоолын төслийг бол дэмжиж байгаа юм. Тэгээд асуудал, хулгай, хуйвалдаан, улс төрийн томилгоо, хамаарал хаана байна, төрийн өмчийн компаниуд дээр байна. Тэнд асуудлууд бугшиж, бугшсанаараа өнөөдөр нийгэм тэсэрч байна л даа. Ийм нөхцөл байдалд байхад даахгүй нохой булуу хураана гэгчээр ахиад л төрийн өмчийн компаниуд байгуулах асуудлууд явж байгаа. Тухайлах юм бол Эрдэс Монгол гээд. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ТӨК-ийн жилийн орлогын 2 хувь буюу жараас дал орчим тэрбум төгрөгийг менежментийн зардалд энэ одоо групп авна гээд л явж байх жишээтэй. Тэгээд ийм байж болох юм уу? Энэ одоо ямар ч үйл ажиллагаа явуулдаг компани юм, хэзээ байгуулагдаж байгаа юм, ямар одоо хүмүүс тэр удирдлагад нь сонгогдож байгаа бүү мэд. Ийм асуудлууд үүсгэсэн, нийгэм бүхимдалтай байхад бид нар ахиад шинээр компани байгуулж байгаад түүндээ жар, далан тэрбум төгрөг зарцуулаад явна гэдэг бол өнөөдрийн цаг үеэ олоогүй байдлын шинж юм.

Тэгэхээр бид нар энэ тогтоолын төслийг дэмжих хэрэгтэй харин. Харин энэ тогтоолын төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжих ёстой юу, үгүй юу гэдэг дээр

ярилцаж, санаачлагчаас бол асуулт асууя. Хугацаа тавьж өгөх боломж байгаа юу гэж? Хугацаа тавиад энэ хугацаандаа харин төрийн болон орон нутгийн өмчийн компаниудтай холбоотой асуудлууд цэгцэлж дуусах хэрэгтэй бид. Шалгаж ямар асуудлууд хаанаа байгаа юм, тэрийг нь ил гаргаж тавьдаг, хариуцлагыг нь тооцдог, цаашилаад олон нийтийн оролцоотой компани болох боломжуудыг нь нээж өгдөг, тэрийгээ ажил хэрэг болгох энэ ажлуудыг энэ хугацаанд хийх хэрэгтэй. Ингэснээрээ бид нар энэ орон нутгийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн менежмент, засаглалыг сайжруулж чадна, илүү хяналттай, илүү том, одоо эдийн засгийн боломжуудыг бас гаргаж ирнэ гэж одоо харж байна. Тэгэхээр энэ тал дээр одоо бид бүхэн бас анхаарах шаардлага болчихсон юм. Энэ бол цаг үеэ олсон зөв тогтоолын төсөл байгаа. Энийг одоо бид бүхэн дэмжих ёстой шүү гэдгийг та бүхэнд бас хэлье. Баярлалаа.

Г.Занданишатар: Цогтбаатар Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ яг нөгөө моратори гэж байгаа утгаараа хориг арга хэмжээ учраас хугацаатай. Харин энэ хугацаагаа бол яг одоо Их Хуралдаа бас яг хэлэлцэх явцдаа аль нь оновчтой вэ гэдгийг хэлэлцэж шийдье л гэж байгаа юм. Таны яг хэлж байгаагаар энэ хугацаанд харин нөгөө цэгцлэх ажлуудаа, болж байгаануудыг нь олон нийтийн болгож хувьцааг нь гаргах ажлууд энэ бүгдийг хийхээр энэ юундаа тогтоолын төсөлдөө зааж өгсөн байгаа юм. Тэгээд амьдрал баян, нээрээ цаашаа ингээд үргэлжлээд түрүүн зарим гишүүдийн ярьж байгаа шиг гэнэт зайлиггүй одоо байгуулах хэрэг эд нар гардаг юм бол тэр үедээ энэ хугацаагаа дуусгаад, тэгээд энийгээ цаашаа үргэлжлүүлэхгүй явж болно. Тэгэх юм бол угаасаа нөгөө суурь сэтгэлгээ суучихсан байна. Юм л бол төрийн компани гээд байхгүй. Гэхдээ зайлиггүй үедээ байгуулаад ингээд явж болно. Эсхүл тэр үедээ нөхцөл байдал бүрдээгүй бол мораторио ахиад сунгаад явчхаж болно.

Тэгээд энэ асуудлуудыг бол анх ингээд дэвшүүлээд л явж байхдаа Занданшатар даргатай спикертэй бол нэлээн ярьж зөвлөлдөж, ингэж явж байж энэ моратори хэлбэрээр ингэж явах нь бол бас зөв юм байна. Тэгээд үнэхээр бас төр л бол муу гээд л ингээд л давхиж ирээд л цавчаад байгаа биш, одоо болно. Төр ямар л төрлийн ажил үйлчилгээ хиймээр байна тэр бүх төрлийнх нь компаниуд аль хэдийн байгуулчихсан байхгүй юу. Барилга бол барилга, Тоск, Носк гээд л байж байна. Банк бол одоо сая ингээд л Хөгжлийн банк гээд, харамсалтай нь одоо асуудал нь ийм болоод л гарч ирж байна. Байж л байна гээд, өөрөөр хэлбэл тэгээд уул уурхай, хөрөнгө оруулалтын гэх юм бол маш том holding компани байна. Тэр бол ямар ч төрлийн ажлыг цаашаа удирдлагаар хангаад, эсхүл удирдлагад нь оролцоод явах боломж байгаа байхгүй юу.

Тэгээд яг таны хэлж байгаагаар энийг цэгцлэхгүй бол ил гарч байгаа нь л энэ шүү дээ. Хөгжлийн банк одоо ингээд л юу нүүрсний хулгай гээд л. Цаашаа явбал энэ төрийн өмчит бүх компаниуд дээр ухлаа ийм юм л гарч ирнэ. Тэгэхлээр энийг бол энэ үүднээсээ л харж, ер нь ямар ч гэсэн энэ тогтоолыг батлах нь зөв юм байна гэж үзсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүн байна уу? Алга. Раднаасэд гишүүнээр. Тэмүүлэн гишүүнээр тасаллаа.

Ш.Раднаасэд: Уул нь энэ Төрийн өмчийн хорооныхон байсан бол хэлэх юм байна. Одоо энэ Хөгжлийн банк, аливаа банкнууд дээр зээлийн барьцаанд хураагдсан гэдэг юм уу, эсхүл тэр зээлдэгчтэй тохирч болохоор өмч хөрөнгүүд байна. Энийг одоо хэн зохицуулдаг вэ? Өнөөдөр энэ хавдрын эмнэлгийг та нар оч, би одоо сүүлийн арваад хоног тэрүүгээр явж байна. Тэр эмнэлэг дээр өнөөдөр хүн үзүүлэх, өвчтэй хүнд үзүүлэх, үйлчлэх тийм боломж бололцоо ерөөсөө бүх юм нь дууссан байна.

Үнэхээр хүнд байна, жинхэнэ ард иргэд чинь тэнд зовж байна. Энэ нүүрсний хулгайчид нь энд жаргаж байхад. Тэгээд одоо тэр Хөгжлийн банкны барьцаанд байгаа гэх юм уу, Хөгжлийн банкны зээлдэгч Билэгт гишүүний нэг 2 эмнэлэг байгаа юм байна. Нэг эмнэлгийг нь Хөгжлийн банкныхан зээлд нь тооцоод ч юм уу, тэрэнд нь одоо үнэлгээ хийгээд зохих хувьд нь тооцоод ч юм уу, ийм авах боломжийг одоо хэн зохион байгуулах ёстой вэ? ЭМЯ зохион байгуулах ёстой юу, Төрийн өмчийн хороо зохион байгуулах ёстой юу, эсвэл энэ Хөгжлийн банк өөрөө зохион байгуулах ёстой юу?

Өнөөдөр бид нар яах вэ, ингээд хуулийн этгээд байгуулж болохгүй гээд ингээд гаргачхаж байна. Маргааш зайлиггүй шаардлагаар байгуулах бол яах вэ жишээлбэл? Энэ амьдрал чинь өдөр болгон өөрчлөгдөөд байна шүү дээ. Өдөр болгон хөдлөөд байна, маргааш юу болохыг хэн ч мэдэхгүй. Тэгээд энэ зүйлүүд дээр их уян хатан байдалтай хандахгүй бол ингээд хатуу хаагаад зогсоогоод хаячих юм уу, үгүй юу? Ер нь энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай холбоотойгоор төрийн болон орон нутгийн өмчит, ялангуяа энэ сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газар дээр хууль зөрчиж баригдсан бүх барилгыг төрийн өмчид авах хэрэгтэй. Энэ дандаа л хулгайн мөнгө байгаа шүү дээ яг ярих юм бол. Дандаа л газраас нь хулгай хийж, энэ Улаанбаатар хотын төвөөр баригдаж байгаа энэ өндөр, өндөр карказууд дандаа л нүүрсний хулгай, газрын баялгийн мөнгө шүү дээ. Тэгээд нэг сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэсэн сул байгаа газрууд дээр нь очоод барьчихсан. Энэ юмнууд энэ тогтоол юм уу, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дотор хийх энэ Газрын хууль дээр бас давхар хийх юмнуудыг хийх, явуулах, явуулахгүй бол энэ нөхцөл байдал чинь ерөөсөө хүнд байна шүү. Энэ захын хорооллууд, энэ эмнэлгүүдээр энэ Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд орооч, орооч. Энэ хавдрын эмнэлэг, тэр Эх нялхсын төвөөр очооч. Тэнд чинь хүмүүс үзүүлэх юм нь

битгий хэл орж чадахгүй байна шүү дээ тэр чинь. Хөл тавих зайгүй байна шүү дээ.

Энд ингээд нэг компани, энд тэндхийн юмнуудын эрх ашгийг хамгаалсны янз янзын тогтоол хууль батлаад сууж байхаар тийм газруудаар очиж асуудлыг бодитойгоор шийдмээр юмнууд зөндөө байх юм. Би одоо энэ эмэгтэй гишүүдэд уриалмаар байна. Та нар үнэхээр энэ өвчтэй зовлонтой хүмүүст нигүүлсэнгүй хандъя гэвэл энэ асуудлыг нэг барьж аваад яваач. Тэр хавдрын эмнэлэг дээр нэг өдөр оч л доо, яг ажлын өдөр, өглөөгүүр. Ямархуу орчин нөхцөлд хүмүүс байна, яаж амьдарч байна тэнд. Очоод тэр Хөгжлийн банк, тэр Билэгт гишүүн ч гэсэн гишүүн байсан эмэгтэй хүн бас. Хөгжлийн банкныхны, ЭМЯ-ныхны, Эдийн засгийн хөгжлийн яамныхны бүгдтэй нь та нар уулзаад, та нарт боломж байгаа шүү дээ. Ингээд нэг ч болтугай ашигтай юмыг нь ард түмэнд хийж өгье л дөө, хэдүүлээ. Энэ зовлонг өөрөө биеэрээ туулсан хүмүүс л энийг мэдэж байгаа. Хүн болгон тэгж зовлонгоо гаргаж яриад байх боломж байхгүй. Тэр хавдар дээр байгаа хүн болгон та нартай уулзаад байхгүй байх, бодвол юм сонсдог л байх.

Г.Занданиатар: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Энэ тогтоолын төслийг бидний хэсэг гишүүд нэлээн эрт ярьсан юм. Тэгээд ярьж байгаад оруулж ирээд одоо хагас жилийн дараа ямар ч байсан батлагдах гэж байх шиг байна, цагаа ч олж байх шиг байна. Нүүрсний хулгай гээд том асуудал нийгэмд үүсээд, бид нар яриад л байсан, яриад л байсан, арай гэж л нэг юм задарч байх шиг байна. Ер нь тэгээд одоо энэ асуудлыг бид нар зөвхөн нэг компанитай, нэг хэсэгтэй, нэг эдийн засгийн нэг сектортой уяж хараад байгаа, хараад ерөөсөө явахгүй байхгүй юу даа. Бид нар хэдэн хүн аваачиж шоронд хийгээд энэ асуудлыг шийдэж чадахгүй. Энэ бол зүгээр л нэг одоо урхаг өвчнийг үлдээгээд л, ил гарч байгаа хэсгийг нь дараад л дуусна. Эрдэнэс таван толгой

компанийн түүхийг хар л даа, бүх гүйцэтгэх захирал нь шоронд орж байна шүү дээ. Өчигдөр бид нар энэ зарим гишүүдийг энд очсон хүн болгон явна гэж хэлээд байхад дооглоод суугаад байсан. Үнэн байхгүй юу. Засаглал нь болохгүй, хяналт байхгүй, Их Хурлаас илүү эрх мэдэлтэй. Та нар зүгээр нэг тоо сонс доо.

Монгол Улсын 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн, гадаадын зээл тусламжтайгаа нийлээд 3.5 их наяд. 3.5 их наяд төгрөгийн төсвийг бид нар энэ Их Хурал дээр 76-лаа хэрэлдээд, хэлэлцээд бүтэн 2, 3 сар хэлэлцэж байж нэг юм баталдаг. Гэтэл Эрдэнэс таван толгой компанийн 2023 оны хөрөнгө оруулалтын дүн хэд гээч 4.2 их наяд. Ганцхан жилийн хөрөнгө оруулалтын төсөв шүү дээ. Тэгээд энийг хэн баталж байгаа гээч хэдхэн хүн ард түмний мандатгүй. Эндээс хулгай явна шүү дээ, явахгүй яах юм. Энийг төсөв болгоны үеэр манай энэ залуу гишүүдэд энэ эдийн засаг ойлгодог хүмүүс бүгдээрээ л хэлдэг шүү дээ. Татвар хураамжийг нь авч орж ирээд тэр санхүүжүүлэх гээд байгаа том төсвүүдээ Их Хурал дээрээ ярьж байгаад шийдье, ард түмний нүдэн дээр шийдье гэж зөндөө л ярьсан шүү дээ.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл орж ирж байгаагийн үндсэн санаа нь бол ерөөсөө л энэ. Ард түмний мандат аваад, олон түмний нэрийн өмнөөс ажиллаж байгаа бол энэ улсад байгаа бүх юмыг л бид нар харж ярих ёстой. Олон улсын байгууллагууд ч гэсэн зөвлөдөг шүү дээ. NRG1 гэж natural resource governance institute буюу Байгалийн баялгийн засаглалын олон улсын хүрээлэн гэдэг байгууллагаас манай Засгийн газар зөндөө л зөвлөгөө авсан байдаг юм. Эд нар дандаа ямар зөвлөгөө өгдөг вэ гэхээр төрийн өмчийн компаниудаа цэгцлээч уул уурхайн. Улсын төсвөөс чинь том төсөв тэнд шийдэгдээд байна, энийгээ болиоч гэдэг зөвлөгөөг үргэлж л өгсөн байдаг байхгүй юу. Зэрэгцээ төсөв гэж нэрлэдэг. Би одоо бас энийг судалж явдаг учраас. Дэлхийн бүх улс орнууд байгалийн баялагтай ялангуяа

улс орнууд бүгдээрээ яг энэ замаар яваад, бүгдээрээ хулгай зэлгээдээ эзлэгдээд, хувьсгал нь болоод, дарга цэрэг нараа сольцгоогоод ингээд л явж байгаа.

Төрийн компаниудаасаа салж чадсан улс орнууд нь хөгжсөөд явж байгаа. Норвег ч гэдэг юм уу, одоо бүр ил тод, засаглал нь сайн байгаа улс орнуудтай бид нар өөрсдийгөө харьцуулах бол бас хол. Уул уурхайн компаниуд төрийн өмчийн байгаад амжилт олсон дэлхий дээр 2, 3-хан л жишээ байгаа. Бид нар чадахгүй шүү дээ энийг, болоогүй, бид нар чадахгүй. Тэгэхээр олон нийтийн хяналтад нь оруулах хэрэгтэй. Төр авлаа гэхээр зэрэг Их Хурлын гишүүд нь ч, ард иргэд нь ч гэсэн алга таидаг. Болохгүй байгаа юмыг авалгүй л яах вэ. Гэхдээ буцаагаад ард нийтийн хяналтад оруулж, листэд буюу одоо хөрөнгийн бирж дээр гаргаж, олон нийтийн хяналтад оруулдаг системийг зайлшгүй хийх ёстой. Энэ тогтоол цаашаа ингээд хэрэгжээд явах ёстой юм. Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайд Их Хуралд үг хэлж танилцуулахдаа энэ төрийн өмчийн компаниудыг олон нийтийн нээлттэй компани болгох багц хуулийн төсөл удахгүй өргөн барина гэж байна. Энэ бол их зөв алхам шүү. Тэгсэн, тэгэхээр одоо бид нар өнөөдөр би энэ гишүүдээсээ хүсэх гэж байгаа зүйл бол энэ тогтоолын төслийг элдэв эргэлзээгүйгээр баталж өгөөч гэж хүсье. Баярлалаа та бүхэн.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Миний хувьд бол энэ өргөн барьсан гишүүдийн нэг нь ингээд энэ дэмжиж байгаа. Тэгээд ер нь төрийн өмчтэй компани бол одоо цаашидаа бас байгуулах шаардлага гарвал яах вэ гээд зарим гишүүд нь бас асууж байх шиг байна. Ер нь төрийн өмчтэй компаниуд бол цаашидаа байгуулах бараг үндсэндээ шаардлагагүй. Та нар бүхэн мэдэж байгаа, сая төрийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гарсан, 7 сарын 1-нээс хүчин төгөлдөр болно. Хувийн хэвшил бол хангалттай, одоо энэ төр бол бүр

илүүдчихсэн явж байгаа, хийж байгаа юм нь бол. Тэгэхээр бол яах вэ энэ тухайн үедээ онцгой нөхцөл байдал үүсээд гараад ирэх юм бол энийг Их Хурал дээр цөмөөрөө ярь л даа бид нарт мэдэгдэхгүй өчнөөн юм байгуулчихсан байдаг, бүгдээрээ энэ ард түмний төлөөлөл юм бол эндээ ярьж байгаад шинээр гарцаагүй байгуулах шаардлагатай бол гээд л эндээ байж байгаад л ярь л даа. Ийм байгаа юм. Тэгэхээр тэрэн дээр бол нэг тийм заавал нээх бололцоог нь үлдээнэ биш, ингээд хааж аваад, тэгээд цаг хугацаагаа тавьж байгаад, тэгээд бид нар бас нэг өөрсдийнхөө хяналтыг алдахгүй байх нэг ийм боломж олгож байгаа тогтоол гэж ойлгож байгаа.

Эцэст нь нэг асуудал бол ер нь бид нар энэ нэг хувийнхаа хувийн хэвшлийнхнийгээ энэ хувийн хэдэн компани ер нь баяжчих вий гэж их айдаг хүмүүс бас байх шиг байгаа юм. Ер нь эдийн засгийн бодлого бол энэ хувийн хэвшлийнхэн ч бай, хувьсгалынх ч бай компаниудаа чадал оруулах, цаашидаа өөр бусад цаашидаа өөрсдөө хөрөнгө оруулалтаа хийгээд явах, дахиад томрох, энэ бололцоог нь хангах чиглэлтэй л байх ёстой. Манайхан энэ компаниудаа бол харин ч чадал оруулахгүй, тэгээд одоо бага дээр нь бараг төлөг болоогүй байхад нь нухаж идчихээд байна шүү дээ. Малаа хүртэл энэ чинь таргалуулж байж, нас бие гүйцээж байж тийм ээ, махны гарцыг нь сайжруулж байж бид нар чинь муулж иддэг шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ хувийн хэвшлийнхнээ баяжих вий гэхээс их айдаг бол одоо төр, төр байх юм бол бид нар цаашидаа хөгжихгүй, ийм л чигээрээ байна. Тэгээд л нэг төрийн хэдэн компани байгуулж очиж хулгайгаа хийгээд л. Хувийн хэвшлийнхэн хэрэв баяжих юм бол тэрнийг чинь нууж хаахгүй, эндээ хөрөнгө оруулалт хийнэ. Одоо бусад салбар руу орно, хөрөнгө оруулалтаа нэмнэ.

Төрөөс хулгайлагчид бол бүгд аваачиж оффшорт нууна. Казахстанд аваачиж байшин барина, Орост байшин худалдаж авна, одоо баруунд хаана ч

байдаг ч юм тийм ээ. Тэгээд бид нар Монголын ард түмэнд татвар хэлбэрээр ирж өгөөжөө өгдөггүй, тэр сайхан байшин барилга баригдаад одоо сайхан үйлчилгээний салбар байгуулчихвал хүмүүс орж үйлчлүүлнэ, тэр үйлчилгээг ч авч чадахгүй, ийм л хор хөнөөлтэй юм болох учраас хувийн хэвшилүүдээ бол бид нар тэгж дэмжихээс нэг айгаад байх юм хэрэггүй. Эдийн засгийн бодлого ч тэр чиглэл рүү явах ёстой юм байгаа юм шүү. Тийм учраас энэ тогтоолыг бид нар нэг их олон юм ярилгүй, одоо тэгээд дэмжээд явчих ёстой. Эрт өргөсөн, харин ч явж, явж энэ цаг үед гарч ирээд өнөөдөр бас энэ Биржийн хуульд явж байгаатай адилхан, энэ Эрүүгийн хууль явж байгаатай адилхан, ингээд бас одоо ард түмний энэ хүсээж байгаа хүсэлт, шаардаж байгаа шаардлагад одоо нийцэж байгаа ийм л хууль тогтоол гэж ойлгож байгаа юм.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Бид нар энэ тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Энэ тогтоолыг бид нар даруйхан шуурхай батлах ёстой. Өнөөдөр үндсэндээ Монголын нийгэмд нүүрлээд байгаа энэ хулгай бол өнөөдөр яг үндсэндээ энэ нийгэмд нүүрлээд байгаа энэ өнөөгийн нийгэм идээ бээр л гэж харж байгаа. Энэ бол энэ Монголын төрд нүүрлэхсэн өвчин эмгэг гэж хараад байгаа юм. Тэгэхээр аливаа өвчин эмгэг, аливаа буруу гажууд зүйл байгаа бол бид нар тэрийг таслан зогсоох ёстой, цэг тавих ёстой. Сүүлийн 20 жил бид нар дэлхийн стандартаас зөрсөн, олон улсын стандартад байхгүй ийм компаниудыг хөгжүүлэх гэж, бий болгох гэж өчнөөн оролдсон. Компани гэж юу юм бэ. Энэ бол нэгдүгээрт, энэ ашигийн төлөө ажиллах ёстой, энэ арилжааныхаа зарчмаар байх ёстой, зах зээлийнх нь зарчим зарчмын дагуу хөгжих ёстой. Компанийн засаглалыг тэндээ бий болгох ёстой. Ингэж байж бид бүхний тэр хүлээгээд байгаа тэр баялгийн санг чинь өнөөгийн нийгэмд бий болгож, өнөөгийн бид нарын хүлээгээд байгаа тэр орлогын

хуваарилалтыг чинь ард нийгэмд бий болгож, ингэж байж эдийн засагтаа хувь нэмрээ оруулах ёстой.

Ийм зүйлийг бий болгож чадахгүй юм бол алдагдалтай байгаа, өр зээлтэй байгаа, хулгайн нүүрсний компаниудыг бид нар өнөөдөр цэг тавих цаг нь бол боссон гэж бол би хараад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ одоо бол цаашидаа бид нар нэг их энэ компани байгуулах гэж, төрийн өмчийн компаниудыг бий болгох гэж тэд нарыгаа компани гэж нэрлээд ч хэрэггүй. Ерөөсөө энэ нийгэм бол цаашидаа хувийнхаа хэвшил дээр тулгуурласан, либерал байдлаар, чөлөөт зах зээлийнх нь зарчмаар хөгжих тэр үндсийг л бид нар бий болгож өгье. Өнөөдөр нэг бий болчихсон байгаа компаниудаа хувьчлаад илүү хувийн хэвшил хөгжих энэ боломж бололцоог нь орон зайг нь бид нар бий болгох зайлиггүй шаардлага бол байна гэж бол хараад байгаа юм.

Тэгэхээр үүний гарц шийдэл бол энэ тогтоол. Өнөөдөр бий болчихсон компаниудыг бид нар ХК-ууд бий болгох, хөрөнгийн биржээр арилжаалах, илүү хувийн хэвшилээр тулгуурласан энэ орон зайг бол энүүгээрээ бий болгоё гэж байгаа юм. Дээрээс нь энэ тогтоол дээр нэмж тусгах ёстой зүйл байгаа шүү Цогтбаатар гишүүнээ. Энэ юу вэ гэхээр илүү цаашид бий болчихсон компаниуд илүү цаашид энэ хувьчлагдах хүртэл хугацаандаа төр болоод төсөвт, төсвөөс гадуур ямар нэг санхүүжилт хийхийг илүү нэмж хориглох заалт оруулах шаардлагатай байгаад байгаа юм. Илүү нэмж хориглох заалт байгаа. Элдэв хандив өгөхийг нь, дэмжиг тусалцаа үзүүлэхийг нь, төсвөөс гадуур санхүүжилт хийхийг нь, төсөвт төвлөрүүлэхийг нь энийг хориглох заалт зайлиггүй шаардлагатай байгаа. Ингээд цаашидаа одоо бүгдийг нь хувьчлаад ХК-ууд болгоод, олон нийтийн оролцоотой болгоод олон нийтээс хамааралтай болгоод, хамгаалалттай болгоод, дархлаатай болгоод бид нар цаашид хувийн хэвшил дээрээ тулгуурласан зах зээлийг хөгжүүлбэ. Энэ үндсэн дээр энэ тогтоолын төслийг бол бид нар дэмжих ёстой. Илүү

сайжруулаад явах ёстой. Хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх ёстой гэж харж байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүн суудалдаа суугаарай. Тэгээд, ер нь ингээд гишүүд бас нэлээн зарим нь эсрэг үг хэлсэн, тэгэхдээ одоо хэлэлцэх эсэхийг нь дэмжчихээд, тэгээд Цогтбаатар Цогтгэрэл гишүүнийхтэй нийлүүлээд, дээр нь тэрэн дээр хувийн хэвилийг дэмжих агуулга ороод хувийн өмчийг хураадаг, цагддаг, хорьдог юмыг цэгцлэх санаануудаа оруулаад энэ өмчийн эрх зүйн юмаа улам тодорхой болгохыг хараад, энэ чинь Үндсэн хуулийнхаа нөгөө нийтлэг зарчимд нийцүүлээд өмч, хувийн хэвилийг дэмжих, хамгаалах, эдийн засгийн либералчлалыг дэмжих, төрийн өмчийн үр ашгийг сайжруулах гээд нэг цогц болгоод гаргачихвал бол зөв байх гэсэн саналуудыг гишүүд хэллээ. Энэ саналыг дэмжиж байна. Ингээд Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Ингээд Цогтгэрэл гишүүний бас тэр тогтоол хуулийн төслийг нэгтгэж хэлэлцэх чиглэлд ажиллая. Энэ Эдийн засгийн байнгын хороо маш их ачаалалтай болж байна шүү, тэр

Стандартчиллын хуулиа тийм ээ, Зөвшөөрлийн хуулиа одоо оноос өмнө гаргаж, бас энэ эдийн засгийн либералчлалын чинь нэг том хөшүүрэг хууль маань бас удааширч байгаа. Дараагийн асуудалд орно. Эрүүгийн хууль дуусаагүй юу.

12.17 цагт

Гурав. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль зүйн байнгын хороо боловсруулсан/

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашидондогийн Ганбат танилцуулна.

Д.Ганбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01, 1667 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай саналыг ирүүлсэн болно. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ болон нэмэгдэл олгох журам, шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу ХЗБХ тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийг хэлэлцлээ.

Шүүхийн ажлын ачааллыг тэнцвэржүүлснээр хэргийг хурдан шуурхай

шийдвэрлэх нөхцөл бүрдэх төдийгүй, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд бодит үр дүнгээ үзүүлнэ гэж үзсэн учраас Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно. Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийг 24-өөр нэмэгдүүлж, зарим аймгийн Сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх, сум дундын шүүхийн шүүгчийн 24 сул орон тоог хасахаар боловсрууллаа. Сул орон тоог шилжүүлж байгаа буюу шүүгчдийн хөдөлгөөн хийгдэхгүй байх учраас зардал гарахгүй. Шүүгчийн нийт орон тоо нь тооны хувьд өөрчлөгдөхгүй, шүүгчийг шилжүүлэх, чөлөөлөх асуудал үүсэхгүй юм.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан орон нутгийн шүүхийн орон тоог хасаж, хотын шүүхийн орон тоог нэмж байгаа шалтгааны талаар. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил тогтоолын төслийг боловсруулахдаа нэг шүүгчид оногдох хэрэг маргаан, тогтоол, шийдвэрийн тоонд үндэслэн шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлж байгаа хэдий ч хэлэлцэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг харгалздаг байх, түүнчлэн аймгуудын шүүгчийн сул орон тооны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат нэг шүүгчид оногдох ажлын ачааллыг улсын тэмдэгтийн хураамж төвлөрүүлж байгаагаар нь тодорхойлж болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй хамт тогтоолын төслийг боловсруулах боломжтой байсан эсэх, дутуу орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын хугацааны талаар, мөн шүүхийн байрны асуудал, ажиллах орчин нөхцөлийг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Шүүх байгуулах тухай хуулийн төслийн талаар Улсын дээд шүүхтэй зөвшилцөх болон Засгийн газарт хүргүүлэх ажлын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэхтэй холбоотойгоор орон

тоо нэмэгдэх эсэх болон Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй уялдаж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Шүүх байгуулах тухай хуулийн төслийн явц, шүүхийн шинэчлэлийн асуудал, шүүхийн хэргийн ачааллыг тэнцвэржүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шүүхийн байрны асуудлыг шийдвэрлэх, түүнчлэн тодорхой хөтөлбөр гаргах дээр ажиллаж байгаа талаар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат нар Чингэлтэй, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүгчийн орон тоог нэмэх талаар санал гаргасан саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, тогтоолын төсөлд тусгасан болно. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. ШЕЗ-ийн дарга Зүмбэрэлхам, Дорждамбын Зүмбэрэлхам, Амгалангийн Насандэлгэр ШЕЗ-ийн гишүүн, Батсүрэнгийн Ундрах ШЕЗ-ийн гишүүн. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд. Ганбат гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Баярлалаа. Энэ бас л цаг үеэ олсон, зайлиггүй гал унтраах ийм тогтоолын төсөл. Шүүх бол маш чухал. Шүүх засаглалууд одоо яг тэр хэмжээнд бол ажиллаж байна уу, үгүй юу гэдэг асуудал байгаа юм. Тэгээд энэ нөхцөл боломжийг нь бид нар хангаж өгөх ёстой л доо. Тэгээд өнөөдөр ШЕЗ-ийн дарга энд байж байх шиг байна. Ер нь шүүгчид маань ажиллах боломжоор хэр хангагдаж байгаа вэ? Сүүлийн үед яг шаардлага хангасан олон улсын шүүхийн стандартын дагуу барилга байшин баригдсан уу? Ер нь нэг ялсан намын үзэмжээр нэг үлдэгдэл төсөв маягаар үлдэгдлээр л санхүүжээд явж байгаа.

Нөгөө талаар энэ ачааллын талаар жигдрүүлэх талаар бол бид бүхэн ингээд энэ тогтоолын төслийг хэлэлцэж байна. Үүнээс гадна таны одоо анхаарал та нарын анхаарал тавих ёстой ШЕЗ-ийн одоо хянаж, анхаарал тавих ёстой нэг юу нь бол одоо шүүгчдийн асуудал юм. Ажиллах боломжоор хангахаас гадна энэ шүүгчид чинь лифт дотор оцгонодог, Улсын дээд шүүхийн шүүгч нар чинь тэр компанийн захирлын арын өрөөнд асуудал шийдээд байж байдаг гэж, ингэж нэг номерын мэдээлэлтэй хүн Засгийн газрын Хууль зүйн сайд энэ тэр нь ярьж байна лаа шүү дээ. Энэ үнэн юм уу? Тухайлбал, одоо манай АН-ын асуудлыг тэнд ярьж байдаг. Хэнд нь тамгыг нь өгөх үү, яах уу, ийх үү гэж. Ийм юм байна уу? АН-ыг одоо тамгыг нь 2 болгож өгч байдаг. Тэр байтугай Улсын Их Хурал дээр АН-ын бүлгийн тамгыг бас 2 болгож байгаа. Энэ олонх. Би тэр хуулийг нь ҮХЦ-д хандчихсан байгаа, шийдэх байх. Улсын Их Хурал бол 2 бүлэг байгуулж, 2 тамга өгөх ёсгүй, ийм хуулийг баталсан. Энэ олонх нь цөөнхийнхөө асуудалд оролцох ёсгүй. Нэг намын асуудалд шүүх оролцох ёсгүй. Намын дотоод асуудалд. Арай хэтэрхий оролцож байгаа.

Шүүхийн гадаа очиж жагсдаг. Намыг тараана гэдэг. Тэр дотор Улсын Их Хурлын гишүүд ч явж байсан. Ийм

замбараагүй байдлыг одоо энэ улс оронд бий болгож, эцсийн шүүх эцсийн шийдвэрийг шүүх л гаргадаг. Тэр 3 шатны шүүхээр шийдвэр нь явчихсан байхад хүчингүй болсон хуулиар анхан шат руу явуулаад, прокурор нь хэрэгсэхгүй болгож байна шүү дээ, тийм юм сонин дээр гарчихсан байна шүү дээ. Бүх хүн хууль шүүхийн өмнө адилхан шүү дээ. Энэ шийтгэгдсэн бүх одоо хүмүүсийг тэрүүгээр нь дамжуулаад явуулья л даа тэгвэл, тийм боломж байгаа бол. Тэр 2 шүүгчид одоо тусгайлсан санал гаргадаг гэсэн. Бүх ялаа эдэлж байгаа энэ хүмүүс дээр тусгайлсан санал гарга л даа, тэр Улсын дээд шүүх чинь. Тэр Цэцэд хандчихсан л юм байна лээ. Энэ юмыг одоо та нар юу гэж бодож байна вэ? Бид нар одоо чадлаараа дэмжээд байдаг, бид нар ч юу байх вэ. Энэ Монголын ард түмэн л ингэж байгаа шүү дээ. Та нарыг сайн ажиллуулахын тулд. Үнэхээр шаардлага хангасан шүүгчид одоо очоод ажиллаж чадаж байна уу, үгүй юу? тэгээд МУИС-ийн төгсөгчид бол шүүхийн, шүүгчийн шаардлага хангахаа больчихсон юм билээ. Одоо тийм одоо төгсөлт төгсөгчидтэй болчихсон юм уу? Энэ олон жил болсон сургууль чинь. Тэгээд бид нар хуулийг биелүүлж байгаа энэ тэр гээд л даналзаад байдаг юм байна лээ.

Г.Занданшатар: Хэн хариулах билээ, 83 Дорждамбын Зүмбэрэлхам ШЕЗ-ийн дарга хариулья.

Д.Зүмбэрэлхам: Ганбат гишүүний асуултад хариулья. Нэгд бол шүүхийн ажиллах боломж ямар байна вэ гэдэг дээр бол одоо энэ талаар санаа зовж байгаад бас талархаж байна. Барилга байшингийн талаар ярилаа. Өнөөдөр шүүхийн ахуй ажиллаж байгаа ахуйн нөхцөл, барилга байшингийн нөхцөл бол маш хүнд байгаа. Энийг бол удаа дараа ярьж байгаа. Өнөөдөр огт байргүй 6 шүүх байна, түрээсийн байранд ажиллаж байгаа 6 шүүх байна, дахиад цаана нь одоо актлагдсан байранд ажиллаж байгаа олон шүүх байна. Одоо ажиллаж байгаа бусад шүүхүүдийн одоо байр байшин ч гэсэн одоо

хугацаа, бололцоо нь хуучирсан, яг одоо шүүх шүүн таслах ажиллагаа явуулахад шаардлага хангахгүй, стандартын бус байранд үйл ажиллагаа явуулж байгаа. Энд бол ер нь одоо стандартын шаардлага хангасан байртай шүүх бол үндсэндээ байхгүй. ШЕЗ-ийн гишүүд ажлаа аваад л бүх шүүхүүдээр явсан. Бид нар ийм дүгнэлтэд хүрсэн. Тэгээд энэтэй холбоотой ямар дүгнэлт бид нар хийж байгаа вэ гэвэл одоо энэ хуучин байшингуудыг одоо жил болгон додомдож, энийг хийхгүй. Төрөөс одоо зориуд бодлого явуулж стандарт хангасан шүүхийн байртай болгох нэгдсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байж энэ асуудлыг шийдэх юм байна гэсэн ийм шийдэлд хүрч байгаа.

Энийгээ бас одоо Улсын Их Хуралдаа танилцуулж, одоо шийдвэр гаргах түвшинд бид нар одоо танилцуулж байгаа. Цаашидаа нарийвчилсан судалгаа хийж байгаа энэ асуудлыг бол шийдчих байх. Үе шаттайгаар. Энэ жилийн хувьд бол 23 онд бид нар бас тодорхой санал дээр санхүүжилт хийе, хөрөнгө оруулалт хийе гэдэг саналыг тавьсан боловч хөрөнгө оруулалтын төсөв бол тусгагдаагүй, хөрөнгө оруулалт бол тэг хөрөнгө оруулалттайгаар одоо төсөв шийдвэрлэгдсэн. Энийг одоо энэ талаараа би ийм зүйлийг хэлмээр байна. Тэгэхдээ бол энэ энийг одоо төрийн бодлогоор нэг бодлогод оруулаад хөтөлбөртэй үе шаттай шийдэхэд бол болохгүй зүйл байхгүй. Ер нь бол энийг цоо шинээр бодлого баримталж шийдэх ёстой асуудал мөн байна гэж.

Дараа нь бол тэр шүүгчдийн ёс зүйтэй холбоотой, шүүгчдийн шаардлага хангахтай холбоотой асуудал дээр бол манай одоо ажиллаж байгаа 500-гаад шүүгч бол өнөөдөр энэ 500-гаад шүүгч л одоо Монгол Улсын шүүхийг нуруун дээрээ авч явж байгаа. Энэ шүүн таслах ажлыг дааж явж байгаа. Энэ улсууд л хийж байгаа. Тэгээд яах вэ одоо ингээд алдаа оноо гарсан зүйл байдаг байх. Тэнд нь бол Ёс зүйн хороо гэдэг Ёс зүй, сахилгын хороо гэдэг байгууллага тусдаа байгуулагдсан,

энэ асуудлыг жичдээ авч үзэж байгаа. Одоо нийт шүүгчид бол ажлаа хэвийн явуулж, хуулийн дагуу одоо хийж байгаа гэж би бол Ерөнхий зөвлөл бол үзэж байгаа.

Хэрэг төвөгтэй холбоотой асуудал байна. Энд бол ШЕЗ бол шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ гээд хууль дээр заасан. Тийм учраас ШЕЗ бол шүүн таслах ажиллагаа руу бол орж болохгүй, ийм хориотой заалттай. Тийм учраас шүүн таслах ажиллагаатай холбоотой зүйл дээр бол би хариулт өгмөөргүй байна, өгч болохгүй.

Дараа нь бол тэр юутай тодорхой одоо ингээд арын өрөөнд асуудал шийддэг ч гэдэг юм уу ийм асуудлууд хэвлэл мэдээллээр сүүлийн үед янз бүрийн шатанд бол яригдаж байна. Энийг эх сурвалжтай, баталгаатай тавих ёстой. Энэ танхим бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн тодруулъя 1 минут.

Д.Ганбат: Таны удирдаж байгаа байгууллага шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэгтэй юм байна. Ер нь ч үүрэгтэй. Энэ тусгай субъектийн хэрэг хэргийг бол АТГ хариуцдаг, шүүх, прокуроруудыг тэнд баздаг. Шүүгч нарыг. Тэгээд хүссэн шийдвэрээ бол гаргуулж чаддаг гэж ярьдаг. Энэ нь одоо тэнд хамааруулснаас болж тэгж гаргаж чадаад байна уу? Энэ АТГ-ын дарга, дэд даргыг бол Монгол Улсын Ерөнхий сайд томилж байгаа. Өмнө нь бол одоо Монгол Улсын Ерөнхийлөгч томилдог байсан, одоо энэ Монгол Улсын Ерөнхийлөгч маань бас хуучин байсан нь тэнд татагдаад явж байгаа. Тэр тавьсан хүн нь өөрөө өөрийгөө шалгаж чадах уу? Тавиулсан хүнээ. Ер нь хулгайч хулгайчийг шалгаж чадах уу, энийг юу гэж үзэж байна вэ? Бие даасан байдал, шүүх хангагдаж байна уу, эсвэл тэндээс хараат, бодитой шийдвэр гаргах үндэслэл.../минут дуусав/

Г.Занданишатар: 83.

Д.Зүмбэрэллхам: Ганбат, Ганбат гишүүний нэмэгдсэн асуултад хариулъя. Тэгээд одоо хэн нь хэнээ шалгах вэ гэдэг асуудал бол цэвэр одоо процессын хуулийн дагуу л явж байгаа юм. Аль нь одоо ямар субъектийг шалгах вэ гээд ингээд харьяалал тогтоочихсон. Тэр харьяаллынхаа дагуу л явж байгаа. Тийм учраас одоо хуулиас гадуур, одоо энэ зөв байна, буруу байна гэсэн ийм дүгнэлтийг бол би өнөөдөр хэлмээргүй байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Шүүгчийн энэ орон тоог нэмэгдүүлж байгаа, ачаалал багатай шүүхээс ачаалал ихтэй шүүхийн байгууллагууд руу шүүгчийг бас шилжүүлж байгаа юм байна. Тэгээд энэ тогтоолын төслийг бол дэмжиж байна. Энэ тогтоол гараад тэгээд одоо бас ажил сайжрах болов уу гэсэн ийм бодолтой байж байна миний хувьд бол. Ер нь одоо шүүхэд улс төрийн нөлөөлөл их байгаа шүү, шүүхэд итгэдэг хүн гэж ер нь байхаа больсон, миний хувьд ч гэсэн итгэхээ больсон. Танай иргэний хэргийн шүүх, тэр захиргааны хэргийн шүүх гэж хүнийг ерөөсөө тийм залхаасан, нэг заварсан шүүх байдаг юм билээ. Хэн ч ойлгомжтой, ажлаас халагдсан хүнийг л жил зургаан сар л шүүх дээр залхааж байгаа шүү дээ. Нэг эд хөрөнгийн маргаантай асуудал зүгээр энгийн хүн ойлгоод асуудлыг шийдчих юман дээр л танай дээр жил зургаан сар л одоо хүнийг залхаан цээрлүүлж байгаа шүү дээ. Үүнээс чинь болоод хүмүүс зарим нэг нь хаяж байна. Больё, энэ шүүхийг шүүх гэдэг чинь ерөөсөө бүтэхгүй юм байна. Хэн ч харсан ийм ойлгомжтой юман дээр ингэж жил зургаан сар ингэж өмгөөлөгч авч эд хөрөнгө, мөнгө төгрөгөөрөө одоо юу гэдэг юм хохирохыг хүн одоо бодохгүй байна шүү дээ. Тийм учраас та хэд наад тэр шүүхийн процессын тухай хууль дээр ямар өөрчлөлт оруулах юм бэ? Энэ асуудлаа яаралтай

оруулж ирэх хэрэгтэй. Хүнийг ер нь залхааж байгаа шүү.

Хоёрдугаарт, энэ шүүгчийнхээ ёс зүйн асуудал дээр ёс суртахууны асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй болчихсон юм байна лээ. Шүүгч гэхээр одоо хүн биш юм уу, хаашаа юм. Нэг л их одоо хүнд сурталтай адилхан л иргэн шүү дээ, Монгол Улсын иргэн. Тийм учраас энэ ёс суртахуун, ёс зүйн асуудал дээр нь бол онцгой анхаарах хэрэгтэй юм байна лээ энэ шүүгч нар дээр. Энэ асуудал дээр ер нь танай ШЕЗ ямар ажил зохион байгуулаад явж байгаа юм бэ? Энэ одоо ажиллаж байгаа тэр 500 шүүгчээ одоо аттестатчилах гэдэг юм уу, ийм асуудлууд хийгдэж байгаа юу? Цаашидаа хийгдэх юм уу? Тэр Дээд шүүхийн шүүгчийг ч билүү, тэр 9 шүүгчийг ч хүртэл одоо юу гэдэг юм, Их Хурлаас 3-ыг нь сонгодог, Ерөнхийлөгч, 3-ыг нь, ШЕЗ 3-ыг нь ч гэдэг юм уу ингэж ийм байдлаар ингээд яваад байх юм бол наад улс төрийн нөлөөлөл чинь бол зогсохгүй. Зүмбэрэллхам даргаа. Та одоо шүүх шударга ажиллаж байна гээд яриад байх юм. Улс төрийн томилгоо хийгдэж байгаа үед наад шүүх чинь хэзээ ч шударга ажиллахгүй. Цаашидаа энэ шүүгч нарын асуудлыг ШЕЗ өөрсдөө оруулж ирж, өөрсдөө сонгон шалгаруулалтаа хийгээд бүгдийг нь Их Хурлаар томилдог болгох хэрэгтэй. Ийм өөрчлөлтүүдийг хийж байж л наад шүүх шударга ажиллана. Одоо энд бол одоо юу гэдэг юм, нэг шударга яриад, шүүх сайн ажиллаж байгаа, шүүх ёс зүйтэй байна гэж ийм юм ярьдгаа болих хэрэгтэй. Наад тогтолцоогоо өөрчил. Энэ ТББ.../минут дуусав/

Г.Занданишатар: Хариулт, Би энэ ШЕЗ бол шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилготой бөгөөд шүүх шүүн таслах ажиллагаанд оролцохгүй, оролцох эрхгүйгээр шүүгчийг шилж олох, шүүгчийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй байгууллага. Сахилгын хороо нь бол ёс зүй, сахилгын зөрчлийг хариуцна, тусдаа. Шүүгчийг томилох асуудал бол Ерөнхийлөгчийн 3, 3-аар биш, зүгээр Их

Хуралд танилцуулснаар л Ерөнхийлөгч томилж байгаа л даа. Шүүгчийн ерөнхий зөвлөл шилжж олоод л, тэрнийгээ тодорхой хариулчхаач. Үндсэн хуулийн дагуу 83.

Д.Зүмбэрэлхам: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ бид нарын оруулж ирж байгаа энэ тогтоолд өөрчлөлт оруулах асуудал бол ер нь ШЕЗ-өөс бол Шүүх байгуулах хуулийн саналыг Засгийн газарт хүргүүлсэн. Засгийн газар ажлын хэсэг байгуулаад тэгээд Улсын Их Хуралд оруулж ирж батлуулах байх. Бид нар энэ шүүхийг байгуулах хууль бол Шүүх байгуулах тухай хууль батлагдана гэж тооцож байгаа. Энийг хүлээхгүйгээр бид нар бас зохицуулалт хийх шаардлагатай болоод ингэж оруулж ирж байгаа. Хэрэв энэ тогтоол батлагдах юм бол бид нар энэ Улаанбаатар хотод байж байгаа байнга одоо ачаалал нь, ачаалалтай ажиллаж байгаа, хэт ачаалалтай ажиллаж байгаа, ингээд 5, 6, 7 шүүх дээр бол ямар ч байсан гэсэн энэ одоо ажлын ачааллыг нь зохицуулах зохицуулчхаж болох юм байна гэж тооцоо хийгээд ингэж оруулж ирж байгаа.

Зүгээр татсан тэр юун дээр орон тоо, орон тоо сул байж байгаа. Одоо ингээд татаж төвлөрүүлэх гэж байгаа энэ орон тоонууд дээр бол ямар ч байсан гэсэн энэ хугацаанд бол ажил нь хэвийн явагдана. Энэ аль, аль талыг нь 2 талыг нь тооцож оруулж ирж байгаа гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ бол их тийм, ер нь бол чухал, энийг шийдүүлэх асуудал бол өнөөдөр маш чухал байгаа гэдгийг би бас дахиж тэмдэглэж хэлмээр байна.

Түрүүнд бол одоо ёс зүйн асуудлыг бол Шүүгчийн сахилгын хороо хариуцаад, манайх бол одоо хуульд заасан тодорхой чиг үүргээ шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр хэрэгжүүлж байгаа гэдгийг бол дахиж хэлье. Тэгээд яах вэ одоо ингээд Шүүхийн тухай хууль бол 2021 онд саяхан батлагдаад л бид нар шинээр батлагдсан хуулиа дөнгөж хэрэгжүүлээд л нэг л жил болж байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан гэсэн энэ хуулиа л одоо нэг жсоохон

хэрэгжүүлээд үзье, тэгээд одоо юу нь болохгүй, юу нь болж байна вэ гэдгийг бас мэдэх хугацаа болоогүй байна. Тэгээд энэ бол шинэтгэлийн чанартай том хууль гэж үзээд энэ хуулиа ер нь даацтай, энийгээ хэрэгжүүлэх гээд аль, аль талдаа одоо хичээгээд үзье л гэдэг ийм байр суурьтай байж байгаа. Тэгээд томилгооны асуудал ч гэлээ гэсэн, ер нь бол одоогийн хуулийн дагуу л явагдаж байгаа. Хэрэв цаашидаа тогтолцоо өөрчилнө гэх юм бол бас хуулийн дагуу л хийгдэх ёстой болно. Ингээд аль аль талдаа бол судлах, турших, үзэх ийм цаг хугацаа харуулна биз гэж бодож байна.

Г.Занданишатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: ШЕЗ-өөс шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тогтоол оруулж ирж байна. Ер нь олон л зүйлийг оруулж ирдэг байсан л даа. Тэгэхдээ энэ өнгөрсөн 30 жилийн хугацааны төр, ард түмний хоорондох итгэлцэл найдварыг алдагдуулсан өнөөгийн нийгмийн энэ одоо хэцүү байдалд хүргэсэн зүйлийг бол би шүүхийг л гэж ингэж үздэг. Яагаад вэ гэхээр үнэхээр Тогтохсүрэн даргаа, Тогтохсүрэн даргаа.

Г.Занданишатар: Гишүүн асуулт асууж байна гишүүдээ.

Ж.Батсуурь: Минутаа эхнээс нь авъя.

Г.Занданишатар: Явж бай, би сүүлд нэмнэ.

Ж.Батсуурь: Тэгэхээр одоо энэ ШЕЗ Их Хурал руу байнга нэг барилга байшин, цалин мөнгө, ёс зүй, энэ нэхдэг зүйлээ одоо болих хэрэгтэй. Яг үнэндээ одоо өнгөрсөн 30 жилийн хугацаанд төр, ард түмний хоорондох итгэлийг алдаж байгаа зүйл бол ерөөсөө л шүүх шүү дээ. Өнөөдөр Монгол Улсад 30 жилийн хугацаанд ямар одоо нүдний булай болсон гэмт хэргүүд, авлигал, хээл хахууль, мөн одоо шамшигдал гарав. Тэр одоо шүүх дээр

очоод бүгдээрээ замхардгаас болж л өнөөдөр төр, ард түмний хоорондох итгэл байхгүй болсон. Шүүгчид авлигаас гадуур байх ёстой цалинг нэмээд л өгсөн. Нөгөө Галсансүхийн хэлдгээр хамгийн өндөр цалинг л өгсөн. Шударга нь хаана байгаа юм, шударга шийдвэр гарсан нь хаана байгаа юм. Хүмүүсийн нүдэн дээр бодитоороо авлигал аваад баригдаад, тэрийгээ хүлээн зөвшөөрчихсөн хүн дөчин сая төгрөгөөр торгуулчаад, гэртээ гэдсээ илээд хэдэн үеэрээ идэх мөнгөө хураачхаад байж байна. Тэгээд энийг шударга шүүх гэх үү.

Тэгээд шүүхийн шинэчлэл ярингуут сонгон шалгаруулалт ярьдаг. Бүх зүйлийг худлаа далдалж оруулж ирдэг. Сонгон шалгаруулалт шиг худлаа зүйл байхгүй. 27 хүн нэр дэвшихэд санал хураагаад 2-хон хүн гарч ирж байгаа байхгүй юу. 270 хүн нэр дэвшээд ч нэмэр байхгүй байх нь байна шүү дээ. Эрх баригч намын томилгооных нь хүмүүс нь одоо эрх барьж байгаа намдаа Байнгын хороо дээрээ сонгон шалгаруулалт дээрээ шивнээд, ингээд нууц санал хураалт байсан ч хэдэн ч хүн нэр дэвшсэн тэр л хүмүүс нь гарч ирдэг ийм л нөхцөл байдал бий болсон. Тийм учраас энэ шүүн таслах үйл ажиллагааг ил тод болгох хэрэгтэй. Бүх хурлыг нээлттэй болгомоор байна, ямрыг нь хаагаад байдаг юм, ямрыг нь нээлттэй хийгээд байдаг юм бэ? Процессын хууль дээр гол зүйл байдаг гэж сая Зүмбэрэлхам дарга хэлж байна.

Энэ тогтолцоогоо өөрчлөөч. Өнөөдөр цалин мөнгө, байр байшин, орон тоо, бусад зүйлийг одоо нэхэж Их Хурал руу байнга дахин ороод ирэхийнхээ оронд бид нар ер нь энэ ард түмний энэ 30 жилийн болж бүтэхгүй байгаа зүйлийг чинь олон түмний хэлэлцүүлгээр, үгүй бол судлаачийн дүгнэлтээр, гадна дотнын орнуудыг судалснаар бид нар ийм тогтолцооны шинэчлэл хийж, хийж байж энэ төр, ард түмний хоорондын гагнаасыг бид нар авч явж чадах юм байна энэ 500 шүүгчид чинь гэсэн байдлаар асуудлыг оруулж ирэхгүй бол нэг асуудал яригдангуут бид нарт орон тоо хүрэхгүй

байна, үгүй бол цалин хүрэхгүй байна, үгүй бол байшин барилга болохгүй байна гэсэн байдлаасаа одоо ангижрах цаг нь болсон байна. Улс төрчийн нөлөөллөөс, улс төрчдийн савраас гарах цаг нь болсон байна. Ард түмнийг сэргэн мандах, Монголын мандан бадрах гол үйл ажиллагаа бол шүүхтэй холбоотой гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлаа томоор нь оруулж ирээч гэж хүсэж байна ШЕЗ. Баярлалаа.

Г.Занданшатар: Хариулах уу? Зүмбэрэлхам дарга 83.

Д.Зүмбэрэлхам: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Тэгээд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын засаглалын хэсэг дээр шүүхийн шүүх эрх мэдлийг хөгжүүлэхийн эцсийн үр дүн нь бол итгэл хүлээсэн шүүхтэй болох асуудал гэж тодорхойлсон байгаа. Тийм учраас өнөөдөр Батсуурь гишүүний яг асууж байгаа энэ чиглэл рүү бүгдээрээ явж байгаа. ШЕЗ-д ч явж байгаа, шүүх ч явж байгаа, Их Хурал ч явж байгаа, энэ төрийн бүх л институт ийшээ чиглэгдэж байгаа. Нийгэмд шударга ёс байх уу, байхгүй юу гэдэг асуудал өнөөдөр шүүхэд олон нийт итгэх үү, итгэхгүй юу, итгэхгүй юу гэдэг асуудал асуудал дээр тогтдог гэдэгтэй санал нэг байгаа бид нар.

ШЕЗ бүрдээд 1 жил болж байна, яг шинэ, одоо шинэ Үндсэн хуульд заасан шинэ бүрэлдэхүүн сүүлчийн бүрэлдэхүүн бүрдээд 1 жил л болж байна. Энэ ийм, шүүхийг ийм болгоё гэдэг шинэтгэлийн шинжтэй хууль батлагдаад бас нэг л жил болж байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт ороод бас 2 жилийг үзэж байна. Ингээд эрх зүйн шинэтгэлийн эрх зүйн шинэтгэл бий болоод эрх зүйн шинэтгэлийн энэ хүрээнд үйл ажиллагаа явуулаад бид нар бас хараахан богинохон хугацаа өнгөрч байна. ШЕЗ бол үндсэндээ бүрдсэн цагаасаа хойш яг одоо энэ Шүүхийн тухай хуулийг үг үсгээр нь хэрэгжүүлэх ийм л бодлогыг барьж ажиллаж байгаа. Энэ дээр бол Улсын Их Хурал ч дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа, бид нар хаана хаана бол хамтраад энэ

чиглэл рүү явж байгаа гэж ингээж бодож байна. Шүүхийн барилга байшингийн тухайд бол түрүүнд нөгөө асуулт асуусан учраас л би энд хариулсан. Орж ирэх болгондоо энийг нэхээд байгаа юм байхгүй.

Ер нь бол асуудлыг тавихгүй байж болохгүй, энийг шийдэх ёстой, энийг төр л шийдэх ёстой. Ийм учраас энэ асуудлыг бол тавина. Энийг одоо шийдэж ард нь гарах ёстой байх гэж ингээж бодож байна. Шүүгчийн сонгон шалгаруулалтын асуудал дээр ч гэсэн ШЕЗ бол зарчмын байр суурьтай байгаа. Хэн ч бидэнд энэ чихэнд хэн нэгэн хүний нэрийг шивнэхгүй байгаа шүү. ШЕЗ шинээр бүрдээд өдий хүртэл 2 сонгон шалгаруулалт явагдсан. 3 дахь сонгон шалгаруулалтаа зарлачихсан байж байна. Энийг цэвэр хараат бусаар авч, яг хуульд заасны дагуу эрэмбэлж, эрэмбээрээ хамгийн эхэнд орсон хүнийг өргөн мэдүүлж томилуулах энэ зарчмаар явж байгаа. Тэгээд энэ цаашидаа бол одоо энэ нь бол шударга шүүх илүү шударга болох ийм үүд хаалгыг бид нар нээж байгаа, суурийг нь тавьж байгаа. Цаашидаа бол одоо ийм шүүхтэй болж бүх одоо иргэдийнхээ итгэлийг хүлээнэ гэдэг бол цаг хугацааны асуудал байх. Өнөөдрийн шүүгчид бол өнөөдрийн байдлаар хууль ёсныхоо дагуу энэ шүүхийн ачааг үүрээд явж байгаа. Бүх шүүгчдийг одоо ганц нэг алдаа дээр яаж, бүх шүүгчдийг одоо шударга бус байна, шүүхгүй баймаар байна энэ тэр гэдэг асуудал бол яригдахгүй байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Одоо санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулт, үг ингээд хамт явчихсан. Энэ нөгөө тогтоолын төсөл учраас. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Гишүүд иртэл би бас нэг юм тодруулъя. Зүмбэрэлхам даргаа, энэ шүүхийн шинэчлэлийн процесс үргэлжилж байгаа гэдгийг манай гишүүд бас ойлгож байгаа байх гэж итгэж байна ШЕЗ бол зөвхөн шүүгчийн бие даан ажиллах нөхцөлийг хангах, шүүгчийг шилж олох гол үүрэгтэй байгууллага. Шүүхийн сахилгын

хариуцлагын хороо бол тусдаа сахилгатай холбоотой асуудал, шүүн таслах ажиллагаа бол тусдаа шүүхээр шийдвэрлэж байгаа асуудалд оролцох эрхгүй, ийм тусдаа институт шүү дээ, тийм ээ. Тэгэхдээ шүүхийн шинэчлэлийн хууль дээр тэр шүүгчийн туслахыг хуульчийн гэрчилгээтэй байна гээд хуульчилчихсан. Энэнээс чинь болоод шүүгч бүгд гацах асуудал үүсэх юм биш биз дээ? Шүүгчийн туслахууд чинь бүгд хуульчийн гэрчилгээтэй байхгүй байгаа шүү дээ тийм ээ, аваад ажил болоод явж байдаг.

Тэгээд тэр хуулийнхаа хэрэгжилтийг хойшлуулах юм уу, хууль санаачлах юм уу, Энхбаяр гишүүнээ, ХЗБХ-ны даргаа та хэд нэг ярьж байгаад наад бүх шүүх нэг гацах нэг асуудал үүсэх юм биш биз? 3 сарын 1-нээс. Тэр асуудлыг та харин хэд яаж үзэж байгаа вэ? Энэ юу яатал энийг нэг хариулаадхаач. 83 дээр Зүмбэрэллхам дарга. 83 тийм.

Д.Зүмбэрэллхам: Их Хурлын даргын сая хэлдэг хэлдэгтэй санал нэг байгаа. Энэ шүүгчийн туслах нөгөө мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээтэй байна гэдэг асуудал дээр бол энэ асуудлыг хүндрүүлж байгаа юм. Ер нь бол цаашидаа бол ийм шаардлага багатай гэж бодож байгаа. Яагаад гэвэл энэ дээр бол төрийн албаны шалгалт өгчихсөн, тэгээд төрийн жинхэнэ алба хаших боломжтой гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн улсууд орж ирээд дээр нь бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл гэдэг бол нэг их тийм шаардлагынхаа үүднээс зөвтгөмөөргүй. Тэгээд яг ачир дээрээ очихоор томилгоонд нөлөөлөөд ингээд сул оронтой олноор гарах, энэ дээр нь одоо шаардлага хангасан хүн орж ирэхгүй байх ийм асуудал бол бодитой үүсэж байгаа. Тэгээд энэ дээр бол ХЗБХ-н дээр асуудал тавиад ингээд оруулаад ирье гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Ярьж байгаа юм байна, тийм ээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн. Ажлын хэсэг.

Б.Энхбаяр: Шүүхэд бол шүүхийн захиргааны 2 албан хаагч байгаа. Нэг нь шүүхийн шүүгчийн туслах, нэг нь шүүхийн нарийн бичиг гэсэн ийм 2 албан тушаал байдаг. Шүүхийн тухай хуулийг хэлэлцэх явцад бол шүүгчийн туслах нь шүүгчийн шүүн таслах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, шүүхийн шийдвэрийг бичих, тэр судалгаа юманд оролцдог нэлээн хариуцлагатай алба, албан хаагч байгаа юм. Тийм учраас шүүх хуралдааны нарийн бичиг буюу техникийн асуудал хариуцсан хүн нь бол одоо эрх зүйч байж болно. Харин яг шүүгчийн шүүн шийдвэр дээр ингэж одоо оролцож байгаа, гаргалцахад оролцож байгаа энэ ажилтан бол заавал хуульчийн шалгалтад орж тэнцсэн хүн байх ёстой гэдэг хууль зүйн шаардлагыг бол тавьсан. Би энэ шаардлагыг зөв гэж боддог.

Зүмбэрэлхам даргын хэлж байгаа шалтгаан бол хууль зүйн үндэслэл, шалтгаан биш. Шүүгчийн туслахуудад хуульчийнхаа шалгалтад тэнцэх бүтэн 1 жилийн хугацаа олгосон байгаа. Бүтэн 1 жилийн. Энэ хүмүүс нь тэр шалгалтдаа тэнцээгүй буруу нь хууль биш. Яагаад тэгээд тэнцэхгүй тийм чадваргүй хүмүүс авсан юм. Энэ хуулийн буруу биш шүү дээ. Яагаад Хуульчдын холбоо хуульчийнхаа шалгалтыг одоо авахгүй байгаа юм. Энэ хуулийн буруу биш. Хуульчдын холбоо одоо Хуульчийн эрх зүйн байдлын хуульд зааснаар 2 жил тутам ээлжит хурлаа хийх ёстой. Энэ хуулийг зөрчөөд одоо бүр 3 дахь жил рүү орж байгаад сая одоо хурлаа хийж байгаа. Энэ хуулийнх нь буруу биш. Одоо ингээд нэг асуудал үүсэнгүүт дандаа асуудлыг хууль руу чихдэг, ялангуяа энэ манай энэ хуулийн байгууллагууд бүр ийм сурчихсан. Өөрсдөөсөө хамаарч байгаа юмыг энэ хууль болохгүй байгаа юм.

Ялангуяа энэ одоо сүүлийн үед хулгайтай тэмцэж байгаа асуудлууд дээр хууль хяналтын байгууллагад ажиллахгүй байгаа, эс үйлдэл хийсэн, хариуцлага тооцохгүй байгаа энэ юмнууд нь одоо өнөөдөр бугшаад, тэсрээд дэлбэрээд гараад ирэнгүүт үгүй ээ энэ одоо шалгадаг

хууль болохгүй байгаад байгаа юм. Дандаа ингэж өөрсдөөсөө займчуулдаг ийм тайлбар бол байж таарахгүй. Үнэхээр гарцаагүй энэ шүүн таслах ажиллагааны одоо үйл ажиллагаанд ийм доголдол, тасалдал үүсэх гээд байгаа нөхцөл байдал байгаа бол тэр дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан бүтэн 1 жилийн хугацаа олголоо шүү дээ. Энийг дахиад сунгаж болох эсэх асуудлыг л ярихаас биш ерөөсөө хуульч байх ёстой гэдэг шаардлагыг авах тухай яриа байж таарахгүй гэж би бодож байгаа юм.

Өнөөдөр одоо шүүгчийн туслахаар дамжаад зүгээр эрх зүйчид ажиллана гээд ингээд харчихсан. Дээд шүүхийн шүүх дээр орж ирсэн гишүүд дээр манай гишүүд хэлсэн шүү дээ. Үгүй ээ, үнэхээр гологдож байна энэ одоо. Сурсан, ажилласан байдал бол энэ Монгол Улсын Дээд шүүхэд одоо ингээд хэмжээний хүмүүс биш байна гэж олон гишүүд ярьсан шүү дээ. Энэ чинь юутай холбоотой байна вэ гэхээр тэр шүүгчийн туслахууд дээр хуульчийн шаардлага тавиагүй, ямар ч хамаагүй одоо хувийн байна уу их, дээд сургууль төгссөн эрх зүйч байхад л хангалттай гэсэн ийм шаардлага тавьснаас болж байгаа. Бид шүүгчийн туслах дээр энэ хуульчийн шаардлагыг тавьж байгаа нь цаашидаа шүүгч болох гэж байгаа хүмүүс дээрээ наана нь ядаж хуульчийн шалгалтдаа тэнцсэн байх ёстой, тэгж байж шүүгчийн туслах болох ёстой, тэгж байж шүүгч болох ёстой гэдэг энэ шаардлагыг л өндөржүүлж байгаа байдал шүү дээ. Тэгээд энэ хууль руу чихдэгээ одоо болимоор байна.

Г.Занданиатар: Зүмбэрэлхам дарга хууль руу чихээгүй байх, тэр дагаж мөрдөх хугацааг л хойшлуулах хууль хэлэлцэнэ үү гэхээс биш, хуулийг өөрчлөх асуудал байхгүй шүү дээ, тэрэнд нийцүүлнэ гэж. Өөрсдөө хуулиа хэрэгжүүлээгүй юм байна лээ. Хууль хулгай хийхгүй байгаа шүү. Хууль хэрэгжүүлэхдээ л хулгай хийгээд байгаа гэдгийг чинь хэлээд байгаа шүү дээ. Тэр асуудлаа бол энэ ШЕЗ-ийн хариуцах ажил шүү. Одоо санал хураалт явуулна. Гишүүд

сууцгаая. Байнгын хорооны саналаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Тогтоолын төслөө батлаад завсарлах уу? 54.2 хувийн саналаар санал энэ санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Саяын асуудлыг анхаарч ажиллаарай. Гуравхан сар үлдсэн байхад наад шүүгчийн туслах нарын чинь ихэнх нь хуульчийн гэрчилгээгүй байсаар байгаа юм байна лээ шүү. Дараагийн асуудалд орно.

12.56 цагт

Дөрөв.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна. Төсөл, төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна, индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдоржоос 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ-ны 2022 оны 19 дүгээр тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Адышаа, Дэлгэрсайхан, Мөнх-Оргил, Сандаг-Очир нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллаа.

ХЗБХ 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд хуулийн төслийн нэгдүгээр зүйлд заасан улсын тэмдэгтийн хураамжийн төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дараа жилийн төсөвт тусгахаар заасан нь Төсвийн тухай хуулиар зохицуулах харилцаа тул дэмжих боломжгүйг илэрхийлсэн болно.

ХЗБХ-ны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогын байгууллагын цахимжуулалт, мэдээллийн

технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдал хангахад зориулан дараагийн жилийн төсөв тусган санхүүжүүлэх, хуулийн төсөлд заасан цолны асуудлыг бусад хуультай нийцүүлэх зорилгоор шадар зөвлөх гэснийг эрхэлсэн зөвлөх гэж, жинхэнэ зөвлөх гэснийг ахлах зөвлөх гэж өөрчилж, итгэмжит зөвлөх гэсэн цолыг хасах. Хуулийг дагаж мөрдөх хугацаа 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдөр байх зэрэг болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаар ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан баярлалаа.

Г.Занданишатар: Баярлалаа, Мөнхцэцэг гишүүнд. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Асуулт алга байна, тасаллаа.

Одоо Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдана, ХЗБХ хуралдах хуралдана. ХЗБХ өнөөдөр хуралдаж Эрүүгийн хуульд болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. Пүрэвдорж гишүүн хөөе суу, та ер нь одоо дандаа ингэж сахилгагүйтэж байдгаа боль. Тэгээд энэ 2 Байнгын хороо хуралдана. Өнөөдөр Эрүүгийн хуулийг хэлэлцэж батална. Өнөө

оройдоо сунаж хуралдах шаардлагатай. Одоо Байнгын хороо, Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл хуралдах учраас чуулганыг түр завсарлуулж байна.

13.00 цагт

2022 оны 12 дугаар сарын 16, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 01 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Тав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар/

Г.Занданишатар: Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл, Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар мэдээлэл сонсоно. Мэдээллийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Мэдээллээс цөөнхийн бүлгийн гишүүд амаар асуулт тавьж, хариулна. Ганибал гишүүнээ танайх цөөнх тийм, тэгэхээр танай цөөнхийн бүлгийн гишүүд л оролцох учраас байвал эхлүүлэх гээд байна. Та нэг дуудаадхаач. 5 минут хүлээлээ, ахиад. Цогтгэрэл гишүүнээ тэгвэл эхэлж байх уу? Тэгье.

Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, төрийн зохицуулалт, гадаад зээлийн өр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёр дахь зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаар

Сангийн сайд Болдын Жавхлан мэдээлэл хийнэ. Ерөнхий сайдын мэдээллийг Болдын Жавхлан сайд танилцуулна.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс нь 1991 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш үндсэндээ хөгжлийн түнш, олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудаас нэн хөнгөлөлттэй, 25-40 жилийн хугацаатай зээл авч суурь болон нийтийн зориулалттай дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн хөрөнгө оруулалтаа санхүүжүүлж ирсээр ирлээ. Монгол Улсын нэг ноогдох үндэсний орлого 2004 гэхэд гэхэд 480 ам.доллартай тэнцэж байсан бол 2010 он гарсаар 1890 ам.доллар хурч, хамгийн ядуу гээгдэх бага орлоготой ангиллаас дэвшиж, дундаж орлоготой ангилалд орсноор зээлийн нөхцөл хатуурч эхэлсэн байдаг. Үүнтэй зэрэгцэн улс оронд маань аж үйлдвэржилт болон тэр дундаа эдийн засгийг төрөлжүүлж, нэмүү өртгийн сүлжээг бий болгосон боловсруулах салбарт бүтээн байгуулалт хийж, эдийн засгийн өсөлтийг дэмжих сорилтыг дагаад тэдгээр хөгжлийн санхүүжилтийн хэрэгцээ, шаардлага 2010 оны эхэнд үүсээд байлаа.

Өөрөөр хэлбэл, төмөр замын сүлжээ, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчим хүчний цахилгаан станц барьж байгуулах зэрэг бүтээн байгуулалтад шаардлагатай эх үүсвэрийг Хөгжлийн банкаар дамжуулан бонд босгож, эрүүл зээл авах замаар бүрдүүлж, ирээдүйд тэдгээр төслүүдээс бий болох экспортын орлого, эдийн засгийн өсөлтийг дэмжих, өрийн эргэн төлөх чадварын харьцаа үзүүлэлтүүд сайжран Хөгжлийн банкны өрийг төслийн орлогоос эргэн төлнө гэсэн концепцын хүрээнд 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үзэл баримтлал батлагдсан байдаг. Гэвч бид энд ямар бодлогын алдаа оноо байв, ямар сургамж үлдэв, цаашид үүнээс яаж ямар тэргүүн шугамаа барьж ажиллах вэ гэсэн асуултууд биднийг өнөөдөр энэ индэрт

хөтөлсөн болов уу. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтөө дагаад арилжааны нөхцөлтэй зээл, гадаад бонд, өрийн баталгаа зэрэг санхүүгийн хэрэгслийг ашиглах болсон хэдий ч зөв зохистой ашиглах бодлого төлөвлөлтөд асуудлууд бишгүй их байсаар ирлээ.

Өрийн хэмжээ ихтэй боловч тэдгээрийг ухаалгаар менежмент хийж чаддаг АНУ, Япон, Их Британи, Франц зэрэг том эдийн засгууд хөгжингүй орнууд байхад багахан өртэй боловч дефолт болох эрсдэлтэй, ойрхон жижиг эдийн засгийн орнууд ч байна. Олон улсын байгууллагуудын зүгээс өрийн хэмжээнд их, бага гэж дүгнэхээсээ өмнө түүнийг зээлийн ашиглалтын үр өгөөж, эргэн төлөх чадварын үзүүлэлтүүд болон тухайн улс орны бодлого болон институцийн чадварыг харгалзан үздэг. Гэсэн хэдий ч бид одоо үүсээд байгаа 33.3 тэрбум ам.доллартай тэнцэх улсын нийт гадаад өр, түүний 24 хувь болох 8.1 тэрбум ам.долларыг бүрдүүлж буй Засгийн газрын гадаад өрийн менежментийн хувьд цаашид бодлого, институцийн хувьд ямар реформ хийх талаар тууштай шийдэл бүхий арга хэмжээг авч хэрэгжүүлэх чухал цаг хугацаанд бид иржээ.

Улсын нийт өрийн 64 хувь буюу 21.3 тэрбум доллар нь хувийн секторынх, харин үүний талаас илүү хувь нь Оюутолгойн өр байдаг. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарт тулгуурласан жижиг эдийн засагтай манай улсын хувьд тухайн салбарт оруулсан доллар бүрийг хөрөнгө оруулагчид төслийн ирээдүйн ашгаас буцаан авах нөхцөлтэйгөөр өр болгож бичдэг бөгөөд эргэн төлөлт нь валютын нөөц, төсөв дээр дарамт учруулахгүйгээр тухайн компанийн хүрээнд төлөгдөж дуусах учиртай. Үүнд Засгийн газар ямар нэгэн төлбөрийн үүрэг хариуцлага хүлээхгүй. Төсвөөс буюу татварын орлогоос эргэн төлөгддөг өр бол Засгийн газрын өр бөгөөд энэхүү өрийн нэрлэсэн үлдэгдэл 2022 оны сүүлийн статистикаар 28.5 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 23.8 их наяд төгрөгтэй тэнцэж

байна. Сүүлийн жилүүдэд баримталсан өөрийн стратегиар бид өрийн хэмжээг хязгаарт нь хүртэл тулгаж, зээллэг хийхээс татгалзаж, аль болох гадаад өр, тэр дундаа бондуудын үлдэгдлийг төсвөөс тодорхой хэмжээгээр төлж барагдуулах зарчмыг баримталсан бөгөөд 2016 он хүртэл төсвөөс гадуурх зарцуулалтаар үүссэн байсан барих-шилжүүлэх нөхцөлтэй концесс, векселийн өрүүдийг төлж барагдуулан, Засгийн газрын өрийн баталгаа гаргахгүй байх чиглэлийг тууштай баримталж ажилласнаар 17 онд 72.5 хувь байсан дотоод нийт бүтээгдэхүүний эзлэх Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн харьцааг 19 онд 55.6 хувь, 22 онд 50.1 хувь болгож бууруулаад байна.

Өөрөөр хэлбэл Засгийн газрын хуулийг чанд мөрдөж ажилласнаар энэхүү өр ДНБ-ий харьцаа энэ онд хуулиар тогтоосон хязгаарын түвшинээс даруй 20 хувиар бага үзүүлэлттэй байгаа юм. Сүүлийн үед Монгол хүн бүр 10000 ам.доллар буюу 34000000 төгрөгийн гадаад өртэй гэсэн мэдээ тарааж, өдөр бүр таны өр өсөн нэмэгдэж байна гэх сэтгэл зүйн дарамтыг үзүүлж байгаа нь сонгууль бүрээр иргэдэд айдас төрүүлж, төөрөгдүүлж буй ёс зүйгүй үйлдэл юм. Энэ үзүүлэлт нь цэвэр улс төрийн зорилгоор иргэд олон нийтийг айлган үймээхээр тооцоолж хэлэгддэг статистик болон эдийн засгийн ямар ч утга ач холбогдолгүй мэдээлэл юм. Нийт гадаад өрийг хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлтийг өндөр хөгжилтэй зарим улсуудын жишээн дээр харвал Люксембургийн нэг иргэнд 6 сая ам.доллар, Исланд улсын 56000 доллар, Хонг Конгийн нэг иргэнд 248000 доллар, Сингапурын нэг иргэнд 326000 доллар, Швейцарын нэг иргэнд 265000 доллар, АНУ-ын нэг иргэнд 73000 ам.долларын өр ноогдож, тухайн улсын иргэн төлж барагдуулах мэт буруу ойлголтыг төрүүлж байна.

Олон улсын хөрөнгө оруулагчид, үнэлгээний байгууллагууд аливаа улсыг хэр их өртэй вэ гэхээс илүүтэйгээр тухайн улс

авсан зээлийн ашиглалт, төсвийн сахилга бат эргүүлээд төлж чадах эсэхэд анхаарлаа хандуулдаг. Ингэхдээ Засгийн газрын өрийг ДНБ, экспортын орлого, Засгийн газрын орлого, Засгийн газрын өрийн үйлчилгээ зэрэг үзүүлэлтүүдтэй харьцуулдаг нь тухайн улсын төлбөрийн чадвар, өрийг барагдуулах боломжийг тодорхойлж, түүнд үндэслэн зээл олгох болон хөрөнгө оруулах шийдвэрээ гаргадаг. Өөрөөр хэлбэл, нэг хүнд ноогдох орлого, ДНБ-ий бодит өсөлт, төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцийн чадамж зэрэг үзүүлэлтүүдэд илүү ач холбогдол өгч ажилладаг. Цар тахлын дараах эдийн засгаа сэргээх, экспортоо нэмэгдүүлэх, гадаад валютын албан нөөц ханшийг тогтоон барих хүндхэн сорилтын зэрэгцээ геополитикийн хурцадмал нөхцөл байдалтай дасан зохицсон, тогтвортой, хүчтэй төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд улс төр, ард түмний сэтгэл зүйн дэмжлэг одоо зайлшгүй бидэнд хэрэгтэй байдаг.

Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 8.1 тэрбум доллартой тэнцэж байгаагаас 5.6 тэрбум долларыг 1991 оноос хойш түнш орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авч ашигласан гадаад зээлийн хөрөнгийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд эдгээр зээлийг 2060 он хүртэл эргэн төлөх хуваарьтай байдаг. Харин үлдэх 2.4 тэрбум доллар нь 2012 оноос эхлэн олон улсын зах зээлд арилжаалсан Засгийн газрын гадаад бондын үлдэгдэл байгаа бөгөөд эдгээр арилжааны нөхцөл бондыг 2031 он хүртэл төлж дуусгах хуваарьтай байна. Ингээд харахаар 2020-2024 оны энэ мөчлөг нь 1990 оноос хойш үүссэн Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх хамгийн өндөр ачаалалтай ийм жилүүд болж байна. Энэ 4 жилд нийтдээ 5.1 тэрбум долларын зохицуулалт хийх үүрэг хариуцлага бидэнд ирж байгаа. Өөрөөр хэлбэл жил бүр 1.2-1.3 тэрбум долларын өрийн зохицуулалт хийх ийм одоо хүндхэн сорилтын жилүүд бидний өмнө байна.

Ингээд юуны өмнө Засгийн газрын гадаад бондын гаргасан түүх, тэдгээрийн

зарцуулалтын талаар ярья. Монгол Улсын Засгийн газар 2012 онд Чингис бондыг гаргаснаар олон улсад Монгол Улсын Засгийн газрын гэсэн кодтой арилжааны үнэт цаасны шинэ түүх эхэлсэн байдаг. Уг 1.5 тэрбум долларын Чингис бондыг 5-10 жилийн хугацаатай, 4-5 хувийн хүүтэйгээр төсөл хөтөлбөр санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан. Арилжааны нөхцөлтэй уг бонд нь хөнгөлөлттэй зээлийг бодвол хүүгийн зардал өндөр байсны зэрэгцээ хугацаа богино, үнэт цаасны хөрөнгийг 1 жилд бүтэн дүнгээр төлж барагдуулах нөхцөлтэй, төсөвт учруулах төлбөрийн дарамт харьцангуй өндөр бөгөөд бондын эх үүсвэрээр өртөг ихтэй, өгөөж багатай, төсөл хөтөлбөр санхүүжүүлж, алдагдал алдагдсан боломжийн зардал ихтэй байлаа.

Иймд цаашид энэ төрлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, төслийн менежмент, эргэн төлөлтийн асуудлыг чангатгах зайлшгүй шаардлага тулгарч байна. Чингис бондын зарцуулалтын хувьд нийт эх үүсвэрийн 12.6 хувийг дотоодын арилжааны банкнуудаар дамжуулан ХАА, хөнгөн үйлдвэрлэл, ноос, ноолуурын салбарт зээлд, 24 хувийг эрчим хүч, хүнд үйлдвэрлэл, барилгын салбарын томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд, харин үлдсэн 63.4 хувийн эх үүсвэрийг төсвийн шинж чанартай, урт хугацаанд эдийн засгийн өгөөжөө өгдөг төмөр зам, авто зам, инженерийн дэд бүтэц, ХАА-н төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлжээ. Эндээс харахад Чингис бондын зарцуулалт нь буцаад тус бондын эргэн төлөгдөх дунд хугацаанд импортыг орлож, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд дорвитой дэмжлэг дунд хугацаанд бидэнд ирээгүй. Засгийн газрын гадаад бондын эргэн төлөлтийн хувьд бид өрийн зохицуулалт хийх бодлогыг 1-2 жилийн өмнө урьдчилан харж, гадаад валютын албан нөөц, төсөвт дарамт учруулахгүйгээр олон улсын зах зээл дэх таатай цонх үеийг ашиглаж зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд өнөөгийн эдийн засгийн хүндрэлийн үед буюу тухайлбал, яг

энэ жилд Чингис бондын эргэн төлөлтөөр гадаад валютын нөөц нэг тэрбум ам.доллараар унах эрсдэлээс сэргийлж чадсан.

Эдийн засгийн тодорхойгүй байдал ихтэй байгаа өнөө үед бид тулгаж биш урьтаж хөдөлсөн эрсдэлт судалгаанд суурилсан өрийн бодлогыг хэрэгжүүлэхээс аргагүйд хүрч байна. Иймээс ч бид Засгийн газрын өрийн баталгаатай Хөгжлийн банкны 23 оны 12 дугаар сард төлөгдөх гучин тэрбум иений Самурай бондыг төлөх валютыг тус банкны эргэн төлөлтийн хүрээнд үүссэн эх үүсвэрээс бүрдүүлж, Монголбанканд эргэн төлөгдөх хугацаанаас 1 жилийн өмнө Япон иенээр бүрэн байршуулаад байгааг мэдэгдэх нь сайн мэдээ болж байна. Хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн банк нь нэгэн цогц санхүүгийн систем болж тооцогддог тул Хөгжлийн банкны дахин санхүүжилтийн эрсдэлээс сэргийлж эх үүсвэрийг бүрэн нөөцөлж чадсан энэхүү арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсад итгэх итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Тухайлбал Чингис бондын 1.5 тэрбум долларын бондын эргэн төлөлтийг Гэрээ, Номад, Сенчури бондын эх үүсвэрээр өрийн дахин санхүүжилт хийж 136.8 сая долларын төлбөрийн эргэн төлөлт үлдээд байсныг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улс бүрэн төлж барагдууллаа. Хэдийгээр бид байгаа жоохон валютаа ашиглаж гадаад өрөө төлж болох ч түүний дараагаар үүсэж болзошгүй эдийн засгийн макро тогтвортой байдал алдах эрсдэлийг бид дараа нь дийлэхгүй. Эдгээр зүйлээс урьдчилан сэргийлж өөрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байгааг өрийг өрөөр дарлаа, урд хормойгоор хойд хормойгоо нөхлөө гэж улс төржүүлж байгаа нь бодит байдлыг мушгин гуйвуулж байгаа хэрэг юм.

Ийнхүү Монгол Улсын Засгийн газар дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар

тахлын дараах эдийн засгийн нөхцөл байдал Орос Украины зэвсэгт мөргөлдөөний эдийн засагт нөлөөлж буй нөлөөллийг үл харгалзан гадаадын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэн цаг хугацаанд төлж барагдуулан ажиллаж байна. Чингис бондын төлбөрийг ийнхүү хугацаанд нь төлж байгаа нь үүний нэг илрэл болж байгаа бөгөөд цаашид ч мөн дээрх үүргээ биелүүлсээр байх болно. Монгол Улсын Засгийн газрын 2012 онд төсөл хөтөлбөрөө санхүүжүүлэх зорилготой Чингис бонд гаргаж байсан бол төсвийн алдагдлыг нөхөх зорилготой Дим сам бондыг 15 онд, Мазаалай бондыг 16 онд, өрийн зохицуулалт хийх зорилготой үүнээс хойш гаргасан Хуралдай, Гэрэгэ бондуудыг 17 онд, Номад бондыг 20 онд? Сенчури бондыг 21 онд олон улсын санхүүгийн зах зээл дээр гаргасан.

Сүүлийн 5 жилийн хугацаанд хийсэн Гэрэгэ, Номад болон Сенчури өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд ижил зээлжих зэрэглэлтэй улсуудаас хамгийн бага түвшин хүүтэйгээр өмнөх бондуудыг мэргэжлийн өндөр түвшинд дахин санхүүжүүлж чадсан нь *finance asia* азийн шилдэг хөрөнгө оруулалт босгосон орон шагнал болон бусад олон улсын хэд хэдэн санхүүгийн салбарын шагналыг авсан байдаг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газар гадаад хөрөнгө оруулалтын зах зээл дээр хоёрдогч зах зээл дээр бонд гаргаж эхэлснээс хойш нийт 7 бонд гаргасан. Үүнээс эхний 3 бонд нь төсөл хөтөлбөр санхүүжүүлэх төсвийн алдагдлыг нөхөх зорилготой гаргасан. Үүнээс хойш гаргасан 4 бонд нь одоо бүгд өмнөх 3 бондын өрийг одоо зохицуулах зорилготой гарсан байдаг.

Бид Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдад тухай бүр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал цаашидын хөгжлийн чиг хандлага төсөв мөнгөний бодлого өрийн удирдлага болон Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн талаарх мэдээллүүдийг

нээлттэй ил тод байдлаар хүргэн ажилладаг бөгөөд цаашид ч мөн хөрөнгө оруулагчдын итгэл Монгол Улсын Засгийн газрын нэр хүндийг хадгалан ажилласаар байх болно. Засгийн газрын гадаад өрийн 70 хувийг эзэлж буй гадаад зээл, түүний зарцуулалт үр өгөөж цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар ярьж байна. Засгийн газар 1991 оноос хойш нийт 326 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор 7.7 тэрбум доллартой тэнцэх хэмжээний гадаад зээлийн хөрөнгийг авч ашигласан бөгөөд үүнээс 290 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 5.1 тэрбум доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төслийн зээлд зарцуулсан бол төсвийн алдагдал санхүүжүүлэх буюу төсвийн дэмжлэгийн зориулалтаар 2.6 тэрбум доллартой тэнцэх 36 хөтөлбөрийн зээлийг хөрөнгийг авч ашигласан.

Эдгээр зээлүүдийг нөхцөлөөр нь ангилбал Монгол Улсын Засгийн газар нь 30-40 жилийн хугацаатай 0-2 хувийн хүүтэй 168 зээл, 15-30 жилийн хугацаатай 1-5 хувийн хүүтэй 131 зээл, 15-аас доош жилийн хугацаатай 0-10 хувийн хүүтэй 27 зээлийг авч ашигласан. Энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр авч ашигласан зээлийн ихэнх хувийг хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээл эзэлж байгааг харуулж байна. Нийт 290 төслийн зээлийн 3.2 тэрбум долларыг нийгмийн шинж чанартай эргэн төлөгдөх нөхцөлгүй 169 төсөлд харин 1.9 тэрбум доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг эдийн засгийн үр өгөөжтэй дотоодод дамжуулан зээлдүүлэх 121 төсөлд тус тус зарцуулсан.

Дээрх төслүүдийн зээлийн 5.1 тэрбум долларын ашиглалтын 66 хувь буюу 3.4 тэрбум доллар нь биет хөрөнгө, барилга, тоног төхөөрөмж болж үлдсэн бол 34 хувь нь зөвлөх үйлчилгээ, үйл ажиллагааны болон магадалиггүй ажлын зардал, шимтгэл зэрэгт зарцуулагдсан байна. Эдгээр төслүүдийн 45 хувийг дэд бүтэц, агаарын тээвэр, боомт, төмөр зам, авто зам, орон сууц, инженерийн шугам сүлжээний хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол эдийн засаг 14 хувь хүрч, эрчим хүч 12

хувь, эрүүл мэнд 8 хувь, ХАА, уул уурхай, нийгэм хамгааллын салбарууд 5 хувь, боловсрол 4 хувь, харилцаа холбооны салбар 3 хувийг тус тус бүрдүүлж байна.

Гадаад төслийн зээлээр хэрэгжсэн томоохон төслүүдээс дурдвал, шинэ нисэх онгоцны буудал, түүний хурдны зам, замын цагдаагийн газрын гүүрэн гарц, Улаанбаатар, Налайх болон Тосонцэнгэл, Улиастай чиглэлийн авто зам, Яармагийн гүүр, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам, Улаанбаатар хотын дулааны цахилгаан станц 3, 4, Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлтүүд, Улаанбаатар Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Үндэсний оношилгоо, эмчилгээний төв зэрэг байна. Дээрх 326 төслийн 203 төсөл нь 3.8 тэрбум долларын санхүүжилт авч, 91-ээс 2022 оны эхний хагас жилийн хооронд хэрэгжиж дууссан бөгөөд үлдсэн 123 төсөл нь 2018-аас 26 оны хооронд хэрэгжихээр 1.3 тэрбум долларын зээлийг одоогоор авч ашиглаад байна.

Хэрэгжиж буй төслүүдээс дурдвал, мөн Төв цэвэрлэх байгууламж, Түлэнхийн төв, Улаанбаатар хотын нүхэн гарц, Улаанбаатар-Дарханы чиглэлийн авто зам, түүний нэмэлт 2 эгнээ барих төсөл, Гэр хорооллын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, орон сууцжуулах төсөл, Төвийн бүсийн эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслүүд, 10 аймгийн дулааны станц шинээр барих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төслүүд, боловсролын чанарын шинэчлэл, сургууль, цэцэрлэг шинээр барих, өргөтгөх төслүүд зэргийг дурдаж болно.

Харин хэрэгжилт нь муу явж байгаа төслүүд болох нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл, Монгол-Германы хамтарсан ашигт малтмалын технологийн их сургууль, Монгол-Энэтхэгийн хамтарсан Мэдээллийн

технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төсөл, Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх төсөл, Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал, төсөл, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл зэргийг цаашид холбогдох судалгааг хийж, шаардлагатай тохиолдолд хэсэгчлэн зогсоох зэрэг арга хэмжээг авч ажиллах болно.

Мөн цаашид гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглахдаа Засгийн газрын өрийн 2023-аас 25 оны стратегийн хүрээнд эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий эх үүсвэрийг үүсвэрээс татгалзаж, харин шинэ стратегийн шинэ сэргэлтийн бодлогод нийцсэн, бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах бодлогыг одоо тууштай баримталж ажиллана.

Энэ ч үүднээс өрийн стратегийг шинээр батлуулснаас хойш 2 талт түншүүд болох Унгар, Польш, Беларусь, БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөд байсан нийт 175 сая ам.доллартай тэнцэх үнийн дүн бүхий 4 төслийн зээлийг ашиглахаас 2 талаас тохиролцон татгалзлаа. Монгол Улсын Засгийн газрын зүгээс 2012 оноос эхлэн Монгол Улсын Хөгжлийн банкны Евро бонд, Самурай бонд, БНХАУ-ын Хөгжлийн банкны Зээл, Кредит свисс банкнаас авсан зээл, МИАТ-ын бойнг хөлөг онгоц авсан зээл болох нийт 7 зээлд Засгийн газрын өрийн баталгааг 3 жилийн дотор гаргасан байдаг. Энэ нь 15-16 онуудад Засгийн газрын өрийн хэмжээнд ихээхэн хэмжээгээр нөлөөлж, төсөвт учруулах болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг нэмэгдүүлсэн.

Харин 2015 оны 2 дугаар сард Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаар Засгийн газрын өрийн баталгаа гаргах шаардлагыг өндөр болгож, баталгаа гаргуулж буй байгууллага нь сүүлийн 3 жил ашигтай ажилласан, хугацаа хэтэрсэн өргүй, зээлдүүлэгч талдаа хамааралгүй, хэрэгжүүлэх төслийн бэлтгэл ажил хангагдсан, баталгаат зээлийг эргэн төлөх чадвартай байх өндөр шаардлагын босгыг тавьсан. Түүнчлэн баталгаа гаргуулах төсөл хөтөлбөрүүдэд эргэн төлөх чадвартай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийж эхэлсэн бөгөөд өндөр эрсдэлтэй байгууллагуудад Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг болих болсон байдаг. Тус шалгууруудаас шалтгаалан 15 оноос хойш Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд гарсан үнэт цаас, Эрдэнэс Монгол ХК-ийн АХБ-аас авсан зээл зэрэг 2 төсөлд баталгаа гаргасан.

Засгийн газрын өрийн баталгааг гаргахдаа Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичигт тусгасны дагуу Монгол Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангах бодлогыг баримталж ажиллана. Чингис бондын зарцуулалт болон төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас үүссэн 2 төсвөөс гадуур гэрээ хийгдсэн барих шилжүүлэх төрлийн концесс, векселийн өрүүд нь дараа онуудын төсвийн хузууг татаж байлаа. Эдгээрийг нэгтгэн төсөвт тусган батлахад төсвийн алдагдал ДНБ-ий 15.2 хувьд хүрсэн. Засгийн газрын дотоод бондыг төсвийн алдагдал болон өмнө гаргасан үнэт цаасыг дахин санхүүжүүлэхэд зөвхөн 16 онд 2.9 их наяд төгрөг, 17 онд 3.1 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг нээлттэй болон хаалттай хэлбэрээр сайн хөтөлбөрүүдийн хүрээнд 596 тэрбум төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг арилжаалсан байдаг.

Үүн дээр нэмээд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Мазаалай, Дим сам болон Кредит свисс банкнаас

арилжааны нөхцөлтэй зээлүүдийг авч ашигласан. Ингэснээр өрийн хэмжээ 2015 оноос 2016 оны хооронд огцом 57.3 хувиар нэмэгдэж байсан. Эдгээр зээлийн хөрөнгийг авч ашигласнаар 2016 онд үүсээд байсан хямралын үед гадаад валютын албан нөөцийг дэмжиж байсан хэдий ч үүнээс шалтгаалж Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр мэдэгдэхүйц өссөн байдаг. Тухайлбал, 12 онд 6 их наяд төгрөгтэй тэнцэж байсан төсвийн зарлагын хэмжээ 16 онд 9.5 их наяд хүртэл өсөж, үүнээс хүүгийн зардал 125.9 тэрбум төгрөгөөс 1.2 их наяд төгрөгт хүрч, даруй 9 дахин өссөн. Үндсэн төлбөрийн хэмжээ 16 онд 1.7 их наяд төгрөг, 17 онд 5.1 их наяд төгрөгтэй тэнцэж байсан. Засгийн газрын зүгээс эдгээр төлбөрийг төлж барагдуулахаар дотоод үнэт цаас арилжаалж байсан хэдий ч өмнөх онуудын богино хугацаат бондуудын дахин санхүүжилтүүд хуримтлагдсаар 1 жилд төсөв дээр ирэх төлбөрийн чадварын төлбөрийн дарамтыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байсан тул арилжааг зогсоохоос өөр аргагүйд хүрсэн.

Түүнчлэн 2013 оноос эхлэн 2017 оныг хүртэл улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй барих шилжүүлэх концессын 90 төслийн нийт 2.4 их наяд төгрөгтэй тэнцэх гэрээг хийж, өмнөх онд хийгдсэн ажлын төлбөрийг төсвөөс авч чадаагүй үлдэгдэл нийт 8, төлбөрт 8 хувиас 16 хувийн хүүтэй векселийг 15 оноос эхлэн бичиж эхэлсэн байдаг. Энэ нь тухайн онуудад хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж, төсөвт дарамт учруулж байсан тул 17 оноос эхлэн шинээр тухайн гэрээнүүдийг байгуулахаа огт зогсоосноор векселийн өрийг бүрэн төлж барагдуулан 22 оны хагас жилийн байдлаар концессын өр 470 тэрбум төгрөг болж буурууллаа.

Төсөв, санхүүгийн сахилга батыг сахиагүйгээс үүдсэн төлбөрийн дарамтыг 17 оноос төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, мөн Орос, ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж олон улсын түнш байгууллагуудаас төсвийн

дэмжлэгийн зээл авч төлж байсан. Ингэснээр 22 оны хагас жилийн байдлаар Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 517 тэрбум төгрөг, энэхүү дотоод үнэт цаасны төлөх хүүгийн хэмжээ 21 онд 118 төгрөгт хүрч буурлаа. Төлбөрийн дарамт хэрхэн буурсан тухай дэлгэрэнгүй дурдвал, 2017 онд дотоод үнэт цаасны хүүгийн төлбөр 608 тэрбум төгрөг, нийт хүүгийн төлбөр төсвийн орлогын 14.5 хувьтай тэнцэж байсан бол 19 оноос дотоод үнэт цаасны хүүгийн төлбөр буурч, 21 онд 118.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд хүүгийн зардал нь төсвийн орлогын 6 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Өөрөөр хэлбэл, 2017 онд төсвийн орлогын 7 төгрөг тутмын нэгийг хүүд төлдөг байсан бол 21 оны байдлаар 16 төгрөг тутмын нэгийг хүүгийн зардалд төлдөг болж, төсвийн үзүүлэлт харьцангуй сайжирлаа. Засгийн газрын дотоод үнэт цаасны хүүгийн зардлыг өсгөхөд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь анхдагч зах зээлийн оролцоо бага байсантай холбоотой. Энэ нь ихэнх арилжаа Монголбанкаар дамждаг, мөн Монголын хөрөнгийн биржээр гарсан ч арилжааны банкнаас өөр оролцогч орох боломж бага байсан тул зах зээлийн жишиг хүүгийн түвшин 15-аас 17 онд бодлогын хүүгээс тав орчим хувийн өндөр тогтоож байсан. Өндөр хүүтэй Засгийн газрын дотоод үнэт цааснаас татгалзаж, төсвийн алдагдлыг хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлээр нөхөж эхэлснээс шалтгаалж нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээ 2016 онд 55.5 хувьтай тэнцэж байсан бол 19 онд 85.7 хувь, 22 оны эхний хагас жилд 93.2 хувьд хүрч өссөн байна.

Энэ нь Засгийн газрын өрийг гадаад валютын ханшаас хамааралтай ханиийн хэлбэлзлийн эрсдэлтэй болгож байгаа учир Засгийн газрын өрийн удирдлагын 23-аас 25 оны стратегийн баримт бичигт тусгасан өрийн багцын үзүүлэлтэд гадаад валютаар илэрхий өрийн хэмжээг бууруулах зорилт тавилаа. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхээр 23 оноос эхлэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх анхдагч болон

хоёрдогч зах зээлийн арилжааг мэргэжлийн хөрөнгө оруулагч, иргэд, ААН-ийн оролцоог бүрэн хангах байдлаар нээх үнэт цаасны арилжаанд оролцогчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, олон нийтэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчдын бааз суурь нэмэгдэж, Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжааны оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх хоёрдогч зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилготой юм.

Эцэст нь хэлэхэд гадаад хөрөнгө оруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагууд, хөгжлийн түнш орнуудад Ардын намын тавьсан өр, АН-ын тавьсан өр гэж ялгаж ярьдаггүй. Зөвхөн Монгол Улсын Засгийн газрын гэсэн ганц кодтой л өр байдаг. Үүнийг санаж, ирээдүйн өрийн удирдлагын бодлогыг ухаалгаар хэрэгжүүлж, бага улс төржүүлж, эх оронч нэгдмэл байр суурьтай байхыг та бүхэнд уриалж байна. Ирээдүй хойч үедээ муу өр биш, сайн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг үлдээцгээе. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Мэдээлэлтэй холбогдуулж, цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дэд дарга Наянтайн Ганибал үг хэлнэ. Индэрт урьж байна.

Н.Ганибал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Монгол Улсад эдийн засгийн хэд хэдэн хямрал нүүрлээд байна. Зах зээлийн нийгэмд ишлэсэн 30 жилийн түүхэнд Монгол Улсын эдийн засаг ийм хүнд шоконд орж байсангүй. Эдийн засгийн өсөлт нь зогсонги байдалд орж, өндөр инфляц дагалдах хосолсон сөрөг үзүүлэлтийг стагфляц гэдэг. Манай улсын эдийн засаг стагфляцад нэрвэгдсэн төдийгүй нэмээд өөрийн хямралд өрийн хямралд өртжээ. Ийм гурвалсан хямралыг даван туулах нь нэн хүнд байдаг. Нийт 3.4 сая хүнтэй манай улсын ДНБ ердөө 14

орчим тэрбум ам.доллар. Гэтэл улсын нийт өр 33.2 тэрбум ам.доллар давлаа. Өнөөгийн эрх баригчид 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеэр Монгол иргэн бүрд 15 сая төгрөгийн өр ногдож буй талаар улс орон даяар ярьж, матрын нулимс унагасан.

Харин одоо энэ үзүүлэлт гучин сая төгрөг хол давлаа. 1991 оноос 2016 оны хооронд Монгол Улсын Засгийн газрын өрийн хэмжээ 4 тэрбум орчим ам.доллар байсныг өнгөрсөн 6 жилд 2 дахин нэмэгдүүлж, 8 тэрбум ам.долларыг давуулж, ам ажил нь алд дэлэм зөрлөө. Хэрэв Монголбанкны своп, Хөгжлийн банкны таван зуун сая ам.долларын бонд, МИАТ, төмөр зам зэрэг төрийн өмчит өмчтэй олон компаниудын өр, өрийн баталгаа зэргийг нэмж тооцвол Засгийн газрын өр ДНБ-ий зуун хувь хүрлээ. Үүнийг Дэлхийн банк баталж, танай Засгийн газрын өр ДНБ-ий чинь 92 хувьд хүрлээ. Монгол Улс хойчид хойч үедээ өр өвлүүлж байна хэмээн дүгнэсэн байдаг. Монгол Улсын гадаад өр олон улсын дундаж зохистой хэмжээтэй харьцуулахад тав дахин өндөр байгааг ОУВС анхааруулж байгаа юм. Ийм их хэмжээний өрийг урьд өмнө нь ямар ч Улсын Их Хурал, Засгийн газар үйлдвэрлэж байсангүй. Энэ их өрийн дарамт, дарамт ирээдүй хойчид маань өвлөгдөн үлдэх төдийгүй улс орны хөгжлийг олон жилээр хойш татна.

Ийнхүү Монгол Улс гадаад өрийн хавханд гүн баттай шигдээд байна. Өрийг өдөөгч хэд хэдэн хүчин зүйл бий. Хамгийн эхэнд төсвийн алдагдал орно. Сүүлийн жилүүдэд манай улсын төсвийн алдагдал 2 их наяд төгрөг хол давдаг хуучтай боллоо. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн төлсөн хөрөнгийг тухайн жилд нь үрж дуусгаад, дээр нь хэдэн их наядаар хэмжигдэх мөнгийг гаднаас зээлж, нэмж зарцуулах төслийг Засгийн газар боловсруулж, Улсын Их Хурал баталсаар өнөөдрийг хүрлээ. Үндэсний аудитын газраас 2018-аас 2020 оны байдлаар шинээр олгосон болон үргэлжилж буй гадаад зээл, тусламжийн ашиглалтад аудит хийсэн. Аудитын

дүгнэлттэй Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ 2018 онд өмнөх оноос 22.3 хувиар, 2019 онд 14.3 хувиар, 2020 онд 28.9 хувиар тус тус тус тус өсжээ. Нийт авсан зээлийн 44 орчим хувь нь төсвийн алдагдлыг нөхөд зарцуулжээ гэж дүгнэсэн.

Энэ байдал сүүлийн 3 жилд улам даамжирлаа. 2020 оны төсвийн алдагдал 4.5 их наяд, 2021 оны 3.7 их наяд төгрөгт хүрч, 2022 онд 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв батлагдсан байдаг. Энэ нь сүүлийн гуравхан жилд Засгийн газрын өр 10 их наяд төгрөгөөр нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлжээ. Төсвийн ийм их хэмжээний алдагдал инфляцыг хөөргөж, үнэ өсгөж буй нь бага орлоготой болон тэтгэврийн насны ахмадуудын амьдралд туйлын сөргөөр нөлөөлж байна. Ийнхүү төсвөөр дамжин үнэ өсөх, үндэсний валютын ханиш унах, валютын нөөц буурах зэрэг олон муу үр дан гарч байна. Дундаж давхарга үндсэндээ үгүй болж, нийтээрээ ядуурч эхэлсэн нийгэм нэн түгшүүртэй байна.

Гадаад өрийг нэмэгдүүлэх дараагийн хүчин зүйл нь бондын зээл. Бондын түүх Сү. Батболдын Засгийн газрын үед буюу 2012 оны 3 сарын 21-нд 5 жилийн хугацаатай, 600 сая ам.долларын Евро бонд босгосноор эхэлжээ. Тухайн үед дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ огцом өсөж, Оюутолгой төсөл хөдөлсөнтэй холбоотой гадаадын шууд хөрөнгө оруулалт түүхэн дээд хэмжээнд хүрч, эдийн засагт асар их хэмжээний валют орж ирсэн юм. Ийнхүү Монголын эдийн засаг 17 хувьд хүрсэн алтан үеийн өнөөгийн эрх баригчдад өөрсдийн хийсэн ажил мэт ажил гэж цаасан малгай өмсөж явсан юм. Чухам ийм таатай үед хуримтлал бүрдүүлэхийн оронд гаднаас бонд босгоод зогсохгүй асар их хэмжээний гадаад зээлүүд авчээ. Тэр үеийн Евро бонд өнөөдрийг хүртэл төлөгдсөнгүй хэвээр л байна. Дүрээ хувиргаад харин Боролдой бонд болжээ.

Монгол Улсын Засгийн газар 2008 оны сонгуулийн амлалтаа биелүүлэхийн

тулд Эрдэнэс таван толгойн нэрээр 350 сая ам.доллар, Оюутолгой нэрээр 250 сая ам доллар, Эрдэнэтээс хоёр зуун тэрбум төгрөг гэх мэтээр нийт тэрбум ам.доллар зээлж, бэлэн мөнгө хэлбэрээр нийтэд тарааж, өнөөгийн өрийн хавхны эхлэлийг тавьсан юм. Эрх баригчид зах зээлийн нийгэмд шилжсэн 32 жилийн 26-д нь Засгийн засгийн эрх нь байсан хэр нь Чингис бондын бүтээн байгуулалтын 20 хувьд нь хүрэх ажил хийж чадаагүйг иргэд шүүмжлэн хэлэлцэж байна. АН-ыг олон бонд босгосон гэж буруутгадаг. Гэвч Самурай бондыг босгох үед хамтарсан Засгийн газрын Сангийн сайдаар Жаргалтулгын Эрдэнэбат ажиллаж байсныг мартдаг. Дим сам бондын талаар тухайн үед Сангийн сайдаар ажиллаж байсан Улаан маш тодорхой хариулт өгөх ёстой гэдгийг ч мэдээгүй мэт дүр эсгэж ирлээ. Эндээс харвал Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны босгосон нийт 11 бондын ердөө 2 нь л АН-д харьяалагдаж байна.

Гадаад өрийг нэмдэг 3 дахь хүчин зүйл бол тооцоо судалгаагүй, үрэлгэн, үр дүнгүй хөтөлбөрүүд. Монгол Улсын Засгийн газар ковид цар тахлаас сэргийлэх зорилгоор нийтдээ 15.1 их наядаар хэмжигдэх 2 том хөтөлбөр хэрэгжүүлээ. Донор улс орон, санхүүгийн олон улсын байгууллагуудаас тэрбум ам.долларын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл авсан. Эрдэнэт УУГ-аас 1.2 их наяд төгрөг, Оюутолгойгоос Арбитрын шүүхийн барьцаанд байсан 1 их наяд төгрөг гээд мэтээр ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсан нь дэлхийн улс орнуудын дунджаас бараг 3 дахин их үзүүлэлт юм. Монгол Улс бүтэн жилийнхээ төсвийнхөө орлоготой тэнцэхүйц хэмжээний хөрөнгийг цар тахлын эсрэг арга хэмжээнд зарцуулжээ. Америкийн судлаачдын гаргасан үр дүнгүй зардлын хувь хэмжээгээр тооцоход ядарсан эдийн засагтаа чамгүй хохирол учруулж амжжээ. Тооцоо судалгаагүй их наядаар хэмжигдэх хөтөлбөрийн сөрөг үр дагавар олон жил үргэлжилж, ирээдүйд багагүй балаг тарих нь тодорхой боллоо. Үүнийг

зөвхөн гадаад өрийн хэмжээ богино хугацаанд асар ихээр нэмэгдсэн үзүүлэлтээс харж болно.

Ийнхүү манай улсын эдийн засгаа дэмжиж, тэлэх зорилт нь дотоод, гадаад өрөөр санхүүжих өртэй энэ эмзэг эдийн засагтай болгож, төсвийн ур урхагшсан алдагдал нь гадаад өр өсгөх суурь шалтгаан болжээ. ОУВС Монгол Улсыг 2023 онд биш юм гэхэд 2024 онд дефолт зарлах топ 10 улсын тоонд байнга оруулж байна. Иймээс манай улсын гадаад өрийн удирдлагыг сайжруулахад одоогийн хууль, журам, стратегийг нэн даруй өөрчлөх шаардлагатай. Тодруулбал, гадаад зээлийг цаашид экспортыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд ашиглах хэрэгтэй байна. Түүнчлэн гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь өөрийн үйл ажиллагаа, орлого, ашгаараа зээлийн төлбөрөө гүйцэтгэх чадвартай нөхцөлд гаднаас зээлийн эх үүсвэр татах, хатуу зарчмыг хуульчлах, хэрэглээ болон халамжийн зээлийн эх үүсвэрээр санхүүжих санхүүжүүлэхийг хориглох эрх зүйн орчин бидэнд хэрэгтэй байна.

Улс орны эдийн засаг сэхээний тасагт гадаадын өргөсөн хиймэл амьсгаа залгагдан хэвтэж байна. Ийм байдалд хүргэхэд нь эрх баригчдын тооцоо судалгаагүй шийдвэрүүд дээр хэт үрэлгэн төсвийн хөрөнгө оруулалт, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөгжлийн банк, арилжааны банкнуудтай холбоотой найдваргүй зээлүүд концессын хэдэн зуун тэрбум төгрөгийн луйврыг залган, нүүрсний оффтейк гэрээний асуудал сөхөгдсөн нь тэрбум ам.доллараар яригдаж эхэллээ. Оффтейк гэрээ Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой аюул учруулж, парламентын засаглалыг үүсгэсэн улс орныг дампууралд хүргэх харалган алхам мөн гэдгийг онцлон тэмдэглэе.

Өнөөдөр Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ эдийн засаг, тусгаар тогтнолын аюулгүй байдалд аюул занал учруулах хэмжээнд хүрлээ. Гадаад өрийн

хэмжээ огцом өсөх нь нийгмийг цочроож, элдэв хөдөлгөөн гарах, түүнийг бусад улс орон өөрийн ашиг эрх ашигт тохируулан ашиглах, тэр бүү хэл улс төрийн дэглэм солигдоход хүргэж байсан жишээ олон бий. Гадаад өрийн асуудал улс төржиж, сонгуулийн санал цуглуулдаг хэрэгсэл огт биш. Харин төрийн хар хайрцгийн хэмжээнд яригдах улс орны хөгжил дэвшлийн бодлогын нэн чухал асуудал гэдгийг эрх баригч та бүхэнд дахин сануулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Мэдээллүүдтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүд. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Доржханд гишүүнээр тасаллаа.

Б.Пүрэвдорж: Өр яаж үүсэх вэ гэж сая манай Ганибал даргын илтгэл дотор бас нэлээн сайн тусаж өгсөн байна. Тэгэхээр 3 зүйлээр өр үүсээд байгаа юм. Эхнийх нь бол төсвийн алдагдал. Сүүлийн 3 жил 11 их наяд төгрөгийн төсвийн алдагдал үйлдвэрлэсэн байгаа. 20 онд 4.5, 21 онд 3.7, 22 онд 2.4 гээд 11 их наяд. Тэгээд энэ 11 их наяд чинь бараг 3 Чингистэй тэнцэнэ. Тэгээд бонд, 2 дахь нь бол бонд босгож өр үйлдвэрлэж байгаа. Тэгээд Засгийн газар Хөгжлийн банк нийлээд 11 бонд босгосон байгаа. Тэрний 9 нь АН-д хамаатай. Дим сам бондыг Ж.Эрдэнэбат Сангийн сайд байж байхдаа босгосон. Самурай бондыг Улаан Сангийн сайд байж байхдаа босгосон. Тэгээд энэ тэр 2 одоо бонд дээр л одоо АН руу бүх юмаа дайрдаг ийм зүйл байгаад байгаа юм.

Тэгээд 3 дахь нь бол тооцоо судалгаагүй хөтөлбөрүүд байгаа. 10 их наядын, 5 их наядын, 15 их наядын хөтөлбөр байж байна. Тэгээд энэ одоо төсвийн алдагдал энэ тооцоо судалгаагүй хөтөлбөрүүд чинь нийлээд 26 их наяд 5 Чингис бондтой тэнцэхээр байна шүү дээ. 5 Чингис бондтой. Тэгээд л ерөөсөө ганцхан тэр нэг Чингис бонд руу нэг хамгийн их бүтээн байгуулалт хийсэн Чингис бонд руу л дайраад байгаа юм. 16 онд 15 сая төгрөгийн өртэй хүн болгон болчихлоо гээд л матрын нулимс унагаж,

унаж унаж засаг авсан МАН өнөөдрийг хүртэл 33 сая болгоод нэг дахин өсгөчихсөн. Тэгсэн мөртөө ганцхан тэр ажил хийсэн Чингис бонд руу буруугаа түлхсэн хэвээрээ л байгаад байна, байгаад байгаа юм. Тэгээд өөрсдөө ажил хийе. Энэ одоо хүмүүсийн бухимдал чинь энэ ард түмнээ хоосорсонтой л холбоотой шүү дээ. 16 онд 1.2 хувийн инфляцтай засаг өгч байсан, өнөөдөр 15, 6 бодит байдал дээр бараг 20 гараад явчихсан байгаа. Энэ чинь инфляц чинь ард иргэдийн халаасыг хоосолсоор байгаад сүүлдээ энэ нүүрсний хулгай гарангуут нь тэр нэг хэсэг нь баяжаад байхаар ихэнх ард түмэн нь бүгдээрээ ингээд хоосроод байх дээр тэр хүмүүс чинь амьдрал хэцүү байна гэж л жагсааж байгаа шүү дээ.

Өрөө өр тавьж болно л доо. Тэгэхдээ тэрнийгээ баялаг бүтээх тэр салбар руу л бүгдийг нь хийх ёстой байхгүй юу. Тэр Чингис бондын чинь хүрээнд 888 төсөл хөтөлбөрт импортыг орлох, экспортыг дэмжих ийм төсөл хөтөлбөрт оруулсны үр дүнд өнөөдөр төсвийн орлого чинь сүрхий биелээд явж байгаа шүү дээ. Өөрсдөө ажлаа хий, өр нэмэгдүүлэхээ боль. Одоо ингээд хариулт нь мэдээж Чингис бонд л ярих байх, хариулт авахгүй.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Өнөөдрийн Ерөнхий сайдын мэдээлэл Монгол Улсын өр Засгийн газар өрөөр мэдээлэл хийгдэж байна л даа. Бид нар одоо энд дахиад өртэй, өргүй, улсын өр, Засгийн газрын өр, эдийн засаг сайн байгаа, муу байгаа гээд л Одоо баахан л юм одоо энэ мэдээж одоо энэ тал талаасаа ярьцаана. Бид нар шүүмжилнэ, эрх баригчид их сайхан байгаа гэнэ. Сайхан байгаа, муу байгааг яг одоо бодит байдал дээр энэ гудамжинд байгаа иргэдийн энэ бухимдал өөрөө харуулж байна. Болж өгвөл виз нь гарвал бүгдээрээ Солонгос явчихыг хүсэж байгаа тэр залуучуудын цуваа тэр оочир дараалал эдийн засгийг бүгдийг нь харуулж байна. Үнэндээ энэ гадна байгаа жагсаал чинь ажлын байргүй

болоод, валютын ханиш өсөөд, юмны үнэ өсөөд болохоо байчихсан иргэдийн бухимдал л энд байгаа шүү дээ. Тэгэхээр энд эдийн засаг сайн байгаа, муу байгаагийн тухай яриа мэдээж энд бид нарын дүгнэлт ямар ч шаардлагагүй.

Хоёрдугаарт нь энэ өрийн асуудал гэдэг чинь дахиад яг саяын бүх зүйлүүдийн огтлолцол болж байна. Экспортын орлого уг нь бол өр гэдэг зүйл чинь гаднаас авсан валютаа одоо төлмөөр байдаг, экспортоосоо орлого олмоор байдаг. Нөгөөг нь уул уурхай буюу экспортын орлогынхоо 93 хувийг бүрдүүлж байгаа уул уурхай тэрнийхээ бараг 90-ээд хувийг нь бүрдүүлж байгаа нүүрсээ бүгдийг нь хулгайлаад идчихсэн. 4, 5 жилийнхээ нүүрсийг бүгдийг нь урьдчилж аваад идчихсэн бид нар. Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг зүйл одоо үнэндээ байхгүй ийм л нөхцөл байдалтай байгаа учраас яг одоо энд тэр өр гэдэг зүйл чинь олон зүйлийн огтлолцол, зүгээр нэг Засгийн газар өр их, бага улсын өр нь тусдаа гэж мэтгэлцэх биш. Яг одоо үнэндээ 33 тэрбум доллар Монгол Улсын өр зуу гаруй их наядын өрөө байгаа шүү дээ. Энэ Засгийн газар төлөхгүй ийм учраас хамаагүй гэж эрх баригчид тайлбарладаг. Яг үнэндээ бас хамаатай шүү дээ.

Тэгэхээр бизнесүүд зах зээл дээрээс төгрөгөөр доллар худалдаж аваад гадагшаа бизнесийнхээ өрийг төлөх нь байна. Энэ ханиш нь нөлөөлөхгүй гэж үү? Энэ Монгол Улсын эдийн засагт нөлөөлөхгүй гэж үү энэ ер нь? Яагаад заавал ингэж тайлбарлаад байгаа юм бэ? Тэгэнгүүтээ тайлбар дотроо хэлдэг Монгол бол бас одоо хөгжиж байгаа орон. Монгол байтугай Америк, Япон өртэй гэдэг. Гэтэл тэр Америк чинь Америкийн бусдаас зээлж байгаа тэр мөнгөн тэмдэгт нь Америкийнхаа доллароор тэд нар чинь зээлээ авчхаж байгаа юм. Японы иенээр тэд нарт зээлж болно, зээлээ авчхаж болно, энэ нь өөрөө хөрвөдөг. Болохгүй бол тэрийгээ хэвлээд төлсөн ч чадах тийм улсууд. Дахиад дээрээс нь тэд нарын тэр баланс тэнцэтгэл дээр нь өрнөөс гадна

авлаа гэдэг том зүйл тэр улс орнуудад бий. Тэгэхээр бид нар яадаг вэ яг эсрэгээрээ хэнд ч хэрэггүй цаас болж байгаа төгрөг төгрөгтэй. Гадаад улс орнууд төгрөг авахгүй. Бид нарын дансан дээр өглөг байхаас биш манай дансан дээр авлага гэдэг зүйл байхгүй. Ийм л нөхцөл байдалтай.

Тэгэхээр тэр яг үнэндээ тэр 33 тэрбум долларын зуу гаруй их наядын гурван сая хүнд хуваагаад нэг хүнд 35 сая төгрөгийн өр ноогдож байна гэдэг бол яг үнэндээ энэ бол улс төрийн угаасаа биш шүү дээ. Энэ бол бодит байдал шүү дээ яг. Тэнд байгаа бизнес чинь Найман шаргаас гараад доллар аваад гадагшаага зарна гэдэг чинь яг үнэндээ шууд бусаар Засгийн газар дээр төрийн бодлого дор валютын ханиш дээр, валютын ханишаар дамжаад иргэдийн худалдан авах чадвар дээр дарамт болж л очно шүү дээ. Одоо ийм л байр суурьтай байдаг. Тэгээд дараагийн 20 минутад би асуух болохоор тэндээ асуултууд асууя.

Г.Занданшатар: Асуулт. 20 минут дээр та чинь асуулт асууна. Салдангийн Одонтуяа гишүүн. Одонтуяа гишүүн. Карт чинь уншигдаагүй байна таных.

С.Одонтуяа: Тэгэхээр эдийн засаг бол хэдэн ухаантай хүмүүсийн бодож олсон зүйл гэхээсээ илүү талхны ухаан байдаг, махны ухаан байдаг, ер нь хүмүүс өөрөө өөрсдийнхөө мэддэг зүйлээр л эдийн засгаа хэмжиж байгаа. Тэгэхээр би бас иргэдэд ойлгомжтой хэллэгээр нь хэдэн зүйлийг хэлж асууя гэж бодож байна. Одоо сүүлийн үед бол бид нар ерөөсөө нүүрсний хулгайгаар л хүмүүс амьсгалж байна. Тэгэхээр энэ нүүрсний хулгай гэдэг бол энэ улс орны эдийн засаг ямар, одоо ялангуяа энэ өрийг төлөх дээр бол энэ нүүрсний хулгайтай зүйрлүүлээд ярья л даа алдагдсан боломж гээд. Жишээлэхэд, одоо Монгол Улсын Засгийн газрын өр найман тэрбум доллар гэж байна. Бид нар бараг энэ нүүрсний хулгайгаар чинь мөнгөөр бараг Засгийн газрын бүх өрөө төлчих

боломж байсан юм биш үү ер нь нэгдүгээрт энэ.

Хоёрдугаарт, АН-ын бүлэг бол удаа дараа хэлж байсан. Төсвийг алдагдалтай баталбал энэ гадаад өрөө төлөхөд бид нар хүндрэлтэй болно, энэ бол боломжгүй болно шүү гэдгийг удаа дараа хэлсэн. Гэтэл Засгийн газар бол хүндрэл үүсэхгүй, бид нар мэдэж байгаа, та нар санаа зоволтгүй, энэ бол алдагдал харин ч гайгүй буурсан, энд бол асуудлаа зуу хувь хариулна хариуцна гэсэн. Тэгэхээр Сангийн сайд та нэг энэ Улсын Их Хурлын танхимд дахиад нэг хариуцлагатайгаар нэг хэлээч. Одоо энэ 23 оны гадаад өр төлбөрт Монгол Улс, Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам бол ямар ч одоо асуудал үүсэхгүй, хүндрэл гарахгүй, бид нар бүх юмаа тооцоолсон гэдгээ та хэлээд бас бид нарын санааг нэг амраагаад өгөхгүй юу. Тэгээд одоо байнгын ийм түгшүүртэй амьдрах ч бас хэцүү байна.

Энэ ямар өр вэ гээд санаа зовоод байгаа вэ гэхээр Гэрээг бондын 533 сая ам.доллар, Хөгжлийн банкны 500 сая ам.доллар, Монголбанкны своп хоёр тэрбум гээд энэ өрүүд төлөгдөхөөр бид энэ Засгийн газарт ийм боломж байхгүй харагдаад байгаа юм. Тэгэхээр одоо энэ өрийг яаж, хаанаас, ямар журмаар төлөх гээд байгаа юм бол? Төсвийн асар их алдагдлаар бол бид нар маш их боломжийг алдсан байна. Тэгэхээр би зүгээр иргэдэд ойлгомжтой хэлээр ярья л даа. Манай улсын энэ алдагдлаар гэр хорооллын бүх айлыг тохилог орон сууцанд оруулах боломж байсан байна. Нийслэлд метро тавьж, утаагүй, түгжрэлгүй болох боломж алдагджээ. Төсвийг нь алдагдалтай баталснаар. Тооцоо судалгаагүй төрийн шийдвэрүүд цаашид үнэ өсөх, ханш сулрах, гадаад валютын нөөц багасах, зээлийн хүү нэмэгдэх гээд маш олон муу үр дагаврыг дагуулж байгаа. Энийг нь бол горьг нь иргэд амсаж байна. Тэгэхээр 13-16 онуудад Монголбанкны 3 их наяд төгрөгийн ипотекийн хөтөлбөрийн хүрээнд 86000 айл орон сууцанд орсон байгаа бол одоо 250000 тохилог орон сууц бариад иргэддээ үнэгүй

бэлэглэх хэмжээний мөнгийг төсвийн алдагдал болгон хувиргажээ. Ингэж одоо бид нар бас татвар төлөгчдийн мөнгөөр ингэж хүйтэн хандах хэрэг бол байхгүй л байсан.

Засгийн газрын ковидын үед хэрэгжүүлсэн бодлого бол Монгол Улсын эдийн засагт бол маш сөрөг үр дагавар авчирсан. Ялангуяа 5.1 их наядын хөтөлбөр энийгээ дүгнээгүй байхдаа 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Ингээд ямар ч тооцоо судалгаагүй, 15 их наяд төгрөг гэдэг бол Монгол Улсын ДНБ-ий 40 хувьд нь хүрчхэж байгаа юм. Ингэж ДНБ-ийхээ бараг тал хагаст нь хүргэж байсан ийм одоо үр дүнгүй бодлого хэрэгжүүлсэн орон манайхаас өөр байхгүй байх гэж би бодож байна. Би бас нэг муу ч, сайн ч бас нэг эдийн засагч ухаантай. Тэгэхээр энэ өөрөө маш том сөрөг үр дүн аваад ирлээ гээд. Нэг асуулт асууя. Одоо энэ ерөөсөө МАН-ын энэ бодлогууд хувийн хэвилийг ер нь дуусгалаа, одоо хүмүүс ерөөсөө бүх компаниа хаагаад гадаад явъя, Солонгост очиж хар ажил хийе гэдэг болчхож. Тэгэхээр хувийн хэвилийг яаж дэмжиж, энэ өрөө төлөх төлөвлөгөө байна вэ, хувийн хэвилийг яаж дэмжих юм 23 онд? Бичил зээл өгөх юм уу, ждү зээл өгөх юм уу? Хувийн хэвшил чинь бас энэ өр төлөхөд бид нар чинь хамтарч оролцох үүрэгтэй шүү дээ. Тэгэхээр энэ зүйлийг бол одоо асуумаар байна.

Хэн Пүрэвдорж гишүүн бас нэг зөв юм хийсэн шүү дээ. Энэ татварт орлого оруулж байгаа компанийнхаа захирлуудад тэр ногоон паспортыг нь өгчих, эд нарыгаа ашиглая гэдэг чинь зөв байхгүй юу. 90 онд Монголын бүх хүнд гадаад паспорт өгвөл энэ зах зээлийг чинь дор нь дүүргээд л хаячихсан шүү дээ. Тэгэхээр иймэрхүү эдийн засгийн хөшүүргийг одоо хэр хэрэглэх гэж байна вэ? Тэгээд л одоо сая Таван толгой руу дайрлаа, баахан юм хэвлэлээр яалаа, ханш нь хувьцаа нь 10 хувь уначихсан, 2300 хувьцаа эзэмшигчийн хувьцаа 10 хувь уначихлаа. Энэ бол өөрөө маш том алдагдал болоод ирж байгаа юм. Тийм учраас энэ иргэд татвараа төлдөг

энэ эрмэлзэл чинь танай нам бодлогоороо устгаад байгаа нь хамгийн аюултай шүү гэж би дандаа хэлдэг. Иргэдээс хамаарах эдийн засаг гэдэг юм байхгүй болчихлоо гэж. АН-ын хувьд 4 арвын бодлого гэсэн бүх хүн давхар баланстэй болохоо болиод л бүгд.../минут дуусав/

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Эхний асуулт дээр нүүрсний хулгайтай холбоотой асуудалтай би санал нийлж байна, санал нийлж байна. Энэ нүүрс тойрсон асуудлуудаас бид маш их боломж, маш их валютын орлого алдсан байна. Одоо ч бид нар эцсийн байдлаар тооцоо нэгдсэн дүн гаргаж чадахгүй байна, чадахгүй байна. Харин энэ одоо хууль шүүх, энэ байгууллагуудаар хүчний байгууллагуудаар энэ эцэслэн тогтоогдсоны дараа 2-уулаа харин бүр нэг тал болж энэ асуудлыг тавих болов уу гэж би ингэж бодож байна. Тодорхой хэмжээнд Засгийн газрын өр төлбөрийг олон нийтийн өмнөөс төлөх ийм боломжоо ч бас тэрийг дагаж алдсан байна. Сүүлийн жилүүдэд, ялангуяа ковид болон энэ жил ингээд бид тооцоолоогүй байсан 2 ч том дараалсан ийм сорилт цохилттой бид тулсан. 2019 онд бид Төсвийн тогтвортой байдлын хуулиа ягштал биелүүлээд, бид одоо төсөв маань ашигтай ажиллах түвшиндээ ирж байсан.

Гэвч энэ томоохон 2 одоо эрүүл мэндийн салбарт гарсан эдийн засаг, нийгмийн салбарт гарсан энэ нөлөөллийг арилгахын тулд төсөв алдагдалтай ажилласан энэ үнэн. Ковидын энэ дайны нөлөөллийг бид арилгаж, энийг аль болох одоо олон нийт, ард түмний нуруун дээр аваачихгүйн төлөө гаргасан төлбөр, зардал нь бол энэ. Бидэнд маш одоо хүчтэй, маш үнэтэй туссан яах аргагүй тэглээ. Харин тэгсний үр дүнд өнөөдөр бид нар эдийн засаг өсөлттэй гарч, харьцангуй одоо эдийн засаг, нийгэм дээрээ бид бага гэмтэлтэйгээр ингэж гарч байгаа юм. Энийг бид тоон үзүүлэлтүүд дээр одоо байнга хэлж ярьж байгаа. Өнгөрсөн жил

тэрний өмнөх жил бид эдийн засгаа 5-6 хувь өсөх байсан боловч яг эсрэгээрээ бүр 7 хувийн уналттай ийм эдийн засаг 20 онд гарсан. 21, 22 онд энэ эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж чадлаа. 22 оны эцсээр бид одоо өнгөрсөн оны унасан тэр суурь дээрээс 3-3.5 хувийн өсөлттэй гарахаар ийм хүлээлттэй болж байна. Энэний төлөө зарсан төлбөр, энэний төлөө гарсан алдагдал гэж ойлгоорой.

Харин бид энэ жилүүдэд алдагдлыг шат дараатай, хэдийгээр одоо хүнд байсан ч гэсэн алдагдлыг шат дараатайгаар төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагын хүрээнд Улсын Их Хурлаас энийгээ батлуулж аваад, төсвийн хүрээгээ батлуулж аваад, энэ хүрээндээ ажилласан. Харин энэ жилийн хувьд бид Төсвийн хуулийн хүрээнд хэрэгжилт маань харьцангуй сайн, үр дүнтэй гарах гэж байна. Энэ оны жилийн эцсээр бидний хуулиар төлөвлөсөн алдагдал маань 100-200 тэрбум төгрөгөөр буурч гарах бас ийм сайн эерэг хүлээлттэй байгаа. Энэ бол одоо төсвийн сахилга батаа бид их сайн барьж байгаагийн үр дүн гэж харж байгаа. Мөн 23 оны Улсын Их Хурлаар батлуулж авсан төсөв маань энэ алдагдлыг эрчимтэй бууруулахад, одоо чиглэсэн ийм сайн төсөв болсон гэж бид харж байгаа юм. Бид 24 онд хүрэх ёстой байсан 1.5 их наядын алдагдлыг 23 онд буюу 1 жилээр нөхөж нааш нь татаж байгаа. Төсвийн тусгай шаардлагыг. Ийм сахилга баттайгаар бид алдагдалтайгаар ажиллаж байгаа. Ирэх жилийн хувьд гадаад өрийн төлбөрүүд бас л том сорилт байгаа. Таны хэлж байгаа зөв. Би түрүүн танилцуулгадаа дурдсан. 1990 оноос хойш 32 жилийн хугацаанд Засгийн газрын үүссэн өрөөс эргэн төлөх хуваарийн хувьд 20-24 онд нийтдээ 5.1 тэрбум долларын өрийн зохицуулалт, өрийн хуваарь ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл жилдээ 1.2-1.3 тэрбум долларын өр төлбөр, зохицуулалт ийм хариуцлага бидний өмнө ирсэн юм. Ингээд 21, 22 онуудад бид амжилттай энэ зохицуулалт өр төлбөрүүдээ барагдуулсан.

Амжилттай гэж хэлж байгааг тодруулж хэлбэл, тухайлбал энэ жилд бид Чингис бондын эцсийн төлбөр 633 тэрбум төгрөгийг төлөх ёстой байсан юм, энийг бид нар урьдчилж энэ зах зээлийн хүндрэлийг харж, өмнөх жил 21 онд Сенчури төслийг амжилттай хэрэгжүүлж, гадаад зах зээл дээрээс нэг тэрбум долларыг Монголын Засгийн газрын түүхэнд хамгийн бага хүүтэйгээр 3.75 хүүтэйгээр босгож, энэ жилд төлөх ёстой байсан өрийг нэгж.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Өнөөдөр энэ Засгийн газраас Засгийн газрын гадаад өр, өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой асуудал орж ирж байна. Тэгээд Монголын ард түмэн бол энэ өрөнд маш эмзэг, өрөнд дургүй. Өргүй бол баян, өвчингүй бол жаргал гэж ингэж ярьдаг. Харамсалтай нь өнөөдөр бид нар өр хулгайдаа баригдаад, өтөнд идэгдэх дээрээ тулж байна. Энэ бол бид нарын одоо бодит үнэн, нөхцөл байдал ийм болчихлоо. Энэ танилцуулга дээр Хэрэг эрхлэх газраас орж ирсэн танилцуулга дээр ч гэсэн байна, 33.3 тэрбум долларын өртэй Монгол Улс гадаадаа, тэр одоо Засгийн газрын өр, компаниудын өр, одоо Монголбанкны өр бүгд орж байгаа байх. Бид нар 3.3 сая хүн амтай, одоо тоо нь ч яг ингэж яаж таараад байдаг юм. Тэгээд хүн болгон нөгөө ярьдаг юм чинь одоо энэ валютаар ярих юм бол төрж байгаа хүүхэд болгон ёстой МАН-ынхны хэлдгээр хүүхэд болгон 10000 долларын өртэй болж байгаа, шууд ингэж харагдаж байна. Тэгэхээр энэ дээр бол хэдүүлээ одоо санаа зовох цаг болсон. Тэгээд Их Хурлын даргаас өгсүүлээд энэ бид нар Их Хурлын гишүүд бүгдээрээ энэ өрний асуудал дээр Засгийн газар бас хамтарч ахиц гаргахгүй бол ингээд хүндрэх нь гэдэг нэг ийм асуудал.

Хоёрдугаарт нь, асуулт нь нэг сая бид нар Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол гээд хавар гаргасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хүнсний хангамж, аюулгүй байдлын одоо

талаар авах зарим арга хэмжээ гээд. Өнөөдөр энэ ХАА-н салбар дээр сая улсын төсөв саяхан баталсан, энэ дээр 225 орчим нэг тэрбум төгрөгийг тавьж өгсөн. Тэгээд ингээд энэний задаргааг нь харахаар 135 орчим тэрбум төгрөгийг хүүгийн татаасанд гээд оруулчихсан. Хүүгийн татаас гэдгийг нь ингээд задлаад үзэхээр яг одоогийн нөхцөл байдлаар бол нэг их наяд төгрөгийн зээл гарч байж, тэр зээлэнд хүүгийн одоо татаас буюу зөрүү маржийг нь өгөх хэмжээний мөнгийг төсөв дээр тавиад өгчихсөн. Энэ дээр тодорхойгүй нэг зүйл байгаа. Юу байгаа вэ гэхээр энэ мөнгийг одоо хаанаас олж авах вэ? Одоо энэ дахиад Засгийн газрын гадаад өр яригдаж байгаа учраас мэдээж гаднын зээл тусламж гээд маш их хэмжээний мөнгө тавьсан байна лээ. Тэгэхээр энэ дээр яг энэ мөнгийг олж авах иргэд энэ ХАА-гаа дэмжих, энэ салбар руу оруулах дээр одоо ямар боломж байна, ямар бодлого байна вэ? Монголбанк болохоор бодлогын хүүгээ нэмээд, мөнгөний эргэлтийг хязгаарлаад зээлийг ингээд хумьчихсан. Банкнууд зээл олгох ямар ч сонирхолгүй байгаа эрсдэлээ хараад. Тэгээд хүү өндөрсчихсэн ийм үед одоо энэ төсвийг дагаж гарч байгаа, энэ гарах энэ хүүгийн татаасаа ашигламаар байгаа байхгүй юу ХАА-н салбар. Тэгэхээр энэ нэг их наяд дээр бас ямар бодлого явж байна гэдэг ийм асуултыг асууя.

Бид нар энэ өрийн тааз гээд бас нэлээн ярьдаг байсан, сүүлийн үед бол ний нуугүй хэлэхэд өрийн таазыг бол бас багасгаж барьж байгаа. Тодорхой асуулт нь энэ 2022 онд бондуудын хүүгийн төлбөрт хэдэн төгрөг яг одоо нийт бондод нь тэрийг нь энэ ажлын хэсэг тодорхой хариулаад өгөөрэй. Нийт тэдэн бонд байна, тэдэн төгрөг хүүд төлж байна гээд. 2000, 2023 онд бас хэдэн одоо хэдий хэмжээний мөнгийг энэ бондуудын хүүд төлөхөөр байна гэдгийг нэг хэлээд өгөөч.

Тэгээд эцэст нь бол энэ бол валютын ханиш 1950-тай 16 онд өгсөн. 2850 хүртэл саяхан байсан. Өнөөдөр 3440 хавьцаа байх шиг байна. Тэгээд энэ юм чинь ингээд одоо Монгол шиг импортын

хараатай улс оронд бол юмны үнийг замбараагүй өсгөж байна. Одоо хөдөөгүүр яваад уулзахаар гишүүнээ 25 хилийн гурил гээд л уулзах болгонд л нэмэгдээд байх юм. 48000 боллоо, 50000 боллоо гээд, хамгийн сүүлд 55000 боллоо гээд ингээд. Юмны үнэ асар их өсөж байна, зөрүүлээд ХАА-н салбарт ажиллаж байгаа улсуудын борлуулж байгаа мах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийх нь үнэ валюттай харьцуулахад унаад байна. Төгрөгөөрөө бол хэвээрээ байгаад байна, малчид ярьж байна шүү дээ 3 төлөг орлуулаад хүүхдийнхээ гутлаа авч чадахаа болилоо гээд. Тэгэхээр энэ дээр одоо бид хэд нэг энэ өрөө багасгах, энэ дээр эдийн засгийн хувьд энэ одоо сайн бодлого, иргэдээ дэмжсэн бодлого барихгүй бол иргэд маань ядуураад дууслаа.

Дээрээс нь бас нэг эмгэнэлтэй зүйл нь төрийн албанд ажиллах хүнгүй болж шүү, хангамж цалин бас харьцангуй гайгүй гэж бид нарын үздэг энэ хилийн цэргийнхэнд армид хүртэл цэрэг армид хүртэл ажилладаг жолоочоор ажилладаг хүмүүс хүртэл маш цөөрөн явчихлаа. Тэгэхээр асуудал.../минут дуусав/

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Одонтуяа гишүүний асуултад гүйцээе. Ирэх жил үнэхээр одоо бас хүнд сорилтын жил байгаа гадаад өрийн хувьд. Бид 3 том Хөгжлийн банк, Засгийн газрын нийт ийм өрийн зохицуулалт хийх ийм жил болж байгаа юм. 5 сард 533 тэрбум сая долларын Гэрээг бонд, 9 сарын 25-нд Хөгжлийн банкны Евро бонд 500 сая доллар, мөн 12 сарын 20-нд төлөгдөх Хөгжлийн банкны 30 тэрбум иений Самурай бонд байгаа. Сайн мэдээ гэвэл бид ирэх жил 12 сард төлөгдөх Засгийн газрын баталгаатай Самурай бондыг Хөгжлийн банк өөрийнхөө эх үүсвэрээр төлөх бүрэн боломжтой болсон, энэ маш сайн мэдээ. Энэ өөрөө Засгийн газрын баталгаатай байсан юм. Хөгжлийн банкаар дамжуулаад тарчихсан байсан тэр чанаргүй зээлүүдийг хурааж буцаан

төлүүлээд ийм боломж бүрэн бүрдсэн. 5 сард төлөгдөх, 9 сард төлөгдөх нийтдээ нэг тэрбум долларын одоо бондын эргэн төлөлт хийх, зохицуулалт хийх бэлтгэл ажлыг бид энэ жил бүрэн хангасан, бүрэн хангасан. Чингис бондоо төллөө.

Мөн энэ жил төлөгдөх бусад өрийн үндсэн өр болон зээлийн хүүнүүдээ хугацааных нь одоо хугацаанд нь бүрэн төлж, төсөв дээрээсээ одоо барагдуулсан байгаа. Мөн зээлжих зэрэглэлээ бид нар хэвээр нь хадгалж чадлаа. Ийм хүнд үед манайтай ижилхэн зээлжих зэрэглэлтэй улс орнуудын ихэнх нь одоо унасан байдаг. Тэгвэл манайх Хөгжлийн банк ч тэр, Засгийн газар ч тэр одоо 3 зээлжих зэрэглэл тогтоодог агентлагууд дээрээ хэвээр хадгалж чадсан, одоо Засгийн газрын болон хувийн секторын өр төлбөрт маш сайн, одоо суурь болсон, бэлтгэл ажил болсон ийм зүйл болж байгаа. Тийм учраас ирэх жилийн өр төлбөр дээр ямар нэг дефолт болохгүйгээр тэр эрсдэл дээр очихгүйгээр Засгийн газар одоо энэ дээр бүрэн хариуцаж ажиллаж байна бид.

Туваан гишүүний асуулт, түрүүн тэр та тэр ХААЯ дээр хэллээ. 135 тэрбум гээд. Тэр чинь ирэх жилийн шинэ зээлүүд биш юм байгаа шүү дээ, үргэлжилж байгаа зээлүүд ч байгаа. Шинэ зээлүүд ч байгаа, нийлээд тийм хүүгийн татаас байгаа юм. Мэдээж хэрэв энийг жижиг, дунд үйлдвэрлэлийн сан ч юм уу, төрийн институтүүдэд өгөх юм бол дараагийн ждү болно. Бид энэнээс бүрэн зайлсхийж байгаа, энэ дээр маш хатуу бодлого барьж байгаа. Харин хүүгийн татаас гаргаж байгаа нь мэргэжлийн байгууллагууд, мэргэжлийн институтүүд банкаар дамжуулж эх үүсвэрийг нь одоо хөөж шахаж гаргах ийм хөшүүрэг бэлдэж байна л гэсэн, одоо төсөвлөж сүүлийн жилүүдэд явж байгаа. Тэгэхээр эх үүсвэр бол одоо банкнууд өөрсдийн эх үүсвэрээр л тавина, бидэнд өөр арга байхгүй. Тэр эх үүсвэрийг бид нар хөнгөлөлттэй хэлбэрээр босгох, нийлүүлэх тийм ачаалал төсөв авч дийлэхгүй.

Тэгэхээр ийм хэлбэрээр л явахаас өөр арга байхгүй. Тэр бонд том өрүүдийг ярьж байна, бид одоо ярихаас өөр арга байхгүй, энийг битгий улс төржүүлж ойлгоорой. Бид Засгийн газар нийтдээ 12 оноос хойш 7 бонд гаргасан юм. 12 онд Чингис бонд, 15 онд Дим сам бонд, 16 онд Мазаалай бонд гээд. Эхний 3 бонд. Эхний 3 бонд нь бол эхнийх нь одоо төсөл арга хэмжээ, сүүлийн 2 нь бол төсвийн алдагдал нөхсөн байдаг. Энэнээс хойш гарсан Хуралдай, Гэрэгэ, Номад, Сенчури бондууд бүгд өмнөх 3 бондынхоо өрийн зохицуулалтыг л хийсээр ирсэн. Бид ингэхээс өөр арга байхгүй. 5, 7 жил, 10 жилийн хугацаатай эргээд бидэнд өнөөдөр тэр өрийг нь барагдуулах, валютын эх үүсвэр, төсвийн боломж, тэр орлогыг өгөөжийг өгөөгүй ийм тохиолдолд бид өөр яах вэ. Бид нар энийг дотооддоо бол ярих ёстой.

Харин гадна талдаа АН-ын өр, тэр Ерөнхий сайдын газрын өр, Ардын намын өр, тэр Ерөнхий сайдын өр гэж байдаггүй. Монгол Улсын Засгийн газар, Монгол Улс гэсэн ганц кодтой л ийм өр байдаг. Хэний ч Засгийн газар байсан хугацаа нь тулсан бол энийг бид хариуцлагатайгаар төлж барагдуулах учиртай. Ийм ч учраас 12 оноос хойш энэ олон улсын хөрөнгийн зах зээл дээр гарч эхэлсэн бондуудын хамгийн эхний, одоо эцсийн төлбөр сая 12 сарын 05-нд тохиолоо. Ингээд одоо манай Засгийн газрын цаг үед тохиосон энэ хариуцлагаа бид маш өндөр хариуцлагатайгаар олон улсын одоо хөрөнгө оруулагч нарын өмнө одоо биелүүлсэн байгаа. Тэр тоонуудыг манай хэд хариулчихдаа, Сүх-Очир дарга 85.

Г.Занданиатар: 85 орж хариулчих. Ажлын хэсэг өөрийгөө танилцуулаад.

Б.Сүх-Очир: Туваан гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир. Монгол Улсын Засгийн газрын одоо Чингис бондыг 2022 оны 12 сарын 05-нд төлсний дараагаар бол бид нарт одоо 4 төрлийн бонд үлдчихээд байгаа. Үүнд

Сенчури Бонд, Хуралдай бонд, Гэрэгэ болон Номад бондууд байгаа юм. Эдгээрийн эргэн төлөгдөх хуваариудын хувьд бол Гэрэгэ бондыг бид нар 2023 оны 4 сарын 26-нд төлнө 533 сая ам.доллар. Номад бондыг 26 оны 4 сарын 7-нд төлнө 600 сая ам.доллар. Хуралдай бондыг 24 оны 3 сарын 9-нд төлнө энэ бол бас нэг 600 ам.доллар, Сенчури бонд бол 2 дахь транчтайгаас нэгийг нь 27 болон 2031 онуудад тус тус төлөх юм. Хамгийн өндөр хүүтэй Хуралдай бонд байгаа 875 тэрбум. Ер нь бондын зардалд тухайн 22 болон 23 онд хэдэн ам.доллар төлөх вэ гэж асуусан. 2022 онд бид нар 184.3 сая ам.долларыг одоо бол яг төлөөд дуусаж байна. Ирэх онд бол яг хуваарийнхаа дагуу бол буураад 153.5 сая ам.доллар байгаа. Хүүгийн төлбөрт гэсэн үг. Бондын хүүгийн төлбөр саяынх.

Г.Занданиатар: 84 Энхжин хариулъя.

А.Энхжин: Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин. Туваан гишүүний асуултад хариулъя. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах одоо эрх жилийн ажлын хүрээнд Улсын Их Хурлаас байгуулагдсан түр хорооны тогтоол гараад одоо доор нь дэд ажлын хэсгүүд байгуулагдсан байгаа. Дэд ажлын хэсэгт нь Монголбанк, ХААЯ, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам гээд холбогдох байгууллагуудаас орсон ажлын хэсэг ажиллаж байгаа. Манай зүгээс арилжааны банкнуудын төлөөлөлтэй өнгөрсөн долоо хоногт уулзалт зохион байгуулсан. Уулзалт дээр ирэх жилийн төсөвт суулгагдсан 135 тэрбум төгрөгийг ашиглаад банкны эх үүсвэрээр зээл олгох боломж байгаа эсэх талаар ерөнхийдөө ярилцсан. Нэг гараад байгаа хүндрэл нь одоо манай бодлогын хүү нэмэгдсэнтэй холбоотойгоор хүүгийн татаас нь бас хангалтгүй байна гэсэн асуудал банкнуудын зүгээс бол хэлж байгаа.

Тэгэхээр энэ дээр манай зүгээс арилжааны банкнуудын саналыг аваад ХААЯ-нд өнөө маргаашиггүй хүргүүлээд, энэ

дээр бас татаасанд өөрчлөлт орох уу, хүүгийн түвшинг бас 3-аас нэмэгдүүлэх үү гэдэг асуудлуудыг ярьж байгаа. Эх үүсвэрийг бол ер нь банкны үүсвэрээр гаргах боломжтой гэж банкнууд бол хэлсэн байгаа.

Г.Занданшатар: Санхүүгийн
Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Сангийн сайд Жавхлан бол хувь хүнийх нь талаас ярихгүй. Зүгээр МАН, эрх баригчид та нар бол нээрээ гомдмоор байна шүү дээ. Сүүлийн 6 жил та нар эрх барьж байгаа. Монголын ард түмэнд юу амлалаа, ямар гоё, гоё юм ярилаа. Та нарт одоо Монголын ард түмэн 67 их наяд төгрөгийг сүүлийн 6 жил бидний амьдралыг дээшлүүлээрэй гэж төсөвт өгсөн. Та нар сүүлийн 3 жил төсвийн алдагдал 10 их наяд боллоо шүү дээ. Энэ чинь 100 мянган төгрөгөөр нэг хонийг тооцох юм бол та нар зуун сая хониор тоглогчихсон байгаа байхгүй юу. Төсвийн алдагдлыг зуун сая хониор хэтрүүлдэг, энэ бол тоглоом. Та нар одоо зүгээр 4 дүгээр ангийн хүүхэд ч ингэж удирдахгүй дээ улсыг. Та нар зүгээр өр тавьж улсыг авч явж байна шүү дээ. Өр тавиад гуйлгачин царайлаад улс хөгжсөн түүх Монгол энэ дэлхий дээр байхгүй. Та нар үнэн, өнөөдөр энэ санхүүгийн салбарын та нараас өөр хаана нэг газар бас Монголын санхүүг хариуцаж байгаа хүн байхгүй. Та нар Монголыг өрөнд бариулаад, өтөнд идүүлчихсэн. Ний нуугүй хэлэхэд та нарыг буруутгахаасаа илүү танай эрх баригчид, танай том дарга нар, нүүрсний хулгай, Оюутолгойн хулгай, ГОК-н Эрдэнэтийн шааригны хулгай гэдэг юмаар ард түмнийг минь туйлдуулаад сөхрүүлчихсэн. Тэгээд та нар тэр тоог нь бичиж боддог улсууд.

Тэгэхээр энэ асуух зүйл бол нөгөө Оюутолгойгоо л асууя даа. Монголын 16 онд 24.8 тэрбум долларын өртэй байсан, энэ бол бас 30 жил үргэлжилж байгаа явдал бас. 22 оны 2 дугаар улирлаар өр 33.5 тэрбум доллар болсон, ДНБ-ээ харьцуулбал харьцуулбал 220 хувьтай. Тэгээд бид

дампуурчихсан улс болчихсон, аль хэзээний та нарын буянаар. Тэгэхээр үүний дотор Засгийн газрын өр нь 24.3 хувь байна, 8.1 нь тэрбум доллар, энэ дотроо энэ дотор Оюутолгойн өр нь 16 онд 7.4 тэрбум доллар байж байгаад одоо яагаад 12.4 тэрбум доллар болчхов? Би тэр салбарын өрөн дотор ярьж байна шүү 21.3 тэрбум долларын өр дотроо задалж ярьж байна. Яагаад Оюутолгойн өр 12.4 тэрбум доллар болтлоо өсөв, та нар зүгээр л амаар нь байдаг хүүхэлдэйнүүд юм уу? Оюутолгойгоос Рио Тинтогоос 12.4 тэрбум доллар өр нэмэгдүүлээд Монголын өрийг нэмэгдүүлээд байхад та нараас зөвшөөрөл авсан уу, нягталсан уу, огт нягтлаагүй юу? Миний асуулт нэгдүгээр асуулт.

Хоёр дугаар асуулт та нар ер нь Рио Тинто хаалттай компани болчихлоо шүү дээ. 12 сарын 12-нд. Би Ерөнхий сайд руу бичиг явуулсан, Ерөнхийлөгч Хүрэлсүх рүү бас бичиг явуулсан. Одоо Рио Тинто бүр та нарыг амаар чинь алгадна, аман дээр чинь. Тэрэн дээр та нар ер нь юм хийсэн үү Туркойс Хилл? Одоо та нар санхүүгийн мэдээлэл авч чадахгүй. Туркойс Хиллээ залгичихсан цаадуул чинь. Хаалттай компани болчихсон, 12 сарын 12-нд би бүр хугацаатай нь ярьж байна шүү дээ. Тэгэхээр миний асуулт 7.4 тэрбум долларын өр байснаа яагаад 12.4 болов, нөгөө бид нарын бөөн юм болоод, гудамд орилоод өлсөөд зовоод махаа зулгааж байгаад нөгөө 2.3 тэрбум долларын өрийг нь тэглэсэн гэж яриад байгаа юм. Тэр юм чинь яагаад энэ дотор ороогүй юм бэ, орсон юм уу, ороогүй юм уу? Ороод 12 аравны ороогүй болоод 12.4 гэвэл та нар Рио Тинтотой нийлж дээрэм хийсэн болж таарч байна шүү дээ. Монголоо цөлмөсөн гэсэн үг болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр одоо ирээдүйд 23 тэрбум долларын өрнөөс сэргийлж Монголын Засгийн газар Оюутолгойн тэр 2.3 тэрбум долларын өрийг тэглэсэн гээд мандан бадруулаад байгаа юм энэ дотор хаана нь яваа вэ? Миний асуулт их тодорхой асуулт. Ингээд өөр тэр их

наядын нүүрсний хулгай, та нар ковидын үед идээж уусан тэр олон сая хоньтой тэнцэх хэмжээний мөнгийг нь би дараа нь тодруулж асууя. Эхлээд би Оюу толгой дээр асуултдаа хариулт авъя. Тодруулга байдаггүй юм уу.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд, нийт 5 минут.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя, их зөв асуулт тавилаа. Наад асуулт дээр чинь гээд хүмүүс будилаад байдаг юм. Монгол Улсын нийт өр 33.3 тэрбум. Түүний 8.1 нь Засгийн газрын өр, бусад нь хувийн секторын өр. Таны саяын дурдсан Оюу толгойн өр буюу 12.8 тэрбум доллар энэ хувийн сектор дотор ороо орж яваа. Мөн саяын таны хэлдэг бид нар өнгөрсөн, одоо хүндхэн өнгөрсөн, өнгөрсөн жилүүдэд хүндхэн бас дунд юман дундуур явж хэлэлцээр хийж үр дүнд хүрсэн сайн зүйлүүдийн нэг нь Монгол Улсын Засгийн газрын ирээдүйд үүсээж болзошгүй өр төлбөр 2.3 тэрбум долларыг тэглэсэн байгаа. Тэр өр чинь энэ дотор орчихсон яваа шүү. 12.8 дотор орчихсон яваа. Өөрөөр хэлбэл Оюутолгойн нийт өр дотор чинь 66 хувийн, одоо 66 хувь буюу хувь нийлүүлэгчдийн төлөх өр, 34 хувь буюу нийлүүлэгчдийн төлөх өр гээд нийт зуун хувийнх нь өр байж байгаа. Тэрэн дотроо энэ нь өөрөө шингээд явж байгаа. Хуваарилагдах нь одоо 34 хувь дээрх нь 2.3 тэрбум доллар байсан. Энэ одоо манайхаас гараад компанийн өр болж ингээж бичигдэж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ 12.8 дотроо байгаа гэсэн үг шүү.

Харин нийт өр алдагдлын хувьд Ганбаатар гишүүнээ, би арай өөр зүйл хэлмээр байна. Би дахин, дахин хэлж байгаа шүү. Гадна талдаа тэр намын энэ намын өр гэж байхгүй. Тэр Ерөнхий сайд энэ Ерөнхий сайдын өр гэж байхгүй. Хэний ч Засгийн газар байсан цаг нь ирвэл бид энэ гадаад өр төлбөрийг цаг хугацаанд нь төлөх үүрэгтэй. Харин дотооддоо бид маш том сургамж авч үлдэх ёстой. Хойч үедээ бид нар ийм муу өр үлдээж болохгүй. Тэр ч үүднээс бид 2018 оноос хойш 3, 3 жилээр

гадаад өрийн стратегиа Улсын Их Хурлаар батлуулж аваад тэр хүрээндээ ажилладаг болсон байгаа. Энэ хүрээндээ харин сахилга баттай ажиллаж байгаагийн үр дүнд өнөөдөр Засгийн газрын нийт өр харин буурчхаад байгаа юм шүү. Бид 8.5 тэрбум доллароос 8.1 тэрбум доллар хүртэл буулгажчаад байгаа юм. Та алдагдлаар өсөж байгаа гэж байна. Алдагдлаар өсөж байгаагийн хэрээр одоо 2020 оноос хойш бид нийтдээ 10.1 их наяд төгрөгийн өрийн зохицуулалт хийсэн. Өрийн зохицуулалт болон өрийн төлбөр хүү төлсөн байгаа.

Тийм учраас одоо нийт хөл дүнгээрээ Засгийн газрын өр нэмэгдээгүй байгаа шүү, нэмэгдээгүй байгаа. Харин энийг зөрөөд ДНБ өсөж байгаа учраас ДНБ-д эзлэх Засгийн газрынхаа өрийн хэмжээг бид өнөөдөр 70 байх ёстойг 50 хувь буюу 20 хувиар хэмнэхээд ингээд явж байгаа юм. Энэ бол сүүлийн жилүүдэд бид гадаад өрнийхөө менежментийг маш сахилгатай, маш одоо хариуцлагатайгаар хийж, ийм одоо сайн үзүүлэлтэд ирсэн байгааг харуулж байгаа юм.

Г.Занданишатар: Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа ганцхан юм асууя даа. Засгийн газрын маань одоо ирэх жил эдийн засаг ямар байгааг, ялангуяа Сангийн сайд бас сайн мэдэж байгаа. Тэгээд энэ нөөцөө одоо бүрдүүлэх зорилгоор ямар нэгэн хөтөлбөр энэ тэр та бүгд маань ярьж байгаа юм байна уу? Валютын сангийн хөтөлбөр. Эсвэл гаднаас мөнгө босгох асуудал ярьж байна уу, аль эсвэл тэгээд зах зээлийнхээ одоо тухайн үеийн нөхцөл байдлаас үл хамаараад бондын дахин санхүүжилтээ хийнэ гэсэн ийм бас бодлогын зорилт тавиад явж байна уу? Ер нь одоо яг өнөөдрийн байдлаар гадаад зах зээл ямар байна вэ? Тэгээд та нар хэрэв 2 дахь хувилбараар буюу дахин санхүүжилт хийнэ гээд явахад хүлээгдэж байгаа, дахин санхүүжилтийн өртөг нь хэд байх юм бэ, ямар хэмжээнд гарахаар юм бэ гэдэг нэг ийм мэдээлэл авмаар байна.

Яах вэ, нэмээд бас нэг Жавхлан сайдаас нэг хүсчихмээр байгаа юм. Энэ санхүүч, эдийн засагчид нь уг нь санхүү эдийн засгаа ярьдаг баймаар байгаа юм. Танай энэ хуулийн сайд чинь өөдөөс энэ 40 тэрбумын задаргаа яриад байх юм, 40 их наядын. Тэгээд өөрөө тэрийгээ ороогдоод байх юм. А гэхээр Б гээд, тэмээ гэхээр ямаа гэж яриад байх юм, их төвөгтэй юм. Тэгээд тэр Хуулийнхаа сайдад, Хэрэг эрхлэхийнхээ сайдад нэг Сангийн яамнаас нэг мэдээлэл өгөөч. Та тухайлбал Блүүмберг дээр бол бас л бодитой л ярьж байна лээ шүү дээ. Хилийн цаана 1-1.5 тэрбум долларын орлогоо бид нар алдаад байгаа гээд. Бодитой шүү дээ энэ чинь. Энэ чинь бол нөгөө төмөр зам тавьсан бол тавиагүй бол биш, алдагдсан боломжийн өртөг биш байхгүй юу.

Яг л өнөөдрийн байдлаар бид нар бодитой алдаад байгаа. Өнөөдөр бид нар нүүрсээ тээвэрлэхдээ амны үнээр л өгөөд байгаа. Төрийнх нь байна уу, хувийнх нь байна уу? Тэгээд л Хятадуудад өгөөд л байдаг. Гэтэл цаашаага бид нар цаад зах зээл рүү л өгөх ёстой шүү дээ. Тэгээд энэ чинь өнөөдрийн түвшинд авах ёстой энэ орлого байж байхад чинь одоо тэр сүүлийн 10 гаруй жил бид нар амны үнээр хийчихсэн, жишиг үнээр ингээд хийсэн. Тэгээд ийм л үнэ байгаа болохоор энэнээсээ 10, 15 хувийн хөнгөлөлтийг бодит үзүүлсэн ч гэсэн шиг нэг ингээд нэг хүлээн зөвшөөрсөн байдлаар хандаад, тэгээд яг өнөөдрийн энэ буруу систем чинь өөрөө ингээд харагдаж байгаагаараа их бага хэмжээний ийм нэг хохирол хулгай үүсчихсэн юм шиг ийм байдлаар ингээд нийтэд ойлгуулаад байна л даа. Тэгээд энэ дээрээ та бүгд маань Сангийн яамнаас нэг юу яах вэ дээ, нэг ганц, хоёр мэргэжилтэн суулгаад л тооцоо хийчихнэ шүү дээ. Та бүгд дээр чинь бүгд гаалийн мэдээнүүд байгаа.

Бид нар болохоор бүх гаалийн статистикуудыг авч үзсэн. Танай жишиг үнэ болоод гэрээний үнүүд нийтдээ 37 хувьд нь бол гэрээний үнээр хийгдсэн. Бүх

өдөр он, сар, өдөртэй нь тулгаж байгаад тэр тооцоолуудаа хийж байгаа юм л даа. Тэгээд хилийн цаадах үнэ энэ тэр гээд нэлээд олон тийм ро дата гэж ярьдаг шүү дээ. Мэдээллүүдийг боловсруулж байж энэ тооцооллоо гаргаж ирээд байдаг. Тэгээд нэг санхүү эдийн засгийнхаа хүмүүсийг суулгаад тооцоолоод гаргаж ирэхээр өөдөөс ингээд Хууль зүйн сайд нь шал өөр тоо яриад байх юм. Тэгээд энэ дээр нэг Засгийн газар бас өөрсдийн нэг тоотой болоод тэгээд тоогоо бас ойртуулаад нэгдсэн болгоод явчихвал уг нь их зүйтэй байх юм. Тэгэхгүй нэг энийг нэг айхтар улс төржүүлэхээсээ илүү бодитоор бид нар яг энэ тооцооллоо тохирчих юм бол дараа дараачийнхаа салбаруудад хэрэгтэй шүү дээ. Тэгээд тийм болохоор энэ дээр бас анхаараач гэж хүсэж байгаа юм шүү. Баярлалаа.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Доржханд гишүүний асуултад хариулъя. Гадаад хөрөнгийн зах зээлийн талаар ярьж байна, үнэн. Ер нь Ази төдийгүй Европ ч гэсэн маш хүнд байна. Бүх мөнгөний урсгал одоо Америкийн зах зээл рүү урсаж байна. Хаана хамгийн хатуу валют байна тэнд яг ийм эдийн засгийн хүнд хямралын үед одоо бүх валютын урсгал төвлөрч байдаг. Энэ одоо яг л онолын дагуу явж байна. Америкийн Fed-н хүү түүхэндээ байгаагүй хамгийн өндөр боллоо, тэнд инфляц ч түүхэндээ сүүлийн 50 жил байгаагүй хамгийн өндөр түвшинд хүрсэн. Азийн хөрөнгө оруулагч нар бүгд мөн тэр зах зээл рүү шилжиж байна. Тэгэхээр бид нэгэнт Азийн зах зээл дээр одоо тоглогчийн хувьд бидэнд ч гэсэн хүнд жил ирэх нь ирэх жил. 3 бондын ажил байдаг.

Тэгэхээр бидэнд хэд хэдэн хувилбарууд байна, хэд хэдэн хувилбар байна. Бидний сүүлийн жилүүдэд зах зээл дээрээ одоо дадлагажсан гэх юм уу, бидний сайн практик болж ирсэн, дахин санхүүжилтийнхээ энэ хувилбар дээр бид ажиллаж байгаа, ажиллаж байгаа.

Мэдээж хүү бол өмнө байгаагүй өндөр хүүтэй гарна, тэр ойлгомжтой. Бидэнтэй ижил зээлжих зэрэглэлтэй улсуудаас энэ жил Ангол, нэг нь юу билээ? Турк энэ 2 улс л бонд гаргаж амжлаа. Хүү нь 8-9 хувийн хүүтэй байгаа, 8-9 хувийн хүүтэй. Ирэх жил ямар байхыг бас л хэлж мэдэхгүй байна. Өдөр болгон нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Ирэх жил Хятадын эдийн засаг яах нь вэ, онгойх нь уу, яах нь вэ? Энэ дайны нөхцөл байдал цаашаага улам хүндрэх нь үү, сунжрах нь уу? Яах нь вэ? Олон юмнаас шалтгаална.

Бидэнд нэг хагас жилийн хугацаа байна. Эхний бонддоо хүртэл. Харин нэг сайн гэвэл би түрүүн хэлсэн. Оны эцэст төлөгдөх Самурай бондоо бид бол анх аюулгүй болсон, цааш нь хийгээд авсан байгаа юм. Тийм учраас дараа дараагийн хувилбарууд бол бас байгаа. Таны хэлж байгаа ОУВС болон бусад одоо донор байгууллагуудаасаа хөгжлийн олон талд институцуудаас одоо тусламж авах хувилбар бол нээлттэй байгаа юм, нээлттэй байгаа. Бид ОУВС-ийн гишүүн орон. Дэлхийн банкны гишүүн орон. Тэд ч гэсэн туслахад бэлэн байгаа гэж байгаа юм. Тэр бол бидний халаасанд байгаа хувилбар, халаасанд байгаа хувилбар. Өөрөөр хэлбэл бид энэ хувилбар руу одоо түргэн шилжиж орох бас тийм маневртай явах ёстой. Байдал сонголтгүй болж ирвэл. Тийм учраас ирэх жил бол нэлээн тийм сорилтын жил болно, үнэхээр сорилтын жил болно.

Гэхдээ бидэнд бол бас боломж байгаа. Нөгөө талдаа бидний одоо энэ богино хугацаанд төлбөрийн тэнцлээ засаж чадах хамгийн том боломж бол ерөөсөө л экспорт, экспорт, экспорт, экспорт. Тэрнээс биш бид нар ийм богино хугацаанд үйлдвэрлэлээ сэргээнэ гэдэг тийм ойлголт, боломж ч байхгүй. Энэ жил бид 36 сая тонныг гаргана гэж байгаад 5 сард больё оо чадахгүй нь үнэхээр бодит байдалтайгаа нүүр туллаа 18 сая болгоё гэсэн. Ингээд харин одоо бид 11 сарын 30-ны байдлаар 28 саяыг гаргачхаад байна. 18 гэж байсан бол 28 сая гаргачихлаа, жилийн

эцэс рүү нэг 29 сая дөнгөж гарах байх. Энэ бол маш том амжилт. Бид яг энэ хурдаараа одоо 23 онд экспортоо явуулж чадах юм бол богино хугацаанд төлбөрийн тэнцлээ сайжруулах бидэнд боломж байгаа. Энэ хугацааг л бид харах хэрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл ирэх оны эхний хагас жил нэлээн зүйлүүд маш тодорхой болж ирнэ. Энэ дээр л одоо бид зөв менежмент, зөв зохицуулалтыг хийх шаардлагатай болж ирж байгаа. Тэр нүүрс тойрсон хэд хэдэн тоонууд яваад байдаг юм. Би таны хэлж байгааг бас сонссон. Ерөнхийдөө нэг нүүрс тойрсон эдийн засгийн нийт объёмыг хэллээ гэж би ойлгосон шүү, нийт объёмыг. Тэрнээс биш одоо хулгайлсан тоо, алдагдсан боломж гэх юм бол арай өөр тоо гарч ирнэ. Энэ дээр би хэдэн тоо хэлье. Ер нь 1995 оноос хойш бид нэг жижиг хэмжээгээр ингээд экспортолж эхэлсэн юм байна лээ нүүрс. Нийтдээ 336 сая тонн нүүрс экспортолсон юм. Энийг нь ингээд хувааж харах юм бол цаг хугацааны хувьд 2011 он гэж угааж хармаар юм байна лээ. Өөрөөр хэлбэл Эрдэнэс таван толгой одоо нүүрсээ экспортолж эхэлсэн он жил. Тэрнээс хойш 298 сая тонныг нь үндсэндээ 300 сая тонн буюу одоо 90 хувь нь 2011 оноос эхэлсэн. Ингээд 2011 оноос нийт экспорт одоо үлэмж хэмжээгээр эхэлснээс хойш нийтдээ 45.5 их наяд төгрөгийн борлуулалтай.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. 5 минутаар асуулт, үг нэг цуг явж байгаа. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу D-парламент цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулж иргэдээс ирүүлсэн саналуудыг одоо нэгтгэж боловсруулаад Засгийн газрын гишүүнээс асуулт асууна бүлгүүдийн төлөөлөл. Эхлээд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууна. Гишүүд асуулт, хариултын цаг өгч байна. Ингээд асуулт, хариулт 20

минут үргэлжилнэ. 10, 10 минутаар цагийг нь тавиарай. Асуулт, хариулт адилхан 10, 10 минут.

М.Оюунчимэг: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэгт иргэдээс бол энэ удаад нэлээд олон асуултууд ирсэн байна. Энэ Баасан гарагийн Ерөнхий сайдын цагийг зөвхөн цөөнх асуулт асууж, хариулт авдаг байсныг хүрээг нь өргөжүүлж, иргэдээс асуултыг нь авч саналыг нь хүргэдэг болсонд иргэд бас талархалтай хандаж байна. Одоо парламентын ардчиллын гол үнэт зүйл нь бол энэ төр иргэний одоо гүүр нь байдаг. Тэгэхээр энэ утгаараа D парламент дээрээ энэ Ерөнхий сайдын цагийн орох сэдвийг нь долоо хоногийн өмнө тавьж, иргэдийн санал асуултыг нь авч байгаад бас талархал илэрхийлснийг бас уламжилъя.

Иргэдийн гол нь Монгол Улсын гадаад өр ингээд жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа. Энэ гадаад өрийн дахин санхүүжилт, үнэт цаасны дахин санхүүжилт, зээлийн үр өгөөж муу, өртөг ихтэй, өгөөж багатай төслүүд хэрэгжүүлдэг. Энэ одоо улс орны эдийн засаг, ДНБ, валютын нөөц энэ тэрд эерэг нөлөөлөл үзүүлэхээсээ илүүтэй улам дарамт учруулж байгаа. Энд бол санаа зовсон тийм асуултуудыг бас ирүүлсэн байна. Нөгөө талаасаа ингээд гадаад өрийн хэмжээ өнөөдрийн байдлаар 33.3 тэрбум америк доллар. Энэнийг ингээд нэг хүндээ хуваагаад үзэхэд одоо нэг хүнд бараг одоо 10 сая америк доллар буюу 34 сая төгрөгийн өр байна, энэ өр маань өдөр бүр өсөж байна гэх мэтчилэн одоо янз бүрийн ингээд мэдээллүүд цацагдаж байна. Энэ бүхэнд иргэд одоо санаа зовсон, шүүмжилсэн, бухимдсан байдалтайгаар бас зарим нэлээд хэдэн асуултууд ирсэн байгаа.

Нөгөө талаасаа өнөөдрийг хүртэл энэ бий болоод байгаа 33.3 тэрбум америк долларын энэ зээл өөрөө хэдийг нь яг юунд зарцуулсан юм, эргэн төлөлт нь хэд байгаа юм, бүтээн байгуулалтад орсон юм уу,

эсвэл одоо төсвийн алдагдлыг нөхөж байгаа юм уу, эсвэл дахин санхүүжилтэд явсан юм уу гээд тоо баримтууд ч тодорхойгүй байгаа зэрэг асуултуудыг иргэдээс нэлээн шүүмжлэлтэй хандаж ирүүлсэн байна. Ингээд иргэдээс ирүүлсэн асуултаа тавья. Эхний асуулт иргэн түмэн Өлзийгөөс ийм асуулт ирсэн байгаа юм. Өнөөдөр 33.3 тэрбум америк долларын өртэй гэж байна. Энэ өрийг нэг хүнээр тооцож ер нь үзвэл хэд байна вэ? Ер нь энэ одоо хэдэн төгрөгийн гадаад өр Монгол улсын нэг иргэнд ногдож байна вэ гэдэг дээр тодорхой хариултыг авахыг хүсэж байна гэсэн байна. Эхлээд энд хариулт авъя.

Б.Жавхлан: Оюунчимэг гишүүний асуултад иргэдийн асуулт тийм ээ, иргэдээс хэлсэн асуултад хариулъя. Гадаад өрийн талаарх мэдээллүүд Төв банкны веб сайтан дээр tof.gov.mn гээд Сангийн яамны веб сайт дээр одоо нэлээн дэлгэрэнгүй байдлаар байж байдаг. Энэ дээр бол одоо сонирхсон иргэд орж харахад бол одоо чөлөөтэй нээлттэй. Иргэд бол бас сүүлийн жилүүдэд нэлээд үгүй энд нэлээн идэвхтэй, энийг орж хардаг болсон байна лээ. Асуултууд бол бас нэлээн ирдэг. Монгол Улсын нийт өрийг одоо нэг хүнд ноогдох байдлаар илэрхийлэх нь өөрөө эдийн засгийн тийм агуулга муутай, ийм үзүүлэлт. Хэрэв шууд ингээд махчлаад энэ 33 тэрбум долларыг 3.3 сая гэх юм бол нэг хүнд 10000 доллар өнөөдрийн ханшаар ингээд 34 сая гэж ингээд ярьж болох энэ их амархан тоо. Би түүрэн хэлсэн том эдийн засагтай улсууд бүр одоо жишээ нь Люксембург нэг хүнд ногдох өрийг нь харах юм бол бүр 6 сая ам, 6 сая ам.доллар. АНУ 70000 доллар, Сингапур 240000 доллар гээд ингээд яриад явбал болно л доо.

Гагцхүү энэ хамгийн гол үзүүлэлт юу байдаг вэ гэхээр энэ зээлийн ашиглалт энэ зээлээр бий болгосон, дараагийн өрийг төлөх, дараагийн эдийн засгийг сөрж гарах тэр баялгийг бий болгосон уу, үгүй юу. Тэр баялаг гэдэг маань өртэй холбож яриад ирэхээр энэ төлбөрийн тэнцэл, алдагдалгүй төсөв, Төв банкны валютын нөөц эдгээр

үзүүлэлтүүдийг одоо харьцуулж ярих нь хамгаас чухал юм байгаа юм. Хувийн секторын өрийг түрүүн Туваан гишүүн бас ярьсан, би санал нийлж байна. Монгол Улсын өр 33 тэрбум. Энэ одоо Засгийн газарт хамаагүй гэж бид бас ярьдаггүй, ингэж ярьдаггүй юм шүү. Энэ бол Монгол Улсын өр, Монгол Улсын валютын нөөцтэй шууд хамааралтай. Монгол Улсын валютын нөөцийг бид хэчнээн сайн байлгаж чадна, хэчнээн сайн менежмент хийж чадна, гадна талдаа Монгол Улсын нийт өрийн төлбөрийн чадвар сайн л харагдана.

Харин нэг хүнд ноогдох гэдгийг дээр бол бид одоо Засгийн газрын өрөө л ярихаас өөр арга байхгүй. Засгийн газрын өр гэдэг бол нийт одоо татвар төлөгчдийн хуримтлал, Засгийн газрын төсөв энэ бүгдтэй нь шууд холбоотой, хариуцлага нь энэ дээр ирнэ. Ингээд харах юм бол 8.1 тэрбум доллар нь нэг хүнд ноогдохоороо нэг найман сая төгрөг буюу 2.2 мянган доллар орчим байгаа. Цаашидаа бид дунд хугацааны гадаад өрийн стратегийнхаа хүрээнд, эцсийн дүндээ Монгол Улсын гадаад өр төлбөрийн төлбөрийн чадварыг нь сайжруулах ийм л одоо үр дүнд хүрэх учиртай юм байгаа юм. Ингэснээр мэдээж төлбөрийн чадвар сайн, одоо төлбөрийн тэнцлийн алдагдал тэглэх учиртай. Төв банкны валютын нөөц нэмэгдэх учиртай ийм зорилгын төлөө л бид Засгийн газар одоо ажиллаж байгаа.

М.Оюунчимэг: Батбаяр, Доржханд, Түмэн-Өлзий гээд хэд хэдэн иргэдийн зүгээс ингэж асуусан байна л даа. 2016 онд 4.9 тэрбум америк долларын өртэй байсан бол энэ 22 онд 8 тэрбумын долларын өртэй Засгийн газрын өр байна. Тэгэхээр энэ зөрүүгийн яг хэдийг нь зээлийн хүүгийн төлбөр төлсөн юм, хэдийг нь бүтээн байгуулалтад бодит төсөлд зарцуулсан юм, хэдийг нь дамжуулан зээлдүүлсэн юм, хэдийг нь төсвийн алдагдалд зориулсан бэ гэдгийг маш тодорхой тоо баримтаар дурдаж өгнө үү гэсэн асуултыг ирүүлсэн байна.

Ялангуяа бүтээн байгуулалт дээр өнөөдөр саяын яриад байгаа экспортыг орлосон яг тийм бодит үр дүнгээ өгсөн ийм төсөл бүтээн байгуулалт байна уу, нэрлэнэ үү 1, 2, 3 гээд. 3-ыг жишээ нь бодитоор нэлээд өгнө үү. Сая ковидын үед ямар ч бүтээн байгуулалт энэ үр ашгаа өгөөгүй гэдгийг бид харлаа гэж бичсэн байна л даа. Энд эхлээд хариулт өгнө үү.

Г.Занданиатар: 85 ажлын хэсэг.

Б.Сүх-Очир: Иргэдийн асуултад хариулъя. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир. Улсын нийт гадаад өр одоо 2022 оны хагас жилийн байдлаар 33.3 тэрбум долларт хүрсэн. Энэнээс Засгийн газарт ноогдох нь 8.1 тэрбум доллар байгаа юм. Энэ үзүүлэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар бол нэг 4.9 тэрбум долларт хүрчихсэн. Өөрөөр хэлбэл энэнээс хойш ойролцоогоор нэг 3 тэрбум доллароор энэ Засгийн газрын өр шууд өөрөө нэмэгдчихээд байх юм. Энэ юу, юунаас болж нэмэгдэв гэдэг асуулт байна. Тэгээд эхнийх нь бол 2017 оны 3 сард бид нар Хуралдай бондыг гаргасан. Хуралдай бондыг гаргахдаа Хөгжлийн банкн дээр байсан, одоо тухайн үеийн 580 сая ам.долларын Евро бонд гээд байсан, тэрний дахин санхүүжилт хийсэн. Тэр Евро бонд маань өөрөө бусад сектор гэдэгт бүртгэгддэг байсан гэсэн үг. Уул нь байсан л өр. Тэгээд Хуралдай бондоор санхүүжүүлээд ирэхээрээ бид нар гарч ирээд энэ Засгийн газрын өр дотроо бол ингээд нэмэгдээд явлаа шүү гэдэг агуулгыг хийсэн байгаа.

Хоёрдугаарт нь жилд Монгол Улсын Засгийн газар бол нэг ойролцоогоор 1.3-1.5 их наяд төгрөгийн гадаад зээлийг бол авдаг. Энэ нь бол ихэвчлэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилготой. Энд бол сүүлийн үед хийгдсэн томоохон бүтээн байгуулалтууд гэх юм бол одоо замуудын замууд байна. Төслийн одоо нэг ёсоор 150 орчим төсөл хэрэгжиж байгаа эдгээр бүтээн байгуулалтууд байгаа.

Ковидын үед болон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хувьд төсвийн дэмжлэг байдлаар авсан зээлийн мэдээллийг би танд одоо хэлж өгье. 2017-гоос одоо 21 он, 21 оны эцсийн жилийн байдлаар бол ковидын дэмжлэгт бид нар ойролцоогоор нэг 4.4, 440 сая ам.доллар буюу ойролцоогоор 4.4 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний бол ковидын үеийн төсвийн дэмжлэг гэдэг агуулгаа явсан.

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр гээд бид нар 2017 оноос хэрэгжүүлсэн байдаг. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд бид нар ойролцоогоор 1.1 тэрбум, 1.2 тэрбум долларыг авсан байдаг. Энэ нь ойролцоогоор дахиад 3.1 их наядаар нэмэгдүүлсэн гээд. Үүнээс гадна ОУВС-ийн шуурхай санхүүчдийн хөтөлбөр гээд зуун сая ам.долларыг жишээ хэрэгжүүлсэн. Эдгээр бүх зээлүүд нь хэлэхээр нэг ойролцоогоор дөрвөн тэрбумаар нэмэгдчихээд байгаа.

М.Оюунчимэг: Энэ яг энэтэй холбоотой л асууж байна л даа. Нөгөө хаад эзэд өвөг дээдсийнхээ нэрээр сүртэй, сүртэй өндөр өртөгтэй арилжааны зээлүүд авчихсан. Тэгсэн хэр нь энэ маань өөрөө үр дүнгээ өгөөгүй. Энэ гадаад өр эдийн засгийг хямрах нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь өөрөө өрийг өрөөр төлж байгаа энэ төсвийн ямар ч сахилга батгүй энэ байдлууд нь өнөөдөр одоо Монгол Улсын энэ эдийн засаг доройтох, иргэдийн орлогогүй, ядуурал үүсэх шалтгаан болж байна гэдэг дээр бол олон хүмүүс бас шүүмжлэлтэй хандаж байгааг бид нар бодолцох бол, энэ бол 2013 оноос хойш, ялангуяа энэ байдал бол дэндүү гарсан, утгаа алдсан, энэ өөрөө өнөөдөр Монголын эдийн засаг хямарч, иргэд ядуурах нөхцөл бүрдсэн гэсэн дүгнэлтийг иргэдээс ирсэн асуулт бас саналаас хийж болохоор байгаа юм.

Тэгээд энэтэй холбоотой ийм асуулт байна л даа, төстэй. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд асуусан. Энэ нэлээд зээлийн хэрэгжүүлэх

ёстой төслүүдийг цаашид үргэлжлүүлэх боломжгүй, зогсоох тийм эрсдэл бий болсон гэж Сангийн сайд түрүүн тайлбар дээр хэлж байна. Яагаад хэрэгжихгүй байгаа гол шалтгааныг хэлж өгнө үү. Хэн үүнд хариуцлага хүлээх вэ? Тодорхой хэсэг нь энэ төслийн эхлэл ч гэсэн тодорхой мөнгө зарцуулчихсан, гэхдээ одоо зогсчихсон. Тэгэхээр энэ зарцуулсан мөнгийг хэн төлөх вэ? Энд хариулт авъя.

Б.Жавхлан: Би хариулъя. Оюунчимэг гишүүний дурдсан тэр иргэний эхний асуулттай би ер нь санал нийлж байна. Ер нь гадаад өрийн сахилга бат, менежмент муутай явж ирснээс л өнөөдрийн энэ өр зээл овоорч байгаа юм. Одоо энийг хэлэхээс өөр арга байхгүй шүү дээ. Бид гадна талдаа өрийн сахилга бат хариуцлагаа бид маш нэр төртэйгөөр Засгийн газраа хамгаалаад ингээд явж байгаа юм. Хэний Засгийн газар байх нь хамаагүй. Засгийн газар 7 бонд гаргасан, 7 бонд гаргасан. Өрийг өрөөр төлж явж ирсэн нь үнэн, ингэхээс өөр арга байхгүй. 2012 онд анх гарсан Чингис бонд л төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор, өөрөөр хэлбэл бизнесийн төсөл, импортыг орлох, экспортыг дэмжих ийм төслүүдийг санхүүжүүлэхээр орж ирсэн. Харамсалтай нь ингэж чадаагүй, тухайн үед одоо бэлэн ТЭЗҮ төсөл хөтөлбөрүүд байгаагүй учраас Чингис бондын 63 хувиар, 63 хувийг төсөв дээр татаж аваад төсвийн санхүүжилт хийж байсан шүү дээ. Төсөл хөтөлбөр санхүүжүүлээгүй байхгүй юу. Бизнес санхүүжүүлээгүй.

Тийм учраас цаг хугацаа нь болох үед энэ зээлээ төлөх валютын орлого, эдийн засгийн өгөөж хуримтлагдаагүй. Энийг бид нар өрийг өрөөр төлөхөөс өөр арга байхгүй. Дараагийн Дим сам, Мазаалай бонд 15, 16 онд орсон төсвийн алдагдал нөхсөн. Ингээд 17 оноос хойш гарсан хуралтай Гэрэгэ, Номад, Сенчури бондууд бүгд өмнөх бондуудын өрийг төлөхөөс өөр аргагүй ийм цаг хугацаа тулж байсан. Тэгэхээр энэ бол маш том сургамж юм байгаа юм, бид одоо ярих асуудал нь бол. Тэрнээс биш одоо энийг

төлөх төлөхгүй, өрийг өрөөр төлж болохгүй, шууд төсвөөр төлнө ч гэдэг юм уу, ийм одоо замбараагүй байдал бол байж болохгүй. Бид нар одоо төлөх чадварынхаа хэмжээгээр төсвийнхөө боломжийн хэмжээгээр одоо үндсэн өрийг нь төлөөд явна, бусдыг нь өрийн одоо зохицуулалт хийж явахаас өөр арга байхгүй. Ингээж хугацааг нь хойш нь шидэж, төсвийн дарамтыг нь багасгаж явахаас өөр арга байхгүй.

Харин цаашидаа бид ийм, одоо бизнесийн зориулалттай, богино хугацаатай ийм арилжааны бонд гаргахгүй гэдгийгээ дунд хугацааныхаа хөтөлбөр дээр одоо хатуу Их Хурлаас даалгавар авсан. Ингээд энэ хүрээндээ ажиллаад явах болно. Харин бид урт хугацааны нэн хөнгөлөлттэй хөгжлийн зээлүүдийг бид аль болох бэлэн зөв төсөл хөтөлбөрүүдээ авч зөв ашиглах нь одоо богино хугацаанд төлбөрийн тэнцлээ, алдагдлыг нь бууруулах, одоо төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нь нэмэгдүүлэхэд одоо ашигтай байх болно. Тодруулж хэлбэл, зөвхөн Улсын Их Хурлаар батлагдсан шинэ сэргэлтийн бодлогын хүрээний хөрөнгө оруулалтуудыг дэмжих. Ингэснээр төлбөрийн тэнцэл Монгол Улсын валютын нөөц дээр одоо үлэмж нэмэртэй ийм л төсөл хөтөлбөрүүдийг одоо цаашидаа санхүүжүүлж явах болно.

М.Оюунчимэг: Иргэн Доржбат 2 асуулт ирүүлсэн байгаа юм. Манай улс ямар улс байгууллагад хамгийн их өртэй байгаа вэ? Хамгийн их өртэй 5 газрыг бодитоор нэрлэж хэлж өгнө үү? Сүүлийн 5-10 жилд өрийн хүүд нь яг ямар хэмжээний мөнгө төлсөн бэ гэсэн асуултыг асуусан байна. Энэ дээр тодорхой бичээд аваад хариулаарай Доржбат гуайн хариулт.

Их Хурлын гишүүн Баттөмөр гишүүн ингээж асуусан байгаа. Оюутолгой төсөл маань гадаад өрийн 12.5 тэрбум америк доллар байгаа. Энэ нийт өрийн 37 хувийг эзэлж байна. Гэтэл 2021 онд Оюутолгой энэ хоёр тэрбум орчим америк

долларын зэсийн одоо баяжмалын экспорт хийсэн. Тэгэхээр энэ дэлхийн хамгийн том баян компаниудын нэг. Тэгэхээр энэ их өрөөсөө тодорхой хэмжээг нь төлөх боломж байна. Ингээж төлж болдоггүй юм уу? Энэ дээр засаг төр яаж шахааж ажиллаж байгаа вэ? Ингэснээрээ нөгөө хүү багатай, урт хугацаатай зээл авч энүүгээрээ ажлын байраа бий болгох, экспортыг дэмжих, үйлдвэрлэлийг хөгжүүлэх ийм бололцоо байна, бид энэ боломжуудыг ашиглаж чадахгүй байна, энэ дээр тодорхой хариулт өгнө үү гэсэн байна. Энд хариулт өгнө үү?

Б.Жавхлан: Иргэнийхээ асуултад хариулъя. Энэ статистик асуулаа. Би Засгийн газар болон нийт улсын хэмжээнд 2 статистик хэлье. Засгийн газрын хувьд одоо манайд зээлдүүлсэн эхний 5 зээлдэгчийг дурдъя. АХБ 1, Япон улс 2, БНХАУ 3, Дэлхийн банк 4, БНСУ 5, Азийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын банк 6 гээд эхний 6 институцүүд нь ийм байна. Улсын нийт гадаад өрийн хувьд олон зээлдэгч оролцсон гэхээр одоо манай, өөрөөр хэлбэл нөгөө бонд holder-ууд. Бондоор дамжуулж хөрөнгө оруулагч хийсэн, энэ нь бол маш олон хөрөнгө оруулагч нар байдаг. Хоёрдугаарт одоо Нидерланд, өөрөөр хэлбэл Оюутолгой гэсэн үг, одоо Рио Тинтотой холбоотой, одоо бүртгэлтэй газар нь. Гуравт БНХАУ, дөрөвт Япон, тавд Сингапур, зургаад Хонг Конг, долод АНУ, наймд Люксэнбург, ёст ХБНГУ, арвант ОХУ, арван нэгт Франц улс, арван хоёрт БНСУ гэсэн эхний 12 улсын одоо нийт гадаад өрийн одоо зээлдэгч талууд байна. Сүүлийн 5-10 жилд өрийн хүүд ямар хэмжээний мөнгө төлсөн бэ гэж асуулаа. Сүүлийн 10 жилд хүүгийн төлбөрт шүү, зөвхөн хүүгийн төлбөрт 7.4 их наяд. 7.4 их наяд буюу өнөөдрийн ханшаар бол одоо хоёр тэрбум доллар гаруй тухайн үеийн ханшуудаар бодох юм бол энэ одоо бас ингээд дээшээ нэмэгдээд явна. Сүүлийн 5 жилд хүүгийн үүнээс бол сүүлийн 5 жилд хүүгийн төлбөр нь 4.8 их наяд байлаа.

Баттөмөр гишүүний дамжуулсан асуултад хариулъя, Оюутолгойтой

холбоотой. Би мөн л бас энэ талаар одоо бас санаа зовж явдаг хүн. Гэхдээ бид энэ жил бол маш том сайн алхам хийсэн, ямар ч байсан энэ Оюутолгойн их өрүүдээс бид Засгийн газрын одоо хариуцах байсан тэр өрийг одоо шилжүүлж компанийн өр болгосон байгаа. Энэ бол маш том амжилт. Өрүүд бол маш хатуу, олон улсын гэрээгээр, одоо хугацаатай. Оюутолгойн өрүүдийг харахад бол 10-аас дунджаар бол 10 жилийн хугацаатай ийм байдаг юм байна лээ. Тэгэхээр өр төлбөрийг бол яг энэ гэрээний хугацаагаар дарамт багатайгаар жигд тавьсан тэр юмаараа л явах нь зүйтэй. Олсон орлогоо тэр чигээр нь одоо өрөө төлөх биш, өрийн дарамтыг аль болох багатайгаар бусад мөн хөрөнгө оруулалтуудаа хийгээд, үйл ажиллагаагаа дэмжээд, ялангуяа одоо ирэх жилээс эхлэх далд уурхайн энэ үйл ажиллагааг одоо маш сайн дэмжиж, тодорхой хэмжээний одоо борлуулалтын орлогоосоо далд уурхайгаа дэмжээд, далд уурхайгаасаа одоо өгөөж авах тэр он жилүүдийг буюу одоо 27, 28 оныг одоо нааш нь татах ийм одоо зорилготой ажиллах нь илүү чухал болов уу гэж зүгээр миний эдийн засагч хүний бодол шүү.

Г.Занданшатар: Нийт 3 минут үлдсэн байна шүү, Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Иргэн Батбаяр ингэж асуусан байна л даа. 2013-аас 16 оны үед АН засаг барьж байх үед Чингис бонд буюу 1.5 тэрбум америк долларын ингээд бонд авсан. Эндээс яг тодорхой төсөл хэрэгжсэн үү? Сая Хөгжлийн банкны энэ зээл төлбөрийг харахад үнэхээр одоо дотор муухай оргиж байлаа гэнэ. Тэгээд та нар 17-гоос 19 онд энэ өрийг дарж байна гээд хэвлэлийн хурал хийгээд байсан, яг дарсан уу? Дарсан хэр нь яагаад буурдаггүй улам өсөөд байгаа юм бэ гэсэн асуултыг иргэн Батбаяр тавиад энэ асуултдаа яг хариулт авъя гэж хэлсэн. Тэгээд яг энэ сүүл бас хугацаа дуусаж байгаа. Би манай иргэд маань энэ D парламентыг ашиглаад Улсын Их Хурлын олонхын бүлэгт маш олон асуултууд ирүүлж, энд идэвхтэй оролцож, санал

бодлоо сайн иргүүлдэг болсон байна. Энэ бол бас иргэд төртэйгөө ойрхон байж өөрсдийнхөө санал бодлыг тусгах, сонирхсон асуултдаа Ерөнхий сайдаас, Засгийн газраас одоо хариултаа авах, энд нь Улсын Их Хурал, Улсын Их Хурлын олонхын бүлэг гүүр болж өгөх энэ бололцоог хангаж өгсөн энэ өөрчлөлт бол их чухал байна. Тийм учраас иргэд та бүхэн маань D-парламент руу орж бас ийм асуултуудаа ирүүлж, өөрсдийнхөө санал бодлыг одоо парламентаараа дамжуулж Засгийн газарт хүргэх бололцоо юм нээлттэй байгаа шүү гэдгийг бас хэлчихье. Тэгээд иргэн Батбаярын асуултад та хариулна уу.

Б.Жавхлан: За 2020 оноос хойш 8.5 тэрбум долларын Засгийн газрын гадаад өрийг өнөөдрийн байдлаар 8.1 тэрбум доллар болгож бид буулгачаад байгаа юм шүү. Бондын өр дээр бол бас бид тусдаа ярих ёстой. Бондын өр дээр. Бондын өр нийтдээ бид 3.3 тэрбум доллар болж, 16 онд хамгийн өндөр эрсдэлтэй хугацаанд байсан. Одоо 2.4 тэрбум доллар болж буурчхаад байгаа. Энийг одоо би түрүүн мэдээлэлдээ хийсэн. Бид одоо хичээгээд тухайн жилд нь юу гэдэг юм, 500 сая доллароор ч юм уу, 500-аас 1 тэрбум долларын хүрээнд байгаа нөөцөөрөө шууд, шууд төлөөд яваад байж болно. Гэтэл нөгөө талдаа одоо маш том макро шок үүсгэх учраас бид тэрийгээ даахгүй. Ингээд өрийн зохицуулалт хийж явахаас өөр арга байхгүй. Тэгэхээр 17, 18, 19 онуудад төлсөн бондын төлбөр буюу түрүүн би хэллээ Хуралдай, Гэрээг, Номад, Сенчури бондууд бол одоо өмнөх бондын өр төлбөрүүд дээр дандаа зохицуулалт хийсэн.

Харин жил бүр тухайн одоо төсвийн нөхцөл байдал, төсвийн чадамжийг харзнаад 100-150 сая долларын хэмжээнд үндсэн өрөө шууд дараа явсан байгаа юм. Тухайлбал, бид энэ жил одоо Чингис бондын төлөгдөөгүй байсан өр үлдэгдэл 136 сая долларын одоо өрийг төсөв дээрээс одоо шууд төлөөд, ингээд өрийг барагдуулж дуусаж байгаа юм. Тэгэхээр нийт өр бол багасаж байгаа,

харамсалтай нь бол хурд нь бол бага байна. Энэ бид одоо энэ нэг үнэ бодит мэдээллийг бол одоо хүргэх ёстой. Гэхдээ цаашидаа бид энэ өрүүдийг хугацааг нь уртасгаж, хүүг нь багасгах, жигдлэх ийм стратегийг бол барьж ажиллаж байгаа юм. Нэмэгдэх өрүүд буюу одоо урт хугацаатай, хөнгөлөлттэй энэ зээлийн эх үүсвэрүүд бол зөвхөн.../минут дуусав/

Г.Занданшатар: Нийт хугацаа дууссан байна 20 минут. АН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, мөн АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуулт асууна. 20 минут.

О.Цогтгэрэл: 20 минутад бас нэлээн хэдэн асуулт асуух хэрэгтэй байна. Сангийн сайд бас тодорхой хариулаад өгөөрэй. Сая Оюунчимэг гишүүний асуудаг асуултууд бас дунд нь адилхан байгаа болохоор эдгээрийг тодотгох журмаар ингээд асууцхъя. Улсын нийт өр 33 тэрбум, энийг төгрөгөөр илэрхийлбэл 110 их наяд. Энэ нь өөрөө засагт хамаатай, хамаагүй гэдэг яриаг би түрүүн бас хэлсэн. Энэ бол шууд бусаар ч гэсэн энэ бол хамаатай үзүүлэлт. Энэ мөнгө чинь Найман шарга дээр очиж доллар болж төгрөг чинь доллар болж гадагшаа гарна. Энэ чинь валютын ханшид нөлөөлнө. Валютын ханшид нөлөөлөхөөр юмны үнэ, ажлын байранд, бизнест, бизнесийн өрсөлдөх чадварт олон зүйлд нөлөөлж байгаа учраас энэ Монгол Улсын энэ өр бол Монголын төртэй холбоотой өр гэдэг ийм байр суурьтай.

Хоёрдугаарт нь яг тодорхой асуулт нь 2016 онд Монгол Улсын саяынх улсын өрийн тухай ярьж байна. Засгийн газрын өр 4 тэрбум байж байгаад одоо 8.1 болчихжээ. Өнгөрсөн 6 жилийн хугацаанд МАН-ын одоо эрх баригчид, үе үеийн Засгийн газрууд, Монгол улсын өрийг Засгийн газрын өрийг төлж барагдуулж байгаа, багасгаж байгаа гэдэг PR-г удаа дараа маш их хийж байсан. Тэгэхэд 4 тэрбум байсан өр яагаад 8 болчихов? Төлөөд багасгаад байсан бол энэ чинь 4-өөс

хасагдахгүй юу? Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын нийт өр Засгийн газарт огт хамаагүй шүү гэж бид ерөөсөө хэлдэггүй шүү. Бодлогын хүрээнд хамаатай байлгүй яах вэ. Харин Засгийн газрын шууд төлбөрт бол мэдээж хамааралгүй шүү дээ, тийм ээ. Энийг хольж хутгаж болохгүй. Бодлогын хүрээ гэдэг нь юуг хэлж байна вэ гэхээр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бид тогтвортой байлгах, цаашид сайжруулах, дээшлүүлэх энэ бодлогын нэг зорилт. Энэ бол хувийн ч бай, улсын ч бай бүх өрийн одоо эрсдэлтэй, эрсдэлгүй байдал дээр шууд нөлөөтэй. Энэ бол бид нарын нэгдүгээр бодлогын зорилт.

Хоёрдугаарт, Монгол Улсын нөөц, Төв банкны нөөц гэж ярьдаг. Энэ бол Монгол Улсын валютын нөөц. Монгол Улсын валютын нөөц өөрөө арвин байх тусмаа таны саяын хэлдэг 33 тэрбум төгрөг буюу нийт Монгол Улсын өрийн эрсдэлгүй байх баталгаа болдог. Энэ бодлогын хүрээнд бид одоо ажиллаж, дунд хугацааны стратегиа энд чиглүүлж ингэж явж байгаа. Түрүүн тийм түрүүн манай Сүх-Очир дарга нэлээн задлаад ярьсан даа. Ер нь сүүлийн 12 жилийн хугацаанд Засгийн газрын өр төлбөрийн хамгийн өндөр ачаалалтай төсөв дээр хамгийн өндөр эрсдэлтэй жилүүд нь 17, 18, 19 онууд байсан. Одоо ч гэсэн хүнд байгаа л даа. Гэхдээ өнөөдрийн хүртэл гэж би ярьж байгаа шүү. Тэр жилүүдэд нийт хүүгийн төлбөр одоо хүүгийн төлбөр 675 тэрбум байсан гэж би түрүүн дурдсан. Ингээд өрийн зохицуулалт хийсэн. Гадаад зээл тусламж авсан, ингэж байж бид дефолт бололгүй тэр жилүүдийг гарсан.

Ингээд 3 жилийн дараа буюу 19 онд хүүгийн төлбөр 119 тэрбум болж буурсан, тав дахин буулгаж чадсан. Өөрөөр хэлбэл урт хугацаатай гадаад зээл тусламжууд бас авсан байгаа шүү буцалтгүй тусламжууд. Ингэж авсны үр дүнд гадаад өрийн хэмжээ нь нэмэгдсэн. Гэхдээ төсөв

дээрх гадаад өрийн дарамт үлэмж багассан. Энэ хугацаанд бид мөн ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт орсон. Тэр хүрээнд 1.1 тэрбум доллар авсан. Үүнээс гадна олон улсын олон талт болон одоо 2 талд донор байгууллагуудаас 2.1 тэрбум долларын одоо урт хугацаатай, нэн хөнгөлөлттэй ийм одоо төслийн санхүүжилтүүдийг авсан байгаа.

О.Цогтгэрэл: 4 тэрбумаас 8 тэрбум болсныг та ингээд тодорхой үгээр нь бол ингээд зөвшөөрөхгүй л байгаад байна л даа. Яг үнэндээ Евро бондыг Номад бонд ч билүү ингээд нэрийг нь солиод дээлийг нь солиод л өмсгөөд байсан болохоос нөгөө өр чинь нэмэгдээд л байсан шүү дээ. Тэгэхээр өр багасаагүй, өр нэмэгдсэн. Энэ дээр Засгийн газрын өрөнд орохгүй мөртөө засагтай холбоотой маш их олон өрүүд байдаг. Монголбанкны свот хэлцэл дээр байгаа, Хөгжлийн банкн дээр Засгийн баталгаагүй өр, магадгүй зарим төрийн өмчит ААН-үүдийн өр гээд энэ өрүүдийг хэрэв эдгээр байгууллагууд, Монголын төрийн эдгээр байгууллагууд төлж чадахгүй бол Монгол Улсын Засгийн газар хариуцах уу? Монголбанкны өрийг. Хөгжлийн банкны өрийг. Энэ шууд болоод шууд бус утгаараа хамаатай юу, аль эсвэл Засгийн газрын баталгаагүй учраас хамаагүй гэж үзэх үү?

Б.Жавхлан: Монголбанкны өрийг Засгийн газар хариуцахгүй. Энэ Монгол улсын нийт өрөнд явж байгаа. Сайн мэдээ гэх юм бол ирэх 7 сард төлөгдөх Монголбанкны энэ своп өрийг дахин хойш нь одоо сунгасан байгаа. Хөгжлийн банкны өрөн дотор Самурай бонд буюу гучин тэрбум иений энэ өр Засгийн газрын баталгаатай байсныг одоо айх аюулгүй болсон. Бид одоо Хөгжлийн банкны эргэн төлөлтөөс 30 тэрбум иенийгээ цааш нь хадгалаад авсан. Энэ дээрээс ямар нэгэн эрсдэл Засгийн газар дээр учрахгүй. Та түрүүн хэллээ бондын өр болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан хөгжлийн урт хугацаатай зээлийг хооронд нь холиод байх шиг байна. Бондыг бол бид нар багасгаж байгаа шүү дээ. Бондын

өрийг. Таны саяын хэлсэн Хуралдай, Гэрэгэ, Номад, Сенчури бондууд чинь дандаа өмнөх өрөө бүгдийг нь тэрэнд зарцуулж төлсөн. Тэрнээс биш тэндээс нэг ч төгрөгийн бонд ер нь нэмэгдээгүй юм шүү. Нэмэгдсэн Засгийн газрын өр маань дандаа урт хугацаатай хөгжлийн зээл, ОУВС, Дэлхийн банк болон урьдчилсан санхүүжилтийн хөтөлбөрт орж ирсэн тэр зээлүүд дээр л нэмэгдсэн байгаа. Тэрнээс биш бондоор нэг ч долларын өр бол нэмэгдээгүй.

О.Цогтгэрэл: Монголбанкны өрийг жишээ нь Засгийн газар хариуцахгүй гэдэг бол худлаа, яаж бодсон ч Монгол Улсын төв банкин дээр байгаа өрийг Монгол Улсын төр хариуцахгүй гэдэг энэ бол зүгээр л та нар тэр Өрийн удирдлагын санхүүгийн тогтвортой байдлын хууль дээр бичсэн нэг бичилт дээр л тоглож байгаа болохоос биш энэ бол Монгол төрийн өр. Энэ бол эндээс яаж ч бултах арга байхгүй. Өртэй холбоотой тэгээд олон асуултууд мэдээж байна. Өр гэдэг чинь дахиад дээрээс нь валюттай л холбоотой асуудал энд явагдаад байгаа юм. Валют гэдэг чинь экспортоос нэг валют олно, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас нэг олно, өр зээл нэг тавина, төсвийн алдагдлаар дамжиж өр болох нь байна, энэ нэг хэдэн томоохон эх сурвалжууд байгаад байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэдэг энэ ойлголт одоо үндсэндээ Монгол Улсад бараг байхгүй болж байх шиг байна. Хэрэв та энэ дээр нэг тодорхой том хариулж өгөөч. Оюутолгойг хасвал гадаадын хөрөнгө оруулалтын сүүлийн жилүүдийн нөхцөл байдал тоо яг хэд байгаа вэ? Энэ дээр яг тодорхой ямар арга хэмжээнүүд авагдаж байгаа вэ?

Б.Жавхлан: Их чухал асуулт шүү. Наадах чинь бол ер нь их гол асуулт шүү. Гадаадын шууд хөрөнгө оруулалт бол манай эдийн засгийн ер нь нэг амин судас байдаг. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор гадаад шууд хөрөнгө оруулалт бол огцом буурсан, огцом буурсан байгаа. Энэний яг

нарийн статистик тоог Энхжин дарга хэлээд өгөх үү?

2022, 23 онуудад уул уурхай дагасан гадаадын шууд хөрөнгө оруулалт бас буцааж сэргэх ийм төлөвтэй байгаа. 23 он дээр ялангуяа бид одоо энэ дээр нэлээн эерэг хүлээлттэй байгаа. Энхжин дарга юуг хасаад Оюутолгойг хасаад FTI статистик хэлээд байх.

Г.Занданишатар: Цаг бага байгаа шүү товч, 82.

Д.Даваасүх: Цогтгэрэл гишүүний асуулт дээр хэлье. Монголбанкны Судалгаа статистикийн захирал Даваасүх. Жилд дунджаар бол ерөнхийдөө санхүүгийн дансан дээр шууд хөрөнгө оруулалт бол 1.4 тэрбум ам.доллар байгаа. Үүний тал орчим нь бол ерөнхийдөө Оюутолгойтой холбоотой тоо байгаа.

О.Цогтгэрэл: Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг ойлголт бол үнэхээр бараг байхгүй болж байгаа. Тэр тусмаа Оюутолгойг хасаад ирэх жилээс энэ далд уурхайн бүтээн байгуулалт нь зогсчихно. Энэний цаана яг үнэндээ бүхэл бүтэн ингэж хөгжил дэвшлийн том үзүүлэлт болсон хөрөнгө оруулалт, тэр тусмаа гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэр тусмаа уул уурхайн бусад салбарын хөрөнгө оруулалт гэдэг энэ сүүлийн засгуудын үед үнэхээр одоо бодлогын том алдаа, үе уламжилсан бодлогын том алдаанууд явж үндсэн дээр хөгжил дэвшлийн бараг том хөшүүрэг болсон энэ зүйл бүрэн дүүрэн ашиглалтгүй, гадаадын хөрөнгө оруулагчид дайжсан ийм л нөхцөл байдалтай байна.

Хоёрдугаарт нь тэр экспорттой холбоотой экспорт гэдэг чинь одоо явсаар байгаад уул уурхай болчихлоо. 10-аад тэрбум доллар ч байна уу, 93 хувь нь уул уурхай гэсэн. Уул уурхай дээр нь тэр ордог орлого нь оффтейк гэрээ оффтейк ч байна уу бартер хосолсон гэрээ юм шиг байгаа юм. Одоо саяын зөвхөн гарч ирж байгаа тэр гэрээнүүдийн дүнг харахад зөвхөн 4-5

тэрбум доллар одоо мэдэгдэж байгаагаар. Энэ чинь 2 манай Эрдэнэс таван толгой чинь нийтээрээ жилдээ өндөр борлуулалттай үедээ жилдээ тэрбум долларын борлуулалт хийдэг компани шүү дээ. Гэтэл одоо магадгүй хэдэн жилийн ч юм борлуулалтаа бүгдийг нь одоо бартердаад урьдчилж аваад зарцуулахыг нь зарцуулаад, баахан гэрээ хийгээд олон улсын хариуцлага хүлээчихсэн байх нь л дээ. Тэгэхээр одоо энэ орлого яах юм бэ? Уул уурхайн нөгөө гол экспорт, экспорт нь уул уурхай, уул уурхай дотроо нүүрс, нүүрсэн дотроо Таван толгой. Таван толгой нь магадгүй 5 жилийнхээ борлуулалтыг зуун хувь гэрээлээд хаячихсан байдаг. Одоо энэ нэгдүгээрт нь энэ нүүрснээс чинь ямар мөнгө орж ирэх юм бэ?

Хоёрдугаарт нь, ер нь энэ уул уурхайн экспорт гэдэг зүйлийг нь энэ бодлого дээр нэг товчхон үг хэлж өгөөч. Энэ чинь одоо бүр бусад уул уурхайд нь ажиллах хүчин хөдөлмөр шингэдэггүй, тэгэнгүүтээ энэ уул уурхай дамжсан орлогын ялгаа, олон зүйлүүд нь гараад энэ эдийн засаг чинь зөвхөн нэг энэ уул уурхай чинь магадгүй бараг эдийн засгаа сүйрүүлэх хэмжээнд, зөвхөн эдийн засгаа биш энэ гудамжинд байгаа нөхцөл байдлыг харахад улс орноо энэ уул уурхайн засаглалгүй энэ уул уурхайн бодлого чинь улс орноо сүйрүүлэх хэмжээнд одоо ингээд тэр босгон дээр очиж байна шүү дээ. Тэгэхээр энэн дээр нэг тодорхой Засгийн байр сууриа хэлж өгөөч.

С.Одонтуяа: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад үргэлжлүүлж хариулъя. Тэр Эрдэнэс таван толгойн оффтейктой холбоотой зүйл дээр би яг тантай ижилхэн санаа зовж байна. Энэ тоонуудыг ил болгоод нэг тооцоолж үзэх хүртэл би их айж байлаа. Ирэх жил одоо ер нь яадаг бол, сая энэ жил жишээ нь бид нар б сараас хойш экспорт маань одоо үлэмж нэмэгдсэн. Үлэмж нэмэгдсэн шүү. Гэтэл орж ирэх валютын урсгал маань үлэмж нэмэгддэггүй. Тэгээд энэ тоонууд ил болоод

тооцоод үзсэн, энд харин нэг жижигхэн би одоо бас тайвширсан. Өөрөөр хэлбэл энэ оффтейкийн нөлөө нь 30 хувь байна. 30 хувь юм байна. Өөрөөр хэлбэл 70 хувь нь гарлаа, 30 хувь нь оффтейк дээрээ явах юм байна лээ, эргэж орж ирэхгүй гэсэн үг ингээд.

Тэгэхээр 70 хувь дээр бид нарт бас нөөц боломж байгаа. Мөн 30 хувийн тэр хийгдсэн энэ оффтейкийн гэрээг одоо сайжруулах нөхцөлийг нь одоо харилцан ашигтай байх, хэлбэр рүү нь оруулах энэ ажил дээр бид ажиллаж байгаа гэж ингэж мэдээлэл өгсөн. Тэгэхээр 70 хувь дээр гаргаж байгаа экспортоо импорттойгоо харьцуулж бид төлбөрийн тэнцлээ сайжруулах, өөрөөр хэлбэл зөрүү нэмэх байх тал дээр ажиллах ёстой юм байгаа юм. Тэгэхээр бид нар ирэх жил экспорт явж байгаа, яг энэ хурдаар нь явуулаад, харин импорт талдаа буюу гарах урсгал дээр маш сайн хяналттай, хязгаарлалттай ингэж явах ийм бид нар бодлого барина. Тэгээд сая энэ Монголбанкныхан тоонуудаа яалдаа. Жилүүдээ харьцуулж динамикаар нь хэл л дээ. Одоо наад гадаадын шууд хөрөнгө оруулалт чинь 1.1 болчихсон байгаа, буурчихсан байгаа ч үнэн. Өндөр жилүүдтэй 10, 11, 12 онуудад гурван тэрбумаас дөрвөн тэрбум доллар хүрч байсан шүү гадаадын хөрөнгө оруулалт.

Гэтэл одоо энэ чинь ингээд 3 дахин буурчихсан байгаа байхгүй юу. Энэ нь бидэнд одоо маш том ийм цохилт болж байгаа. Энийгээ сэргээхийн тулд бид гадаад өрнийхөө менежмент, өөрөөр хэлбэл манай макро эдийн засгийн гадна талд одоо харагдах байдал, энэ үзүүлэлтүүдийг бид одоо эхэлж эмчилж байж, сайжруулж байж гадаадын хөрөнгө оруулалт тэрийгээ дагаад аяндаа өөрсдөө орж ирэх. Бидэнд өөрсдөд нь бол одоо байгалийн баялаг, бусад одоо аялал жуулчлалын салбар гээд гадаадын хөрөнгө оруулалтыг татах болохуйц потенциалын ийм л соронзууд татах хүчүүд бол бидэнд байгаа. Гагцхүү бид нар макро менежмент, энэ гадаад өрнийхөө энэ

нөхцөл байдлуудыг одоо сайжруулах нь одоо хамгийн одоо тулгамдсан чухал том зорилт болж байна.

С.Одонтуяа: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Бас энэ өртэй холбоотой зүйлийн нэг томоохон хүчин зүйл төсөв. өсөв дээр 2 том одоо тийм аймшигтай 2 том дүр төрх яваад байгаа юм. Нэгдүгээрт нь 2017 онд 9 их наядын төсвийн зардалтай байсан Монгол Улс 5 жилийн дотор 20 их наяд болчихлоо. Төсөв нь 2 дахин томорчихлоо. Нөгөө эдийн засаг нь хэд дахин томорч, яаж байгаа билээ? Төсөв нь томроод байдаг, төр нь томроод байдаг. Тэгээд 2 дахь тоо нь энэ томорч байгаа төсөв нь өөрөө сүүлийн 3 жилд 10.6 их наядын алдагдалтай. Алдагдалтай буюу тэр томорч байгаа хэсэг нь татварын орлогоороо бусад зүйлээрээ томрохгүй, энэ нь өөрөөр томроод байгаа юм, алдагдлаар томроод байгаа юм. 17 оноос 22 он хүртэл 9 их наядын төсөв 20 их наяд болсон. Энэ нь яг сүүлд зөвхөн сүүлийн 3 жилд 10 нийтийн алдагдалтай.

Тэгэхээр энэ чинь өөрөө энэ өр үйлдвэрлээд байгаа үндэс нь одоо яг суурь тэр урсгал, тэр цоргоны одоо хоолой чинь эндээ байгаад байгаа юм биш үү? Тэгээд яагаад энийг ингэж мэдсээр байж сүүлийн жилүүдэд ингэж огцом төсвийн алдагдлаар төрийн данхайлтаар ингэж Монгол Улсын өрийг нэмээд байгаа вэ? Энэ бодлого одоо цаашид энэ чигээрээ үргэлжлэх юм уу?

Б.Жавхлан: Төсвийн алдагдал, нөгөө талдаа төсвийн тэлэлтийг ярьж байна. Зөвөө зөв. Ер нь бол цаашидаа бид энэний яг эсрэг мөчлөг сөрсөн бодлого явуулж байгаа. Энийгээ бид дунд, урт хугацаанд төсвийн хүрээнийхээ мэдээдлээрээ тодорхойлчихсон, Их Хурлаасаа даалгавар авчихсан ингээд ажиллаж байгаа юм. Энэ яг бодлоготойгоо нийцсэн төсвийг маань Их Хурал одоо маш сайн дэмжиж баталж өгсөн байгаа шүү. Алдагдлаа бид нар тодорхой хэмжээнд бууруулж байгаа. Бууруулах, бууруулахдаа бид нар 1 жилийг

нөхөж бууруулж байгаа. 1.5 их наяд дээр бид нар одоо 24 онд хүрэх ёстой байсныг 23 он буюу 1 жилээр татаж байгаа. 19 он хүртэл уг нь бид төсвийнхөө алдагдлыг бууруулаад ашигтай гаргах хэмжээнд очиж байсан. Харамсалтай нь дэлхий нийтээрээ хэний ч тооцоолоогүй бид ковидын нөхцөл байдал, ковидын төсөв рүү явж орсон. Ингээд ганц манай улс биш шүү, ганц манай одоо бид биш, дэлхий нийтээрээ төсвийн алдагдал руу орж шилжсэн. Бүх улс гүрэн ийм байдал руу орсон.

Энийг харин их сайн менежмент хийж, төсвийн алдагдлаа шат дараатай бууруулж, сахилга баттай явах нь хамгаас чухал байгаа юм. Төсвийн тэлэлт хэрэв бид тэр 23 он хүртэл хорин, өмнөх төсвийн тэлэлтийн тэр хурдаар явж байсан бол 24 их наяд хүрэх тийм төсөвтэй байгаа байсан. Харин бид 20 их наяд дээр ДНБ маань одоо 50 их наядын босго давлаа. Ингэснийхээ харин өөрөөр хэлбэл төсвийг нь тэлэхийн хэрээр дотоодын бүтээгдэхүүн буюу одоо эдийн засгийн өсөлтөө дэмжиж чадсаны үр дүнд энэ хэчнээн их алдагдал гарсан ч гэсэн бид нар богино хугацаанд ковидын нөлөөг арилгаж эргүүлээд бид нар эдийн засгийн өсөлтөө одоо барьж авч чадсан. Энэний төлөө л гарсан төлбөр юм байгаа юм.

Тэгэхээр бид ДНБ-ийхээ өсөлтийг ч хангаж чадсан, төсвийнхөө хэт тэлэлтийг ч бас тодорхой хэмжээнд барьж чадсан ийм 21, 22 оны жилүүд байлаа. 23 оны төсөв дээр ч тэр хэд одоо тэлэх байсан, тэр одоо хурдыг сааруулж, бид одоо 20 их наяд дээр буюу өмнөх жилээс одоо 10 дотор хувиар өссөн ийм одоо төсвийг өргөн барьж батлуулж чадсан.

О.Цогтгэрэл: Минут бас дуусаж байх шиг байна. Саяын, одоо эдийн засгийн үзүүлэлтүүд, олон талын зүйлүүдийг ингээд ярихад зөвхөн бид нар энэ заалан дотор маргалдаж мэтгэлцэхээсээ урьд дээр хоёрхон зүйлээр л дүн тавьж болох юм гэж. Нэгдүгээрх нь ард иргэдийн ахуй нөхцөл байдал яг энэ гудамжинд байгаа энэ нөхцөл байдал чинь яг эдийн засгийн бодит

тусгал нэг энд нэгдүгээрт явж байна. Бодит тоо тоогоороо бол олон улсын зах зээл дээр Монголын санхүүгийн хэрэгслүүдийн зээлжих зэрэглэл, тэр одоо үнэлгээгээр В гэж үздэг байх. Тэр В гэдэг үнэлгээ чинь өөрөө олон улсын санхүүгийн зах зээлийн тэр самбар дээр жанк гэдэг ангилалдаа ордог байх. Энэ чинь В3+ байвал дээшээгээ сонирхол татахуйц байдаг байх. Одоо бол манай бонд жанк. Жанк гэдэг нь яг юу билээ, жаахан хатуухан үгээрээ бол бараг тэр хөрөнгө оруулалт хийх шаардлагагүй, эрсдэл өндөртэй, бараг л хогийн бонд гэсэн үг. Тэр ангилалд л, манайх энийгээ сайн гэж хэлдэг. Гэтэл олон улсын ангиллаараа бол жанк гэдэгт л ордог шүү дээ.

Тэгэхээр бид нарын ажлын үнэлэлт дүгнэлт бол ийм байна. Тэгээд төгсгөлд нь Чингис бондоор цахилгаан станцуудын өргөтгөл хийж, аймгуудыг дутууг гүйцээж, авто замуудыг холбож, гудамж төсөл гээд тоолбол асар олон зүйлүүдийг хийсэн. Энийг 1.5 тэрбум доллароор маш бага ажил хийсэн гэж сурталчилдаг. Бага байна уу, их байна уу ямар ч байсан ийм тодорхой хэмжээний нүдэнд үзэгдэх ажлууд хийгдсэн. 1.5 тэрбум доллароор.

Хамгийн эхний тэр ярилцаж байсан тоонууд буюу сүүлийн 6 жилд, сүүлийн 6 жилд эрх баригчид 4 тэрбум долларын өрийг нэмэгдүүлжээ. Чингис бондоор тийм ажлууд хийж, яг энэ дөрвөн тэрбум доллароор нүдэнд үзэгдэхүйц гарт баригдахуйц яг ямар, ямар ажлууд хийгдсэн бэ? Та нэг энэ дээр 1-т, 2-т, 3-т нь гээд хэлж өгөөч. Сүүлийн 6 жилд дөрвөн тэрбум долларын өр нэмэгджээ. Энэ дөрвөн тэрбумаар яг ямар ажлууд хийгдсэн юм бэ? Нүдэнд үзэгдэж гарт баригдахуйц. Чингис бонд дээр бол бид нар олон ажлыг бас тоочиж хэлж бас чаддаг.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүнээ таны асуултад хариулъя. Тэр зэрэглэлийн хувьд бол одоо би танд их муу зүйл хэлэх нь байна шүү, уучлаарай, битгий та бухимдаарай. 16 онд ВВ+ байсан шүү дээ манайх, В+ ч байсан. Харамсалтай нь бид

маш хүнд өрийн дарамтад орж, тийм нөхцөл байдал хүлээж авсан. 16 он хүртэл зэрэглэлүүд буурсан, тогтвортой байлгаад бид В энэ зэрэглэлүүд сайжруулж байгаа. Энэ хүнд жилүүдэд харин бид нар тогтвортой байлгаж чадаж байгаа, энэ жилийн. Ялангуяа бид нар Хөгжлийн банк дээр нэлээн санаа зовж байсан. Хөгжлийн банк энэ бүтэн жилийн хугацаанд муу зээлүүд дээр маш сайн ажилласан учраас бид тогтвортой.../минут дуусав/

С.Одонтуяа: Цаг дууссан. Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал, гадаад үнэт цаасны дахин санхүүжилт, өрийн зохицуулалт, гадаад зээлийн үр өгөөж, дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл, Засгийн газрын өрийн баталгаа, эрсдэлийн үнэлгээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Сангийн сайд Жавхлан хийж, гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дараагийн асуудалд орно.

16.14 цагт

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Өмнө нь гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 10 санал байна. Энэ Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Зарлана, зарлана. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн болон дэмжээгүй, дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлж болно.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг байгаа юу тийм ээ Наранцогт? Ажлын хэсгийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Ажлын хэсэгт П.Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Ууганбаяр, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Даваасамбуугийн Мөнхбаатар Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаа удирдлагын газрын дарга, Жамсрангийн Солонго Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Баттулгын Эрдэнэбат Гадаадын иргэн, харьяатын газрын хуулийн мэргэжилтэн, Төмөрчөдөрийн Нарантунгалаг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч.

Үдээс хойших нэг бүртгэлийн санал хураалт нэг явуулах уу даа. Үдээс хойш тэгээд. Үдээс хойших хуралдаан эхэлж байгаа тул бүртгэлийн санал хураалт явуулъя, бүртгэлийн санал хураалт гишүүдээ, идэвхтэй оролцоорой. Гишүүд танхимдаа цуглая. Одоо хүлээж байгаарай Пүрэвдоржоо, ирцээ хараадахъя. 56.6 хувийн ирцтэй байна. Зарчмын зөрүүтэй 10 санал байгаа. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүмүүс асуулт асууж биш ээ, асуулт асуухгүй, үг хэлэх ийм дэгтэй байгаа. Саналыг танилцуулъя. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын цахимжуулалт, мэдээллийн технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ш.Адъяаа, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир цаашид ажлын хэсэг гэх. Үг

хэлэх гишүүд саналаа өгье дэмжсэн, дэмжээгүй 3. Учрал гишүүнээр тасаллаа. Нямбаатар гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: Баярлалаа. Энэ Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдоржийн санаачилсан хуулийн төсөл байгаа юм. Бас Пүрэвдорж гишүүн өөрөө өмнө нь энэ албыг толгойлж байсан, Гадаадын иргэн, харьяатын байгууллагыг удирдаж ажиллаж байсан, амжилттай удирдаж байсан хүний хувьд бас энэ байгууллагын хөгжил, энэ байгууллагыг цаашаа цахимжуулах тал дээр ийм одоо үгүй ээ үгүй, би яг бодит зүйлийг ярьж байна л даа. Тэгэхээр би хөгжил талдаа энэ их дэмтэй зүйл байгаа юм. Одоо Гадаадын иргэн, харьяатын байгууллага, Хил хамгаалах байгууллага 2 мэдээллийн технологийн салбарт дундын мэдээллийн сантай явж байгаа. Тэгэхээр энэ дундын мэдээллийн санг цаашид бид нар шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа.

Хоёрдугаарт, гадаадын иргэн, харьяатын байгууллага одоо цахим виз нэвтрүүлээд дэлхийн одоо бараг зуугаад улсад цахим визээ нэвтрүүлэх энэ амжилттай явагдаж байгаа. 2023 оныг Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсад айлчлах жил болгон зарласантай холбогдуулаад Гадаадын иргэн, харьяатын байгууллага цаашид энэ цахим шинэчлэл, цахим аюулгүй байдал талдаа тодорхой зүйлүүдийг хийх зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгээд энэ саналыг Мөнх-Оргил гишүүн, Байнгын хороон дээр бас хэд хэдэн гишүүд гаргаад энэ хамгийн дундаж одоо хувилбар байна гээд ажлын хэсэг дээр энэ саналыг дэмжээд явсан юм. Тийм учраас би Их Хурлын гишүүдийг энэ саналыг дэмжиж өгөөч гэдгийг бас хичээнгүйлэн хүсэж байна.

С.Одонтуяа: Дэмжиж үг хэллээ. Одоо Сандагийн Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ.

С.Чинзориг: Энэ 40.3 дахь найруулга яагаад ийм юм орж ирсэн юм бол доо. Төсвийн тухай хуулиас чинь энэ

төсөвт байгууллагуудын төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны орлогоор орсон орлого бол тэгээд л дараа жилийнхээ төсөвт тусгаад л дахин, дахин хуваарилагдаад л явдаг шүү дээ. Энийг заавал одоо ингэж юунд нь оруулж дараа дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэж ингэж оруулах зайлшгүй шаардлага одоо байгаа л юм байх даа. Тэртээ тэргүй энэ чинь улсын төсвийн орлого болоод л орж байгаа орлого болоод ороод ирнэ. Тэгээд энэ чинь тэгээд дараагийнхаа жилийнх нь төсөвт дахин хуваарилагдаад л ороод ирж байгаа юм шүү дээ. Энийг заавал ингэж тодруулах шаардлага байсан юм болов уу гэж би бол бодож байгаа юм.

Хоёр дахь асуудал би дараа дараагийн санал дээр үг хэлээд яах вэ гэж бодоод. 2 дахь санал хураалт байгаа, энэний дараа уншигдах байх. Тэр 41-ийн 41.1, 41.2 дахь заалт байгаа юм. 41.1 дээр энэ төрийн байгууллага гээд тодорхойлчихсон байна. Энэ чинь бол агентлаг шүү дээ. Агентлаг чинь одоогийнхоо хуулийнхаа хэвшмэл хэллэг нэр томъёогоор бол төрийн захиргааны байгууллага гэж явдаг шүү дээ бүр ажлын хэсэг. Тийм тусгай чиг үүргийн хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн гээд тодорхойлчихсон байх юм. Энэ чинь бол агентлаг. Тийм учраас бол төрийн байгууллага дангаараа гэж бичихгүй төрийн захиргааны байгууллага мөн гэсэн ийм одоо томъёоллоор явах ёстой шүү дээ. Энэ ажлын хэсэг энийг ярьсан юм болов уу, үгүй юм болов уу гэж. Би тэгэхээр яах вэ гишүүдээ хүндэтгээд дахин, дахин үг аваад яах вэ гээд. Дараагийн санал дээр нь бол саналаа хэлчхэж байгаа юм.

С.Одонтуяа: Ганзоригийн Тэмүүлэн шүг хэлнэ.

Г.Тэмүүлэн: Энэ зүгээр яах вэ, сая асуулт асуух дээр бас хоцорчихлоо. Тэгээд яах вэ, ардаас хууль санаачлагч өөрөө Пүрэвдорж гишүүн ч гэсэн өөрөө хариулт үг хэлэх юм байна, би тайлбар хэлээч гэж хүсэх гээд байгаа юм. Тэгээд энэ Гадаад

иргэний эрх зүйн байдлын тухай хууль дээр гээд л. Ер нь зүгээр манайхны хувьд энэ хуулиудыг харахаар нэг ийм онцлогийн зүйл гарч ирээд байна. Салбар салбарын хууль орж ирдэг. Ард нь эргээгээд өөр өөрсдийнхөө байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх гэсэн, санхүүжилт төсвийг нь нэмэгдүүлэх гэсэн ч гэдэг юм уу ийм зүйлүүд дагалдаж орж ирээд байгаа юм. Тэгээд гадаадын иргэн харьяат гээд аваад үзэхээр улсын төсөвт төвлөрүүлэх гэж байсан орлогуудыг буцаагаад энэ нэмэлт орлого ч гэдэг юм уу, нэг талдаа энэ төсвийн нэгдмэл байдалтай холбоотой асуудлаар эргээд л орлогыг нь байгууллагуудаа татан төвлөрүүлэх гэдэг, өөрөө өөрсдийгөө санхүүжүүлэх гэдэг, нэмэлт эх үүсвэр бий болгох гэдэг. Энэ зүйл чинь зөв юм уу? Яагаад ийм зүйлүүдийг одоо салбар салбарын хууль дээр оруулж ирээд байгаа юм бэ? Энэ чинь одоо байгууллагуудынхаа амбицыг, салбарынхаа амбицуудыг ингээд хууль дээр гаргаж идэхээ боль л доо. Төсвийн хууль дөнгөж саяхан батлагдчихсан шүү дээ.

Дараагийнх нь заалт дээр ч гэсэн энэ юуны асуудал орж ирэх юм, төрийн тусгай, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага болно. Албан хаагч нар нь төрийн тусгай албан хаагч байна энэ тэр гээд орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ чинь ялгаагүй дахиад л цалингийн шатлал дээр зөрүүний асуудлууд гарч ирнэ шүү дээ. Ирэх оноос хэрэгжээд эхэллээ гээд төсөв, мөнгөний асуудлыг нь яах асуудал явах гэж байгаа юм, хаанаас санхүүжүүлэх гээд байгаа юм бэ? Ингэх шаардлага байгаад байгаа юм уу? Байгууллага болгоныг ингээд нэг нэгээрээ амбицаараа хөтлөөд төрийн тусгай албан хаагч нар болгоод байх ер нь шаардлагатай юм уу, ямар онцгой шаардлага байгаад байгаа юм, ямар үндэслэл байгаад байгаа юм бэ? Магадгүй энэ хууль санаачлагч өөрөө ардаас үг хэлэх юм байна. Энэ дээр би бас тайлбар хэлээч гэж хэлэх гээд байгаа юм. Ингээд нэг салбар салбарын амбиц гаргаад, дураараа ингээд нэг төсөв мөнгийг санхүүжүүлэх эрхүүдийг өөр өөрсөд дээрээ татаж аваад, нэмэлт

орлогуудыг төсөв дээр төвлөрүүлээд буцаагаад нэгдсэн төсвөөсөө энэ чинь бид нар байгууллагууд дээр хуваарилдаг зүйлүүдийг, нэмэлт орлогуудыг татаад байдаг чинь зарчмын хувьд буруу шүү дээ энэ их. Пүрэвдорж гишүүн та энэ дээр бас тайлбар хэлээч гэж бодоод байгаа юм.

С.Одонтуяа: Хариулах дэг байхгүй. Тэгэхдээ одоо Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би энэ гадаадын харьяатын байгууллагад 3 жил ажилласан. Тэгээд намайг очиход ширээ дүүрэн ийм цаас тавьчихсан, тэр цаасан дээр яадаг вэ гэхээр хилээр очиж байгаа олон удаагийн бизнес дээр заавал газрын дарга нь гарын үсэг зурдаг байсан юм. Тийм учраас нөгөө нэг энэ одоо аялал жуулчлал чинь нөгөө нэг хүний гарын үсэг дээр очоод гагцхихдаг байсан байхгүй юу даа. Тэгээд энэний учрыг нь олоод нийтдээ 86 журам байсныг нь 44-ийг нь хүчингүй болгосон. Тэгээд 44, үлдсэн 42 журмын журмаар нь бол энэ гадаадын харьяатын байгууллагын албан хаагч нар дарга нь ч тэр, бүх хүмүүс бүгдээрээ ямар ч эрх байхгүйгээр зөвхөн үүрэгтэй ажилладаг болгосон юм. Тэгээд энэний хүрээнд одоо бүх хил дээр байгаа мэргэжилтэн албан, юу байцаагч нар тэр газраа олон удаагийн, нэг удаагийн визийг олгодог болсны үр дүнд энэ байгууллага 2012 онд 4 тэрбум төгрөгийн орлого олдог байгууллагыг дараа жил нь гэхэд 13 тэрбум төгрөгийн орлого ордог байгууллага болгосон байхгүй юу даа.

Тийм учраас дүрэм журмын цаана ямар их тийм одоо хүнд суртал байдаг вэ гэдэг нь эндээс харагдаж байгаа. Тэгэхээр энэ гишүүд нэг зүйлийг бас андуурч ойлгоод байна. Хэн Нямбаатар сайдаа, та бас энэ дээр дэмжиж байгаа юм байна. Тэгэхээр энэ чинь нөгөө нэг хураамж, шимтгэл чинь ерөөсөө орон нутгийн төсөвт ордог шүү дээ. Улсын төсөвт ордоггүй, орон нутгийн төсөвт ордог. Тэгээд энэ би бол энэ хууль хуульдаа оруулж ирэхдээ хураамж, шимтгэлээс нь 20 хувийг одоо энэ байгууллагад нь үлдээх тухай санал оруулж ирснийг Мөнх-Оргил гишүүн зарчмын

зөрүүтэй санал гаргаад, энэ ер нь бол энэ Их Хурал дээр уначхаж магадгүй юм гэж үзээд ерөөсөө зөвхөн тэр хураамж, хураамж шимтгэлээс ямар ч юм авахгүй. Тэр орон нутгийнхаа төсөвтөө ордгоороо орно.

Зөвхөн виз бичсэн тэр хөлс байна шүү дээ 40 доллароор одоо жишээ нь нэг удаагийн цахим виз олголоо гэхэд 40 доллар бол Хан-Уул дүүргийнхээ төсөвтөө ордгоороо орчихно. Тэр шинэ хөлс тэр виз бичсэний хөлс болгох үйлчилгээний хөлс болох 5 долларыг л үлдээх тухай ярьж байгаа юм. Тэр байгууллага чинь өөрөө тэр визний чинь одоо наалт бүх юмнуудыг бүгдийг нь хийнэ, үйлчилгээний зардал гарна. Тэр 5 долларыг л авах тухай ярьж байгаа болохоос биш энэ ерөөсөө тэр нөгөө нэг орон нутгийн төсөвт орох ёстой тэр хураамж, шимтгэлээс авах тухай ойлголт ерөөсөө байхгүй болсон шүү. Яг энэ санал хураалтын явцад бол манай Мөнх-Оргил гишүүн зөв болгоод биччихсэн байгаа. Тэгээд энэ Их Хурлын гишүүд та бүхнийг энэ саналыг дэмжээд өгөөч. Энэ надад бас энэ юу ирчихсэн байгаа юм. Энэ Хууль зүйн яамны нэг нягтлан, ерөнхий нягтлан бодогчийн юу ирчихсэн байна, санхүүгийн дарга нарын бичиг ирчихсэн байна.

Энэ бичгээр энэ жилийн хувьд бол нөгөө энэ үйлчилгээний хөлс 179 сая төгрөг л одоо энэ байгууллагад ирж байгаа юм байна 179 сая. Тэгээд энэ 179 сая төгрөгийн л асуудал байхгүй юу даа. Бусдаар одоо нэг 10 хэдэн тэрбумаас 20 хувийг авах тухай ерөөсөө ярихгүй байгаа.

С.Одонтуяа: Ням-Осорын Учрал гишүүн үг хэлнэ.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүний энэ ажлын хэсгийн гаргаж байгаа санал бол нөгөө санаа нь бол зөв. Тэгэхдээ арга бол мэдээж санаагаа зөвтгөхгүй л дээ. Тэгэхээр наадах чинь санаа нь бол их зөв байгаа юм. Ингээд төсөв мөнгө хуваарилаад, мэдээлэл технологийн шинэчлэл хийе гээд. Гэхдээ одоо бид нар нэг зүйлийг ойлгох ёстой. Хуулийн давхардал

хийдлийг арилгахгүй бол болохгүй баймаар байгаа юм. Жишээ нь энэ Хууль зүйн яам боловсруулаад Их Хурлаас баталсан тэр Нийтийн мэдээллийн хууль байгаа шүү дээ, тэр чинь дэд бүтэц нь тодорхой хуульчлагдсан. Гэтэл өнөөдөр мэдээлэл технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад гэж ингэж томъёолж ер нь болохгүй. Нийтийн мэдээллийн үндсэн систем гэдгийг томъёолсон, дэмжих системээ томъёолсон. Аюулгүй байдлыг хангах байгууллага нь энэ хуулиар тодорхой байгаа.

Тэгэхээр байгууллага болгон өөр өөрсдөө мэдээллийн технологийн шинэчлэл хийгээд аюулгүй байдлаа хангаад явна гэдэг ийм ойлголт энэ дээр гарч байгаа нь бол зохимжтой биш. Бид нар чинь өнгөрсөн хугацаанд замбараагүй явж ирсэн энэ төсөл хөтөлбөрүүдийг хооронд нь уях гээд бас зүдэрч байгаа шүү дээ. Жишээ нь нийтийн мэдээллийн үндсэн системтэй холбох, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулсан ч гэдэг юм уу, ингэж томъёоллыг нь өөрчилж өгөхгүй болохоор энэ их ойлгомжгүй байгаа юм. Тэгээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульдаа, дээрээс нь Кибер аюулгүй байдлын хуульд ч гэсэн кибер аюулгүй байдлын энэ онц чухал мэдээллийн дэд бүтцийн жагсаалтад чинь энэ харьяат орсон шүү дээ. Тэгэхээр мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулан нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбоход ч гэдэг юм уу, ингэж нэг тэр нэр томъёоныхоо уялдаа холбоог анхаарахгүй бол болохгүй байгаа юм.

Өнгөрсөн 2 жилд төрийн байгууллагууд нийтдээ жаран хоёр тэрбум төгрөгийн сервер, тоног төхөөрөмж авсан байна лээ. Бид нар шалгалт хийсэн чинь хэнд ч хэрэггүй төмрүүд л байгаа шүү дээ. Очоод энийг яах юм гэхээр үгүй ээ, тендер зарлаад авчихсан юм, ажиллуулах хүн нь ч ойлгомжгүй, дотор нь хэрэглэх программ нь ч хаана байгаа нь мэдэгдэхгүй, ашиглалтыг нь хариуцах хүн байхгүй, энийг та нар авчхаач гээд бид нарт одоо ингээд санал болгодог байхгүй юу. Тэгээд би нөгөө

үндэсний дата төв дээр очоод энийг та нар аваад байрлуулчихаад гэхээр үгүй ээ наадах чинь зөрнө шүү дээ, манайх чинь өөр шүү дээ гээд ингээд. Тэгээд бид сая Засгийн газраас тэр сервер, тоног төхөөрөмжүүдийг төрийн байгууллагууд авах шаардлагагүй, хуулийнхаа дагуу авах шаардлагагүй буюу тэр Үндэсний дата төв дээр байгаа сервер тоног төхөөрөмжөө сайжруулаад харин өөр дээрээ сервер байх юм бол солилцох боломжийг нь олгоод яв гэж тэр Эстони засаглалын академиас зөвлөсний дагуу яг тэр нөгөө нэг тархсан биш систем дээр бүртгээ л гэж ингэж оруулж ирсэн байхгүй юу.

Тэгэхээр шууд ингэж нэг мэдээлэл технологийн шинэчлэл, аюулгүй байдлыг хангахад зориулсан төсөв гэх юм бол наад чинь бие даасан нэг ийм бодлого орж ирээд л алдагдаад явна шүү дээ. Тэгээд тийм учраас наадхаа нэр томъёотойгоо уялдуулах хэрэгтэй байх. Нэр томъёо дээр эргэж хараач гэж одоо бас нэг чиглэл өгөөд эргээд харвал яасан бэ?

С.Одонтуяа: Пүрэвдорж гишүүн горимын санал гаргах гэж байна, горимын санал.

С.Чинзориг: Чинзориг гишүүний гаргасан санал, дээрээс нь Тэмүүлэн гишүүн болон Учрал гишүүний гаргасан саналын дагуу Хуралдаан даргалагчаа эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөөч. Санал битгий хурааж хураалгаач гэсэн ийм горимын саналтай байна. Та энэ бас яг Чинзориг гишүүний ялангуяа хэлсэн тэр саналыг бас авахгүй бол ерөөсөө болохгүй юм байна. Тийм энэ туршилагатай гишүүд бол үнэхээр туршилагатай байдаг юм байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.1-д зааснаар анхны хэлэлцүүлэг явуулах үед зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, холбогдох зүйл хэсэг заалтай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлнэ гэсэн заалтыг үндэслээд,

Байнгын хороонд шилжүүллээ. Гүйцээн боловсруулахаар.

2 дахь саналын томъёолол. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.1, 41.2 дахь хэсэг болгох:

“41.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн.

41.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байна.” санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэдгээр санал хураая. 68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3 дахь санал Төслийн 1 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн тайлбарыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гэхдээ бас энэ туршилагатай гишүүдийнхээ үгийг бас их авдаг гишүүн байна л даа Пүрэвдорж гишүүн. 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4 дэх санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.14.2 дахь заалтын “шадар зөвлөх” гэснийг “эрхэлсэн зөвлөх” гэж, 41.14.3 дахь заалтын “жинхэнэ зөвлөх” гэснийг “ахлах зөвлөх” гэж өөрчилж, 41.14.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.16 дахь хэсгийн “цолд хамаарах албан тушаалын ангилал,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.17 дахь хэсгийн “Албан

хаагчийн” гэснийг “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн” гэж, “мэргэшлийн, эрдмийн” гэснийг “докторын, мэргэшлийн” гэж өөрчилж, “нэмэгдлийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Өглөө Улсын Их Хурлын дарга танай, манай гэхгүй гэсэн шүү. Найруулгын саналаар санал хурааа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 41.18 дахь хэсгийн “оногдуулах” гэснийг “ногдуулах” гэж, 3 дугаар зүйлийн “Улсын байцаагч” гэснийг “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч,” гэж, “41.7.2.” гэснийг “41.8.1.” гэж, “41.7.3.” гэснийг “41.8.2.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.4.” гэж, энд нэг алдаа юм байна шүү. Энийг засаарай найруулаарай хоёр орсон байна, гэснийг “41.7.2.” гэснийг “41.8.2.” гэж, “41.7.3.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.4.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.6.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.8 хувиар найруулгын санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67.4 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай

хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалт,” гэсний дараа, мөн зүйлийн 57.5.4 дэх заалтын “гаалийн байгууллагын ажилтан” гэсний өмнө “гадаадын иргэн, харьяат,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтын “шинжээч, мэргэжилтэн” гэсний дараа “, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэх бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүллээ. Пүрэвдорж гишүүний хууль батлагдлаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Дараагийн асуудал.

16.41 цагт

Зургаа.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, өнөөдөр анхны хэлэлцүүлэг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Лхагвын

Мөнхбаатар танилцуулна, индэрт урьж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хуулийн төслийг D-парламент.мн цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авсан бөгөөд иргэдээс хуулийн төслийн 3 зүйлтэй холбоотой 5 санал ирүүлснийг ажлын хэсэг нэг бүрчлэн хэлэлцсэн болно. ХЗБХ 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

ХЗБХ-ны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд, авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах эрх бүхий албан тушаалтан үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасаж, 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээс гадна хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхгүй байх, Улсын Их Хурлын гишүүний ХОМ-ийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн АТГ-аас шалгах зэрэг болно. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Раднаасэд гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Максимын Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч бөгөөд төрийн хууль цаазын шадар зөвлөх, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Базаргүрийн Гантуяа, Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүхэд

төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор Отгонбаярын Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Цолмон, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн сургуулийн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Сэнгээгийн Гантулга, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч, доктор, дэд профессор Бадамын Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Батсүхийн Баатарсайхан, Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Доржсүрэнгийн Батсүх. Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асууна шүү.

Ш.Раднаасэд: Энэ тэгээд одоо яг хууль санаачлагчийнхаа барьсныг юу юуг нь өөрчилчхөв? Хамаг юмыг нь л зөөллөөд тавьчих шиг болох юм. Одоо хулгайтайгаа тэмцье гэвэл арай өөрөөр тэмцмээр байна шүү дээ. Энэ ял чинь хэвээрээ л байна шүү дээ, илүү чангалаач дээ тэгээд. Тэгээд 30, 40 саяын торгуулийг 400, 500 сая болгоод 4, 5 тэрбум болго л доо. Өнөөдөр л гэхэд тэр 30 сая доллар Таван толгойн хэлтсийн даргын Эрдэнэс таван толгойг хэлтсийн даргын зуслангийн амбаараас олдлоо гээд гараад байна шүү дээ, Чинбатаа энэ үнэн юм уу? Сая энэний өмнө тэр Монгол Улс өрөө төлж чадахгүй байна, өрөө авч өрийг нь өр дарж байна гээд байна шүү дээ. Энэ хэдэн хэлтсийн дарга нарын чинь зуслангийн амбаарыг нь ухахад өрөө дарчих юм биш үү? Энийг яриач Чинбатаа. 30 сая доллар зүгээр хэлтсийн даргын амбаараас гарч ирж байна шүү дээ.

Энд холбоотой энэ сайд дарга нарыг чинь амбаарыг ухах юм бол 300, 400 сая гарч ирэх юм биш үү? Энэ бид нар өрөө төлөхөд амархан байгаа юм байна. Энэ тэгээд ялыг нь илүү чангалъя л даа, яагаад

болохгүй байгаа юм бэ? Тэгээд бид нар одоо юундаа энэ хөрөнгө орлогын мэдүүлгээ ингэж Байнгын хороогоор хэлэлцээд л АТГ өгөх үү, өөрсөд дээрээ хадгалах уу гээд ийм юм хийгээд байгаа юм бэ? Боль л доо, юунаасаа нуугаад байгаа юм бэ? Энэ Их Хурлын гишүүдийн ХОМ-ийг өг л дөө, тэр АТГ нь, өгсөн дарууд нь шалгуулж байя. Бүр Олон нийтийн зөвлөлөөр нь шалгуулж байя. Үнэхээр авлигатай тэмцье гэж байгаа юм бол. Тэгээд халдашгүй дархан эрх нь дууссаны дараа хөөн хэлэлцэх хугацаа тоолно ч гэх шиг ийм утгагүй юм дахиад энэ хууль дотроо явуулж байх юм. Энэ ард түмний чинь зарлаад байгаа жинхэнэ хулгайч нар дотор чинь дандаа 2, 3, 3-аас дээш удаа сонгогдсон Их Хурлын гишүүд байлаа шүү дээ. Энэ Их Хурлын гишүүдийг Үндсэн хуульдаа өөрчлөлт хийж 2-оос олон удаа сонгогдохыг нь болиулах хэрэгтэй, удах тусмаа улам хулгай хийдэг. Тэгээд эд нар чинь түдгэлзэхгүйн тулд хөөн хэлэлцэх хугацааг нь зогсоохгүйн тулд дахин, дахин Их Хурлын гишүүн болохын тулд эд нар чинь үхэн хатталаа ажиллана шүү дээ, сонгуульд. Энийг засъя л даа.

Энэ яагаад хууль санаачлагчаас орж ирсэн тэр ХОМ-той, холбоотой ХОМ-тэй холбоотой юмыг янзалчхав? Энийг дэмжиж байгаа юм уу, Хууль зүйн сайдаа? Засгийн газар чинь авлигатай тэмцэнэ, энэ ард түмнийхээ талд бид хамт байгаа гээд Ерөнхий сайд өчигдөр яриад л байсан шүү дээ. Тэгээд энэ чинь түрүүчээс нь ингээд эрэг боолтоор маань суллаад байна шүү дээ юмнуудыг чинь, орж ирсэн хуулийг чинь. Үнэхээр энийг зарчмын хувьд дэмжиж байгаа бол хэл л дээ, тэгээд одоо ингэх юм байна гээд. Тэрийг Ёс зүйн байнгын хороо одоо энийг яах, юуг нь хэлэлцэх юм бэ? Энийг эндээ хадгалъя, тэндээ хадгалъя гэх юм уу, эндээ л хадгалъя гэнэ шүү дээ. Зүгээр хоёрын хооронд ийм юм хийснээс өмнөхөөр л биччихээч дээ. Юуг нь та нар айгаад ичээд байдаг юм бэ? Ямар хэрэгтэй юм бэ ингэж худлаа хууль хийсэн байж, энэ жагсаалыг тарааж.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Байнгын хорооны дарга Лхагвын Мөнхбаатар.

Л.Мөнхбаатар: Раднаасэд гишүүний зарим асуултад хариулъя. Ажлын хэсгээс бас нэмж хариулах байх, зарим ажлын хэсгийн гишүүдэд хандсан зарим асуулт байх шиг байна. Энэ Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хууль, түүнд дагалдуулан оруулж ирсэн хуулийн төслүүд байгаа. Энэ хуулийн төслүүд дээр бол ялын бодлогыг нэлээн чангатгасан, ийм хуулийн төсөл. Чангатгасан хуулийн төсөл. Ер нь одоо тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бол тодорхой төрлийн гэмт хэрэг гарч байгаа шалтгаан, нөхцөлийг нь судлаад ял шийтгэл хөнгөн байна гэж үзэж, энэ нь одоо тодорхой зөрчлийн гэмт хэрэг нэмэгдэхэд нөлөөлж байгаа бол ял шийтгэлийг чангатгадаг. Энэ ч агуулгаараа энэ хуулийн төслийг Засгийн газраас ийм агуулгатай оруулж ирсэн. Энэ агуулгаар нь Улсын Их Хурал дахь байгуулагдсан ажлын хэсэг, Байнгын хороо дэмжсэн. Эндээс бол ял шийтгэлийн хувьд бууруулсан зүйл огт байхгүй гэдгийг хэлье.

Энд бол нэлээн томоохон ял шийтгэлүүд явагдаж байгаа шүү бас. Торгодог ял байхгүй болсон, сая хэлдэг торгоод байдаг 40 сая төгрөгөөр торгодог гэсэн энэ зүйл чинь байхгүй болоод торгох ялыг эндээс авчихсан. Одоо зөвхөн хорих ялтай болсон шүү дээ. Эрх мэдэл, эрх мэдлээ урвуулан ашигласан энэ тохиолдолд 2-8 жил, хахууль авсан тохиолдолд хахууль авсан тохиолдолд улс төрд нөлөө бүхий этгээд, улс төрд нөлөө бүхий этгээд гэдэгт Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн даргаас дээш, Улсын Их Хурлын гишүүд, сайд нар, дэд сайд нар, прокурор, шүүхийн дарга, орлогч нар, Ерөнхийлөгч хүртэл байгаа. Энэ хүмүүс хэрэв хахууль авсан тохиолдолд 12-20 жилийн хугацаатай хорих ял оноох оноож байгаа юм. Энэ бол одоо үнэхээр Эрүүгийн хуульд заасан хамгийн өндөр ял гэж ойлгох хэрэгтэй. Хүнийг алах гэмт хэрэг байна. Энд 8-15 жилийн ял өгдөг. Хүндрүүлэх

нөхцөлтэй бол 12-20 жилийн ял өгч байгаа. Тэгээд үүнтэй ижил хэмжээнд өгч байгаа учраас энэ авлигатай тэмцэх ажилд асуудалд үнэхээрийн одоо чангаруулсан хамгийн хүнд ялыг өгч байгаа гэж бас ойлгох хэрэгтэй. Энэ бол одоо яг хүндрээд харах юм бол их хамгийн хүнд ял. Гэхдээ энийг бол өнөөдөр Улсын Их Хурал, Ажлын хэсэг, Байнгын хороо, Улсын Их Хурал ингээд дэмжээд явж байгаа. Засгийн газар энэ саналыг оруулж ирснийг нь огтхон огтхон ч буруулаагүй шүү гэдгийг хэлье.

Дараагийн нэг асуудал бол энэ ХОМ-тэй холбоотой энэ асуудлыг бас яриад байгаа юм. Энэ дээр бол нэг ийм л зүйл байгаа юм. Авлигын эсрэг хуулийн 11-ийн 11-дүгээр зүйлийн 1 дээр нэг ийм заалт байгаа юм. ХОМ-ийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж хадгална гэж заасан. Энэ дотор Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны ХОМ-ийг АТГ гээд заачихсан, энэ нь байгаа юм байгаа. Өөрөөр хэлбэл, хуульд заасан хугацааны дотор буюу жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдөр хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар гаргадаг. Ингээд энэ хугацаанаас хойш бол үүнийг хэн ч өөрчлөх боломжгүй. Хэрэв өөрчилсөн байх юм бол энэ өөрөө гэмт хэрэг өөрчилдөг байх юм бол. Энийг өөрчлөх гэж энэ Улсын Их Хурал энийг яриад байгаа зүйл огт биш үү. Энэ бол одоо ойлголтын бас жаахан зөрүү байх шиг байна гэж би одоо бодож байна.

Энд яагаад энэ асуудал орж ирсэн бэ гэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хууль дээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ гээд заасан. Энэ заасан энэ заалт дотор эрхлэх асуудлынх нь хүрээн дотор гишүүний ХОМ-ийг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцахаар заасан юм байгаа юм. Энэ нь өөрөө ямар агуулгатай вэ гэхээр Улсын Их Хуралд олон өргөдөл гомдлууд ирнэ, ХОМ-тэй холбоотой, ёс зүйтэй холбоотой олон

мэдүүлэг ирнэ. Энэ үед нь бас хянаж шалгаж байгаа энэ Байнгын хороо чинь тодорхой мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгүүдийг нь авч үздэг, шалгадаг, ингээд тодорхой эрүүгийн шинжтэй гэдэг юм уу, ийм шинж байх юм бол түүнийг холбогдох байгууллага буюу АТГ нь шилжүүлж байгаа юм, шилжүүлж байгаа юм. Энэ процессыг хэлж байгаа юм шүү. Тийм учраас энэ ийм зүйл байна гэдгийг би та бүгдээ хэлье. Тэгээд энэ дээр нь угаасаа энэ дээр өөрчилсөн зүйл бол байхгүй. Энэ Ёс зүйн хороо гэж үг байсныг нь одоо Ёс зүйн хороо гэж бол Улсын Их Хуралд байхгүй. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо гэдэг ийм нэгжтэй болчихсон Улсын Их Хурлын.../минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд, түрүүн тодруулга хариулья.

Х.Нямбаатар: Би дөнгөж сая АТГ-ын мөрдөн шалгах албаныхантай холбогдлоо. Олон нийтийн сүлжээгээр гучин сая долларыг нүүрсний гэх хэрэгт шалгагдаж байгаа, хоригдсон хүмүүсийн одоо зуслангийн байшингаас олоо гэдэг ийм мэдээллийг өнөөдөр олон нийтийн сүлжээнд явж байна. Тэгэхээр энэ батлагдаагүй, нотлогдоогүй мэдээллийг олон нийтийн сүлжээнд манай сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд тавимааргүй байна. Сая мөрдөн шалгах албанаас тодруулахад ямар нэгэн ийм мөнгө төгрөг үзлэг нэгжлэгийн явцад олдсон зүйл байхгүй. Харин эсрэгээрээ мөрдөн шалгах ажиллагааны явцад битүүмжилсэн хөрөнгө хогшил, тодорхой хэмжээний тэр бэлэн мөнгө, айл гэрт байсан зүйлүүд бол бий. Яг одоо гучин сая доллар энэ тэр олчихсон ийм зүйл бол огт байхгүй шүү. Энэ бол ташаа мэдээлэл явж байна гэдгийг хэлж байна.

Хоёрдугаарт, Раднаасэд гишүүн бас хандаж хэллээ. Бид нар энэ авлигатай тэмцэх тэмцэлд ял шийтгэлийн бодлогыг урд хожид байгаагүй хатуу болгож байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн хорих ялын хамгийн дээд хэмжээгээр

авлигын гэмт хэргүүдэд ял оногдуулахаар 20 жил хүртэлх хугацаатай ял оногдуулахаар, ингэхдээ ямар нэгэн хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх бүх нөхцөлүүдийг Хэрэг хянан шийдвэрлэх хууль дээр давхар хааж өгч оруулж ирж байгаа. Эрүүгийн хуулийн 22.1, 22.4 гэдэг энэ зүйл ангиудын ялын одоо дээд босгыг нь нэмэгдүүлж байгаа. Дээр нь бид нар улс төрд нөлөө бүхий албан тушаалтан гэдэг ангилалтай зэрэгцүүлээд төрийн болон орон нутгийн өмчит компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудыг бүхэлд нь энэ 22.1-ийн субъект болгож шинээр бас томъёолж, сая ажлын хэсэг дээр ярьж оруулж ирсэн юм.

Тэгэхээр би бас Раднаасэд гишүүнд өчигдөр ч Байнгын хорооны хурал дээр хэлж байсан. Би таныг бас бухимдалтай, олон нийтийн сүлжээнд янз бүрийн байдлаар таны нэр төр, алдар хүндэд халдсан ийм үйлдэл болсон. Энд бухимдаж байгаа гэдэг энэ агуулгаас ойлгож байна. Гэхдээ бид нар энэ 3.5 сая хүний амьдралыг шийдэж байгаа хуулийг ямар нэгэн сэтгэл хөөрөл, эмоци дунд шийдэж болохгүй. Бид нар Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хязгаарт захируулж, уг асуудлыг оруулж ирж байгаа. Дээр нь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал дээр бид нар нэг цэг тавья. Хөөн хэлэлцэх хугацаагаар ял завхсан зүйл өнөөдрийн хугацаанд байхгүй байгаа албан тушаалын хэрэгтнүүд дээр. Хоёрдугаарт, албан тушаалын гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж оруулж ирж байгаа. Гуравдугаарт, бүрэн эрхийг нь түдгэлзүүлж шалгах өнөөгийн нөхцөл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд прокурор оруулж ирэх тэр нөхцөл нь хэвээрээ байгаа. Бүрэн эрхээ түдгэлзүүлэлгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан тохиолдолд уг хэргийн хөөн хэлэлцэх хугацааг царцаая, бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс эхэлж үргэлжлүүлж шалгадаг энэ одоо бичилтийг хийж орж ирж байгаа нь өндөр хөгжилтэй, эрх зүйн өндөр хөгжилтэй орнуудад байдаг яг жишгийг бид нар одоо

бас хуулбарласан гэдгээ хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж, өчигдөр хэлэлцэх эсэх дээр нь би бас 2, 3 санал гаргасан юм. Харин богино хугацаанд ажлын хэсэг ажилласан гэхэд бас гишүүдийн гаргасан саналуудыг нэлээн бас анхааралтай авч үзсэн юм шиг байна гэж бол бодож байна. Миний гаргасан санал яриад байсан саналуудаас 2 ч, 2 ч асуудал нь бас өөрчлөлт ороод ирж байгаа юм байна. Нэг дэх асуудал нь би тэр нэгдүгээр зүйлийн 4 дэх заалт дээр төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн бол авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн бол торгох ялтай байна, зорчих эрхийг нь хязгаарлах ялтай байна, энэ чинь одоо бид нарын би бол ийм ял байж болохгүй гэсэн ийм байр суурь илэрхийлж байсан юм.

Өнөөдөр одоо хамгийн гол нь энэ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дээр чинь л энэ удирдах албан тушаалтан, гүйцэтгэх албан тушаалтнууд дээр чинь л энэ төрийн өмч хөрөнгийг бас хулгай хийж байгаа, луйвардуулж байгаа боломжийг нь хулгайлж ийм асуудал их гараад байна. Тийм учраас бид нар энэ удирдах албан тушаалтнуудад нь торгох ял, зорчих эрхийг хязгаарлах ял өгч болохгүй юм шүү гэж санал гаргаж байсан. Тэгээд өнөөдөр сая энэ ажлын хэсгийн анхны хэлэлцүүлэгт бэлдсэн материалыг аваад үзэхэд нэгийн 4 дэх нэгдүгээр зүйлийн 4 дэх заалтыг тэр чигт нь бол хасчхаж байгаа байна. эгэхээр бол нөгөө миний яриад байсан торгох ял, зорчих эрхийг хязгаарлах ял бол үндсэндээ байхгүй болчхож байгаа юм байна гэж бол ойлгож байна.

Хоёр дахь асуудал нь хялбаршуулан хэрэг хялбаршуулсан журмаар хэрэг

шийдэхтэй холбоотой асуудал дээр би бас хэт бус их хавтгайрчхаад байгаа юм уу гэж санал яриад байсан юм. Яах вэ, улс төрийн, улс төрд нөлөө бүхий этгээдүүд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтнууд дээр бол энэ хялбаршуулах журмаа хэрэг шийдэх нь байхгүй болгож болох юм. Улсад учруулж байгаа хохирол нь бага, нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл нь бага гэж үздэг юм уу, төсвийн одоо шууд захирагч нар, сургуулийн эрхлэгч, эмнэлгийн эрхлэгч, цэцэрлэгийн эрхлэгч ч гэдэг юм уу ийм улсууд дээр бас гарч байгаа хэрэг дээр бол энэ хялбаршуулах журам нь журмаар хэрэг шийдэх нь одоо байвал яасан юм бэ, жаахан ялгамжтай авч үзвэл яасан юм бэ гэдэг ийм зүйл бас өчигдөр ярьсан юм. Тэгээд энэ ажлын хэсэг бас энэ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 9 дээр оруулаад ирчихсэн юм шиг байна гэж би бол ойлгож байна.

Улс төрийн төрд нөлөө бүхий этгээд гэсний дараагаар төрийн болон орон нутгийн өмч, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах эрх бүхий албан тушаалтан гээд нэмье гээд ороод ирж байгаа учраас бол хялбаршуулах журмаар хэрэг шийдэх, энийгээ жаахан хүрээг нь хумиад, улс төрд нөлөө бүхий этгээдүүд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой тухай хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтнууд нь хялбаршуулах, журмаар хэрэг шийдэхийг нь бол хязгаар хориод, бусад одоо албан тушаалтнуудад тэд төсвийн захирагч нар, төсөвт байгууллагуудын эрхлэгч дээр эд нар энэ хялбаршуулах журмаар хэрэг шийдэх боломжийг нь бол нээгээд үлдээчхэж байгаа юм байна гэж бол ойлгож байгаа. Тэгээд ингээд ялгамжтай хандаж байгаа юм байна гэж ойлгож байгаа.

Тийм учраас бол энэ гишүүдийн гаргасан саналуудыг бас нэлээн ажлын хэсэг богино хугацаанд ч гэсэн нэлээн анхааралтай авч үзэж, хуулийг

боловсронгүй болгох талаар нэлээн анхаарч ажилласан юм байна гэж бол бодож байна. Ийм одоо бас санал л хэлье гэж бол бодож байгаа юм.

Г.Занданшатар: Хариултгүй юу тийм ээ? Санал хураалтдаа орно, санал хураалтаа бэлдээрэй. Тэгээд ер нь бас сая сайд хэллээ. Янз бүрийн мэдээллүүд явж байна. Нийгмийн сэтгэл зүй тогтворгүй байна. Тэгэхдээ юу ч шидээж өгч байсан, ямар ч шүүлтүүргүй хүлээж аваад сошиалаар савладаг ард иргэд байж болох боловч төрийн ажил тийм байж болохгүй. Ямар ч эргэцүүлэн бодох, анализ хийх, мэдээллийг нягтлах, шинжлэх ухааны үндэстэй тооцоо судалгаа, харьцуулсан судалгаа хийх чадваргүй, шидсэн өгөөш бүрийг шууд үмхэж аваад л, хөөрөөд л, хараагаад л, бухимдаад л сэтгэлийн хөдөлгөөнөөр гаргасан шийдвэр болгон энэ 3.5 сая хүний иргэний амьдралд нөлөөлнө гэдгийг бодож бид ултай шүүдэр авч бодох хэрэгтэй.

Сая Нямбаатар сайд ч хэлээ. Янз бүрийн одоо мэдээлэл хүмүүсийн анхаарлыг татах, аль эсвэл гадаад, дотоодоос ч шиддэг юм уу янз бүрийн ийм өгөөш мэдээлэл болгон тэр болгон үнэн эсэхийг нягталж шалгаж байх тийм анализ хийх чадвар бол нэн ялангуяа энэ манай эрдэмтэн судлаачид, ажлын хэсэг бол анхаарч байх ёстой. Хүн амины хэрэгтэй тэр тэнцүү шахуу ял өгчхөөд байхад ялын бодлогыг одоо хүн амины хэрэгтэй шахуу ял өгч байгаа биз дээ энэ чинь тийм ээ? Тийм учраас энэ бүх юмнуудаа бол сайн эрх зүйн шинжлэх ухааны онол гээд Нарангэрэл багш, Эрдэнэбулган нарын бичсэн ном энэ тэр ч байдаг байх. Тэгээд тэр онол ном энэ тэр энэ бүхэл бүтэн систем гэдэг юмыг манай хуульч гишүүд нэн ялангуяа анхаарч энэ ажиллаж байвал зохино.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Байнгын хорооноос зарчмын зөрүүтэй саналын томъёолол 23 санал байна. Зарчмын зөрүүтэй 23 санал дотор бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол ХЗБХ дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Гэмт хэрэг үйлдсэн этгээд түүнийг яллагдагчаар татахаас өмнө” гэснийг “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Дамдины Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт явуулъя. Асуулт гэж байхгүй, зарчмын зөрүүтэй санал дээр. Санал хураалт явуулъя. Дэгээрээ асуулт гэж байдаггүй, зарчим нь гээд. Дээрэлхсэн юм байхгүй, чи. Хуулиараа явж байна, хуулиараа явж байна, одоо жооохон дэгтэй байцаа одоо, сандарч тэвдэж байж болно. Тэгэхдээ энэ төрийн ажилд хүндэтгэлтэй ханд, төрийн ажил явж байна. Ингээд санал хураалт явуулъя. Дэгээрээ хуулиараа явж байна. 29 гишүүн дэмжиж, 65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9 дэх хэсгийн “дууссан эсэхээс” гэснийг “дууссанаас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дахь хэсгийг хасах.

“1.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс ажлын чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийн “5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тэнцүү байна” гэсний дараа “Энэ хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгт оногдуулах торгох ялын нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байна” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “найман жил” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэснийг “хүртэл хугацаагаар” гэснийг “хүртэл, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “энх тайвны эсрэг” гэсний дараа “, авлигын” гэж гэснийг “энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй.” гэсний дараа “Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсгийн “улс төрд нөлөө бүхий этгээд” гэсний дараа “, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ чинь одоо хүрээг нь улам өргөтгөөд л улам л ялын бодлогыг нь чангалж байгаа юмнууд байгаа юм байгаа биз дээ тийм ээ? Хүрээг нь өргөтгөөд төрийн өмчийн компаниудын захирлуудыг ч гэсэн бүх насаар нь уу?

10.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “1 дэх хэсэг.” гэснийг “1 дэх хэсэг, 1.1,1.2 дахь заалт.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах. Энэ чинь 10 байсан уу? 11. Өөрчлөн найруулах.

“1.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 1 дэх хэсгийн “хууль ёсны болох нь тогтоогдоогүй бол” гэснийг “үндэслэлгүй

болох нь тогтоогдсон бол” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай Тайлбар нэмэх:

“Тайлбар.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “томилогдох” гэснийг “ажиллах” гэснийг “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “сонгогдох” гэснийг “ажиллах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 76.7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Үнэнбатаа энэ найруулга дээр томилогдох гэснийг ажиллах гэснийг зөв үү, засварыг нь хийгээрэй. Найруулгын засвар хийх ёстой юм байна шүү энэ чинь.

14.Төслийн 4 дүгээр зүйлийн “заалт, 22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын “3.1.4-т” гэсний өмнө “3 дугаар зүйлийн” гэж, мөн зүйлийн “4.1-д” гэсний өмнө “4 дүгээр зүйлийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ тоо яриад байгаа улсууд тэр тоогоо хуулийн байгууллагад очиж нотлохгүй бол гэмт хэргийг нуун дарагдуулсан зүйл ангитай шүү. Тоо, мэдээд байгаа тоонуудаа батлах хэрэгтэй.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Пүрэвдорж гишүүн хурал үймүүлэхээ больё

энэ санал хураалт явж байна. 72.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Пүрэвдорж гишүүнээ санал хураалт явж байна. 69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Хорин хоёрдугаар бүлэгт заасан” гэснийг “Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж. Санал хураалт. Авсан, авсан. 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Одоо жаахан шуурхай явцаагай.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “, 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалт, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “гэмт хэргийг” гэсний өмнө” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Алх цохисон хойно хэлэх юм. Чи алх цохисон хойно хэлчихлээ, уучлаарай. Эцсийн хэлэлцүүлэг дээр анхаар. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Гадаадын иргэнийг хэлчихсэн. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Одоо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг ХЗБХ-нд шилжүүлж байна. Байж байгаарай, байж байгаарай, байгаарай. Одоо ХЗБХ хуралдана. Гишүүд ХЗБХ-ны гишүүд ХЗБХ-ны хуралдаа. Дараагийн асуудалд орно.

17.17 цагт

Долоо.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ХЗБХ-ны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дэд дарга, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийг бууруулах хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ. ХЗБХ 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар танилцуулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Өлзийбатын Мөнх-Ундрага, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн болон газрын мэргэжилтэн Лувсанцэрэнгийн Пүрэвсүрэн.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Захиргааны эрхийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнга хороонд шилжүүлээ. Тийм.

Найм.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Эрхэм гишүүн Цэндийн Сандаг-Очирыг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчөөр өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 22 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авч авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хуулбарын төслийг бэлтгэсэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн

хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгнө үү.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг оролцуулъя. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Зоригтын Батболд Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга, Батболд байна уу? Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн буюу дэд дарга Нанжидын Хүдэрчулуун, Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Жамсрангийн Батжаргал, Монголын эрчим хүчний барилга засварын холбоо болон Монголын үндэсний барилгын ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн Махвалын Батболд.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль төслийг эцэслэн батлах, бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Асуулт хариултгүй тул. Явж болно. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэцгээ.

Баталсан хуулиудын эцсийн найруулгыг сонсьё. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн, хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна, эцсийн найруулаг сонссонд тооцлоо.

ХЗБХ аль зэрэг удаж байна вэ? Ирцээ бүрдүүлж байна уу, аль зэрэг удахаар байна вэ? Оруулах өөрчлөлт нь өөрчлөлт гайгүй юу? Та хэд сайн уншилтыг

нь хийсэн үү? Үнэнбат энэ тэр туслаад тэр яаруу хууль хуудуутай гарах вий, сайн уншиж үзээрэй, үг үсгийн алдаа, найруулга.

Оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Энийг нэн яаралтай горимоор хэлэлцэж байгаа. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгаа бэлдсэн байна уу? Танилцуулга иртэл хүлээж байя. Танилцуулга бэлэн болсон байна уу? Эхлэх үү, арай болоогүй юу?

Ес.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа үргэлжлүүлэе. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ХЗБХ-ны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Лхагвын Мөнхбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслийн зарим заалтаар дахин санал байх шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 42-ын 42 дугаар зүйлийн 42.3-д заасныг баримтлан нэг санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-ын саналаар санал хурааж, хуралдаанд оролцсон гишүүдийн 90.1 хувь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөх хэлэлцүүлэг дээр танилцуулсантай адилхан хүмүүс байгаа ажил, нэр, албан тушаал адил. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Асуулт асууна Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Өчигдөр энэ хууль хэлэлцэх эсэх нь орж байхад би бас яг энэ хууль дээр бас нэг тийм но байна гээд. Тэгээд тэрнийхээ дагуу үг хэлсэн. Тэгэхээр өчигдрийн орж ирсэн юугаар бол одоо нэг юу байдаг юм, яг энэ нүүрсний хулгайд холбогдсон нэг төрийн албан хаагч их хэмжээний улсад хохирол учруулчихсан бол Эрүүгийн хуулийн 21-ийн, 21.1.2-оор, тийм ээ, 21.2-оор, 21.2-оор 2-8 жилийн ял байгаа юм. Одоо шинэ орж ирсэн юугаар. Тэгээд хэрэв тэр хүн өөрөө өөрийнхөө гэмт хэргийг одоо илчлээд хүлээн зөвшөөрөөд,

тэгээд хамжигч нараа энэ тэрээ бүгдийг нь одоо хэлж өгөөд, тэгээд хохирлоо барагдуулчих юм бол 6.7-гоор ялаа хөнгөрүүлэх боломжийг авчхаж байгаа юм. Тэгээд 6.7-гоор ял хөнгөрүүлэх дээр хамгийн одоо доод интервалыг буюу 2 жилээс, 2 жил авчхаад 2 жилээсээ 50 хувиар ялаа бууруулчих юм. Тэгээд 1 жил болчихно гэсэн үг. 1 жил болчихоод дахиад нөгөө нэг сайн хүмүүжсэн энэ тэр гээд нөгөө нэг 6 сар болоод л одоо их хэмжээний хохирол учруулсан тэр нөхөр ингээд зургаахан сарын дараа дахиад л нөгөөдөх хулгайн хэргээр шоронд орлоо гээд бид нар байж байсан, зургаахан сарын дараа гарсан сошиал дээр юм биччихсэн явж байх нь байна шүү дээ. Ийм юмыг ингээд оруулаад ирчихсэн байсныг л би өчигдөр бас энийг эсэргүүцэж үг хэлсэн юм л даа.

Тэгээд энэний дагуу ажлын хэсэг хуралдаад, дээрээс нь Нямбаатар сайд энэ асуудлаа бас тодорхой хэмжээгээр ойлгоод, тэгээд энэний дагуу энэ 17.1.6-г хасаж оруулж ирж байгаад бас энэ миний тэмцэл бас зөв байсан байна гэдэгт би их ойлгосон. Энэ ажлын хэсгийнхэн, тэгээд ялангуяа одоо энэ тайлбарлахад маш их дэмжлэг үзүүлсэн энэ одоо дэд ажлын хэсэг буюу энэ яг нарийн мэргэжлийн алба, энэ албан одоо энэ ажлын хэсэгт суугаа энэ эрхмүүд маш сайн тайлбарлаж өгсөнд их баярлалаа. Тэгээд ер нь бол бид нар аль болох энэ хуулийнхан бид нар хууль баталдаг. Хуулийнхан тэр хуулийн цоорхойгоор юм савируулдаг юмыг бид нарыг ингээд цоорхой хийчих юм бол тэр савируулдаг юм нь байгаад л байна. Тийм учраас аль болох цоорхой нөхөх тэр хуулиудыг л бид нар хийж дуусгах ёстой байхгүй юу. Тийм учраас цааш цаашидаа бас энэ Эрүүгийн хууль дээр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль дээр бол нэлээн олон цоорхойнууд байгаа. Тэр цоорхойнууд дээр бас ингээд хамтраад ажиллаад, нүхнүүдийг бөглөөд, өглөөд явах юм бол илүү сайн болно гэж харж байгаа.

Бас нэг зүйл нь бол энэ хэрэг хялбаршуулах бол энэ өнгөрсөн хугацаанд 10 хэдхэн хэрэг л шүүхээр авлига, албан

тушаалын гэмт хэрэг шийддэг байсан бол сүүлийн үед чинь ингээд зуун хэдэн 160, 70 байна уу. 180-аад хэрэг одоо шийдэж байна шүү дээ. Тэгэхээр энэ нөгөө нэг явж байгаа ийм хэрэг илрүүлэхэд нь нөлөөлж байгаа энэ юмаа бид нар ингээд бүгдийг нь ингээд хялбаршуулахгүй гэхээр болохгүй байгаад байгаа юм л даа. Тэгэхээр яах вэ авлига албан тушаалын гэмт хэрэг дээрээ бас энийг хялбаршуулахгүй гэж яаж байгаа. Хамгийн гол нь жагсагчдын хүсээд байгаа энэ хүмүүс тэмцэж байгаа хүмүүсийн хүсээд байгаа нэг л зүйл байгаа шүү дээ. Хялбаршуулаад торгуулиуд гарчхаж байна гэж байгаа юм. Тэрийгээ л эсэргүүцэж байгаа болохоос биш тэр хүмүүс одоо энэ чинь энэ бид нарын оруулж байгаа, хэлэлцэж байгаа энэ хуулиар чинь торгуулийн ялыг нь байхгүй болгочихсон шүү дээ. Тэгээд тийм учраас энэ торгуулийн ялгүй, заавал хорих ял.../минут дуусав/

Г.Занданиатар: Хариулт авчхаад дараа нь, хариулт хангалтгүй бол. Хэн хариулах юм бэ? Ажлын хэсэг Баттөмөрийн Энхбаяр гишүүн ажлын хэсэг хариулчих. Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулт өгнө. Хэлээд байна. Ажлын хэсэг Баттөмөр, карт нь, Энхбаяр гишүүн карт нь болохгүй байна гэж байна. Нямбаатар сайд хариулж байя.

Х.Нямбаатар: Өчигдөр зөвөө зөв. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гишүүн бид нар энэ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж байхад бас ойлголтын буруу зөрүүтэй зүйл байсан. Би ч гэсэн бас буруу ойлголт авсан. Пүрэвдорж гишүүнд бас эвгүй үг хэлсэндээ уучлалт хүсье.

Хоёрдугаарт бид нар бас урьд шөнө ажлын хэсэг нэлээн сайн ажиллаад, Засгийн газраас өргөн барьсан төслийг илүү чамбайруулах тал дээр нэлээн хэдэн зарчмын зөрүүтэй саналуудыг боловсруулсан. Тэгээд би өнөөдөр энэ авлигын авлигатай хийх тэмцэлд Монгол Улсын Засгийн газар түүчээлээд Монгол Улсын Их Хурал яаралтай горимоор

хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газар, төр авлигатай хийх хамгийн хүчтэй тэмцлийг одоо эхлүүлж байна. Хууль, эрх зүйн орчин гэдгийг бас энэ үг хэлэх завшаан олдсон дээрээ хэлмээр байгаа юм.

Өнөөдөр цөөнхийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Адьшаа, Одонтүяа гишүүн 3 яг одоо олонхтой цуг хамтдаа сэтгэл нэгдэж, энэ авлигатай хийх тэмцлийг чангатгахад өнөөдөр ингээд гар бие оролцож байгаад бас талархлаа илэрхийлье. Дээр нь Пүрэвдорж гишүүн бол бид нар одоо 2 парламент яг цуг сууж байна. Олон ч зүйл дээр бид хоёр зөрж, санал бодол зөрдөг, зарим тохиолдолд одоо бие биеийгээ хэлэх, хэлэхгүйгээр хэлдэг. Гэхдээ одоо сүүлийн жилүүдэд манай Пүрэвдорж гишүүний парламентчийн одоо гаргаж байгаа бас энэ туршилага илүү их туршилагажисж байна. Сая өчигдөр тэр Эрүүгийн хуулийн 6, 7 дээрх бас зөрчилтэй асуудлуудыг олж харж, бид нар ингээд зарчмын зөрүүтэй саналаар эцэслэсэн гэдгийг хэлье.

Г.Занданиатар: Энхбаяр гишүүн. Өнгөрсөн, өнгөрсөн. Одоо бие биеэ магтахаа боль, одоо ингээд ажлаа явуулъя. Баттөмөрийн Энхбаяр гишүүн. Баттөмөрийн Энхбаяр гишүүн, чи бүр өнгөрчихсөн хойно чи тэгээд 1 минутаа авъя. 1 минут өгье. Чи ажил энэ Байнгын хорооны дүгнэлтээ бас, Бөхчулууны Пүрэвдорж. Байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна. Ганцхан өөрчлөлт.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нөгөө энэ хялбаршуулах, хялбаршуулах энэ одоо арга хэмжээ бол авлигын эсрэг бол нэлээн сайн ажилласан байна. 180-аад хэрэг илрүүлсэн гэж байна шүү дээ, шүүхээр шийдүүлсэн гэж байна шүү дээ 1 жилийн дотор. Урьд нь бол 19 онд, 18 онд чинь 10 хэдхэн л байгаад байдаг б. Тийм 6 хүртэл байдаг. Тэгэхээр энэ чинь ажиллаж байгаа энэ механизмаа бас ингээд бүр утгагүй устгаж болохгүй. Тийм учраас одоо энэ дээрээ бас дараа, дараагийн дээр энэ хэрэв энэ хэрэг илрүүлэлт нь бас буцаад сөргөөр

нөлөөлөх юм бол тоо хэмжээ одоо тэр багасах юм бол бас бид нар энийгээ буцаж харах зайлиггүй шаардлага гарч байгаа шүү. Ер нь бол яах вэ энэ мэдээж одоо энэ жагсагчдын хүсээд байгаа зүйл бол хялбаршуулаад торгуулчхаад байна гэж байгаа юм. Гэтэл бид нар энэ өөрчлөлтөөрөө бүгдийг нь торгуулийг нь бүгдийг нь байхгүй болгочихсон шүү дээ, заавал хоригдохоор болж байгаа юм. Тэгэхээр энэ чинь бас.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэгээд ер нь бол Үндсэн хуулийн хяналт тэнцлийн, энэ гүйцэтгэх засаглалд тавих хяналт тэнцлийн хамгийн чухал механизм бол энэ цөөнхийн хяналт юм байгаа шүү дээ. Тэгээд ингээд цөөнх парламентад байж, хяналт тавьж, ер нь аливаа бүх асуудлаар зөвхөн цөөнхийн бүлэг биш, ямар ч асуудлаар олонх, цөөнх болж байдаг. Тэгээд тэр цөөнхийн хяналт гэдэг юм бол энэ олон асуудлыг илрүүлэхэд тэр Эрдэнэт үйлдвэр, Хөгжлийн банк, Эрдэнэс таван толгой энэ бүх асуудлаар Улсын Их Хурлын гишүүд л шүгэл үлээсэн. Муу, сайн хэлэгддэг ч гэсэн Улсын Их Хурлаас л энэ бүх мэдээлэл Улсын Их Хурлын гишүүдээс л мэдээлэл гарч байдаг. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд чинь бас тэр үг хэлэх эрх, цөөнхийн хяналтын механизм, хяналтын механизмын хамгийн том хэлбэр нь Үндсэн хуулийн хяналтын механизм, парламент өөрөө байгаа юм. Энэ эрх зүйт төр тогтоохын чинь үндэс нь. Тийм учраас энэ парламентын дархлаа, парламентын ардчиллыг хамгаалах гэдэг бол зүгээр энэ хэсэг зуурын сэтгэлийн хөдөлгөөнөөр бас ханддаг асуудал гэдгийг хаана хаана онцгойлон анхаарахыг хүсэж байна.

Өөр нийгэмд парламентын ардчилал ингэж сонсдог, тэгээд тэр мэдээллийг хянаж шалгаад ямар нэгэн байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээллийн 80 хувь нь энэ парламентын ордноос гарч байдаг. Энэ хэлэлцүүлгүүдээс гарч байдаг. Олонх, цөөнхийн мэтгэлцээнээс гарч байдаг. Тэгэхээр энэ өнөөдрийн энэ илэрч байгаа бүх хэргүүд бол парламент дээр шүгэл үлээсний үр дүн гэж

үзэж болно. Энэ том хэргүүдийн асуудал бол. Тийм учраас энэ хоорондоо маш уялдаа холбоотой, зөвхөн сэтгэлийн хөдөлгөөнөөр биш, их бодлоготой хандах асуудлууд гэдэг нь бол зүйтэй. Пүрэвдорж гишүүн одоо энэ цөөнхийн хяналтаа, манай сөрөг хүчин цөөнх хяналтын үүргээ бас сайн гүйцэтгэж байх хэрэгтэй. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна. Таны микрофоныг дуу цаируулагчийг ажилд ортол ашиглаад хэдэн гэсэн үг хэлчихлээ, хариулт өгчихлөө.

Б.Энхбаяр: Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл болон ам хэлээс гадна бодит үйлдэл шаарддаг ажил. Бодит үйлдэл бол 2 зүйл дээр гол төвлөрдөг. Нэгдүгээрт, яг энэ авлигатай тэмцэх энэ ялын бодлогыг баталсан хууль, эрх зүйн шинэтгэлийг хийж чадах уу, үгүй юу гэдэг эхний асуудал. Хоёрдугаарт, энэ яг хуулийг ягштал хэрэгжүүлэх хууль хяналтын байгууллагууд, шударга шүүхийн асуудал байдаг. Ийм 2 талтай.

Өнөөдөр МАН-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн Засгийн газраас нэн яаралтай горимоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн авлига, албан тушаалын гэмт хэрэгт улс төрийн нөлөө бүхий этгээдүүдийг оногдуулах ял шийтгэлийн бодлогыг Эрүүгийн хуульд заасан ялын хамгийн дээд хэмжээ болох бүх насаар нь хүртэл хорих, ийм ял шийтгэлтэй болгох хуулийг Улсын Их Хурал батлах гэж байна. Авлигачдад үүнээс цааш дээш өгөх ял Эрүүгийн хуульд байхгүй. Монгол Улсын Засгийн газар болон Улсын Их Хурал хамтдаа авлигачдад цээрлэл үзүүлэх энэ улс төрийн хүсэл эрмэлзлээ үгээрээ биш одоо бид нарын дараах кнопоороо дамжуулж илэрхийллээ. Энэ үйл ажиллагаанд парламентын олонх болсон МАН-ын гишүүд мөн өнөөдөр бас энэ сөрөг хүчнээс Улсын Их Хурлын дэд дарга Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Адышаа, Туваан нар бас оролцож, яг энэ үйл хэрэгт бас хамтдаа оролцох гэж байна.

Энэ хууль батлагдсаны дараа би нөгөө зоосны нөгөө тал болох хууль хяналтын байгууллагуудад бас хандаж 2 зүйлийг хэлмээр байна. Нэгдүгээрт, бүх насаар нь одоо хорих хүртэл ялын бодлоготой болж байгаа нь хуулийн хонгил, хуулийн мангасыг хуулийнхны атгад өгч байгаа хэрэг байж болохгүй. Хурц шиг, Дорлигжав шиг прокурортой үед бол энэ хэзрийг хуулийнхан Улсын Их Хуралтай нь, Засгийн газартай нь, төрийн өмчийн компаниудтай нь базах зэвсэг болгож ашиглах боломжтой. Тийм учраас энэтэй хамт энэ ялын бодлогыг хэрэгжүүлсэнтэй хамт Засгийн газраас ялангуяа мөрдөх албаны тэр дортоо гүйцэтгэх хяналтгүйгээр хийгдэж байгаа энэ гүйцэтгэх ажил, хүний эрхэнд халдаж байгаа гүйцэтгэх ажил, энэний хяналтыг сайжруулах, прокурорын хяналтыг сайжруулах, шүүхээс өмнөх энэ одоо гэмт хэргийг илрүүлэх, нотлох, хянах процесстой холбоотой шинэтгэлийг даруй хийх шаардлагатай гэж үзэж байгаа юм. Энэ хяналт ард түмний хяналтаас гадуур байж болохгүй, болохгүй.

Тийм учраас энэ хяналтыг бол заавал хэрэгжүүлэх ёстой шүү гэдгийг би зориуд тэмдэглэж хэлэх гэж байгаа юм. Ингэхгүйгээр хууль хяналтын байгууллагууд, парламентыг одоо нэг тэр Дэмбэрэл гэж гишүүний дүүг шоронд долоо хонуулж хорьж байгаад, Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах кноп дар гэж шантаажилж байсан энэ урьдын хар түүхүүдийг атгуулж болохгүй. Өнөөдөр парламент өөрөө сайн муугаа өөрөө шүүгээд явдаг Монголын ардчилсан тусгаар тогтнолын баталгаа болж байгаа юм. Тийм учраас нүүрснээс эхлээд Хөгжлийн банкнаас эхлээд бүх асуудлыг парламент өөрөө шүүгээд ард нь гарч чадна. Ард.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал юм байна. 2/3-оор босгосон юм байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 4 дэх” гэсний дараа “хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь” гэж нэмэх. Санал гаргасан ХЗБХ санал хураалт. 95.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүлж байна.

ХЗБХ эцэслэн батлах бэлтгэл хангуулсан уу? Эцэслэн батлах бэлтгэл хангагдсан бол эцэслэн батална. Үнэнбатаа сайн уншсан биз. Хийдэл зөрчил гаргаж болохгүй шүү дээ, яаруу сандруу гээд. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т долоо хоногийн Баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуулийн хуралдааны ирц, хуулийн төслийг эцэслэн батлах ирц хангахаар бол бусад өдөр цагт хуулийн төслийг эцэслэн баталж болно гэж заасан байгаа. Тэгээд энэ дэгийн дагуу эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар нийт гишүүдийн олонх буюу 39-өөс дээш гишүүн дэмжиж байж энэ хууль эцэслэн батлагдана 44.2-т тэгж заасан байгаа. Санал хураалт явуулъя, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт

явуулъя. 44 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 43 гишүүн нь дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Болорчулуун гишүүнийг дэмжсэнд тооцож протоколд оруулъя, олон хүн харсан учраас. Заавал тэнд протоколд дараа нэгмөсөн тэмдэглүүлье. Дараа нь үг хэлье. Бас энэ санал хураалтыг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Болорчулуун гишүүн үг хэлнэ. Та протоколд тусгах ёстой, тэгэхгүй бол тэнцсэнд тооцогдохгүй. Дараа нь та, дараа нь Баагаагийн Баттөмөр гишүүн.

Х.Болорчулуун: Техникийн ажиллагаанаас болоод миний дэмжсэн санал гарсангүй, дэмжиж байгаа шүү.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Би энэ саналыг дэмжсэн юм, тэгсэн энэ аппарат ажиллахгүй байна. Би дэмжсэн шүү, дэмжсэн гэдгээ хэлж байгаа юм.

Г.Занданшатар: Хуулиудыг эцэслэн баталаа. Эрүүгийн хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг эцэслэн баталлаа.

Нийт ард иргэд ээ, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өнөөдөр эцэслэн баталлаа. Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, мөн Авлигатай тэмцэх олон улсын өдөр буюу 12 дугаар сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах иргэдийн саналыг судлан үндэслэх ажлын хэсэг байгуулж, 6 хоногийн хугацаанд үндсэндээ Улсын Их Хурлын ажлын хэсэг, Засгийн газрын ажлын хэсэгтэй хамт одоо өдөр, шөнөгүй нэлээн нягт нямбай ажиллаж, хуулийг богино хугацаанд эцэслэн баталлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Манай ажлын хэсгийнхэн их сайн ажиллалаа.

Ер нь авлигын гэмт хэргийн хор уршгийг нийт нийгэм даяараа төлдөг. Энэ авлига бол төрд итгэх итгэлийг алдагдуулж байна, ардчиллыг доройтуулж байна. Өнөөдрийн хууль ч гэсэн энэ авлигатай тэмцэхэд том алхам өгнө гэдэгт бид итгэж байгаа. Иргэд, олон нийт бухимдалтай байна, амьдралын чанар, шударга бус зүйлтэй эвлэрэхгүй гэдгээ илэрхийлсэн олон хоног эвлэлдэн нэгдэж, тэмцэж байгааг та бид харж байна. Хууль батлах бол нэг хэрэг шүү манай хуулийнхан. Хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хууль хяналтынхан бол хариуцлагатай ажиллахыг манай энэ гишүүдийн хэлээд байгаа энэ хэргүүдийг үнэн бодитой илрүүлж, тэгэхдээ хүн хэлмэгдүүлж болохгүй. Жинхэнэ хэрэгтнүүдийг хаацайлж болохгүй, авлига, албан тушаалын гэмт хэрэгт ялын бодлогыг хамгийн чангаар оногдуулдаг болсон энэ эрх зүйн орчинд бол одоо дайчин, шуурхай ажиллах хэрэгтэй байна.

Энэ хуулиар хуулиар халдашгүй байдлыг нь баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон

үеэс эхлэн сэргээн тооцох зохицуулалтыг тусгалаа. Гэмт одоо ял, гэмт хэргийн бодлого зайлшгүй байх, чанга байх энэ бодлогыг ингэж хуульчилж байна. Авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээд аливаа хэлбэрээр өршөөл үзүүлэхгүй байхаар хуульчиллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, сайд, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Дээд шүүхийн шүүгч, Ерөнхий прокурор, ер нь аймаг, нийслэлийн Засаг дарга нар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нар, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон үүн дээр нэмэгдээд хамгийн их хардлага дагуулдаг энэ төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах болон эрх бүхий албан тушаалтны авлигын гэмт хэрэг үйлдсэн бол гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг боллоо.

Түүнчлэн эдгээр албан тушаалтан авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасаж, 5-12 жил хугацаагаар хорих ял оногдуулдаг боллоо. Сүүлийн жилүүдэд иргэд, олон нийтийн шүүмжлэлийг ихээхэн дагуулсан зүйл бол эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан этгээдүүд асар их хохирол учруулчихаад дөчин сая төгрөг төлөөд өнгөрдөг гэсэн ийм бухимдал, ийм зөрчил, одоо хууль хэрэглээний зөрчил гэж бас нэг талаасаа хэлж болно. Хуулийн хийдэл гэхээсээ. Үүнийг шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт торгох ялыг оногдуулахгүй байхаар зохицууллаа. Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн этгээдийн үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх зохицуулалттай боллоо.

Үндсэндээ энэ хуулиар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгтэй холбоотой бүлгийг бүхэлд нь хөндөж, гэмт хэрэгт оногдуулах ялын

бодлогыг чангатгалаа. Ингэснээрээ бид одоо энэ Улсын Их Хурал бол авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох 3 баг зорилтынхоо нэгийг хангалаа. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Тэгэхээр энэ нэг систем учраас энийг улам нягтруулж, нямбайруулж, цогц хуулийг нь ЭХХШТХ, Эрүүгийн хуулийг бол байгаа хийдэл, зөрчлүүдийг хэрэг маргаан удаашруулдаг асуудлуудыг нэг мөр шийдвэрлэх чиглэлээр энэ ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй.

Эрүүгийн эрх зүй бол онолынх нь үндсэн дээр, практик амьдралын шаардлага, хууль хэрэглээнд гарч байгаа асуудлууд дээр Дээд шүүх, шүүгч нар, прокурор оролцоод энэ хуулийг бол их эрх зүйн онол дээр тулгуурлаж, орчин үед зөвхөн эрүүгийн эрх зүйн онол төдийгүй, эдийн засгийн онол, салбар дундын шинжлэх ухаан болж хөгжиж байгааг харгалзан үзэж шинжлэх ухааны үндэстэй энэ хэрэг авлигатай тэмцэх ийм цогц шийдлийг бас гаргаж ирж тэмцмээр байгаа юм. Их Хурал одоо энэ олборлох салбарын ил тод байдлын санаачилгын хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиудыг хэлэлцэж байна. Шүгэл, үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг одоо хэлэлцэж байна. Энэ мэтчилэн ийм цогц багц хуулиудаар авлигатай тэмцэх бодлогыг бол Улсын Их Хурлын анхаарлын төвд байсаар ирсэн.

Ер нь бол энэ бүх том хэргүүдийг шүгэл үлээгч энэ Улсын Их Хурлын гишүүд байсан гэж хэлж болно. Зоригийн хэргээс авхуулаад, Хөгжлийн банкны асуудал. Дандаа Улсын Их Хурлын Хяналт шалгалтын түр хороод, энэ шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу тийм мөрдөн шалгах эрхтэй болж, хяналт шалгалтын эрхтэй болж, энэ хүрээндээ асуудлууд хөндөгдөж яригдаж, нийгэмд хүрч, Засгийн газар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд шаардлага санал тавьж, чиглэл өгч байсны үр дүнд энэ оффтейкийн гэрээнүүд ил тод болохоос авхуулаад энэ асуудлууд хөвөрч эхэлсэн. Тийм учраас энэ бол Их Хурал бол Их Хурлын бас шударга

гишүүдийн санаачилгаар авлигатай тэмцэх ажил бол алхам алхмаар урагшилж байгаа. Эрх зүйт төр бэхжих, хөгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр алхам алхмаар ажил төрлүүд хийгдэж байгаа гэдгийг бас онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Төрийн ордонд л одоо бүх болох бүтэхгүй байгаа юм шиг байж төрийг харлуулдаг, борлуулдаг ийм сэтгэлгээ ийм сошиал давлагаа бол ард иргэдийг, олон нийтийг төөрөгдүүлэх зорилготой ийм жинхэнэ гэмт хэрэгтнүүдийн, аль эсвэл гадаад, дотоодын бүлэглэлүүдийн ийм өгөөш хатгалга байж болзошгүй учраас Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн анхаарал сонор, сэрэмжтэй байж, аливаа мэдээллийг нягт нямбай нягталж шалгаж, олон нийтэд хүргэж байхыг хүсье. Багцаа баримжаагүй тоо, нотлох баримт, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл бол ард олонд асар их бухимдлыг бас дагуулж байна.

Үнэн зөв шүгэл үлээгчийн мэдээлэл бол үнэн зөв байх явдал хамгийн чухал юм шүү. Ингээд Эрүүгийн хуулийг эцэслэн, Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг эцэслэн баталлаа. Хууль бус үйлдэл нь далд явагддаг авлигын гэмт хэргийг илрүүлэх мөрдөн шалгахад томоохон ахиц гарна гэж итгэж байна. Ажлын хэсэг, гишүүддээ баярлалаа, ажлын амжилт хүсье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан байна. Унших юмнууд. Ер нь бол 12 дугаар сарын 10-ны өдөр одоо энэ Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах асуудлуудыг манай энэ Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Лхагвын Мөнхбаатар, Баттөмөрийн Энхбаяр гээд олон гишүүд хөндөж, бид ярилцаад энэ асуудал урагштай явж байна. Цаашидаа улам чамбай болгох хэрэгтэй.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.УЯНГА